



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2026 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2026 ОНЫ 4 ДҮГЭЭР САРЫН 30-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
НЭГДСЭН ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ГАЗАР

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2026 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр, Пүрэв гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-16
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	17-116

1.Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин, Х.Ганхуяг нар 2025.12.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжилнэ/	16-21
2.Гадаад зээллэгийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Н.Алтаншагай нарын 21 гишүүн 2025.12.26-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	21-25
3.Нийгмийн ажлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулуун нарын 24 гишүүн 2025.12.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	25-61 108-110
4.Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.05.16-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	61-94 110-115
5.Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 01 дүгээр дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөнтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/	94-97
6.Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн нарын 4 гишүүн 2025.03.31-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	97-108
7. Баталсан хуулийн эцсийн найруулга сонсох	115-116

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы
4 дүгээр сарын 30-ны өдөр /Пүрэв гараг/-ийн
нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 76 гишүүн хүрэлцэн ирж, 60.3 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 00 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: М.Бадамсүрэн, Ж.Бат-Эрдэнэ, Э.Болормаа, А.Ганбаатар, С.Ганбаатар, Д.Цогтбаатар, Д.Рэгдэл, М.Энхцэцэг;
Чөлөөтэй: Ж.Баясгалан, Т.Мөнхсайхан, Ц.Туваан, Н.Учрал;
Эмнэлгийн чөлөөтэй: П.Мөнхтулга, Б.Тулга;
Тасалсан: Д.Амарбаясгалан, Э.Бат-Амгалан, Л.Оюун-Эрдэнэ.

Хоцорсон: С.Амарсайхан-1 цаг 05 минут, О.Амгаланбаатар-05 минут, Ч.Анар-17 минут, Х.Баасанжаргал-27 минут, Д.Батлут-01 минут, Ж.Батсуурь-01 минут, Н.Батсүмбэрэл-15 минут, Б.Батцэцэг-1 цаг 54 минут, П.Батчимэг-43 минут, Э.Батшугар-03 минут, Ж.Баярмаа-15 минут, Х.Булгантуяа-13 минут, Г.Ганбаатар-12 минут, Ц.Даваасүрэн-16 минут, Т.Доржханд-24 минут, Б.Дэлгэрсайхан-35 минут, Б.Жавхлан-1 цаг 50 минут, Б.Жаргалан-03 минут, Д.Жаргалсайхан-1 цаг 40 минут, Ц.Идэрбат-06 минут, Ц.Мөнхбат-2 цаг 42 минут, Н.Номтойбаяр-04 минут, С.Одонтуяа-01 минут, Г.Очирбат-04 минут, Б.Пунсалмаа-06 минут, А.Ундраа-27 минут, Ч.Ундрэм-11 минут, О.Цогтгэрэл 01 минут, С.Цэнгүүн-04 минут, Б.Чойжилсүрэн-07 минут, Б.Энхбаяр-21 минут, Ж.Энхбаяр-34 минут, Р.Эрдэнэбүрэн-3 цаг 00 минут.

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт энэ долоо хоногт төрсөн өдөр нь тохиож буй Улсын Их Хурлын гишүүн Э.Бат-Амгалан, Г.Уянгахишиг, Ш.Бямбасүрэн нарт Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс баяр хүргэж, эрүүл энх, аз жаргал, сайн сайхныг хүсэн ерөөв.

Нэг.Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин, Х.Ганхуяг нар 2025.12.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжилнэ/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул нар байлцав.

Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга О.Цогтгэрэл Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлаас авсан завсарлагын хугацаа дууссан тухай мэдэгдэж үг хэлэв.

Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудал санал хураалтаар үргэлжлэв.

С.Бямбацогт: Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 43
Татгалзсан: 47
Бүгд: 90
47.8 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Хуралдаанд оролцсон гишүүдийн олонх хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжээгүй тул “Хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах тухай” Улсын Их Хурлын тогтоол баталсанд тооцов./10:18/

Хоёр.Гадаад зээллэгийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Н.Алтаншагай нарын 21 гишүүн 2025.12.26-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монголбанкны дэд Ерөнхийлөгч Г.Энхтайван, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, мөн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогын газрын дарга Ч.Хишигдалай, Эрчим хүчний яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга О.Хуягцогт, Нийслэлийн Засаг даргын эдийн засгийн хөгжил, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч Т.Даваадалай, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын дарга М.Үнэнбат, мөн газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Л.Эрдэнэбадрах, Ашигт малтмал газрын тосны газрын Газрын тос боловсруулах газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Чулуунбат, “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн гүйцэтгэх захирал Д.Алтанцэцэг, мөн компанийн Гэрээ, эрх зүйн газрын дарга У.Чинзориг, “Сэлбэ 20 минут корпораци” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн гүйцэтгэх захирал У.Баатар нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, зөвлөх Ё.Энхсайхан нар байлцав.

Гадаад зээллэгийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төслийн талаар Төсвийн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав. /Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42.2.1-д заасны дагуу хураалгах санал/

Төсвийн байнгын хорооны дэмжээгүй санал:

С.Бямбацогт: 1.Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлан, Р.Батболд, Н.Батсүмбэрэл, Ж.Баярмаа, Ц.Даваасүрэн, Б.Заяабал, З.Мэндсайхан,

Б.Пунсалмаа, П.Сайнзориг, Г.Хосбаяр, Д.Энхтуяа нарын гаргасан, Хуулийн төслийн 5 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай хэсэг нэмэх:

“5.4.Дунд хугацаанд хэрэгжих төслийн орлогоороо хөрөнгө оруулалтын зардлаа бүрэн нөхөх боломжтой, эдийн засгийн үр ашиг бүхий хөгжлийн төсөл, арга хэмжээг нэгдсэн төсөвт нөлөө үзүүлэхгүйгээр санхүүжүүлэх чиглэлийг баримтална.” гэсэн Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 50

Татгалзсан: 50

Бүгд: 100

50.0 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн У.Отгонбаярын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

С.Бямбацогт: Улсын Их Хурлын гишүүн У.Отгонбаярын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 54

Татгалзсан: 46

Бүгд: 100

54.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

С.Бямбацогт: 1.Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлан, Р.Батболд, Н.Батсүмбэрэл, Ж.Баярмаа, Ц.Даваасүрэн, Б.Заяабал, З.Мэндсайхан, Б.Пунсалмаа, П.Сайнзориг, Г.Хосбаяр, Д.Энхтуяа нарын гаргасан, Хуулийн төслийн 5 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай хэсэг нэмэх:

“5.4.Дунд хугацаанд хэрэгжих төслийн орлогоороо хөрөнгө оруулалтын зардлаа бүрэн нөхөх боломжтой, эдийн засгийн үр ашиг бүхий хөгжлийн төсөл, арга хэмжээг нэгдсэн төсөвт нөлөө үзүүлэхгүйгээр санхүүжүүлэх чиглэлийг баримтална.” гэсэн Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 60

Татгалзсан: 40

Бүгд: 100

60.0 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Саналын томъёоллоор санал хураалт явуулж дууслаа.

Гадаад зээллэгийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төслийг эцэслэн батлуулах бэлтгэл хангуулахаар Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 10 цаг 31 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Нийгмийн ажлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулуун нарын 24 гишүүн 2025.12.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд З.Мэндсайхан, Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Ням-Очир, мөн яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга Б.Бадамжав, Үндэсний дата төв Улсын төсөвт үйлдвэрийн газрын Их өгөгдөл, систем нэгтгэлийн газрын дарга Э.Баттөр, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн ажлын бодлого, төлөвлөлт хариуцсан шинжээч С.Учрал, Эрүүл мэндийн яамны Эрүүл мэндийн нийгмийн ажилтан, судлаач Л.Долгор, хуульч, судлаач Г.Оюунболд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, зөвлөх Б.Мажигсүрэн, референт Н.Монголмаа нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулуун, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Болормаа нар танилцуулав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.4-т “Хуулийн төслийг баталснаар улсын төсвийн орлогын хэмжээ буурах, зарлагын хэмжээ нэмэгдэхээр байвал энэ тухай Засгийн газрын саналыг заавал сонсох бөгөөд хуралдаанд энэ хуулийн 31.2-т заасан Засгийн газрын гишүүн танилцуулна.” гэж заасны дагуу Засгийн газрын саналыг Сангийн сайд З.Мэндсайхан танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга, Б.Баярбаатар, М.Ганхүлэг, Л.Соронзонболд, Ж.Ганбаатар, П.Наранбаяр, Б.Батбаатар, Х.Булгантуяа, Х.Баасанжаргал нарын тавьсан асуултад хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулуун, А.Ариунзаяа, Сангийн сайд З.Мэндсайхан, Үндэсний дата төв Улсын төсөвт үйлдвэрийн газрын Их өгөгдөл, систем нэгтгэлийн газрын дарга Э.Баттөр, Эрүүл мэндийн яамны Эрүүл мэндийн нийгмийн ажилтан, судлаач Л.Долгор, хуульч, судлаач Г.Оюунболд нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, С.Зулпхар, Ц.Мөнхтуяа нар үг хэлэв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав./12:32/

Дөрөв.Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.05.16-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Байгаль

орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Ц.Сандаг-Очир, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Батбаяр, мөн яамны Тусгай хамгаалалттай газар нутгийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга Ц.Уранчимэг, Хүрээлэн буй орчны бодлого, үнэлгээний газрын Байгаль орчны үнэлгээ, аудитын хэлтсийн дарга Б.Алтанзул, хуульч, судлаач М.Энхмэнд, судлаач И.Бямбахүү нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, зөвлөх Бад.Баярмаа нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга нар танилцуулав.

Үдээс өмнөх хуралдаан 3 цаг 00 минут үргэлжилж, 13 цаг 00 минутад өндөрлөв.

Үдээс хойших хуралдаан 14 цаг 00 минутад эхлэв.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэг, Д.Бум-Очир, Б.Бейсен, С.Одонтуяа, Д.Энхтуяа, Д.Энхтүвшин, Л.Мөнхбаясгалан, М.Мандхай, Б.Батбаатар, Г.Хосбаяр, О.Саранчулуун, Х.Баасанжаргал нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга, ажлын хэсгийн гишүүн, Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Ц.Сандаг-Очир, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Батбаяр, мөн яамны Тусгай хамгаалалттай газар нутгийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга Ц.Уранчимэг, Хүрээлэн буй орчны бодлого, үнэлгээний газрын Байгаль орчны үнэлгээ, аудитын хэлтсийн дарга Б.Алтанзул нар хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав./15:25/

Тав.Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 01 дүгээр дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөнтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны зөвлөх Ч.Батбямба, референт А.Амармэнд, Б.Баясах, О.Мөнгөнчавхдас нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатар танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин, Г.Ганбаатар нар үг хэлэв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав./15:36/

Зургаа.Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн нарын 4 гишүүн 2025.03.31-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Эрдэнэбаяр, мөн яамны Бодлого төлөвлөлтийн газрын ахлах шинжээч С.Жаргалсайхан, Эмнэлгийн тусламжийн бодлогын хэрэгжилтийн газрын мэргэжилтэн Н.Отгонжаргал, Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах үйл ажиллагааг зохицуулах албаны дарга Б.Алтантулга, мөн албаны зөвлөх П.Батчулуун, “Өөжин мед” үр шилжүүлэн суулгах эмнэлгийн эмч Г.Гэрэлцэцэг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, зөвлөх Г.Анар-Эрдэнэ, референт Н.Монголмаа нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар танилцуулав.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд, Б.Бейсен, Б.Батбаатар нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар, Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах үйл ажиллагааг зохицуулах албаны дарга Б.Алтантулга нар хариулж, тайлбар хийв.

Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн талаар Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав. /Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42.2.1-д заасны дагуу хураалгах санал/

Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны дэмжсэн санал:

С.Бямбацогт: 1.Төслийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн “Эрхтэн, эд” гэсний дараа “, эс” гэж, мөн зүйлийн 6.2.1 дэх заалтын “гэрлэлтээ бүртгүүлснээс хойш 3-аас доошгүй жил” гэсний дараа “, бэлгийн эс шилжүүлэн суулгах тохиолдолд нэгээс доошгүй жил” гэж мөн заалтын “гэрлэгчид дундаасаа” гэсний дараа “төрсөн” гэж, мөн зүйлийн 6.2.2 дахь заалтын “гадаад улсын иргэн,” гэсний дараа “харьяалалгүй хүн” гэж, мөн заалтын “эрхтэн, эд” гэсний дараа “, эс” гэж тус тус нэмж, мөн зүйлийн 6.2.1 дэх заалтын “тус улсад” гэснийг хасах гэсэн Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 61

Татгалзсан: 48

Бүгд: 109

56.0 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

2.Төслийн 15 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 15.13, 15.14 дэх хэсэг нэмэх:

“15.13.Нэг донорын бэлгийн эсийг зөвхөн тухайн нэг гэр бүлд ашиглахыг зөвшөөрнө.

15.14.Үр хөврөлийг эцэг, эхээс нь бусад хүмүүст ашиглахыг хориглоно.” гэсэн Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 63

Татгалзсан: 46

Бүгд: 109

57.8 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

3.Төслийн 22, 23 дугаар зүйлийг нэгтгэн 22 дугаар зүйл болгож, доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“22 дугаар зүйл. Амьгүй донорын гэр бүлд олгох тэтгэмж болон амьд донорт үзүүлэх дэмжлэг

22.1.Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний оршуулгын тэтгэмжийг эрүүл мэндийг дэмжих сангаас олгоно.

22.2.Амьд донорт эмнэлгийн тусламж, үйлчилгээг хөнгөлөлттэй үзүүлэх журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, рашаан сувилалд сувилуулах журмыг гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

22.3.Хуульд заасан бусад.” Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 67

Татгалзсан: 42

Бүгд: 109

61.5 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

4.Зарчмын зөрүүтэй 3 дугаар санал буюу хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний оршуулгын тэтгэмжийг эрүүл мэндийг дэмжих сангаас олгох санал дэмжигдсэнтэй холбогдуулан хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл болон Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах гэсэн Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 68

Татгалзсан: 41

Бүгд: 109

62.4 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дууслаа.

Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг эцэслэн батлуулах бэлтгэл хангуулахаар Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 16 цаг 16 минутад хэлэлцэж дуусав.

Гурав дахь асуудал буюу Нийгмийн ажлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудал санал хураалтаар үргэлжлэв.

С.Бямбацогт: 1.Нийгмийн ажлын тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 64

Татгалзсан: 45

Бүгд: 109

58.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн:

С.Бямбацогт: 2.Ахмад настны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 68

Татгалзсан: 41

Бүгд: 109

62.4 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Боловсролын ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 64

Татгалзсан: 45

Бүгд: 109

58.7 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 69

Татгалзсан: 40

Бүгд: 109

63.3 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Нийгмийн халамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 66

Татгалзсан: 43

Бүгд: 109

60.6 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 67

Татгалзсан: 42

Бүгд: 109

61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Хүүхэд хамгааллын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 68

Татгалзсан: 41

Бүгд: 109

62.4 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 66

Татгалзсан: 43

Бүгд: 109

60.6 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Нийгмийн ажлын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 67

Татгалзсан: 42

Бүгд: 109

61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Нийгмийн ажлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 16 цаг 22 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв дэх асуудал буюу Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дэмжсэн санал:

С.Бямбацогт: 1.Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга, Н.Алтаншагай, Б.Бат-Эрдэнэ, Г.Ганбаатар, С.Замира, Ц.Идэрбат, Ц.Мөнхбат, Б.Мөнхсоёл, С.Одонтуяа /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалт буюу 7 дугаар зүйлийн 7.9 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“7.9.Төслийг байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл, цар хүрээ, төсөл хэрэгжих газар нутгийн байршил, хүчин чадлыг харгалзан дараах байдлаар ангилна:

7.9.1.зэрэглэл I буюу их эрсдэлтэй төсөлд байгаль орчин, нийгмийн бүрэлдэхүүн хэсэгт үзүүлэх сөрөг болон хуримтлагдах нөлөөлөл нь төслийн нөлөөллийн бүсийн хэмжээгээр хязгаарлагдахгүй, байгаль орчин, нийгмийн сөрөг нөлөөллийг бууруулахад нэмэлт арга хэмжээ шаардлагатай, газар чөлөөлөлтийн хамрах хүрээ ихтэй үйл ажиллагааг;

7.9.2.зэрэглэл II буюу дунд эрсдэлтэй төсөлд байгаль орчин, нийгмийн бүрэлдэхүүн хэсэгт үзүүлэх сөрөг нөлөөлөл нь төслийн нөлөөллийн бүсийн хэмжээгээр хязгаарлагдах боломжтой, байгаль орчин, нийгмийн сөрөг нөлөөллийг бууруулахад нөхцөл, болзолтой арга хэмжээ шаардлагатай, газар чөлөөлөлтийн хамрах хүрээ хязгаарлагдмал үйл ажиллагааг;

7.9.3.зэрэглэл III буюу бага эрсдэлтэй төсөлд байгаль орчин, нийгмийн бүрэлдэхүүн хэсэгт үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл хязгаарлагдмал, эсхүл эрсдэлгүй үйл ажиллагааг.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 63

Татгалзсан: 46

Бүгд: 109

57.8 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалт буюу 7 дугаар зүйлийн 7.13 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“7.13.Төсөл хэрэгжүүлэгч нь байгаль орчны ерөнхий үнэлгээнд санал авах хүсэлтийг төслийн товч танилцуулга, газрын эрхтэй холбоотой баримт бичгийн хамт тухайн сум, дүүргийн Засаг даргад гаргана.” гэсэн саналыг хуралдаан даргалагчаас гүйцээн боловсруулах чиглэл өгч санал хураалт явуулаагүй болно.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалт буюу 7 дугаар зүйлийн 7.14 дэх хэсгийн “ажлын 10 хоногт” гэснийг “ажлын 15 хоногт” гэж, “хариу өгсөнд” гэснийг “зөвшөөрсөнд” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 60

Татгалзсан: 49
Бүгд: 109
55.0 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “3.1.4 дэх заалтын “үнэлгээ гэж” гэсний дараа “зэрэглэл I, зэрэглэл II” гэж,” гэснийг, төслийн 4 дүгээр зүйлийн “3 дугаар зүйлийн 3.1.4 дэх хэсгийн “байгаль орчны” гэснийг “байгаль орчин, нийгмийн” гэж,” гэснийг болон төслийн 5 дугаар зүйлийг хасаж, 3.1.4 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж төслийн 3 дугаар зүйлд нэмэх:

“3.1.4.“байгаль орчны төлөв байдлын үнэлгээ” гэж зэрэглэл I, зэрэглэл II төслийн техник, эдийн засгийн төлөвлөлтийн баримт бичиг, зураг төсөл, улсын болон бүс нутаг, салбарын хэмжээнд хэрэгжүүлэх хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулах явцад тэдгээрийг хэрэгжүүлэх нутаг дэвсгэрийн байгаль орчин, нийгмийн төлөв байдлыг судлан тогтоож цаашид төсөл, хөтөлбөр, төлөвлөгөө, бодлого боловсруулахад анхаарах байгалийн нөхцөл, орчны онцлогийг тодорхойлохыг;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 61
Татгалзсан: 48
Бүгд: 109
56.0 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 4 дэх заалт буюу 7 дугаар зүйлийн 7.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“7.6.Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тайланд шинжилгээ хийж, дүгнэлт гаргах ерөнхий шинжээч, шинжээчийн эрхийг байгаль орчны асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллага олгох бөгөөд дараах шаардлагыг хангасан байна:

7.6.1.ерөнхий шинжээч нь Төрийн албаны тухай хуулийн 23.2.2-т заасан шаардлагыг хангасан, байгаль орчны чиглэлээр 8-аас доошгүй жил ажилласан, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх мэргэжлийн чадвар, ажлын туршлагатай байх;

7.6.2.шинжээч нь Төрийн албаны тухай хуулийн 18.1.4-т заасан шаардлагыг хангасан, байгаль орчны чиглэлээр 3-аас доошгүй жил ажилласан, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх мэргэжлийн чадвар, ажлын туршлагатай байна.” гэсэн саналыг хуралдаан даргалагчаас гүйцээн боловсруулах чиглэл өгч санал хураалт явуулаагүй болно.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 7 дахь заалт буюу 9 дүгээр зүйлийн 9.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“9.4.Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр батлагдсан менежментийн төлөвлөгөөнд нэмэлт, өөрчлөлт оруулах, хянах, тайлагнах журам, аргачлалыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 67
Татгалзсан: 42
Бүгд: 109

61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 9 дэх заалт буюу 10 дугаар зүйлийн 10.5 дахь хэсгийн “хамтран” гэсний дараа “төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн захиргаа,” гэж нэмэх гэсэн саналыг хуралдаан даргалагчаас гүйцээн боловсруулах чиглэл өгч санал хураалт явуулаагүй болно.

8.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 10 дахь заалт буюу 14.1.2 дахь заалтын “орон нутгийн захиргаа” гэснийг “нутаг дэвсгэрийн захиргаа” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 66
Татгалзсан: 43
Бүгд: 109

60.6 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 7 дугаар зүйлийн хуулийг дагаж мөрдөх хугацааг “2026 оны 8 дугаар сарын 01” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 68
Татгалзсан: 41
Бүгд: 109

62.4 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн нэр томъёог жигдлэх, зүйл, хэсэг, заалтын дугаарыг нийцүүлж өөрчлөх, бүтэц найруулга, хууль зүйн техникийн засварыг хийх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 67
Татгалзсан: 42
Бүгд: 109

61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

**Хоёр.Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн
байнгын хорооны дэмжээгүй санал:**

С.Бямбацогт: 1.Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддоржийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалт буюу 7 дугаар зүйлийн 7.14 дэх хэсгийг хасах гэсэн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 60
Татгалзсан: 49
Бүгд: 109

55.0 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддоржийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 10 дахь заалт буюу 18 дугаар зүйлийн 18.7 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“18.7.Иргэн тухайн төслийн үйл ажиллагаатай нь холбогдуулан газрын хэвлийн баялгийн ашиглалтын нөхцөл байдал, байгаль орчинд үзүүлж байгаа нөлөөлөл, нөхөн сэргээлтийн талаар мэдээлэл авах, танилцах хүсэлтийг төсөл хэрэгжүүлэгч, төрийн байгууллага, албан тушаалтанд гаргаж болох бөгөөд төслийн нөлөөлөлд өртөх иргэдийн олонхын бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр байгаль орчны нөлөөллийн үнэлгээг эергээр дүгнэхийг хориглоно.” гэсэн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 61
Татгалзсан: 48
Бүгд: 109

56.0 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

3.Төслийн 3 дугаар зүйлийн 9 дэх заалт буюу 10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“10.4.Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 10.5-д заасан танилцуулгаас гарсан саналыг нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланд тусгасан эсэх болон үнэлгээний шинжилгээ хийсэн шинжээч, мэргэжлийн зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн төслийг хэрэгжүүлэх эсэх асуудлыг шийдвэрлэх бөгөөд хэрэв байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тухайн төсөл нь усны нөөц, амьжиргааны тогтвортой байдалд ноцтой сөрөг нөлөө үзүүлэх нь тогтоогдсон тохиолдолд төслийг хэрэгжүүлэхийг хориглоно.” гэсэн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 48
Татгалзсан: 61
Бүгд: 109

44.0 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдсэнгүй.

4.Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддоржийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 9 дэх заалт буюу 10 дугаар зүйлийн 10.5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“10.5.Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний тайланг төсөл хэрэгжүүлэгч, үнэлгээ хийсэн мэргэжлийн байгууллага хамтран төслийн нөлөөлөлд өртөх иргэдэд танилцуулж, санал авах ажлыг зохион байгуулах бөгөөд төслийн улмаас иргэдэд учирсан хохирол, зардал, амьжиргааны алдагдал, усны хүртээмж, байгаль орчин, нийгэм, соёлын орчинд үзүүлсэн үр дагавар, нөлөөллийг хамруулан иж бүрнээр үнэлж, бүрэн нөхөн төлнө.” гэсэн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 45
Татгалзсан: 64

Бүгд: 109

41.3 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдсэнгүй.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дууслаа.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 16 цаг 34 минутад хэлэлцэж дуусав.

Тав дахь асуудал буюу Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг анхны хэлэлцүүлгээс эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх горимын саналаар санал хураалт явуулав.

С.Бямбацогт: Байнгын хорооноос гаргасан, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг анхны хэлэлцүүлгээс эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 64

Татгалзсан: 45

Бүгд: 109

58.7 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлуулах бэлтгэл хангуулахаар Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 16 цаг 37 минутад хэлэлцэж дуусав.

Долоо.Баталсан хуулийн эцсийн найруулга сонсох

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./16:39/

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 7 асуудал хэлэлцэв.

Бусад.Улсын Их Хурлын гишүүн Ж.Галбадрахын урилгаар Япон Улсын Парламентын Төлөөлөгчдийн танхимын гишүүн, Төлөөлөгчдийн танхим дахь Япон-Монголын парламентын найрамдлын бүлгийн Ажлын албаны дарга Такабэ Арата тэргүүтэй төлөөлөгчид, Улсын Их Хурлын гишүүн Ц.Баатархүүгийн урилгаар Чингэлтэй дүүргийн 2, 3, 4, 5, 21 дүгээр хорооны иргэдийн төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаясгалангийн урилгаар Говьсүмбэр аймгийн Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 10^б, 11^б ангийн багш, сурагчид, Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлангийн урилгаар Хан-Уул дүүргийн 4, 5 дугаар хорооны хэсгийн ахлагчид, Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрамын урилгаар Сэлэнгэ аймгийн

Сүхбаатар сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 11^б ангийн багш, сурагчид, Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, Н.Алтаншагай нарын урилгаар Нийслэлийн ерөнхий боловсролын 74 дүгээр сургуулийн 12 дугаар ангийн багш, сурагчид, Нийслэлийн ерөнхий боловсролын англи хэлний “Кингс Кидс” сургуулийн 9 дүгээр ангийн багш, сурагчид, Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргалын урилгаар Нийслэлийн ерөнхий боловсролын “Эрдмийн өргөө” сургуулийн 8, 9 дүгээр ангийн багш, сурагчид, Монгол Улс дахь Франц сургуулийн багш, ажилчид, Нийслэлийн ерөнхий боловсролын 24 дүгээр сургуулийн 12 дугаар ангийн багш, сурагчид, Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын урилгаар Нийслэлийн ерөнхий боловсролын 153 дугаар сургуулийн 12 дугаар ангийн багш, сурагчид Төрийн ордон, Улсын Их Хурлын чуулганы үйл ажиллагаатай танилцав.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хуралдаан зохион байгуулах газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

Хуралдаан 5 цаг 40 минут үргэлжилж, 126 гишүүнээс 109 гишүүн хүрэлцэн ирж, 86.5 хувийн ирцтэйгээр 16 цаг 40 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Л.ӨЛЗИЙСАЙХАН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ГАЗРЫН ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2026 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр,
Пүрэв гараг Төрийн ордон “Их хуралдай” танхим 10 цаг 00 минут.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

С.Бямбацогт: Улсын Их Хурлынхаа эрхэм гишүүдийн өглөөний амгаланг айлтгая. Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны 2026 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн ирц 126 гишүүнээс 74 гишүүн буюу 59.5 хувийн ирцтэй бүрдсэн байна. 75 гишүүн хүрэлцэн ирсэн байна. Чуулганы ирц хүрсэн учраас 2026 оны хаврын ээлжит чуулганы 4 дүгээр сарын 30-ны өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье.

Өнөөдрийн чуулганы нэгдсэн хуралдаанд Сүхбаатарын Эрдэнэболд, Бат-Өлзийн Бат-Эрдэнэ, Пүрэвжавын Сайнзориг, Бөхчулууны Пүрэвдорж, Хишигдэмбэрэлийн Тэмүүжин нарын гишүүд хамгийн түрүүлж ирцдээ орсон 9 цагт ирсэн байна аа.

Төрсөн өдөр нь тохиож буй гишүүдийг та бүхэнд мэндчилгээ дэвшүүлье.

4 дүгээр сарын 27-нд Улсын Их Хурлын гишүүн Энхтайваны Бат-Амгалан, 4 дүгээр сарын 29-нд Улсын Их Хурлын гишүүн Гончигдоржийн Уянгахишиг, 4 дүгээр сарын 30-нд Улсын Их Хурлын гишүүн Шинэбаярын Бямбасүрэн нар төрсөн байна. Улсын Их Хурлын гишүүн Энхтайваны Бат-Амгалан, Гончигдоржийн Уянгахишиг, Шинэбаярын Бямбасүрэн нартаа төрсөн өдрийн мэнд хүргэж, Монгол төрийн эрхэм түшээ ард түмнийхээ элч болсон танд болон та бүхний гэр бүлд Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Энэ 7 хоногийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх тов дараалалд орсон асуудлаас Дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай асуудал Улсын Их Хурлын гишүүн Даваагийн Цогтбаатарын гаргасан горимын саналын дагуу хойшлогдсон байна.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд ХЗБХ-ны 4 дүгээр сарын 29-ний хуралдааны явцад Их Хурлын гишүүн Гончигдоржийн Уянгахишиг гишүүний гаргасан горимын саналыг нь дэмжээд хойшлуулсан байна аа. Энэ Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль их чухал хууль шүү. Одоо энэ хүүхэд багачууд скүүтэр, сурон, мопед унаад явган хүний зам дээгүүр зорчиж, иргэдийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдалд хохирол учруулж байгаа. Мөн замын хөдөлгөөний аюулгүй байдлын дүрэм мэдэхгүйгээсээ болж авто замын хөдөлгөөнд оролцож өөрсдөө бас амь насаа алдах, эрүүл мэндээр хохирох ийм асуудлууд гарч байгаа. Үүнийг зохицуулсан хуулийг яаралтай батлах ёстой. Энийг бас ирэх 7 хоногтоо яаралтай хэлэлцээд батлах шаардлагатай байгаа шүү. Тийм болохоор дахин дахин хуулиуд хойшлуулмааргүй байна шүү гэдгийг гишүүддээ сануулж хэлье. Улсын Их Хурлын гишүүн Пүрэвийн Батчимэг нарын гишүүд санаачилсан ийм хууль байгаа.

Өнөөдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.
7 асуудал хэлэлцэнэ.

Нэгдүгээрт нь, Худалдаа аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулна. Улсын Их Хурлын гишүүн Дашцэрэнгийн Энхтүвшин, Хассуурийн Ганхуяг нар 2025 оны 12 дугаар сарын 27-ны өдөр өргөн мэдүүлсэн хэлэлцэх эсэх.

Хоёрдугаарт нь, Гадаад зээллэгийн ашиглалт үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэг үргэлжлүүлэн явуулна. Улсын Их Хурлын гишүүн Наранцэцэгийн Алтаншагай нарын 21 гишүүн 2025 оны 12 дугаар сарын 12-ны өдөр өргөн мэдүүлсэн эцсийн хэлэлцүүлэг явуулна. Зарчмын зөрүүтэй нэг саналтай.

Гуравдугаарт нь, Нийгмийн ажлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна. Улсын Их Хурлын гишүүн Отгоны Саранчулуун нарын 24 гишүүн 2025 оны 12 дугаар сарын 17-ны өдөр өргөн мэдүүлсэн хэлэлцэх эсэх асуудлыг шийдвэрлэнэ. Одоо асуулт хариулт 120 минут.

Дөрөвдүгээрт нь, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна. Засгийн газар 2025 оны 5 дугаар сарын 16-ны өдөр өргөн мэдүүлсэн.

Тавдугаарт нь, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна. Цэцийн 2026 оны 1 дүгээр дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөнтэй холбогдуулан хэлэлцэж байгаа.

Зургаад нь, Эрхтэн, эд эс шилжүүлэн суулгах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна. Улсын Их Хурлын гишүүн Жигжидсүрэнгийн Чинбүрэн нарын 4 гишүүн 2025 оны 3 дугаар сарын 31-ний өдөр өргөн мэдүүлсэн.

Долоод нь, Баталсан хуулийн эцсийн найруулгуудыг сонсоно оо.

Ийм дарааллаар өнөөдөр хэлэлцэх асуудлыг хэлэлцэнэ ээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 29.1-д Улсын Их Хурлын дарга хууль санаачлагчаас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн төслийг хэлэлцүүлж бэлтгэх байнгын хороог хэрэв тухайн төсөлд хэд хэдэн Байнгын хороо эрхлэх асуудлын хүрээнд хамаарах бол зөвлөлтэй зөвшилцөн холбогдох болон бусад байнгын хороог тогтоож нэгдсэн хуралдаанд мэдээлнэ гэж заасан. Үүний дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хуулийн төслийг холбогдох байнгын хороонд хуваарилсан талаар танилцуулъя.

Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг Улсын Их Хурлын гишүүн Жуковын Алдаржавхлан 2026 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр өргөн мэдүүлснийг ТББХ-нд хуваарилсан.

Хэлэлцэх асуудалдаа орцгооё.

Худалдаа аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулна аа.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан Улсын Их Хурал дахь АН-ын бүлэг 2026 оны 4 дүгээр сарын 23-ны өдөр 4 дүгээр сарын 30-ны өдрийн 10 цаг хүртэл завсарлага авсан байгаа. Завсарлагын хугацаа дууссан байна аа. Завсарлагын хугацаа дууссантай холбогдуулан Улсын Их Хурал АН-ын даргын АН-ын бүлгийн даргаас үг хэлэх үү? Одонгийн Цогтгэрэл гишүүний микрофон өгье.

О.Цогтгэрэл: Танхимын тухай хуулийн хэлэлцүүлгүүд бас үргэлжилж байгаа. Энэ хуулийн төсөлтэй холбогдуулж АН-ын бүлгээс завсарлага авсан. Завсарлагатай холбогдуулж өчигдөр бид нар оролцогч талууд танхим хууль санаачлагч Улаанбаатар хотын танхим тэгээд бизнесийн төлөөллүүд гээд бас нэлээн өргөн бүрэлдэхүүнтэй хэлэлцүүлгийг АН-ын бүлгээс зохион байгуулсан. Энэ хэлэлцүүлгийн хүрээнд болоод ер нь яригдаж байгаа асуудал энэ хууль дээр бас учир дутагдалтай олон олон зүйлүүд байна аа.

Танхим гэдэг нь уг нь бол төрийн хүнд суртлаас бизнесүүдийг чөлөөлөх, дэмжих, хамгаалах, бас ер нь дэмжих чиглэлд төр хувийн хэвшил хоёрын хооронд холбоос болж ажиллах энэ үндсэн чиг үүргийнх нь хүрээнд ажиллах олон олон зохицуулалтууд байх ёстой байтал ер нь яг энэ хуулийн үндсэн агуулга, үзэл санааг харахад өрсөлдөөнийг хумьсан, иргэний нийгмийн байгууллага мэргэжлийн холбоодуудын оролцоог хумигдсан. Ер нь саяын үндсэн чиг үүрэг үүрэг биш ХАҮТ гэдэг нэг байгууллагад төрийн эрх мэдлийг хэрхэн яаж шилжүүлэх вэ гэдэг ийм үзэл баримтлалын хүрээнд болчихжээ гэдгийг оролцогчид нэлээн олноор энэнд бас шүүмжлэлтэй байр суурь хамгийн гол нь гол гол оролцогч талууд бүгдээрээ эсрэг байр суурьтай. Ерөөсөө энд санал нэгдэж байгаа зүйл байхгүй. Танхим нь нэг өөр зүйл хэлсэн. Хууль санаачлагч нэг өөр зүйл хэлсэн. Бусад оролцогчид өөр зүйл хэлсэн. Ийм нөхцөл байдалтай хуулийн төслийн нөхцөл байдал хэлэлцүүлэг болж хувирсан.

Тэгээд энэ бүгдээс харахад энэ хуулийн төслийг ер нь хууль санаачлагчид нь буцаагаад дахиж энэ бизнесүүдийнхээ оролцоотойгоор эргэж өргөн барьж хэлэлцүүлэх нь зүйтэй юм уу гэдэг байр суурь давамгайлж байсныг энд та бүгдэд ингээд мэдээлэл болгож хэлье ээ.

С.Бямбацогт: Завсарлагын хугацаа дууссан сунгахгүй. Одоо Худалдаа аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх талаар санал хураалт явуулна аа. Гишүүд санал хураалтдаа бэлдье.

Чуулганы хуралдааны танхимд ирцдээ орсон 126 гишүүнээс 90 гишүүн ирцдээ орсон байна. 89 гишүүн. Хуралдааны санал хураалтад бэлтгэсэн 49 гишүүн болсон байна. Бусад гишүүд санал хураалтдаа бэлдье. Би хэлж байгаа шүү дээ. Өглөө ирцдээ орчхоод гараад явчихдаг байж таарахгүй. Санал хураалт бол ирцтэй адилхан чухал ач холбогдолтой. Хуралдаанд олонхын саналаар асуудлыг шийдвэрлэдэг. Тийм болохоор санал хураалтад дэмжсэн, дэмжээгүй саналаа яг

өөрсдийн биеэр өгдөг байх нь чухал байгаа. Тэгээд дэмжихгүй байж болно. Дэмжихгүй байгаагаа тэгвэл ирцдээ ороод санал хураалтдаа бэлдээд дэмжихгүй кнопоо дараад л өгчих хэрэгтэй.

61 гишүүн санал хураалтад бэлэн болсон байна. Санал хураалт явуулъя.

Худалдаа аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Санал хураалтад 90 гишүүн оролцсоноос 43 гишүүн буюу 47.8 хувийн саналаар энэ санал дэмжигдсэнгүй ээ.

Тэгэхээр бусад асуудлаар санал хураахгүй тийм үү? Буцаах тогтоолын төсөл хаана байна.

Монгол Улсын Их Хурлын тогтоол. Хуулийн төсөл буцаах тухай.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.14 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас Тогтоох нь:

Нэг. Монгол Улсын Их Хурлын гишүүн Ганхуяг, Энхтүвшин нараас 2025 оны 12 дугаар сарын 17-ны өдөр Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Худалдаа аж үйлдвэрийн танхимын хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Худалдаа аж үйлдвэрийн танхимын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Статистикийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Өрсөлдөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрчим хүчний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээг худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Чөлөөт бүсийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Мэргэжлийн болон техникийн боловсрол сургалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Худалдаа аж үйлдвэрийн танхимын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг нэгдсэн хуралдаанд хуралдааны санал хураалтад оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй тул хууль санаачлагчид нь буцаасугай.

Буцаахаар чинь одоо нэг жилийн хугацаанд дахиж өргөн барихгүй билүү? Гэхдээ өөр субъект өргөн барьж болно тийм үү? Адил агуулгаар бас энэ хуулийг өргөн барих дэг байхгүй юм байна. Тийм болохоор одоо бас их онцгой анхаарах ёстой. Яг өнөөдөр МҮХАҮТ дарга нарын гадаад, дотоод аялал, бизнес эрхлэгчдийг бизнес аялал зохион байгуулах гарал үүслийн гэрчилгээ олгож тодорхой санхүүгийн эх үүсвэрээ бүрдүүлэх, дээрээс нь Топ 100 ААН шалгаруулж алдаршуулах гэсэн их тодорхой нэг хэдэн ажлууд л хийдэг. Яг үнэндээ иргэн, хуулийн этгээд, хувийн хэвшлийн ААН-үүд 2-ыг холбох чиг үүргээ тийм бүрэн хангалттай сайн хэрэгжүүлж чадахгүй байгаа. Уул нь төр хувийн хэвшил 2-ыг холбох гүүр нь болж байх ёстой. Гэтэл гүүрний манаач нь болоод энэ ААН-үүдээ, татвар төлөгчдөө, баялаг бүтээгчдээ дэмжсэн төртэй холбосон хүнд суртлыг багасгасан. Энэ Монгол Улсынхаа эдийн засгийг тэлэхэд хувь нэмрээ оруулсан үйл ажиллагаа явуулах

ёстой шүү. Тэгэхээр энэ тал дээр бас ямар шийдэл байж болох вэ? Хууль энд хуулийн төсөл буцлаа. Бас дараагийн энэ хуулийг сайжруулах шаардлага байгаа. Энэ дээр гишүүдийг хууль санаачлагчдыг Засгийн газар гишүүдийг анхааралдаа авахыг хүсье ээ.

Хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг санал хураалтад оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй тул төслийг хууль санаачлагчид нь буцаах тухай тогтоол батлагдсанд тооцлоо.

10.15 цаг

Дараагийн асуудалдаа оръё.

Гадаад зээллэгийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэг

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан Улсын Их Хурал дахь МАН-ын бүлэг 2026 оны 4 дүгээр сарын 24-ний өдөр 4 дүгээр сарын 30-ны өдрийн 10 цаг хүртэл завсарлага авсан. Завсарлагын хугацаа дууссан байна аа. Завсарлагын хугацаа дууссантай холбогдуулан МАН-ын бүлгийн даргаас үг хэлэх үү? Үг хэлэхгүй юм байна. Одоо байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна аа.

Зарчмын зөрүүтэй саналыг дэмжсэн, эсрэг байр суурьтай намын бүлгийг төлөөлж мөн аль нэг нам, бүлгийн нам, эвслийн бүлэгт харьяалагдаагүй тус бүр 2 хүртэл гишүүн үг хэлж болно оо. Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн үгээ хэлье. 1 дүгээр микрофон.

Д.Энхтүвшин: Эрхэм гишүүдийн энэ өглөөний амгаланг айлтгая аа. Тэгээд энэ гадаад зээллэгтэй холбоотой хууль дотор Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс энэ Сэлбэ дэд төвтэй холбоотой асуудлыг яагаад орж ирсэн үндэслэлийг ойлгохгүй талаараа энэ орох үндэслэл хангалттай байхгүй байгаа талаар маш тодорхой заалтууд оруулсан байгаа. Гэтэл энэ төсөл маань ажлын хэсэг дээр унасан санал маань Их Хурал дээр АН бас нэг хуралтай байх үеийг нь давхардуулаад Улсын Их Хурлын гишүүдийн эс үйлдлээр энэ заалт нь босоод ирсэн. Тэгэхээр энэ заалт Сэлбэ дэд төв маань болохоор хувийн хэвшлийн орон зайг унаж байгаа ийм төсөл байгаа. Монгол Улсын барилгын салбар жилдээ нэг 19 мянга орчим айлын орон сууц ашиглалтад оруулдаг. Энэ төсөл маань нийслэл одоо дангаараа бараг энэний 50 хувьтай тэнцсэн 9 мянга орчим айлын орон сууц одоо жишээлбэл барихаар ийм төсөл байгаа. Тэгэхээр энэ бол эдийн засагт хувийн хэвшлийн орон зайг хумиж байгаа. Дээр нь энэ төслийн төсвийн сахилга батаас гадуур одоо ийм төсөл хөтөлбөрийг өмнө нь бонд гаргаад санхүүжүүлнэ гэж орж ирсэн мөртлөө одоо бас тодорхой хэмжээний шалтаг тайлбарууд хэлээд энийг төсвийн тусгай шаардлагуудаас гадуур хийх гэж байгаа нь бол зохистой биш ээ гэж бодож байгаа. Тэгэхээр энэ хуулийн төслийг уул нь зүй нь бол буцааж татаж аваад илүү сайжруулаад энэ Сэлбэ дэд төвтэй холбоотой заалтаа хасаад оруулаад ирээсэй гэж бодож байсан. Гэхдээ одоо санал хураалтаар шийдэх байх.

Ер нь Улсын Их Хурал дээр ч гэсэн сая энэ танхимын тухай хууль бас ингээд хэлэлцэх эсэх нь дэмжигдсэнгүй. Хэдүүлээ ер нь ингээд дарга цэрэг томилгоо л ярьдаг, эсвэл яаралтай горимоор орж ирсэн юм ярьдаг энэ улсын тогтолцоо эрүүл

болох тал руугаа хууль тогтоомжууд санаачлаад оруулаад ирэхээр ингээд зохион байгуулалттайгаар ч юм уу, тодорхой хэсэг бүлгийн нөлөөнд автаж ингээд унагаж байна. Өнөөдөр бие даасан хараат бус байх ёстой бүх институц маань улс төрөөс хараат болчихсон. Тэгээд 1 ядаж хувийн хэвшлийн орон зайг одоо жишээлбэл энэ хараат бус болгоё оо гэхээр энэ төслийг АН-ын гишүүд маань голдуу дэмжсэнгүй. Тэгээд энэнтэй адилхан энэ хууль дээр ч гэсэн бие даасан байх ёстой төсвийн тогтвортой байдлын зөвлөл маань энэ Сэлбэ дэд төвийг оруулахгүй байх ёстой гэсэн ийм санал оруулж ирсэн. Тэгэхээр бид нар саналыг нь авахгүй юм бол ийм зөвлөлүүдийн санал дүгнэлтүүд гараад хэрэг байгаа юм уу. Бие даасан байдлыг нь одоо хангаад энэ санал дүгнэлтүүдийг нь хүлээж авахгүй юм бол энэ байгууллагуудын ач холбогдлыг нь улам сулруулж байна аа.

Тэгээд цаашдаа энэ бие даасан байгууллагуудын чадвар чадамжийг сайжруулах чиглэлээр энэ тавьсан саналуудыг нь авдаг байх чиглэлээр Улсын Их Хурлын гишүүд анхаарч ажиллаарай гэж, ажиллаасай гэж хүсэж байна. Баярлалаа.

С.Бямбацогт: Баярлалаа. Зочин танилцуулъя. Нийслэлийн ерөнхий боловсролын Амжилт Кибер сургуулийн 9.1, 9.2 дугаар ангийн багш сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа Төрийн ордонтой танилцаж байна аа. Эрхэм сурагчид хүүхэд багачууд та бүхнийхээ сурлагад нь өндөр амжилтыг, амьдралд нь аз жаргал, эрүүл энх, сайн сайхан бүхнийг Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс хүргэе ээ. Онц сураарай бүгдээрээ.

Одоо Ринчиндоржийн Батболд гишүүн асуултаа асууя, үгээ хэлье. Батболд гишүүн алга байна. Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн үгээ хэлье. Урьдчилж ирсэн нэрсийн дагуу хэлнэ. Та индэр дээрээс 1 дүгээр индэр.

Ц.Даваасүрэн: Та бүгдийнхээ энэ өглөөний амгаланг эрье. Би өмнө нь хэлчихсэн учраас зүгээр товчхон. Тэгэхээр энэ дээр нэг төслүүд дээр хоорондоо маргалдсан нэг юм ажиглагдаад байгаа юмаа. Би зүгээр одоо энэ төслүүдийн хувьд хэрэгцээ байна уу гэвэл байна гэж харж байна. Ялангуяа Сэлбэ төвийн асуудал бол Бат-Үүлээс эхлээд Барилгын сайдаар үе үеийн ажиллаж байсан улсуудын хүрээнд хэрэгжүүлж байсан ийм төсөл өө. Би одоо бас зургийг нь гаргаад ингээд явсан хүн. Энэ барилгын Сэлбэ төвийн зургийг гаргахаас гадна би Сэлбийн эргээр 2 урсгалтай, 4 эгнээ замын зургийг бас хийж өгсөн. Тэгэхээр энэ хэрэгцээ шаардлага бий юу гэвэл бий. Би одоо улс орныхоо эрх ашгийг бодоод хэлж байгаа шүү. Энэ бол зүгээр нэг бизнес хоорондын өрсөлдөөн тэмцлийн асуудал биш. Гагцхүү энд юу байна гэвэл төсвийн асуудал байна аа. Тэр төсвүүдийг нь нягтлах хэрэгтэй. Тэр Туулын замын ч тэр, одоо энэ Сэлбийн ч тэр. Төсвийг нь л ярих ёстой болохоос биш энэ төслийг нураах асуудал биш байх аа гэж би ингэж бодоод байна аа.

Тэгээд та нар энэ Чингэлтэй рүү явсан энэ ганц замаар яваад энэ түгжрэл арилах уу. Одоо хэдэн жилийн дараа ингэнэ. Энэ бүгдийгээ нураасны дараа түгжрэл нөгөө бүүр болохоо болиод ирэхээр нөгөө нураасан улсуудаа харааж эхэлнэ. Тэгээд ингээд энэ юмнуудаа их бодоод, ажлын хэсэг гаргаад юм уу ер нь бол аудитаар шалгуулах ёстой юм шүү дээ. Их Хуралд чинь аудит гээд байгууллага байна шүү дээ. Тэр аудитаараа шалгуул. Энэ төслүүд рүүгээ оруулаад, тэр цагдаадаа эхэлж өгдөг юм бишээ. Юу гэж Их Хуралд одоо аудитын байгууллага харьяалагддаг юм. Энийгээ хий. Энэ учир зүггүй энэ нэг хоорондоо тэмцсэн тэмцэл бизнес хоорондын зөрчилдөөнөө битгий төрийн бодлого руу оруулж ирээд бай. Хийх ёстой юмаа хийх ёстой. Одоо би шахмал түлшний үйлдвэр бариад утааг нь бууруулаад өгсөн. Одоо

гэтэл нөгөө шахмал түлшний үйлдвэрээ нураагаад одоо яасан Хятадаас оруулж ирж байгаа шүү дээ. Үгүй ингээд байх юм бол энэ Монгол орон чинь яаж хөгжих юм, яаж үндэсний үйлдвэртэй болох юм. Яаж энэ шийдэх асуудлуудаа шийдэх юм. Энэ улс төрд чинь бүх юмыг зогсоож гацааж байна шүү дээ.

Тэгээд би эцэст нь дахиад хэлье. Зүгээр өр зээлийн асуудлаа хянах ёстой. Өрийн бүртгэл байх ёстой. Энэ дээр болгоомжтой хандах ёстой. Харин төслүүдийн хувьд тэр эргэлзээгээ тайлахын тулд Үндэсний аудитыгаа оруулаад тэгээд энэ төсөвт өртгүүдийг нь шалгуулаад нягтлаад ингээд шийд ээ. Та нар чинь улс төрийн өндөр түвшний төрийн бодлого тодорхойлогч улсууд шүү дээ. Тийм учраас судалгаатай, дүгнэлттэй ийм юмнуудаа хийж байгаад дараа нь шийдвэрээ гаргадаг байх ийм нэг хэлбэр лүүгээ орох хэрэгтэй.

Тийм учраас энэ төслийн асуудал дээр жоохон нухацтай ханд аа нөхөд өө. Тэгэхгүй бол би ер нь энэ Монгол орон цаашдаа яаж хөгжих юм гэдэг дээр эргэлзэж эхэлж байна. Ийм байдлаар явах юм бол. Тэр шуналтаад байдаг бол тэр шуналыг нь тэр аудитаараа шалгаад гаргаж ир. Шуналаар бас ажил зогсож болохгүй. Нөгөө талаар улс төрийн хоорондын тэмцлээс болж ажил зогсож болохгүй ээ гэдгийг хэлье ээ.

Тэгээд өрийн удирдлагын асуудал дээрээ анхаараад, тэр өрийн бүртгэлээс гадуур явна гэдэг бол хэцүү зүйл шүү. 2014 онд нэг ийм зүйл болсон. Тэгээд АН унасан. Одоо бас бид нар ингээд байх юм бол бас л хариу авна шүү дээ биднээс.

С.Бямбацогт: Гишүүд хуулийн төсөлтэй холбогдуулан үг хэлж дууслаа.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна аа. Санал хураалтдаа бэлтгэе.

Улсын Их Хурлын гишүүн Жанчивын Галбадрахын урилгаар Япон Улсын Парламентын Төлөөлөгчдийн танхимын гишүүн, Төлөөлөгчдийн танхим дахь Япон, Монголын парламентын найрамдлын бүлгийн ажлын албаны дарга Такэбэ Арата тэргүүтэй төлөөлөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа Төрийн ордонтой танилцаж байна аа. Япон, Монголын хамтын ажиллагаанд 2 улсын парламентын үйл ажиллагаанд илүү бас өндөр амжилт гаргахыг энд Монгол Улсад айлчилж байгаа айлчлал нь амжилттай болохыг хүсэн ерөөе.

Чуулганы ирцэд 98 гишүүн байна. Санал хураалтад бэлэн болсон 51 гишүүн байна аа. Бусад гишүүдийг санал хураалтдаа бэлтгэхийг урьж байна аа. Санал хураалтад бэлдэж амжаагүй еще санал хураалтдаа бэлэн болъё.

Зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулна аа. Гишүүдийг суудалдаа сууж, санал хураалтдаа бэлдэхийг урьж байна. Энэ гадаад зээлийн ашиглалт дээр Эрдэнэбүрэнгийн УЦС, Газрын тос боловсруулах үйлдвэр, Сэлбэ хотхон гээд нэлээн чухал томоохон төслүүдийн хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэрийг шийдэх асуудал байгаа. Төсвийн байнгын хороо дэмжээгүй зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулна аа.

Гадаад зээллэгийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хууль болон хуулийн төслийн талаар Төсвийн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

Төсвийн байнгын хороо дэмжээгүй.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1 дэх заалтыг үндэслэн хураалгасан санал.

1.Хуулийн төслийн 5 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай хэсэг нэмэх:

5.4.Дунд хугацаанд хэрэгжих төслийн орлогоороо хөрөнгө оруулалтын зардлаа бүрэн нөхөх боломжтой эдийн засгийн үр ашиг бүхий хөгжлийн төсөл арга хэмжээг нэгдсэн төсөвт нөлөө үзүүлэхгүйгээр санхүүжүүлэх чиглэлийг баримтална. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Алдаржавхлан, Батболд, Батсүмбэрэл, Баярмаа, Даваасүрэн, Заяабал, Мэндсайхан, Пунсалмаа, Сайнзориг, Хосбаяр, Энхтуяа.

Тэгэхээр Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Горимын санал Ухнаагийн Отгонбаяр гишүүн горимын санал.

У.Отгонбаяр: Санал хураалтаас төхөөрөмж ажилласангүй. Тийм учраас энэ саналыг цуцалж өгөхийг горимын санал гаргаж байна аа.

С.Бямбацогт: Ер нь бол сая тэгсэн. Би ч гэсэн санал хураалтдаа бэлдэж амжсангүй, Анар гишүүн бэлдэж амжсангүй. Тийм учраас Ухнаагийн Отгонбаяр гишүүний гаргасан горимын саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтыг хүчингүй болгох горимын саналыг дэмжье гэсэн томьёоллоор.

Санал хураалтад 100 гишүүн оролцсоноос 54 гишүүн буюу 54 хувийн саналаар хүчингүй болгох горимын санал дэмжигдлээ.

Одоо түрүүн уншиж танилцуулсан Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт.

Санал хураалтад 100 гишүүн оролцсоноос 60 гишүүн буюу 60 хувийн саналаар энэ санал хураалт дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулж дууслаа.

Гадаад зээллэгийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Төсвийн байнгын хороонд шилжүүллээ.

Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Баатархүүгийн урилгаар Нийслэлийн ЧД-ийн 2, 3, 4, 5, 21 дүгээр хорооны иргэд Улсын Их Хурлын үйл ажиллагаа Төрийн ордонтой танилцаж байна аа. Та бүхнийхээ ажилд нь амжилт, амьдралд нь эрүүл энх, сайн сайхан бүхнийг Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс хүргэе ээ. Баатархүү гишүүн маань энд сууж байна, манай Батсүмбэрэл гишүүн бас байна ЧД-ийн гишүүд.

Дараагийн асуудалдаа оръё оо.

Бас Батнайрамдал гишүүн одоо алга байна.

Нийгмийн ажлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг.

Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Отгоны Саранчулуун танилцуулна аа. Индэрт урьж байна.

О.Саранчулуун: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 11 дүгээр хэсэгт Гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална. Мөн 19 дүгээр зүйлийн нэг дэх хэсэгт төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, зөрчигдсэн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна хэмээн тус тус заасан байдаг. Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан Алсын хараа 2050 урт хугацааны хөгжлийн бодлогод иргэн бүр чанартай амьдрах орчин, нийгмийн хамгааллын баталгаатай байх, хүн амын ялгаатай хэрэгцээнд нийцсэн нийгмийн үйлчилгээг хөгжүүлэх, салбар дундын бодлого, зохицуулалтыг сайжруулах, өрхийн амьжиргааг дэмжих зэрэг зорилтууд тодорхой тусгасан.

Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт халамжаас хөдөлмөрт шилжих бодлоготой уялдуулан нийгмийн үйлчилгээ хөдөлмөр эрхлэлтийн эрх зүйн орчныг шинэчлэх, ядуурлыг бууруулах зорилтыг дэвшүүлсэн байна аа. Хэдийгээр олон улсын болон үндэсний стандарт тухайлбал нийгмийн ажлын боловсрол, үйлчилгээний стандартууд, мэргэжлийн ёс зүйн дүрмийг баримтлан ажиллаж байгаа боловч нийгмийн ажилтны эрх зүйн байдлаар нэгдсэн байдлаар зохицуулсан салбар дундын уялдаа холбоог хангах, үйлчилгээний чанар хүртээмжийг баталгаажуулах цогц эрх зүйн орчин өнөөг хүртэл бүрдээгүй байна аа.

Өнөөдөр хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжид нийгмийн ажлын үйлчилгээ нь салбар бүрд өөр өөрөөр явцуу хүрээнд зохицуулагдаж, нэгдсэн бодлого, арга зүй, удирдлага дутмаг байгаа нь бодит байдал дээр үйлчилгээний чанар, нийгмийн халамж, хамгааллын хүртээмжид сөргөөр нөлөөлж байна аа. Хүний эрхийн байгууллагуудын тайланд дурдсанаар нийгмийн ажил нийгмийн ажлын үйлчилгээ нь олон улсын жишигт хүрэхгүй, ялангуяа хүүхэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх хамгаалал хангалтгүй байгаагаас хүчирхийлэлд өртөх, амьдралын чанар буурах зэрэг эрсдэл өндөр хэвээр байна аа.

Иймд нийгмийн ажлыг шинжлэх ухаан, мэргэжлийн онол арга зүйд тулгуурлан бие даасан салбар болгон хөгжүүлж, нийгмийн хамгааллын халамжийнхаа үйлчилгээг мэргэжлийн түвшинд хүргэх шаардлага бидэнд зүй ёсоор тавигдаж байна аа.

Нийгмийн сэтгэл зүй, эрүүл мэнд, боловсрол халамжийн үйлчилгээний уялдаа холбоог сайжруулах, хүн амын бодит хэрэгцээнд тулгуурласан урьдчилан

сэргийлэх чиглэлээр хүртээмжтэй тогтолцоог бүрдүүлэх зорилгоор нийгмийн ажлын тухай анхдагч хуулийн төслийг боловсрууллаа.

Хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн холбогдох заалтын дагуу анхдагч хуулийн төсөл хэлбэрээр боловсруулсан бөгөөд нийт 7 бүлэг 49 зүйлтэй. Хуулийн төсөлд дараах үндсэн зохицуулалтыг тусгалаа. Үүнд:

Нэгдүгээрт нийгмийн ажлын үйлчилгээг зөвхөн асуудал үүссэний дараа бус урьдчилан сэргийлэх, тандалт судалгаанд тулгуурлан иргэний хэрэгцээнд нийцүүлэн үзүүлэх тогтолцоог бүрдүүлнэ.

Хоёрдугаарт зорилтот бүлэгт чиглэсэн нийгмийн хамгааллын үр дүнтэй, хүртээмжтэй үйлчилгээг бий болгож эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, бага орлоготой өрх зэрэг бүлгүүдэд чиглэсэн урьдчилан сэргийлж хамгаалах, чадавхжуулах арга хэмжээг хэрэгжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэхээр.

Гуравдугаарт нийгмийн ажлын үйлчилгээний нэгдсэн тодорхойлолт, төрөл, үе шат, тайлагнал, мэдээллийн сан, хамтын ажиллагааны зохицуулалтыг тодорхой болгож салбар дундын уялдааг хангахаар.

Дөрөвдүгээрт эрүүл мэнд, боловсрол, хууль сахиулах, нийгмийн халамжийн байгууллагын хамтын ажиллагааг бэхжүүлж, нийгмийн ажилтны үүрэг оролцооны хүрээ, хариуцлагыг тодорхой болгож, үр дүнг үнэлэх тогтолцоог бий болгоно оо.

Тавдугаарт иргэдийн өөрийн амьдралдаа шийдвэр гаргах оролцоог нэмэгдүүлнэ. Бие даан амьдрах, нийгмийн харилцаанд оролцох чадварыг нь дэмжих ёстой. Ахиц дэвшлийг нь үнэлэх тогтолцоог нэвтрүүлнэ.

Зургаадугаарт хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэн зэрэг өөрийгөө төлөөлөх чадваргүй иргэдийн эрхэм чанар, нэр төрийг хамгаалсан үйлчилгээ үзүүлэх хувь хүний мэдээллийн нууцлал хамгаалалтыг хангасан зохицуулалтыг тусгасан.

Долоодугаарт нийгмийн ажилтны мэргэжлийн хариуцлага, ёс зүй, нэгдсэн стандарт арга зүйг бий болгож аль ч салбарт ажиллаж байгаагаас үл хамааран нийгмийн ажилтнуудын суурь зарчим, мэргэжлийн үнэт зүйл, шаардлагад үнэлгээний тогтолцоог мөрдүүлэхээр тусгасан болно оо.

Энэхүү хуулийн төсөл батлагдсанаар нийгмийн ажлын үйлчилгээний эрх зүйн орчин тодорхой болж, эмзэг бүлгийн иргэдийн бие даах, амьдралдаа эзэн болох, нийгмийн оролцоотой болох шийдвэр сайжирна. Чадавх нь сайжирч, хөдөлмөр эрхлэлт нэмэгдэн, нийгмийн хамгааллын бодлого, халамжаас хөдөлмөр лүү чиглэсэн бодлого илүү үр дүнтэй хэрэгжих боломж бүрдэх юмаа.

Цаашлаад ядуурлыг бууруулах, иргэдийн амьжиргааг дээшлүүлэх, эдийн засгийн идэвхийг нэмэгдүүлэхэд эерэг үр нөлөө үзүүлнэ гэж үзэж байна.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Нийгмийн ажлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэхийг шийдвэрлэж өгөхийг хүсье ээ. Анхаарал тавьсанд баярлалаа.

С.Бямбацогт: Отгоны Саранчулуун гишүүнд баярлалаа. Одоо төслүүдийн талаарх Хүний хөгжил нийгмийн бодлогын байнгын хорооны санал дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Хөххүүгийн Болормаа танилцуулна аа. Таныг индэрт урьж байна аа.

Х.Болормаа: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулуун нарын 24 гишүүн 2025 оны 12 дугаар сарын 17-ны өдөр өргөн мэдүүлсэн Нийгмийн ажлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо 2026 оны 4 сарын 28-ны өдрийн хуралдаанаараа авч хэлэлцлээ.

Хууль санаачлагч нь нийгэм, сэтгэл зүй, эрүүл мэндийн салбарын үйлчилгээ, үйл ажиллагааг хүн амын бодит хэрэгцээнд тулгуурлан хүргэж, тогтвортой хөгжлийн зорилтуудыг хангах, нийгмийн халамж, хамгаалал нь шаардлагатай бүлэгт хүрч очих, хүний суурь хэрэгцээг хангахын тулд нийгмийн ажил үйлчилгээний дэд бүтэц болон нийгмийн ажлын мэргэжлийн хүрээ, тэдний мэргэжлийн үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх шаардлагатай гэж үзэн хуулийн төслийг боловсруулсан байна аа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.6.6-д заасны дагуу хуулийн төслийг баталснаар улсын төсвийн орлогын хэмжээ буурах, зарлагын хэмжээ нэмэгдэхээр байвал энэ тухай Засгийн газрын саналыг заавал сонсоно гэж заасны дагуу Засгийн газрыг төлөөлж Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд Аубакир танилцуулга хийлээ.

Дээрх хуулийн төслийг иргэдийн оролцоог хангах санал авах зорилгоор Улсын Их Хурлын Ди парламент мн цахим сайтад байршуулсан болно оо.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа 2022 онд гарсан цар тахлын үед Япон улсаас манай улсад иргэдийн эрүүл мэндийн нийгмийн ажилтан нь иргэдэд тусламж үйлчилгээ үзүүлдэг мэргэжлийн ажилтан байх талаар, Улсын Их Хурлын гишүүн Зулпхар манай улсад нийгмийн ажилтны тогтолцоо олон жилийн өмнөөс хэрэгжиж эхэлсэн боловч нэгдмэл эрх зүйн орчин бүрдээгүй, удирдлага нь салангид байдгаас шалтгаалан мэргэжлийн нэгдсэн удирдлага дутмаг тул үйлчилгээний төрөл, хэлбэрийг тодорхой болгож, тэдний нийгмийн баталгааг хангах асуудлыг тусгах шаардлагатай талаар, Улсын Их Хурлын гишүүн П.Наранбаяр техникийн шинжтэй загваруудыг дурдан нэмэлт санхүүжилт, мэдээллийн сан бүрдүүлэх төсөв болон бусад хуулийн заалттай давхацсан байгааг анхаарч, уялдаа холбоог хангах талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Бум-Очир нийгмийн ажилтны талаар бие даасан хуульгүй байгаа нь ямар асуудал үүсгэж байгаа, мэргэжлийн бус хүмүүс нийгмийн ажилтны чиг үүргийг хэрэгжүүлж байгааг зогсоох шаардлагатай.

Мөн хуулиар салбар хоорондын уялдааг сайжруулах тал дээр анхаарах, манай улсад нийгмийн ажилтны үйлчилгээ авах шаардлагатай иргэдийн тоо

хэрэгцээний талаар Улсын Их Хурлын гишүүн Л.Энхнасан Хуулийн төсөлд нийгмийн ажилтан нь мэргэжлийн сэтгэл зүйн үйлчилгээ өгөх талаар орсон нь оновчтой эсэх, мөн Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл өргөн баригдвал энэ хуультай хэрхэн уялдах талаар Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн хүнд хагалгаа болон эмчилгээний дараа үзүүлэх шаардлагатай үйлчилгээг хангах, нэг цэгээс үйлчилгээ авах тогтолцоог уялдуулах, Нийгмийн ажилтны үйлчилгээний стандарт, лицензийн асуудал, санхүүжилтийн тогтолцоог тусгах. Сангийн яамны оролцоог хангаж салбар хоорондын уялдааг зохицуулах талаар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Галбадрах ЕБС-д хүүхдийн төлөвшлийн асуудлыг дангаар хариуцдаг нийгмийн ажилтан байх ёстой. Үүнийг сургуулийн удирдах ажилтан хийх нь зүйтэй талаар, Улсын Их Хурлын гишүүн Г.Хосбаяр салбар хоорондын уялдаа холбоог дурдаж байгаатай адил нутаг дэвсгэрийн нийгмийн ажилтны уялдаа холбоог сайжруулахад анхаарах талаар асуулт асууж, хариулт авч санал хэлсэн болно оо.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.11-д заасны дагуу Нийгмийн ажлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд тус бүрийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих эсэх талаар асуудлаар ил санал хураалт явуулж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонх хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно оо.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Нийгмийн ажлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Ахмад настны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Боловсролын ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн халамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хүүхэд хамгааллын тухай хуульд оруулах тухай, Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Нийгмийн ажлын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаар Хүний хөгжил нийгмийн бодлогын байнгын хорооны санал дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүгдээсээ хүсэж байна аа.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

С.Бямбацогт: Болормаа гишүүнд баярлалаа. Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Лхагвын Мөнхбаатарын урилгаар нийслэлийн ерөнхий боловсролын Орчлон сургуулийн 8-ын Б ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа Төрийн ордонтой танилцаж байна аа. Энэ хаврын чуулганаар Улсын Их Хурал сургуулийн орчинд суралцагчийн эрүүл мэндийг хамгаалах, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх, аливаа өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн Сургуулийн орчны эрүүл мэнд, аюулгүй байдлын тухай хуулийн төслийг хэлэлцэж байгаа.

Мөн одоо өсвөр үе, хүүхэд залуусыг хорт зуршилд автах, донтохоос урьдчилан сэргийлэх, тамхидалтыг бууруулах зорилготой Тамхины хяналтын тухай хуулийн төсөлд нэмэлт өөрчлөлтийг хэлэлцэж байгаа.

Мөн замын хөдөлгөөнд хүүхэд багачууд сурон мопед, скутер унаж оролцож амь нас, эрүүл мэндээ өөрсдөө хохирох, иргэдийг хохироох ийм асуудал гарч

байгаа. Үүнийг зохицуулах тухай хуулиуд хэлэлцэж байгаа. Тийм болохоор хүүхдийн эрх ашиг хамгаалалттай холбоотой Улсын Их Хурлаар хэлэлцэж байгаа хуулийн төслүүд дээр хүүхэд багачууд та бүхэн бас саналаа өгөх бүрэн бололцоотой шүү гэдгийг энэ ташрамд дурдъя. Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс та бүхнийхээ сурлагад нь өндөр амжилт, амьдралд нь эрүүл энх, аз жаргал сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. Тэгээд онц сураарай. Аав ээжийнхээ үгэнд сайн ороорой.

Төслүүдийн талаарх Засгийн газрын саналыг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Сангийн сайд Загджавын Мэндсайхан танилцуулна аа.

Хуулийг та бүхэнд уншиж танилцуулъя. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 36.4-т хуулийн төслийг баталснаар улсын төсвийн орлогын хэмжээ буурах, зарлагын хэмжээ нэмэгдэхээр байвал энэ тухай Засгийн газрын саналыг заавал сонсох бөгөөд хуралдаанд энэ хуулийн 31.2-т заасан Засгийн газрын гишүүнд танилцуулна гэж заасан. Үүний дагуу Засгийн газрын гишүүн Сангийн сайд Мэндсайхан Засгийн газрын байр суурийг танилцуулна аа. Индэрт урьж байна. Гишүүд нэг жоохон чимээгүй намдъя. Танхим их чимээтэй байна шүү.

3.Мэндсайхан: Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулуун нараас санаачлан боловсруулсан Нийгмийн ажлын тухай хуулийн төслийг Засгийн газраас дараах үндэслэлээр дэмжих боломжгүй саналыг хууль санаачлагчид хүргүүлсэн болно оо. Үүнд:

Хуулийн төслийн зардлын тооцооллыг авч үзвэл хууль хэрэгжүүлэхтэй холбоотой анхны хөрөнгө оруулалт 800 сая төгрөг, цаашид жил бүр 96.5-160 тэрбум төгрөгийн төсөв шаардагдахаар байгаа бөгөөд нийгмийн ажилтны орон тоог 3188 хүнээр нэмэгдүүлэхээр заасан байна. Засгийн газраас Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төслийг Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөнд нийцүүлэн нийт урсгал зардлыг ДНБ-ний 24 хувьд багтааж Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн бөгөөд төсвийг Их Хурлаар хэлэлцүүлэх явцад зөвхөн багш, эмчийн цалин хөлсийг нэмэгдүүлэх, ахмадын тэтгэврийг нэмэгдүүлэхтэй холбоотой зардлыг нэмэгдүүлэн баталсан болно оо.

Төсвийн сахилга батыг сайжруулах, үр ашгийг нэмэгдүүлэх бодлогын хүрээнд Засгийн газраас орон тоо нэмэхгүй байх. Зөвхөн нэн шаардлагатай шинэ арга хэмжээг санхүүжүүлэх төсвийн байгууллагын батлагдсан төсөвт зохицуулалт хийх замаар өөрийн төрийн чиг үүргийг иргэдэд хэвийн хүргэх арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллах бодит шаардлага үүсээд байна аа.

Мөн манай улсын уул уурхай голлох түүхий эдийн үнэ дэлхийн зах зээл дээр буурсан, эдийн засгийн идэвхжилт сайнгүй байгаа зэргээс шалтгаалан Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийг боловсруулахад, мөн урсгал болон хөрөнгийн зардлын хэмжээг өмнө оноос нэмэгдүүлэх боломжгүй байх тул шинээр орон тоо нэмэх замаар төрийн бүтцийг данхайлгах, төсөвт их хэмжээний зардлын нөлөөлөлтэй хууль тогтоомжийг төсвийн нөхцөл байдал сайжрах хүртэл хэрэгжүүлэхгүй байх шаардлагатай байна аа.

Хуулийн төсөлд заасан нийгмийн ажлын үйлчилгээтэй холбоотой зохицуулах харилцааг төсөв санхүүгийн нөхцөл байдал сайжрах хүртэл одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомжийн уялдааг хангах зохицуулалтуудыг сайжруулах байдлаар шийдвэрлэх боломжтой гэж үзсэн тул хуулийн төслийг дэмжээгүй болно оо.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

С.Бямбацогт: Мэндсайхан сайдад баярлалаа. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя. Нийгмийн ажлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Отгоны Саранчулуун нарын 24 гишүүн 2025 оны 12 дугаар сарын 17-ны өдөр өргөн мэдүүлсэн. Хэлэлцэх эсэхийг нь хийж байгаа.

Ажлын хэсэг Төмөр-Очирын Ням-Очир Боловсролын яамны ТНБД, Батсүхийн Бадамжав Боловсролын яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга, Лхагважавын Пүрэвдулам ЭМЯ-ны Бодлого төлөвлөлтийн газрын салбарын хүний нөөцийн хэлтсийн мэргэжилтэн алга байна уу? дуудаарай. Сангарагчаагийн Учрал Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны Нийгмийн ажлын бодлого төлөвлөлтийн газрын Төлөвлөлт хариуцсан шинжээч, Эрдэнэбилэгийн Баттөр Үндэсний дата төвийн төв улсын төсөвт үйлдвэрийн газрын Эх өгөгдөл системийн нэгдлийн газрын дарга, Алтангадасын Номин Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын Захиргаа удирдлагын газрын хуулийн ахлах мэргэжилтэн алга байна. Ирэх ёстой шүү. Лувсандандарын Долгор Эрүүл мэндийн нийгмийн ажилтан судлаач, Ганчулууны Оюунболд хуульч судлаач ийм ажлын хэсэг хүрэлцэн ирсэн байна аа.

Ажлын хэсгийн гишүүд болон Засгийн газрын гишүүдэд бас хууль сануулъя. Улсын Их Хурлын тухай хуулийн 21.24-д нэгдсэн хуралдаанд мэдээлэл хийж байгаа Засгийн газрын гишүүн Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орсон холбогдох албан тушаалтан болон бусад этгээд үнэн зөв, бүрэн гүйцэд мэдээлэл өгөх үүрэгтэй.

21.25-д нэгдсэн хуралдаанд мэдээлэл хийх, асуултад хариулах, тайлбар өгөх албан тушаалтан өөрийн танилцуулсан мэдээллийн үнэн зөвийг хариуцах бөгөөд мэдээллийг санаатайгаар нуун дарагдуулах, худал мэдээлэл өгөх, танилцуулах, Улсын Их Хуралд худал мэдээлэл ирүүлэхийг хориглоно.

21.31. Чуулганы хуралдаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүрэлцэн ирээгүй, тайлбар өгөхөөс татгалзсан, хуралдаанд оролцсон этгээд хуралдааны дэг зөрчсөн бол парламентыг үл хүндэтгэсэн үйлдэлд тооцож тухайн этгээдэд Төрийн албаны тухай болон холбогдох бусад хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ гэж заасан байгаа.

Тийм болохоор ажлын хэсгийн гишүүд та бүхэн энэ Их Хурлын тухай хуулийн дэгийн зохицуулалтыг маш сайн санаж, асуултад хариулж, мэдээлэл өгөхийг хүсье ээ.

Улсын Их Хурлын гишүүд байнгын хорооны санал, дүгнэлт хууль санаачлагчийн илтгэл болон хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна. Улсын Их Хурлын гишүүн Болдын Уянга гишүүн асуултаа асууя.

Б.Уянга: Энэ өдрийн мэнд хүргэе ээ. Нийгмийн ажлын тухай анхдагч хуулийн төслийг хэлэлцэхийг бол дэмжиж байгаа. Тэгээд Саранчулуун гишүүн болон хамт өргөн барьсан 25 гишүүдэд талархал илэрхийлье. Нэлээн тогтож ажлын албаныхантайгаа хамтран сууж үзсэн байгаа. Тэгэхээр дараах асуултууд байна. Тэгээд нэмээд ойлголтыг маань сайхан задруулаад өгөхийг хүсье.

Хуулийн төсөлд тусгагдсанаар бол 2 талт үндэсний хороо байгуулна гэж байгаа юм. Хуулийн этгээд бас тусгай зөвшөөрөл авдаг болж байгаа. Нийгмийн ажилтны мэргэжлийн нэгдсэн холбоо, Мэргэжлийн хариуцлагын холбоо байгуулах зохицуулалтууд орж ирж байгаа юм байна лээ. Тэгэхээр энэ маань нөгөө чөлөөлье гэсэн санаачилгатай хэр нийцэж байгаа вэ? Ер нь бол нийгмийн ажил үйлчилгээтэй холбоотой агуулга тус тусын хуульдаа ингээд суугаад явдаг юм байна гэж ойлгогдсон. Нийгмийн халамжийн тухай хууль, Гэр бүлийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Боловсролын ерөнхий хууль, Ахмад настны хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг эрхийн тухай хууль гээд. Тэгээд яг шаардлагатай зохицуулалтуудаа эдгээр тус тусын хуульд нь суулгах байсан юм биш үү. Тэгэхээр ер нь энэ тусдаа Нийгмийн ажлын тухай хууль гарснаараа нийгмийн ажил үйлчилгээ чанаржих уу? Тэрэн дээр тайлбар авъя аа.

Төрийн байгууллагад ажиллаж байгаа нийгмийн ажилтан бол мэдээж тусгай зөвшөөрөл шаардагдахгүй ээ. Гэхдээ хуулийн этгээд тусгай зөвшөөрөлтэй байх болж байгаа юм байна. Тэгэхээр энэн дээр ойлголт маань зөв байна уу? Энэ дээр тодруулга авъя аа.

Сая Сангийн яамнаас мэдээлэл хийж байх шиг байна. Зардлын тооцооллын судалгаанд жил болгон энэ хуулийн төслийг хэрэгжүүлэхэд нэлээдгүй их мөнгө шаардана гэсэн тусгагдсан байсан. 100 тэрбум давсан байсан. Тэгэхээр энэ маань хэмнэгдэх ямар нэгэн байдлаар танагдах ч юм уу тиймээ тиймэрхүү боломж байна уу? Ер нь энэ санхүү санхүүгийн тооцоон дээр нэмэлт тайлбарыг өгнө үү?

С.Бямбацогт: Хууль санаачлагч хариулъя. Отгоны Саранчулуун гишүүн. За уучлаарай би зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Лувсанбямбаагийн Мөнхбаясгалангийн урилгаар Говьсүмбэр аймгийн ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 10-ын В, 11-ийн В ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа Төрийн ордонтой танилцаж байна аа. Энэ хаврын чуулганаар Улсын Их Хурал хүүхэд багачуудынхаа эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөл боломжийг бүрдүүлэх чиглэлээр сургуулийн орчинд орчны эрүүл мэнд, аюулгүй байдлын тухай хуулийн төслийг хэлэлцэж байгаа. Мөн хорт зуршил тамхинаас хамгаалах зорилгоор Тамхины хяналтын тухай хууль хэлэлцэж байгаа. Мөн одоо бас замын хөдөлгөөнд оролцохдоо өөрийн болон бусдын амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдал учруулахгүй байх сурон мопед, скутерийг зохицуулсан ийм хуулиудыг хэлэлцэж байгаа. Тэгээд энэ хуулийн төслүүд дээр хүүхэд багачууд та бүхэн маань саналаа өгөх бас бололцоотой шүү гэдгийг та бүхэндээ хэлье. Та бүхнийхээ сурлагад нь өндөр амжилт, амьдралд нь эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг нийт Улсын Их Хурлынхаа гишүүдийн нэрийн өмнөөс хүсэн ерөөе өө.

Улсын Их Хурлын гишүүн Отгоны Саранчулуун хууль санаачлагч хариулъя.

О.Саранчулуун: Уянга гишүүний асуултад хариулъя. Баярлалаа. 1 дүгээрт нь лиценз буюу чөлөөлье санаачлагатай холбоотой асуудлыг хөндөж байна.

Нийгмийн ажлын тухай хуульд үйлчилгээний лиценз огт тусгаагүй байгаа. Учир нь одоо ажиллаж байгаа нийгмийн ажилтнуудын 60 хувь нь мэргэжлийн бус буюу өөр чиглэлээр мэргэжилтэй гэхдээ нийгмийн ажлыг хийдэг боловч тэд нарыг бид нар сургах чадваржуулах нь чухал байгаа. Шууд шаардлага тавьж болно, болохгүй гэхээсээ илүү. Тэгэхээр төрийн албаны журам дээр нэмээд лицензийн шаардлага тавих нөхцөл боломж байхгүй байгаа. Тэгэхээр хэрвээ лицензийн асуудлыг хөндөх юм бол одоо ажиллаж байгаа хүмүүсийнхээ 60-аас илүү хувийн ажлын байрны асуудал хөндөж байгаа учраас энд хуульд тусгаадаагүй байгаа.

2 дугаарт нь Засгийн газраас тусгай зөвшөөрөлтэй адилтгах зөвшөөрөл энэ дээр нэмэхгүй бодлого барьж байгаа гэдэгтэй уялдуулсан учраас энэ зөвшөөрөл гэдэг зүйл тусгаадаагүй байгаа. Ер нь бол яах вэ нийгмийн ажилтан бол лицензтэй үйлчилгээ үзүүлдэг ийм улс орнууд байдаг. Тэд нарын хувьд бол санхүүжилтийн тогтолцоо, үйлчилгээний төрөл хэлбэр нэлээн тодорхой ингээд заагладаг. Бид нар одоохондоо тэр түвшин рүү явахын тулд эхлээд бид нар одоо хүргэж байгаа нийгмийн ажлын үйлчилгээнийхээ мэргэжлийн ямар үйлчилгээг нийгмийн ажлын мэргэжил гэдгээ тодорхойлох орон зайг нь бий болгосны дараа шилжилтээрээ аяндаа бусад улсын жишгээр энэ лиценз зөвшөөрөл гэдэг асуудал руу цаг хугацаа шилжих нь бол цаг хугацааны асуудал байгаа юмаа. Тэгэхдээ энэ бол дор хаяж 2030 он хүртэл ийм асуудал хөндөгдөхгүй гэдгийг бас хэлье.

Зардлын тооцоон дээр асуулт асуусан. Энэ хуулийн төсөл 4 жилийн өмнөөс Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын яаман дээр анх одоо анхны хувилбар танилцуулагдаад, нэлээн олон хэлэлцүүлгүүд хийгдэж явж байсан. Тэр үед анхны нийгмийн ажлын үйлчилгээг бий болгохтой холбоотой тооцоонууд бид нарын хуулийн төслөөр хамт ирсэн. Бид анхны өргөн барьсан өргөн барихаар зэхсэн хуулийн төсөл дээр дүн шинжилгээ хийж илгээсэн зардал маань таны хэлсэнчлэн 106 тэрбум төгрөг байсан. Энийг бид нар Засгийн газраас өгсөн саналын дагуу дахиж шинэчлээд яг одоо энэ хуулийн төсөл дээр үүсэж байгаа зардал 920 сая төгрөг болсон байгаа. Юун дээр нь 106 болсон бэ гэхлээр энэ бол тухайн үед шинээр ажиллуулахаар төлөвлөсөн нийгмийн ажилтнуудын зардал байсныг хуулийн хэлэлцүүлэг сайжруулах явцад засаад энэ төсөл дээр зөвхөн мэдээллийн сангийн болон холбоо байгуулах зардлыг тусгасан. Ийм төсөвтэй болж өөрчлөгдсөн байгаа шүү.

Гуравдугаарх нь нийгмийн ажлын үйлчилгээ хэр чанаржих юм бэ гэж байна. Энэ хуулийн хамгийн 1 дүгээр зорилго нь энэ байгаа. Нийгмийн ажлын үйлчилгээ, нийгмийн сэтгэл зүйн үйлчилгээ гэж энэ юм. Зөвлөгөө гэдэг нэрийн дор янз бүрийн стандартгүй, хариуцлагагүй ч юм уу эхлэлгүй, төгсгөлгүй ийм процедурыг бид нар илүү сайжруулж, тодорхойлж, томъёолж өгснөөрөө одоо хүргэж байгаа нийгмийн ажлын үйлчилгээг яг утгаар нь хийх, сайжруулах ийм бололцоог бас бий болгож байгаа юмаа. Хэрвээ чанартай үйлчилгээтэй болоод ирэх юм бол үйлчилгээ авч байгаа хүн амын бүлэгт очих нийгмийн халамж хамгааллын үйлчилгээ бас сайжрах ийм тооцоолол төсөөлөлтэй байгаа гэсэн үг.

С.Бямбацогт: Баярлалаа. Нэмэлт хариулт хэрэгтэй юу? Гайгүй юм шиг байна. Улсын Их Хурлын гишүүн Баярмагнайн Баярбаатар гишүүн асуултаа асууя.

Б.Баярбаатар: Гишүүддээ өглөөний мэнд хүргэе. Энэ нийгмийн ажлын тухай гээд анхдагч хуулийн төслийг дэмжиж байгаа. Энэ хуулийн төслийг боловсруулж Их Хуралд өнөөдөр хэлэлцэх эсэхийг нь хэлэлцүүлэхээр өргөн барьсан Саранчулуун

гишүүн, хамт өргөн мэдүүлсэн гишүүдэд талархал илэрхийлье. Хэлэлцэх эсэхийг нь дэмжээд, ажлын хэсгийг байгуулаад, нийгэмд тусдаа үйл ажиллагаа явуулдаг Гүнж төв, Хөөрхөн зүрх гээд төрийн бус байгууллагууд байгаа. Эд нарыг дэмжих ажлын хэсгийн бүрэлдэхүүнд оруулж, өргөн хэлэлцүүлгийг өрнүүлж энэ их нийгэмд тусдаа ийм хууль болох болов уу гэсэн ийм хүлээлт үүссэн байна аа гэдгийг хэлье. Тэгээд бас хуулийн төсөлд энэ 20 гаруй саналыг би ажлын хэсгийн хууль төсөл өргөн баригчид хүргүүлсэн байгаа. Тэгээд тэр саналуудыг тусгаж ажиллахыг хүсье.

Хэдэн зүгээр нэг ийм танин мэдэхүйн шинжтэй асуултууд би Саранчулуун гишүүнээс асууя. Одоо ер нь яг хэдэн салбар, хэдэн байгууллагад нийт хэдэн нийгмийн ажилтан яг ажиллаж байгаа вэ? Энэ талаар мэдээллийг. Энэ хуулийн төсөл батлагдсанаар тал талд байгаа нийгмийн ажилтнуудыг нэгдсэн бодлогоор шийдвэрлэж чадах уу, хангаж чадах уу гэдэг. Энэ нийгмийн ажилтнуудын чинь зарим нь төрийн албан хаагч байгаа. Зарим нь олон улсын байгууллагад ажиллаж байгаа. Энэ цалингийн зөрүүний асуудал ер нь өнөөдөр хэр байгаа вэ? Энэ цалингийн шатлал ангилал нь өнөөдөр яаж зохицуулагдахаар байна? Энэ дээр одоо бас энэ хуулийн төсөл хэрхэн тусгагдсан талаар ийм тодорхой мэдээллүүдийг хууль санаачлагчаас асууя.

Тэгээд нийт гишүүддээ хэлэхэд их чухал хууль байгаа шүү. Энийгээ бид бас хэлэлцэх эсэхээ дэмжээд ажлын хэсгийн түвшинд илүү чамбайруулаад батлах нь энэ хаврын чуулганаар батлагдсан хуулиудын бас нэг гол хууль болох юмаа гэдгийг хэлье. Тэгээд асуултдаа хариулт авъя аа. Баярлалаа.

С.Бямбацогт: Хууль санаачлагч хариулъя. Отгоны Саранчулуун гишүүн хариулъя.

О.Саранчулуун: Одоо төрийн үйлчилгээнд гэх юм уу 3 мянга гаруй нийгмийн ажилтан боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, хууль зүйн салбарт ажиллаж байгаа. Энэ хууль зүйн энэ салбарт ажиллаж байгаа 3 мянга гаруй нийгмийн ажилтнууд маань дундаж цалингийнхаа тухайн салбарынхаа цалингийн дунджаас 60 хувь бага цалинтай байгаа нэгдүгээр асуудал.

2 дугаарт нь тэдгээр энэ 3 мянга гаруй нийгмийн ажилтнуудын 60 хувь нь өөр бакалавр нь өөр мэргэжлээр сурсан ийм хүмүүс байгаад байгаа. Ажлын цалингийн ангилал зэрэглэл нь бүгдээрээ өөр. Хүн болгон өөр. Хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан гээд тэгэхэд ТҮМ 4 зэрэглэлтэй, 1.3 сая төгрөгийн цалин авдаг. Гэсэн хэдий ч тэр хүн дээр дунджаар 2 мянгаас 3 мянган хүн оногддог ийм ачаалалтай. Хөдөлмөр халамжийн нийгмийн ажилтан ТЗ 8 гэдэг ангилалтай. Мөн 1.3 сая төгрөгийн цалинтай гэсэн хэрнээ мөн маш их ачаалалтай ажилладаг. Хөдөлмөр халамж аймаг сумд ажиллаж байгаа нийгмийн ажилтан болохоор ТЗ 9 гэдэг ангилалтай. Цалин 1 аравны мөн 3 сая төгрөгийн цалинтай, ЗДТГ төрийн захиргааны хүрээнд ТЗ-ийн ангилалд өөр нийгмийн ажилтнууд бас ажиллаж байгаа. Ингээд 4 өөр салбарт 20 гаруй журмын доор энэ 3 мянга гаруй нийгмийн ажилтан маш бага цалинтай, нийгмийн баталгаа багатай, ажлын байрны тодорхойлолт нь өөр өөр бүгдээрээ өөр ийм байдаг.

Дээрээс нь мэргэжлийн удирдлагаар хангадаг тэр систем бас өөр байхгүй байгаад байгаа. Тэгэхээр орон нутгаас хамаараад ихэнх тохиолдолд манай нийгмийн ажилтнууд эрүүл мэндийн салбарт ажиллаж байгаа нийгмийн ажилтнууд болохоор нийгмийн эрүүл мэндтэйгээ холилдоод ингээд яваад байдаг. Зарим тал

дээр ажлын байрны тодорхойлолт дээрээ. Боловсролын салбарт байгаа нийгмийн ажилтнууд болохоор сэтгэл зүйчтэйгээ бас ингээд холилчихсон нэг ийм олон нийтийн ойлголт талдаа ч тэр, ажил олгогч талдаа ч тэр, ажлын байрны тодорхойлолт талдаа ч тэр байгаа. Тэгэхээр энэ өөр өөр шатлалтай ийм өөр өөр нөхцөлд янз бүрийн ажил хийдэг нөхцөлд дунджаар ажилд орсон нийгмийн ажилтан 3 жилийн дараа ажлаа сольж байна, 3 жилийн дараа. Тэгэхээр энэ дээр өнөөдөр бид нар энэ нийгмийн ажил гэдэг мэргэжлийг тиймээ улсын тэргүүлэх мэргэжил болгож зарлаад Боловсролын зээлийн сангаас дэмжлэг үзүүлье гэсэн ч энэ дээр орох хүмүүсийн тоо жилээс жилд багасаж байгаа.

Гэтэл энэ хүмүүсийн нуруун дээр Нийгмийн халамж хамгааллын жил болгон гардаг 400, 500 тэрбумын зардлыг яаж хүргэх вэ гэдэг асуудал явж байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ хуулиар тэр мэргэжлийн холбоо гэдэг том бүлэг байгаа. Тэр холбоо нь өөрөө энэ дээрээ ажиллах энэ орон зайг нь бид нар дэмжиж эхлүүлж өгч байгаа. Энэтэй холбоотой зохицуулалтууд нь дандаа мэргэжлийн холбоо дээр болон тэр 2 талт үндэсний хороогоороо Засгийн газартайгаа ярилцаж хэлэлцдэг тодорхой давтамжтайгаар цалин, зэрэглэл нийгмийн баталгааны асуудлыг хөнддөг ийм зохицуулалтыг бас оруулж байгаа юмаа.

Ер нь яах вэ олон хүмүүс асуугаад байгаа лиценз гэдэг энэ шаардлага бол 2030 он хүртэл бид нар энийг тавих бололцоо өнөөдөр байхгүй байгаа. Яагаад гэвэл 60 хувь нь өөр мэргэжлээр сурч байгаа хүн.

С.Бямбацогт: Баярбаатар гишүүн тодруулж асууя.

Б.Баярбаатар: Тэгээд хууль эрх зүйн хувьд бол яалт ч үгүй дутагдалтай байгаа хууль зохицуулалтын хувьд мөн. Энэ нөгөө нийгмийн ажилтны ачаалал гээд гол асуудал байгаад байгаа юм. Өнөөдөр яг тухайн ажлын байран дээр нь очоод үзэхээр үнэхээр ачаалалтай ажиллаж байгаа, хүрэлцэхгүй байгаа. Тэгэхээр энэ хууль бол эрх зүйн зохицуулалт талаасаа энэ ачааллыг яаж бууруулах вэ? Н нэг. Нийгмийн ажилтны тоог нэмэгдүүлэх зарчмаар бууруулах гэж байна уу, эс үгүй бол ажил, чиг үүрэг, хуваарийнх нь талаар нь одоо өөр зохицуулалт хийж бууруулах уу? Салбар салбар өөрийн өөрийн гэсэн онцлогтой байгаа. Энэ дээр одоо бас яаж энэ хуулийн төсөл хэрхэн бодлого гаргаж тусгаж байна вэ гэдэг талаар та хариулж өгөөч.

С.Бямбацогт: Саранчулуун гишүүн хариулъя хууль санаачлагч.

О.Саранчулуун: Тийм нийгмийн ажилтны мэргэжлийн нийгмийн ажилтны эрэлт хэрэгцээ манайд хангагдаагүй, эрэлт хэрэгцээ ихтэй, тэгэхдээ яг одоо ажиллаж байгаа орон тоо нь бол хүрэлцэхгүй байгаа. Тэгэхээр хэрвээ бид нар нийгмийн ажилтан гэдэг та нөгөө хүнээ харахаас илүү бид нар нийгмийн ажлын үйлчилгээгээ өнөөдөр харах болчихоод байгаа байхгүй юу. Бид нар өнөөдөр мэс заслын үйлчилгээ ямар дүрэм журамтай, ямар зөвлөлөөр гарсан тогтоолтой дүрэмтэй үйлчилгээ явдаг шиг нийгмийн ажлын үйлчилгээ ч гэсэн тийм байх хэрэгтэй. Тэгэхийн тулд бид нар тэр орон тоон дээр байгаа тэр ажиллаж байгаа хүмүүсээ чадваржуулж аваад, тэд нарыгаа холбоогоороо дамжуулж сургаад, төртэй зөвшилцөж ажилласнаараа үйлчилгээний чанар сайжраад ирнэ. Нөгөө талдаа энэ олон өөр ажлын байрны тодорхойлолт, цалин баталгаа сайжраад ирэхээр ажлын байр илүү бат бөх болж ирэхээр энэ дээр ажиллах хүмүүсийн тоо нэмэгдэх байх гэдэг ийм л зүй тогтол харж байгаа.

Тэгэхээр чиг үүргийг нь дахин сайжруулж томъёолж өгснөөрөө нийгмийн ажилтнуудын энэ ачаалал буурна гэдэг ийм л энэ хуулийн зохицуулалт ерөөсөө чиг үүрэг нь илүү нарийвчилж өгч байгаа бол гэдэг.

С.Бямбацогт: Мөнгөнцогийн Ганхүлэг гишүүн асуултаа асууя.

М.Ганхүлэг: Өглөөний мэнд ээ. Хүмүүнлэг иргэний ардчилсан нийгмийн төлөө бид зорьж байгаа. Тэр утгаараа бас нийгмийн туслалцаа хэрэгтэй байгаа тодорхой бас одоо зам зүг чигээ зөв олоход нь дэм болох энэ ажлыг зохион байгуулдаг байсан нийгмийн ажилтныг дэмжих тухай хуулийн төсөл орж ирж байгаад талархалтай байгаа. Хуулийн төслийг санаачлагч Саранчулуун гишүүний хувьд энэ чиглэлээр докторын зэрэг хамгаалсан нэлээн олон улсын түвшинд судалсан хүний хувьд нэлээн чамбай хуулийн төсөл орж ирж байна гэж харж байна. Хэлэлцүүлгийн шатанд бас тодорхой асуудлуудыг ярилцаад боломжтой бол ажлын хэсэгт ороод ажиллая гэсэн ийм саналтай байгаагаа илэрхийлье ээ.

Үндсэндээ одоо байгаа нийгмийн ажилтнуудын тоо эрх зүйн орчинтой холбогдолтой асуудлуудыг дэлгэрүүлээд асууя. Мөн дээрээс нь зөвхөн нийгмийн ажилтан мэргэжилтэй бакалаврын зэрэг юу авсан хүмүүсийн тухай асуудлаас нэлээн өргөн хүрээнд энэ хуулийн хүрээ гарч явах зохицуулах ийм бололцоонууд байгаа юу гэдгийг тодруулж асууя. Жишээлэх юм бол одоо хүн бүр нийгмийн ажилд идэвхтэй оролцох тэр санаа зорилгыг дэмжсэн тодорхой зохицуулалтууд энэ хуулийн хүрээнд бас хөндөгдсөн зүйлүүд байна уу? Ялангуяа ахмад настнууд тэтгэврийн орлогоос гадна нийгмийн ажил үйл ажиллагаанд оролцох боломж байх уу? Оюутан залуучууд цагийн болон бусад хөдөлмөр эрхлэх чиглэлээр энэ ажлуудад оролцох боломж байх уу гэсэн энэ ерөнхий асуултыг асууя.

Мөн дээрээс нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөөлөл та өөрөө байгаа. Хэд хэдэн хэлэлцүүлгүүдийг зохион байгуулсан. Гэрээсээ гарцгаая нэртэй томоохон хөдөлгөөнийг санаачлаад явж байгаа. Монгол Улсын төр засгийн бодлого гэртээ байгаад асраад байвал дэмжээд байя гэдэг ийм бодлого руу чиглээд байгаа. Харин энэ нийгмийн туслах үйлчилгээ хувийн туслахын үйлчилгээтэй холбогдолтой асуудал энэ хууль дээр тусгагдаж байгаа дэмжлэг болох зүйлүүд байна уу? Хөгжлийн бэрхшээлтэй иргэд нийгмийн амьдралд оролцоход нь нийгмийн ажилтнууд мөн хувийн туслахууд залж чиглүүлэх ийм бололцоог тусгасан зүйлүүд байна уу гэдгийг тодруулж асууя.

Төсөв санхүүгийн боломжин дээр төрийн болон бусад өөр дэмжлэгүүд бас ямар зүйлүүд байгаа вэ? Судалж үзсэн зүйлүүд байна уу? зөвхөн төрөөс гадна энэхүү нийгмийн ажилтны үйл ажиллагааг дэмжих чиглэлээр тодорхой зохицуулалтуудыг, татварын тодорхой чиглэлүүдийг хуульчилж тусгах байдаг юм уу ийм онцгой татваруудыг чиглүүлэх энэ тэр байдлаар эх үүсвэрээ бүрдүүлэх гарц гаргалгаанууд байна уу гэсэн асуудлуудыг нарийвчилж асууя.

С.Бямбацогт: Хууль санаачлагч хариулах уу? Отгоны Саранчулуун гишүүн хариулъя.

О.Саранчулуун: Ганхүлэг гишүүнд баярлалаа. 1 дүгээр асуудал нь нийгмийн ажилтнуудын хүний нөөц чадваржуулалт, залуучуудын асуудлууд, ахмадуудын асуудлыг ямар холбоо харилцаатай талаар хөндөж байна. Нийгмийн ажилтан хүн

бол зөвхөн халамжийн тэнд байгаа лангуун дээр байгаа халамжийг хүнд авч хүргэдэг ресейпшн шиг хүн биш байгаад байгаа юм. Уг нь бид нар юу гэж сурсан бэ гэхээр, бид нар оюутнууддаа юу гэж заасан бэ гэхээр хүн болгонд давуу тал нөөц бололцоо байгаа. Тэрийг нь нөхцөл байдлын шинжилгээ гэж илрүүлээд тэрэн дээр нь тулгуурлаад тэр хүнийг ажилтай хөдөлмөртэй болгох, өөрийн амьдралдаа шийдвэр гаргах эзэн болоход нь тусалдаг ийм үйлчилгээ байдаг юмаа. Энийг энэ нөхцөл байдлын үнэлгээ гэдэг маягтыг хэрэглэнэ, ингэж төлөвлөнө өө гээд. Ийм түүлүүдтэй хэрэгслүүдтэй тэрийг нь зааж ирсэн. Гэтэл өнөөдөр яах вэ бид нар нийгмийн ажлын үйлчилгээ маань яг энэ агуулгаараа ганцхан хүүхэд хамгааллын салбар дээрээ бол нэлээн явчихсан. Илүү хариу арга хэмжээний хэлбэртэй.

Харин бид нар ахмадуудад, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зүгээр ер нь оюутан залуучуудыг өөрсдийгөө чадавхжуулахтай холбоотой асуудал дээр өнөөдөр нийгмийн ажил бол хүрээгүй л байгаад байгаа, байхгүй л байгаад байгаа. Ахмадад чиглэсэн ажил чинь илүү нөгөө эрүүл мэндийн агуулга руугаа хөгжчихсөн байгаад байгаа. Тэгэхээр Ахмад настны тухай хуульд жишээлбэл нийгмийн ажлын үйлчилгээг яг энүүгээр нь хүргэнэ ээ гээд тусгаад өгчих юм бол ахмадад чиглэсэн нийгмийн ажил геронтологийн салбарт чинь нийгмийн ажил чинь яг ингээд гал ус шиг орж ирж дэмжлэг үзүүлж үйл ажиллагаа явуулдаг байхгүй юу. Ийм бололцоо бий болно.

Хоёрт нь хөгжлийн бэрхшээлтэй хүн гэрээсээ гарцгаая. Хүмүүс яагаад гэрээсээ гарч чадахгүй байгаа вэ гэхээр гэрээсээ гараад очих газар байхгүй байгаад байхгүй юу. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс гэрээсээ гараад очих газар байхгүй. Залуучууд бол хаана ч очиж болно оо тиймээ кино театр соёлын үйлчилгээ авч болно, олон нийтийн гоё гоё эвентүүдэд оролцож болно. Хөгжлийн бэрхшээлтэй хүнд өнөөдөр гэрээсээ гараад очих газар байхгүй байна. Тэрэн дээр ямар бодлого, ямар үйл ажиллагаа байх ёстой гэхлээр 1 дүгээрт очих газар байхгүй, 2 дугаарт тэр хүний сэтгэл дотор бас очих газар байхгүй байгаад байгаа байхгүй юу. Тэгэхээр тэр хүний сэтгэлд би гараад тэнд очно гэдэг төлөвлөгөөгөө өөрөө гаргаж би хаана очиж өөрийгөө хөгжүүлэх вэ, би хаана очиж сурах вэ гэдэг юмыг нь мэдээлэлжүүлж чадавхжуулдаг хүн чинь уг нь бол хорооны халамжийн нийгмийн ажилтнууд байгаа байхгүй юу. Нөгөө талд эмнэлэг дээр байдаг эмнэлгээс гарах төлөвлөгөөнд ажилладаг эрүүл мэндийн нийгмийн ажилтнууд байхгүй юу. Тэгэхээр энийг бол ингээд энэ зүй тэр үйлчилгээг нь томъёолж өгөх юм бол энэ үйлчилгээнүүд сайжирна аа. Тэгэхээр энэ зайлшгүй тэр гэрээсээ гарцгаая болон хүртээмжтэй бүүр хэдэн мянган хувь хоорондоо холбоотой гэсэн үг.

Гуравдугаарт нь төсөв яригдаж байгаа. Энэ хууль дээр одоо үүсэж байгаа харилцаан дээр 2 янзын төсөв яригдаад байгаа. Нийгмийн ажилтны холбоо яаж төсвөө байх юм бэ гэж байгаа. Мэргэжлийн холбоодын адилаар гишүүнчлэлийн төсвийг байлгана. Нөгөө талдаа бид нар олон улсын төсөвт төсөв төсөл бичих, олон улсын байгууллагууд он удаан жил нийгмийн ажлын үйлчилгээг дэмжиж ирсэн учраас энэ дээр хамтран ажиллах зүгээр бололцоотой. Нэмж нэг минутаа нэмж авъя тэгэх үү?

Нөгөө талд болохоор хүмүүс бас хараад байгаа. Энэ хууль дээр байгаа төсөв чинь.

С.Бямбацогт: Асуултаа дуусгачихъя. Саранчулуун гишүүний микрофон.

О.Саранчулуун: Энэ хууль дээр байгаа төсөв бол одоо байгаа нийгмийн үйлчилгээ, халамж хамгааллын үйлчилгээний чанарыг сайжруулахад оршиж байгаа юм шүү. Одоо миний гарт байна шүү дээ энэ ингээд 500 хуудас ийм маягтууд байгаа. Энэ ар өвөргүй хэвлэсэн байгаа шүү манайхаан. Тэгээд энэ дээр юу байгаа гэхлээр нэг өрхөд дунджаар 4-5 салбараас 20 гаруй маягтууд ингээд авагддаг. Хүний ингээд нас хүйс, эрүүл мэнд, гэр бүлийн асуудлуудын 4 салбарын маягт байгаа. Энэ маягтууд хэний гараар бөглөгдөж ер нь цаашаагаа явдаг вэ? Статистикийн хороон дээр очиж байна гэхлээр нийгмийн ажилтнууд байгаа байхгүй юу. Гэхдээ энэ бүх маягтууд голдуу статистикийн мэдээ бүрдүүлэх зорилгоор болохоос биш эргээд салбар дундын уялдаа, энэ үйлчилгээ авсан хүн эргээд хөл дээрээ боссон юм уу, босоогүй юм уу, ажилд орсон юм уу, ороогүй юм уу? хорих хүмүүжих газраас гарчхаад эргээд ямар зан үйлийн асуудалтай юм гэдэг энэ маягтын мэдээлэл огт байхгүй байгаад байгаа.

Тэгэхээр энэ хууль дээр тэр мэдээллийн сан буюу салбар дундын уялдааг зохицуулах агуулгаар цэгцлэх юм бол энэ.

С.Бямбацогт: Мөнгөнцогийн Ганхүлэг гишүүн тодруулж асууя.

М.Ганхүлэг: Тэгээд яах вэ хуулийн хүрээ маань одоо байгаа 3 мянган нийгмийн ажилтнаа зөвхөн харж байна уу? Хүн бүр ер нь нийгмийн ажилтан байх, нийгмийн ажил үйл ажиллагаанд оролцох чиглэлийн заалтууд байна уу гэсэн яах вэ ерөнхий асуулт байгаа. Тэгээд энийг бас ажлын хэсгийн хүрээнд цаашдаа ярилцаад явах нь зөв байх аа гэж бодож байна.

Энэ 7.1 дээр 8 үндсэндээ үйлчилгээг заасан байгаа юм. Тэгэхээр энэ үйлчилгээг үндсэндээ бүгдийг нь үндсэндээ юу хийх байгууллагууд гарч ирэх үү, эс үгүй бол яг чиглэл чиглэлээр нь үндсэндээ салбарлуулж явах уу? Тэгээд энэ дээр яг тодорхой ямар зохицуулалтууд хийхээр туссан байгаа вэ гээд нэлээн нарийвчлаад асуучихъя. Тэр хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон энэ юу ахмадууд давхар ажиллах ийм боломж байх уу гэсэн тийм асуулт байгаа юм. Тэгээд энийг тодорхой хариулаач ээ.

С.Бямбацогт: Хэн хариулах вэ? Хууль санаачлагч Саранчулуун гишүүн хариулъя.

О.Саранчулуун: Нийгмийн ажлын үйлчилгээг үйлчилгээ бол ер нь 20, 30 төрөл байдаг аа. Дэлхийн олон оронд хөгжиж байгаа. Монгол улсад одоо хийгдэж байгаа, одоо хэрэгжиж байгаа хууль эрх зүйн 13 хуулийн 162 заалт дээр 20 гаруй журмаар зохицуулагдсан нийгмийн ажлын үйлчилгээ байгаа холбоотой. Эд нарыг бид нар илүү цэгцлээд, илүү стандарт руу нь ойртуулахын тулд 8 төрлийн үйлчилгээг тодорхойлж өгсөн байгаа хуулийн заалтаар. Энэ 8 төрлийн үйлчилгээ бол тухайн салбараасаа хамаараад харилцан адилгүй байгаа. Жишээлэх юм бол хавдраар өвдөөд эмнэлгээс гарч байгаа хүнд чиглэсэн, эмнэлгээс гарахтай холбоотой эрүүл мэндийн нийгмийн ажлын үйлчилгээ бол жоохон өөр байдаг. Дотроо ингээд салбараас хамаараад өөр байгаа. Гэхдээ бүх нийгмийн ажлын хувь хүнд чиглэсэн, гэр бүлд чиглэсэн үйлчилгээ бол адилхан 5 хүчдэлийг туулдаг. Нөхцөл байдлын үнэлгээ хийлээ, төлөвлөлөө, эргэж хүргэлээ, дараа нь дараах холбоо гэдэг юм заавал яригддаг зэргээр нэлээн нарийн тодорхойлсон байгаа. Нийгмийн ажил бол заавал мэргэжлийн үйлчилгээ учраас хүн...

С.Бямбацогт: Асуултаа дуусгачихъя. Нэг минут Саранчулуун гишүүн.

О.Саранчулуун: Ахмад настан ер нь залуучуудыг нийгмийн ажилтан байж болох уу. Ер нь нийгмийн ажлын үйлчилгээ хийж болох уу гэдэг асуулт өөрөө бас нөгөө аягүй ийм хүмүүсийн ойлголтыг нэлээн харуулаад. Тэгэхээр нэг сайн дурын ажил хийгээд л нэг одоо буяны ажил ч юм уу хийгээд энэ нийгмийн ажил гэдэг энэ тодорхойлолт шиг л ингээд сонсоод байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ бол биш. Нийгмийн ажил чинь өөрийн гэсэн онолтой, аргатай, бие даасан мэргэжил учраас хүн болгон энийг хийх боломжгүй. Бид нар хуульч хүмүүсийг эдийн засагч хийе гэж хэлдэггүй шиг бид нар ямар ч хамаагүй хүмүүсийг за чи нийгмийн ажил хийгээрэй гэдэг боломжгүй. Тэгэхээр өнөөдрийн энэ хэлэлцүүлгээс ч гэсэн хүмүүс бас энийг ойлгож авах юм бол олон ажил олгогч нар өнөөдөр нийгмийн ажилтан авъя гэдэг орон тоон дээрээ өөр хүмүүсийг авахгүй юм байна аа, мэргэжлийн хүн авах юм байна аа гэдгийг бас ойлгох хэрэгтэй.

Харин нийгмийн ажилтан олон нийтийн шууд бус ажил, нөлөөллийн ажил хийхдээ энэ ахмадууд, оюутнуудыг оролцуулсан зохион байгуулсан ажлыг илүү түлхүү хийдэг байхгүй юу. Тэр талаараа л оролцоотой гэсэн үг.

С.Бямбацогт: Тодруулж асууя. Нэмэлт асуулт нэг минут. Ганхүлэг гишүүн.

М.Ганхүлэг: Тийм тийм, яг нийгмийн ажлын үйл ажиллагааг мэргэжлийнхэн зохион байгуулах хийх тал дээр санал нэг байгаа тийм. Яах вэ бид зөвхөн нийгмийн ажлыг харахдаа 3 мянган бакалаврын зэрэгтэй түүний 60 хувь нь өөр мэргэжлийн хүмүүс. Үүнийгээ нэмэгдүүлээд явна аа гэдэг байдлаар харалгүйгээр ер нь хүн болгон нийгэмдээ идэвхтэй оролцохыг нь дэмжсэн тийм үзэл санаа энэ дээр Нийгмийн ажилтны тухай хууль биш байгаа юм л даа. Нийгмийн ажлын тухай хууль байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ дээр байгаа юу?

Ер нь тэр агуулгыг жоохон хөндөж оруулах нь нийгэмдээ эсрэгээрээ илүү бага зардлаар, илүү олон хүнийг хамрах ийм үзэл санаа байх юмаа гэдэг тухай л бас яриад байна. Тэрнээс биш нийгмийн ажилтны ажлыг үгүйсгээгүй шүү тийм. Ер нь бусад энгийн хүмүүс энэ ажлыг хийснээрээ тодорхой дэмжлэг авах ч байдаг юм уу янз бүрийн тийм боломж бололцоог бид нар хөндөж ярих ёстой юу гэдэг тухай л асуугаад байна л даа.

С.Бямбацогт: Ажлын хэсэг хариулах уу? Хэн хариулах вэ? Ажлын хэсгийн 4 дүгээр микрофон. Оюунболд хуульч судлаач хариулъя.

Г.Оюунболд: Сайн байна уу? Ганхүлэг гишүүний асуултад хариулъя. Хуульч Оюунболд байна. Нийгмийн ажлын тухай хуулийг боловсруулах явцад хэрэгжсэн гол заалтууд болох нийгмийн ажлын төрөл хэлбэрүүд байгаа. Тэрний нэг нь энэ олон нийтийн оролцоог дэмжих урьдчилан сэргийлэх ийм арга хэмжээг тусгасан. Тэгээд энэ дээр нөгөө иргэдийн болон олон нийтийн сайн дурын оролцоог дэмжих маягаар хувь хүнийг чадавхжуулах тодорхой хүнд нийгэм сэтгэл зүйн зөвлөгөө өгөх гэх мэт ийм үйлчилгээг энэ хуулийн төсөлд тусгасан байгаа. Эдгээр үйлчилгээнүүд нь халамжийн болон бусад үйлчилгээнд хамаарахгүй тусдаа яг нийгмийн ажлын ажил гэж тодорхойлогдсон ийм үйлчилгээнүүдийг хуулийн төсөлд тусгаж өгсөн байгаа.

С.Бямбацогт: Баярлалаа. Улсын Их Хурлын гишүүн Жамбалын Ганбаатар гишүүн биш уучлаарай Лхагвасүрэнгийн Соронзонболд гишүүн асуултаа асууя.

Л.Соронзонболд: Бүгдэд нь өглөөний мэнд хүргэе ээ. Яах вэ энэ нийгмийн ажлын тухай хууль нийгмийн ажлын хүрээ нь бол өөрөө маш өргөн байдаг тийм ээ. Зүгээр энэ дээр ингээд харахаар жишээлбэл хувь хүний хөгжлийг дэмжих үйлчилгээтэй холбоотой асуудлыг энэ мэргэжлийн холбоо маань хариуцаад мэдээллийн санг бүрдүүлэх гээд байна л даа. Тэгэхээр би бол Монгол улсад хувь хүн болгон өөрийнхөө хувь хүний хөгжлийнхөө төлөө ажилладаг, өөрөө бие дааж ажиллаж чаддаг энэ тал руугаа илүү хөгжих ёстой гэж боддог. Саранчулуун гишүүн ч гэсэндээ ер нь өөрөө хүн өөрөө асуудлаа шийдвэрлэдэг байх тал руугаа илүү ярьдаг л даа.

Тэгэхээр би энэ нийгмийн ажилтны хууль дээр байгаа энэ хувь хүний хөгжлийг дэмжих үйлчилгээ байна. Энэ чинь янз бүрийн л үйлчилгээ байж болно шүү дээ. Сургалт байж болно, зөвлөгөө байж болно. Тэгээд энийг бүгдийг нь тэгээд мэргэжлийн холбоонд аваачаад заавал тэнд аваачих ямар шаардлага байгаа юм бэ гэдэг 1 дүгээр асуулт байгаад байгаа юм.

Хоёрдугаарт бол хувь хүний нийгмийн үйлчилгээний хүрээ чинь төрийн байгууллагаас гарч байгаа үйлчилгээ байна, хувийн сектороос ч байж байгаа үйлчилгээ байж болох гээд байна. Тэгээд бүх мэдээллийн нэгдсэн санг энэ холбоон дээр авчирч байгаад л бөөгнүүлэх гээд байна л даа. Тэгэхээр энэ хувь хүний нууцлалын тухай хуультай холбогдолтой асуудлууд эд нар гээд олон асуудал байгаа шүү дээ. Энэ бүгдийг яаж зохицуулж байгаа вэ гээд. Дараагаар нь болохоор яах вэ ер нь нөгөө энэ салбар дээр 3 мянга гаруй ажиллагсад ажилладаг. Цалин хөлсний асуудал нэлээн хүнд байдаг тухай бол танилцуулга дээр дурдагдсан байгаа. Тэгэхээр холбоо маань болохоор энэ асуудлаар ямар ч байсан төртэй, ялангуяа төрийн ажил хийж байгаа улсуудтай холбоотой асуудлаар нэлээн тохирч ажиллах юм байна гэж ойлгож байгаа юм. Гэтэл одоо яг иймэрхүү байдлаар ингээд бүх салбар дээр иймэрхүү байдал нэвтэрчих юм биш үү, нэвтрэх болох гээд байна уу даа л гэдэг ийм л нэг хардлага байгаад байна даа. Тэгэхээр энэ 3 асуудал дээр хариулаач.

С.Бямбацогт: Хууль санаачлагч Отгоны Саранчулуун гишүүн хариулъя.

О.Саранчулуун: Соронзонболд гишүүний асуултад хариулъя. Баярлалаа. Хувь хүний хөгжлийг дэмжих гэдэг энэ үйлчилгээний цаана юуг ярьж байгаа вэ гэхээр жишээлбэл бид нар бэлгийн хүчирхийллийн хохирогч болсон насанд хүрээгүй хүүхдүүд, хүүхдийн асрамжид амьдарч байгаа 0-17 насны хүүхдүүд байна. 895 гээд тоонууд ярьж болж байна. Хүнсний эрхийн бичигт хамрагддаг 43 мянган айл өрх байна. Нийгмийн халамжийн дэмжлэг зайлшгүй шаардлагатай өрхөд амьдарч байгаа хүүхдүүд 509, хөдөлмөр эрхэлж байгаа хүүхэд гээд тэгэхээр 430 гээд зөвхөн хүүхдийн асуудлыг ярихад л бид нар хэдэн мянган хүүхэд өнөөдөр хүнд нөхцөлд амьдарч байгаа. Тэр хүүхэд ээж аавын хариуцлагагүй гэдэг юм уу ээж аавын үл хайхрах хүчирхийллийн дунд ч юм уу амьдарч байгаа.

Тэгэхээр энэ хүүхдүүд, энэ гэр бүлүүдэд чиглэсэн энэ үйлчилгээ уг нь бол бусад орнуудад байдаг нь яадаг вэ гэхээр хүүхдээ хэрхэн өсгөх, хүүхдээ хэрхэн хамгаалах, эцэг эхийн хариуцлага зэрэг асуудлууд дээр нийгмийн ажилтан хүүхдийн эрхийн талаас нь оролцож явдаг. Энэ чиглэл байгаад байгаа юм.

Мэргэжлийн холбоо энэ дээр ямар үйлчилгээ, ямар зүйл хийж байгаа вэ гэхлээр хуульчдын мэргэжлийн холбоо шиг тиймээ одоо юуг нийгмийн ажил гэдэг мэргэжлийн зааг ялгааг нь тодорхойлж өгч байгаа. Нийгмийн ажилтнуудын сургалтыг нь хариуцаж зохицуулж байгаа. Нэгдсэн үйлчилгээнүүдийн стандартуудыг ингэж гаргах ийм бодлогын баримт бичгүүд дээр бас мэргэжлийн холбоо ажилладаг. Гишүүдийн эрх ашгийг хамгаалах дээр бас Засгийн газартай түрүүний дурдсанчлан 2 талт үндэсний хороо гэдэг бүтцийг бий болгохоор энэ хуульд тусгасан байгаа. Энэ нь өөрөө Засгийн газартай харилцаж ажиллах ийм бүтэц байна.

Тэгэхдээ мэдээллийн сангийн асуудал дээр хэд хэдэн ойлголт явагдаж байгаа. Энэ мэдээллийн сан бол хувь хүний мэдээллийг мэргэжлийн холбоо аваад хариуцчих асуудал огт биш юмаа. Би түрүүн дурдаад байгаа миний гарт байгаа энэ 500 хуудас материал дандаа айл өрхөөс авдаг анкет асуумжууд байгаа. 4 өөр салбарын 20 гаруй чиглэлийн асуултууд байгаа. Гэхдээ эд нар бол зөвхөн статистикийн зориулалттай тоогоо тоолоод тавьдаг зориулалттай мэдээ болохоос биш энэ үйлчилгээ авсан, энэ эмзэг бүлэгт байгаа хүмүүс өнөөдөр аль түвшинд яваа юм бол оо, хүнсний талон авсан айл өнөөдөр яаж ажилд орох тухай бодож байна вэ ч гэдэг юм уу тиймээ. Энэ залгамжтай холбоотой мэдээллүүд огт байхгүй байгаа. Энийг тэр мэдээллийн сан буюу одоо байгаа е-халамж юм уу, Гэр бүл нийгмийн хамгааллын яамны ихэнх мэдээлэл дээр тулгуурлаж байгаа учраас тэрэн дээр илүү дахин зохион байгуулаад, тэнд мэдээлэл нийлүүлэгч талууд буюу олон талбаруудын оролцоонуудыг оруулсан ийм зохицуулалтыг бид нар хийхээр маш бага төсвөөр боломж төсвөөр ингэж зохицуулахаар тусгагдаж байгаа.

Тэгэхээр энэ бол мэргэжлийн холбоод тусдаа мэдээллийн сантай хамтарч, тэр дүрэм журам, үйлчилгээний процедур дээр оролцох учраас шууд хувь хүний нууц буюу энэ олон мянган хүний мэдээллийг мэдээлэл мэргэжлийн холбоо хариуцахгүй гэсэн үг. Тэгээд нэмэлтээр манай ажлын хэсгээс хариулаад өгөөч. Мэдээллийн сан дээр ажлын хэсгийн хариулт.

С.Бямбацогт: Улсын Их Хурлын гишүүн Жуковын Алдаржавхлангийн урилгаар Хан-Уул дүүргийн 4, 5 дугаар хорооны хэсгийн ахлагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа Төрийн ордонтой танилцаж байна. Манай Алдаржавхлан гишүүн энд сууж байна. Бас өчигдөр Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт өргөн барьсан. Өнөөдөр усанд орох соёлын өвийг хамгаалах тухай ЮНЕСКО-гийн конвенцод нэгдэн орох хэлэлцээрийг өргөн барьсан их ажил хэрэгч ажиллаж байгаа сайн гишүүн шүү гэдгийг сонгогчид нь магтаж хэлье ээ. Та бүхнийхээ ажилд нь амжилт, амьдралд нь эрүүл энх, сайн сайхан бүхнийг Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс хүсэн ерөөе.

Ажлын хэсэг 4 дүгээр микрофон нэмэлт хариулт.

Л.Долгор: Соронзонболд гишүүний асуултад хариулья.

Эрүүл мэндийн нийгмийн ажилтан Долгор байна. Мэдээллийн санд бид нар 3 төрлийн үйлчилгээг бүртгэхээр төлөвлөсөн байгаа хуулийн төсөлд. 1 дүгээрт нь бол нийгмийн ажлын шууд үйлчилгээний талаарх мэдээлэл, 2 дугаарт нь нийгмийн ажилтнуудын мэргэжлийн үйл ажиллагааны талаарх нэгдсэн мэдээлэл, 3-д нь нийгмийн ажлын шууд бус үйлчилгээний талаарх мэдээлэл, үр дүн, тайлан гэсэн 3 хэсэг мэдээллийг бүртгэнэ. Хувь хүнтэй холбоотой хувь хүний нууцлалтай

холбоотой мэдээллийн хэсгийг нь бол төр хариуцна. Энийг бол бид нар хууль өргөн барьсны дараагаар салбар яамдуудтай хамтраад дахин хэлэлцүүлгүүдийг зохион байгуулаад мэдээллийн сангийн одоо байгаа мэдээллүүдээ нэгтгэх, илүү нарийвчилсан зохицуулалтуудыг гаргах боломжтой юм байна гэдгийг ойлгож байгаа. Тэгэхээр энэ хэсгийг илүү нарийвчлан сайжруулах боломжтой байгаа гэсэн үг.

Тэр нийгмийн ажилтнуудын мэргэжлийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг нь бол нийгмийн ажлын мэргэжлийн нэгдсэн холбоо хариуцна. Мөн шууд бус...

С.Бямбацогт: Асуултаа дуусгачихъя хариултаа 4 дүгээр микрофон.

Л.Долгор: Тэгэхээр энэ мэдээллийн сангийн зохицуулалтыг бол цахим яам болон бусад салбарын яамнуудтай хамтраад илүү нарийвчилсан зохицуулалт хийж аль хэсэгт нь ямар хязгаарлалтууд тавих вэ гэдгийг хууль дээр нарийвчлан тусгах боломжтой байгаа.

С.Бямбацогт: Баярлалаа. Соронзонболд гишүүн тодруулъя.

Л.Соронзонболд: Яах вэ энэ нөгөө нийгмийн ажлын үйлчилгээний шууд үйлчилгээний төрөл гээд хувь хүний хөгжлийг дэмжих үйлчилгээ гээд байгаа шүү дээ. Тэгээд тэрийг тодорхойлолтыг уншихаар яг ингээд эмзэг бүлэг гэхгүйгээр бүх л хүмүүс рүү чиглэсэн үйлчилгээ байна гэж хараад байхгүй юу. Гэтэл бид нар одоо Монгол Улсад аливаа зөвшөөрөл тиймээ зөвшөөрөл янз бүрийн юмгүйгээр үйл ажиллагааг эрхлэх боломжийг нь бий болгоё оо гэж яриад байдаг. Тэгэнгүүт одоо энд хуульд ингээд харахаар хувь хүний хөгжлийг дэмжих чинь болохоор мэдээж би Саранчулуун гишүүний яриад байгаа тодорхой эмзэг бүлэг юм уу тэр хэсгийг бол ойлгож байна. Гэтэл нийт иргэд рүү чиглэсэн бүх үйлчилгээ энэ хүрээнд чинь хамрагдаад тэгээд энд одоо бүх мэдээлэл нь боловсруулагддаг дата нь цуглардаг болох гээд байгаа чинь зөв юм уу л гэж асуугаад байгаа байхгүй юу. Бүх нийгмийн сегмент рүү хандаад байна шүү дээ.

Тэгээд одоо энэ юуны нийтлэг үйлчилгээний төрлүүд чинь 7.1 дээр заасан 8 төрлийн чинь хамгийн чухал хэсэг нь аль хэсэг нь юм. Тэр рүүгээ илүү төвлөрсөн байх ёстой байсан юм биш үү гэсэн надад одоо тийм бодол байна. Тэгэхгүй бүх одоо нийгмийн сегмент рүү л хандсан ийм л ажлууд хийх гээд байна шүү дээ.

С.Бямбацогт: Санал хэлчхэв үү. За хариулъя. Саранчулуун гишүүн хууль санаачлагч хариулъя.

О.Саранчулуун: Одоо байгаа нийгмийн ажлын үйлчилгээн дээр жишээ аваад Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны хүрээнд олон нийтийн оролцоонд түшиглэсэн нийгмийн халамжийн үйлчилгээ гээд нэг үйлчилгээ байгаа. Тэр дотор ингээд 9 бүлэг ийм төрлийн үйлчилгээ байгаа. Тэрэн дээр жишээлбэл зөвлөгөө гээд биччихсэн байгаа. Зөвхөн зөвлөгөө гэдэг ч юм уу тиймээ. Тэгэхээр тэр нь яадаг вэ гэхлээр одоо байгаагаар бол Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар гэрээ, тендерээр гүйцэтгэгчийг сонгоод тэр нь нэг ТББ тэр үйлчилгээг тухайн төрийн өмнөөс хүргээд эргүүлээд тайлангаа өгдөг ийм тогтолцоо байгаад байгаа гэсэн үг. Тэгэхээр энэ мэтчилэн одоо байгаа нийгэм халамж хамгааллын үйлчилгээнүүд нь өөрөө өргөн ерөнхий нэр агуулгын доор яг зөвлөгөө гэдэг нь юуны зөвлөгөө юм, яг

ямар зөвлөгөө өгөх юм, ямар үе шаттай байх юм гэдэг нь нарийн тусгагдаагүй учраас бид нар энэ хуулийн дотор тэр 8 төрлийн үйлчилгээг задалж өгөөч гэж тодорхойлж байгаа гэсэн үг. Энэтэй холбоотой журмууд нь бас дагаж тушаал журмууд нь дагалдаж...

С.Бямбацогт: Улсын Их Хурлын гишүүн Жамбалын Ганбаатар гишүүн асуултаа асууя.

Ж.Ганбаатар: Саранчулуун гишүүний хуулийг би ерөнхийд нь харсан. Их том хууль байна лээ л дээ. Тэгээд яах вэ би дундаас нь хэд хэдэн зүйлийг асууя. Зүгээр асуултаасаа өмнө би нэг зүйлийг хэлье. Саранчулуун гишүүн маш өөрөө сайн мэдэж байгаа. Манай БГД-т Болдбаатар гээд нэг залуу идэвхтэй байдаг. Тэгээд тэр залуу өөрөө юу гэдэг вэ гэхлээр үгүй намайг хөгжлийн бэрхшээлтэй гэж битгий хар л даа. Би хүний хийж чаддаг бүх ажлыг хийнэ ээ. Зүгээр намайг хөдөлмөр хийх боломжоор дэмжээч ээ гэж ийм л зүйлийг хүсдэг юм байна лээ. Саранчулуун гишүүн өөрөө энийгээ мэдэж байгаа тиймээ. Би одоо энэ талаар Саранчулуун гишүүнтэй зөндөө ярьж байсан.

Тэгэхээр би юу хэлэх гээд байна гэхлээр нийгмийн халамж шаардлагатай хэсэг рүү ямар нэгэн үйл ажиллагаа явуулахдаа үгүй би хөдөлмөр эрхэлмээр байна аа, хөдөлмөр эрхлэх боломжтой байна аа, би нийгэмдээ оролцмоор байна аа гэдэг энэ агуулгыг нь энэ хуульд хэр тусгасан бэ? Дандаа ингээд юу гэдэг юм тиймээ нэг тийм асуудалд нэг тийм ажил хэрэгч байдлаар хандах асуудлыг нь энэ хуульд хэр тусгасан бэ гэдгийг л би зүгээр асуух гэсэн юм. Зүгээр би сонсохоороо зүгээр яах вэ төрийн хийж байгаа ажлуудыг холбоодуудаар дамжуулаад эс үгүй бол ААН-үүдэд өгөөд хийлгүүлэх гэж байгаа. Би бол зөв байх гэж бодож байна. Би зүгээр энэ хуулийг бүхэлд нь дэмжиж байгаа. Гэхдээ би зүгээр доторх агуулгыг нь юу гэж хэлэх гэж байгаа вэ гэхлээр хүмүүсийг хөдөлмөр хийх сонирхлыг төрүүлэх асуудлуудыг хэр тавьсан бэ?

Манай Хөдөлмөрийн хууль тэс эсрэг явсан шүү. Өнөөдөр манай Монгол Улс бол ер нь экспортын бүтээгдэхүүн олон улсад гаргах өрсөлдөх чадвар байхгүй шүү. Монгол Улс ямар нэг зүгээр нэг ийм энгийн бүтээгдэхүүнийг манай давуу талтай бүтээгдэхүүн бол уул уурхай ч юм уу манай нэг давуу талтай бүтээгдэхүүн болох байх л даа. Зүгээр нэг бид нарын өдөр тутмын хэрэглээний бүтээгдэхүүн бол бид үйлдвэрлээд олон улстай өрсөлдөх чадамж байхгүй. Юу байна гэхлээр энэ бол дотоодын энэ зардлын өсөлт бид нарыг ийм биш болгож байгаа юм. Тэгэхээр энэ бол манай маш том сул тал болж байгаа юм л даа. Зүгээр БНХАУ-тай биш гэхэд зүгээр Вьетнамтай, Бангладештай юу байдаг юм Казахстантай өрсөлдөх боломжгүй. Тог цахилгаан өндөр үнэтэй, бүтээмжээсээ илүү цалинтай бид. Тэгээд ийм учраас энийг олон талын хууль дээрээ анхаардаг байх хэрэгтэй. Хүний хөдөлмөр хийх хүсэл сонирхлыг өдөөдөг байх хэрэгтэй. Энэ хууль ч гэсэн тэр тал руугаа бас олон зүйл заалтаар нь харсан байх аа гэж би итгэж байна. Тэгээд хариулт аваад тодруулъя баярлалаа.

С.Бямбацогт: Хууль санаачлагч хариулъя. Отгоны Саранчулуун гишүүн.

О.Саранчулуун: Ганбаатар гишүүний асуултад хариулъя. Баярлалаа.

Энэ хууль дээр жишээлбэл нийгмийн ажил ийм ийм ажил хийгээд энэ хүмүүсийг ажилд оруулна аа ч гэдэг юм уу ийм тодорхойлолт байхгүй. Энэ хууль

өөрөө нийгмийн ажлын үйлчилгээ гэдэг нь хувь хүний хөгжлийг дэмжих ёстой, хүний давуу талд тулгуурлаж нөхцөл байдлын үнэлгээ хийх ёстой гэдэг тэр мэргэжлийн ажлыг нь тодорхойлж өгснөөрөө шууд бус утгаараа дэмжиж холбогдож байгаа гэсэн үг. Гэхдээ одоо ийм байгаа. Хууль зүйн салбарт жишээ аваад үзье л дээ. Шүүхийн шийдвэрийн биелүүлэх газрын ерөнхий нэг систем байна л даа. Судлагдсаны дараа нийгэмшүүлэх хөтөлбөр гэж уул нь байдаг тиймээ. Тэрэн дээр бол төсөв байхгүй, ажлаас дараа нь ажилд яаж ордог вэ гэдэг тэр иргэдийн мэдээлэл нь тэр халамжийн системтэйгээ уялдаагүй байгаа. Уул нь зүй нь бол яах вэ гэхлээр хороо халамж руугаа очоод ажилд ороод явдаг ийм тогтолцоо байгаа. Энэ бол манай нийгмийн ажлын мэдээллийн систем дээр уялдаж ирэх нэг зүйл байгаа жишээлбэл.

Эрүүл мэндийн салбарын мэдээллийг харъя. Эрүүл мэндийн салбарын мэдээллийг харахаар өвчний тухай кэйс, гэр бүлийн тухай кэйс гээд авч ашиглах ч болох маш сайн өгөгдөлтэй мөртөө эмнэлгээс гарсны дараа хүн яаж эргэж ажилдаа орох вэ, яаж хиймэл хөлөө хөлтэй болох вэ ч гэдэг юм уу, хаанаас авах вэ ч гэдэг юм уу тиймээ сэтгэл зүйн хувьд яаж нөхөн сэргээлтээ хийх вэ, нийгмийн даатгалаа яах вэ гэдэг асуудлууд бас байхгүй байгаа. Тэгэхээр тэр маягтууд дээр тэрийг нь цэгцэлж нэмж оруулах ёстой гэдэг энэ зохицуулалт мэдээллийн сангаар дамжиж бий болно оо гэсэн үг.

Тэгвэл хөдөлмөр эрхлэлт дээр өнөөдөр манайд e-job гээд нэг веб сайт байна. Энэ систем дээр ажил хайгчийн бүртгэл байгаа. Тэгэхдээ энэ дээр нийгмийн ажлын кэйс уялдаагүй байгаад байгаа. Ажил хайж байна орох гэдэг асуудал байгаа болохоос биш хэн ажил хайж байгаа вэ, ажилд орсон хүний кэйс ямар байна вэ гэдгийг нийгмийн ажилтан оруулж туслаад дэмждэг юм байхгүй. Жишээлбэл өрх хороон дээр ажиллаж байгаа нийгмийн ажилтан өөрийнх нь харьяалал байгаа нэг хүн ажилд ороход e-job руу жишээлбэл өөрийнхөө нийгмийн ажлын нэвтрэх эрхээрээ ороод ийм ийм кэйстэй, ийм ийм давуу талтай учраас энийг ийшээ шилжүүлье ч гэдэг юм уу ийм уялдаа холбоо огт байхгүй байхгүй юу. Тэгээд тэгсэн мөртөө манайх ийм их дата цуглуулдаг мөртөө энэ чинь улсын төсөв шүү дээ тиймээ. Маш их дата цуглуулдаг мөртөө улсын төсөв.

Тэгэхээр энийг нь жоохон чамбайруулж цэгцэлье. Тэгээд мэдээлэл нийлүүлэгч талууд болох энэ 4 салбар байгаа. Боловсрол, эрүүл мэнд, хууль зүй, хөдөлмөр эрхлэлт гэсэн салбарын мэдээллүүдийг хооронд нь уялдаатай болгоё. Энэ дунд хүмүүсийг ажилд зуучлах, холбох, ажил хийх боломжтой боломжгүй 2-ыг ангилах систем бий болно оо гэдэг ийм зохицуулалт байгаад байгаа. Ер нь бол нийгмийн ажлын нэг үнэт зүйл байдаг. Тэр нь юу вэ гэхээр зарчим хүн болгонд давуу тал байгаа гэж үздэг. Тэгэхээр өнөөдөр хэрвээ Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд нийгмийн ажлын үйлчилгээ ийм байна аа гэдгийг оруулчих юм бол Болдбаатар шиг олон хүмүүс ажилд орох бололцоотой болох байхгүй юу. Болдбаатарт өнөөдөр өөрөө шийдвэр гаргачихсан хүн. Гэтэл Болдоо шиг шийдээгүй хүмүүст бид нар яаж ажилд орох вэ гэдгийг заан чиглүүлж шийдвэр гаргахад нь тусалдаг нь өөрөө нийгмийн ажлын тэр хувь хүний хөгжлийн хөгжлийг дэмжих гэдэг үйлчилгээтэй утга агуулгын хувьд нэг байхгүй юу. Тэгэхээр тийм агуулгаар туссан гэсэн үг.

С.Бямбацогт: Зочин танилцуулъя. Нийслэлийн ерөнхий боловсролын амжилт Кибер сургуулийн 10-ын 1 дүгээр ангийн багш сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа Төрийн ордонтой танилцаж байна аа. Та бүгдийнхээ сурлагад нь

өндөр амжилтыг хүсье. Амьдралд нь эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг нийт гишүүдийнхээ нэрийн өмнөөс хүсэн ерөөе. Тэгээд онц сураарай.

За Улсын Их Хурлын гишүүн Жамбалын Ганбаатар гишүүн тодруулж асууя.

Ж.Ганбаатар: Сараа гишүүн тэгээд энэ холбоо санхүүжих асуудал нь яаж явах юм бол? Улсын төсвөөс юм уу, ААН-үүдээс юм уу, эс үгүй бол биеэ даагаад юм уу, эсвэл энэ чинь одоо санхүүжээд ажил ямар нэгэн байдлаар энэ чинь юм бүтээнэ, хийнэ, хүмүүс рүүгээ хандана, тэгэхлээр яах ёстой билээ?

С.Бямбацогт: Хариулъя. Отгоны Саранчулуун гишүүн.

О.Саранчулуун: Баярлалаа. Одоогийн энэ хуулийн төсөлд тусгагдсан 920 сая төгрөгийн 800 сая нь бол одоо байгаа энэ мэдээлэл маягтуудыг цэгцлэхтэй холбоотой, мэдээллийн сантай холбоотой зардалд гэж тусгагдсан байгаа. 120 сая нь бол холбоо байгуулж өгөх, тэр 2 талт үндэсний хороо бүх Монголд байгаа энэ 3 мянга гаруй нийгмийн ажилтнаа цуглуулаад хуралдаж үүсгэх ийм зохион байгуулалтаар тусгачихсан байгаа. Нийгмийн ажлын мэргэжлийн холбоо бол бусад хуульчдын холбоо болон аялал жуулчлалын мэргэжлийн холбоотой адилхан жишгээр гишүүнчлэлийн татварыг холбооныхоо зөвлөлөөр тогтоогоод ингээд босгох ийм урьдчилсан тооцоолол байгаа.

Өнөөдрийг хүртэл Монголд хөгжиж ирсэн энэ олон төрлийн нийгмийн ажлын үйлчилгээ нийгмийн ажил бол дандаа олон нийтийн олон улсын байгууллагын санхүүжилтээр Жайка гэх мэтээр НҮБ-ын хүүхдийн сан зэрэг олон улсын төслүүд дээр нийгмийн ажил өнөөдөр дэмжигдэж өдий хүртэл ирсэн байгаа. Тэгэхээр одоо энэ бол бие дааж явахын тулд түр...

С.Бямбацогт: Пүрэвсүрэнгийн Наранбаяр гишүүн асуултаа асууя.

П.Наранбаяр: Баярлалаа. Энэ хууль нэлээн бас энэ нийгмийн ажлыг цэгцэлсэн. Мэргэжлийн зүгээс нь сайжруулах гэж оролдсон нэг ийм зарчмын шинжтэй анхдагч ийм хууль гэж харж байгаа учраас үзэл баримтлалынх нь хүрээнд мөн хэлэлцэх эсэх дээр нь дэмжинэ. Ийм байр суурьтай байгаа. Ялангуяа бид энэ төрийн үйлчилгээний алба, төрийн захиргааны алба, улс төрийн алба, тусгай албыг нэг хуулиар ингэж зохицуулж явж байгаа. Цалин хөлсний бодлого нь нэг хуульдаа захирагдаж явж байгаа ийм үед ийм байдлаар салбар салбарын онцлогийг тусгасан ийм хуулиуд органик ийм шинжтэй хуулиуд гарч ирж байгаа нь чухал ач холбогдолтой гэж харж байгаа энэ бол. За 3 мянга гаруй нийгмийн ажилтны асуудал яригдаж байгаагийн энэ нэг 980 орчим нь яг үндэс сургуулиуд дээр ажиллаж байгаа ийм нийгмийн ажилтан.

Тэгэхээр энэ дээр нэг жоохон асуудлууд гараад байгаа нь энэ санхүүгийн тооцоо гэж харж байна аа. Тэгэхээр санхүүгийн тооцоон дээр жишээлэх юм бол энэ нийгмийн ажилтныг энэ чинь зарим нь хувийн хэвшилд ажиллаж байгаа шүү дээ. Гэтэл яг нэг төрийн албанд байгаа шиг, үйлчилгээний албанд байгаа шиг нэг ингэж зохицуулах нь зохимжгүй юмнууд харагдаад байна. Түрүүнд Засгийн газрын юун дээр дурдагдаж байна. Жил бүр нэг 95-160 тэрбум төгрөг шинээр хэрэгтэй гээд ингээд яриад байна шүү дээ. Гэтэл хууль санаачлагч маань 0.8 тэрбум төгрөг хэрэгтэй. 800-гаад сая төгрөг хэрэгтэй гээд энэ нь зөрүү гараад байна. Тэгэхээр энэнтэй холбоотойгоор нэг асуулт асуух нь 1 дүгээрт Хүний хөгжил нийгмийн

бодлогын байнгын хороон дээр Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд ирж үг хэлэхдээ энэ хуулийн төслийг дэмжиж байна гээд хэлчихсэн. Өнөөдөр энэ чуулган дээр сонсож байгаа Сангийн сайд дэмжихгүй гээд Засгийн газрын байр суурийг хэлчихсэн. Энэ чинь ингэж болж байгаа юм уу? Энэ Засгийн газраас энд хариулах хүн хэн бэ? Байнгын хороон дээрээ дэмжинэ гэж хэлчээд чуулган дээр ороод ирэхээрээ дэмжихгүй гэдэг чинь юу болж байгаа юм? Төрийн чинь залгамж чанар хаа байна, юу гэсэн үг юм бэ? Энийг хариуцлагатай Засгийн газраас энэ дээрээ тайлбар тавихыг энэ танхимд тайлбар тавихыг бол 1 дүгээрт хүсэж байна.

Тэгээд энэ санхүүгийн тооцоо чинь өөрөө зөв үү буруу юу тиймээ. Хамгийн гол нь тэр мэргэжлийн холбоо байгуулахад 120 сая төгрөг байна уу бас зарцуулна гээд. Монгол Улсын энд тэнд байгаа 3 мянга гаруй нийгмийн ажилтныг бүгдийг нь цуглуулж ингээд нэг мэргэжлийн холбоо байгуулна гээд хуулийн төсөлдөө заагаад санхүүгийнхээ юун дээр 120 сая төгрөгийг хурал зохион байгуулна гээд тавьчихсан байх шиг байсан. Ингэж болох уу? Та бүхэн энийгээ тайлбарлаж, хүмүүс бас энэ чинь татвар төлөгчдийн юм байгаа учраас энэ дээр тайлбарлаж өгөөч ээ гэж хүсэж байна.

Ер нь бол яах вэ Мэргэжлийн холбооны тухай хууль гэж байгаад байгаа. Гэтэл энэ хууль маань өөрөө энэ дээрээ мэргэжлийн холбоогоо ингээд заагаад оруулчихсан. Тэгэхээр энэ хэрхэн энэ хууль хоорондын уялдаа хангагдаад байна вэ гэдгийг л асуухад бас Нийгмийн халамжийн тухай хууль гэж байна, Төрийн албаны тухай хууль байна, Үйлдвэрчний эвлэлийн хууль байна. Энэ хуулиудтай энэ хууль нь та бүхний боловсруулж орж ирж байгаа энэ хууль хэрхэн уялдаж байгаа вэ гэдгийг асуумаар байгаа юм. Яагаад гэвэл жишээлбэл энэ 37 дугаар зүйлийн нийгмийн ажилтны нийтлэг эрх үүрэг гэхээр л нийгмийн ажилтны эрх хууль ёсны сонирхлоо хамгаалуулахаар эвлэлдэн нэгдэх эрхтэй гээд энэ ингээд заачихсан. Энэ чинь Үйлдвэрчний эвлэлийн хууль дээрээ байдаг зүйл.

37.1.4 дээр төрийн байгууллага албан тушаалтны гаргасан хууль бус шийдвэрийг биелүүлэхээс татгалзах гээд. Энэ чинь төрийн албаны тухай хууль дээрээ байдаг зүйл. Энд тэнд байгаа хуулиудыг зүгээр авчраад ингээд тавьчихаар болохгүй шүү дээ. Тэгэхээр энэ хуулийг тэгж нүсэр хийхдээ биш яг амьдралд хэрэгтэй уялдуулах шаардлагатай өнөөдөр юу шаардаад байна, нийгмийн ажилтнууд энэ юман дээр нь илүү анхаарч хийгээсэй гэж хүссэндээ л ийм зүйлийг асуугаад байгаа гэдгийг ойлгоорой. Тэгээд ер нь бид цаашдаа энэ дээр бас...

С.Бямбацогт: Асуултаа гүйцээгээд асуучихъя. Наранбаяр гишүүний микрофон.

П.Наранбаяр: Баярлалаа. Тэгээд энэ мэргэжлийн холбооныхоо өмнө ёс зүйн хариуцлагаа хүлээнэ гэж заачихсан нийгмийн ажилтан. Ажил олгогчийнхоо өмнө мэргэжлийн үйл ажиллагааныхаа хариуцлагыг хүлээнэ гээд заачихсан. Тэгэхэд хариуцлагыг ингэж 2 салгаж болдог юм уу? Тэгвэл ажил олгогч ёс зүйг шаардах эрхгүй болчхож байна гэсэн үг үү? Одоо тэр сургууль дээр ажиллаж байгаа 978 нийгмийн ажилтнаас захирал нь ёс зүйн хариуцлагыг нь нэхэж чадахгүй л болчхоод байна гэсэн үг шүү дээ. Заавал одоо энэ мэргэжлийн холбоо л энийг чинь хариуцна гээд. Тэгэхээрээ иймэрхүү заалтууд байна аа. Энэ бүхнийг та бүхэн хэрхэн харж хооронд нь уялдуулж байгаа юм бэ? Эцэст нь хэлэхэд энэ хууль бол өөрөө ач холбогдолтой байна аа. Хуулийн бичилт бас болохгүй байна аа. Хууль дээр ингээд давхацчихсан, уялдуулах шаардлагатай юмнууд байна аа. Хасах юм зөндөө олон

байна. Яг амьдралд нь хэрэгтэй. Манайх нэг хууль бичилт нь нэг ийм байдаг. Тэрний бүрэн эрх гээд нэг бичээд, тэгээд л тэрний одоо юу гээд ингээд эрх мэдлийг хуваарилах юм их хийдэг. Гэтэл яг амьдралд хэрэгтэй энэ заалтуудыг нь л голломоор байгаад байгаа юм.

С.Бямбацогт: Засгийн газрын гишүүдийг танхимд урья. Засгийн газар нэгдсэн дүгнэлттэй, нэгдсэн байр суурьтай. Танхимын зарчмаар ажиллах ёстой. Тэгэхгүй гишүүдэд таалагдах гээд, хэн нэгэн хэсэг бүлэгт таалагдах гээд танхимын байр сууриа тийм үү зөрчсөн байр суурийг илэрхийлэх ёсгүй ээ.

Хууль бас уншиж танилцуулж өгье. Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 36.3. Засгийн газар Хууль тогтоомжийн тухай хуулийн 21.13-д заасны дагуу тухайн хуулийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ бусад хууль болон эрх зүйн бодлогод нийцээгүй, Хууль тогтоомжийн тухай хуулийн хуульд заасан шаардлагыг хангаагүй гэсэн дүгнэлт гаргасан бол уг дүгнэлтийг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн нэгдсэн хуралдаанд 10 минутад багтааж танилцуулна. Засгийн газрын дүгнэлттэй холбогдуулан гишүүн асуулт асууж, үг хэлэхгүй.

36.4 хуулийн төслийг баталснаар улсын төсвийн орлогын хэмжээ буурах, зарлагын хэмжээ нэмэгдэхээр байвал энэ тухай Засгийн газрын саналыг заавал сонсох бөгөөд хуралдаанд энэ хуулийн 31.2-т заасан Засгийн газрын гишүүн танилцуулна гэсэн байгаа. Үүний дагуу Сангийн сайд Мэндсайхан танилцуулсан. Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн сайд одоо ямар байр суурь илэрхийлсэн, энэ 2 сайд орж ирж байр сууриа тайлбарлааа. Чуулганы хуралдаанд дуудаж байна.

Хууль санаачлагч Отгоны Саранчулуун гишүүн Наранбаяр гишүүний асуултад хариулж байна.

О.Саранчулуун: Наранбаяр гишүүний асуултад хариулъя. Баярлалаа. Тантай бас би техник талаасаа болон энэ давхардал уялдааны талаар үнэхээр санал нэг байна. Гэхдээ бие даасан хууль хэрэгтэй байсан юм уу гэдэг асуулт дээр би хариулахыг хүсэж байна л даа. Бид нар тийм бие даасан хуульгүй яваад 20 гаруй жил болоод өнөөдөр бид нар халамжаас хөдөлмөрт гэдгээ баталж чадахгүй яваа нэг үр дагавар нь энэ байгаад байгаа. Нөгөө талдаа энэ бол нийгмийн ажилтны тухай хууль биш. Нийгмийн ажлын үйлчилгээг илүү тодорхой болгох, хил хязгаар, зааг хүрээг нь цэгцлэхтэй холбоотой зүйл заалтуудыг хуулийн төслөөр оруулаад байгаа. Нөгөө талд мэргэжлийн, нийгмийн ажлын мэргэжлийн одоо холбоо бол нийгмийн ажилтнуудаа сургадаг, төлөвшүүлдэг, мэргэжлийн удирдлагаар хангахад нь үздэг. Нөгөө талдаа ёс зүйн асуудлыг ч гэсэн хөнддөг ийм бүтэц байгаа.

Харин ажил олгогч хөдөлмөрийн тэр ажлын байрны тодорхойлолт дээрээ аль салбарт ажиллаж байгаагаас үл хамаараад нийгмийн ажлын мэргэжлийн үйлчилгээ хүргэх үүрэгтэй гэдгийг 1 дүгээрт тусгасан байгаа. Энэ дээр хэрвээ бид нар ажлын хэсэг байгуулагдсаны дараа тодорхойлолт болон зарчмын хувьд, техникийн хувьд засан сайжруулах зүйлээ яах юм бол засаж сайжруулъяаа. Мөн би ажлын хэсгээс нэмэлт хариултыг мэргэжлийн холбооны талаар болон бусад холбоодуудаас ялгаатай талаар манай ажлын хэсгээс нэмж хариулбал хариулж өгөөч.

С.Бямбацогт: Ажлын хэсэг 4 дүгээр микрофон хариулъя

Г.Оюунболд: Наранбаатар гишүүний асуултад хариулъя.

Хуульч Оюунболд байна. Наранбаяр уучлаарай. Нөгөө ер нь хууль тогтоомжийн яг энэ хуулийг боловсруулахад харьцуулсан судалгаа хийж үзсэн байгаа. Тэгээд нөгөө хуулийн үйлчлэлд Төрийн албаны хуулиар үүрэг хүлээдэггүй нийгмийн ажилтнууд байгаа. Өөрөөр хэлбэл олон улсын, хувийн ТББ-ын нийгмийн ажилтнуудад хүлээх нийтлэг үүргийг хуулийн төсөлд тодорхойлохоор бас ингэж харагдаж байгаа байх. Таны хэлсэнчлэн бусад хуулиудтай нийцүүлэх зүйл заалтыг илүү нягтлах энэ бол боломжтой байгаа. Мэргэжлийн холбооны хувьд болохоор одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Мэргэжлийн холбооны хууль нь нарийвчилсан зохицуулалт байхгүй, мэргэжлийн холбоог бүртгэхтэй холбоотой зарим зүйл заалтууд Үндсэн хуулийн цэцэд маргаан үүсгэх гэх мэтчилэн ийм нөгөө тодорхойлолт хэт ерөнхий зохицуулалт байгаа учраас мэргэжлийн холбооны чиг үүргүүд, гүйцэтгэх үйл ажиллагаа хариуцаж байгаа тодорхой үйл ажиллагаанууд төртэй хэрхэн ажиллах талаар ийм нарийвчилсан...

С.Бямбацогт: Пүрэвсүрэнгийн Наранбаяр гишүүн тодруулж асууя.

П.Наранбаяр: Баярлалаа. Тэгэхээр Саранчулуун гишүүний хариултад би дахин хэлэхэд би ийм бие даасан хууль байх ёстой гэж шууд дэмжиж байгаа шүү. Энийг ч огт асуугаагүй. Зүгээр энэ хуулиа чамбайруулах тал дээр л яриад байгаа юм. Тэгэхээр энэ зардлын тооцоо гээд бидэнд тараасан материал дээр ингээд байгаа юм л даа. Анхдагч хурал хийх зардал 120 сая, нийгмийн ажлын хурал зохион байгуулах гээд ингээд ийм тооцоо оруулж ирээд байгаа юмаа. Тэгэхээр энэ чинь нөгөө хэмнэлтийн хууль бусад хурал цуглаан зохион байгуулахад шууд одоо ингэж болдог юм уу? энийг бас асуугаад байгаа гэсэн үг шүү.

Дээр нь нэмээд бас энэ хууль чинь ингэж байгаа шүү дээ. Нийгмийн ажилтнууд нийгмийн тэр мэргэжлийн ажилтны мэргэжлийн холбоондоо заавал гишүүн болно, тэгээд заавал гишүүнчлэлийн татвараа хураалгана аа гээд. Гэтэл эд нар чинь бас үйлдвэрчний эвлэлд байж байдаг дээр нь нэмээд ингээд хураагаад цалин нь бага байгаа. Энэ заалтуудыг сонголттойгоор хийж болоогүй юм уу гэдэг бас ийм байгаа. Дээр нь тэр гишүүний татвар хураамжтай холбоотойгоор төсвөөс авах бас...

С.Бямбацогт: Хууль санаачлагч хариулъя. Дараад нь Мэндсайхан сайд хариултаа бэлдэж байгаарай.

О.Саранчулуун: Зардлын тооцоог задлаад үзэх юм бол программ хангамж хөгжүүлэлт 320 сая, сервер лиценз нь 180 сая, мэдээлэл цуглуулалт оруулалт 140, аюулгүй байдал 90 сая, сургалт 40, ашиглалт дэмжлэг 30, нийт ингээд 800 байгаа. Энэ бол нөгөө нэг мэдээллийн сантай холбоотой 4 салбарын мэдээлэл нийлүүлэгчийн харилцаатай холбоотой зардлыг ингэж тооцоолж оруулсан байгаа. 120 сая нь болохоор хурал зохион байгуулалт дээр 45 сая, оролцогчдын зардал 30, ёс зүйн зөвлөл байгуулах 20, мэдээлэл сурталчилгаа 15, тайлан нөөц 10, нийт 120 саяыг ингэж задалж оруулсан байгаа.

Бид нар өнөөдөр мэргэжлийн холбоог нь байгуулж өгөөд түр эхлүүлж өгөөд энэ дээрээ бид нар анхны хурлыг нь хийж өгөхийн тулд 3 мянга гаруй оролцогчдын оролцоог хангах нь өөрөө маш чухал эхлэл байгаа. Цаашдаа нийгмийн ажлын

холбоодын гишүүн гишүүдийн татвараар үйл ажиллагаа явуулна гэсэн ийм л тооцоолол байгаа. Энэ дээр бид нар нэмж дэлгэрүүлж задалж нөгөө...

С.Бямбацогт: Засгийн газрын байр суурийг илэрхийлэх ёстой. Засгийн газрын гишүүд өөр өөр байр суурьтай, зарим нь дэмжиж байгаа, зарим нь дэмжихгүй байгаа. Зардлын тооцоолол нь хэт өндөр гэж яригдаад байна гэдэг асуултуудыг гишүүд асууж байна аа. Энэ дээр Сангийн сайд Мэндсайхан хариулъя.

З.Мэндсайхан: Энэ Саранчулуун гишүүний боловсруулсан санаачилсан хууль дээр 2025 оны 8 дугаар сарын 20-ны өдөр Засгийн газраар хэлэлцээд дэмжихгүй байхаар шийдвэрлэж Хууль зүйн сайдад хариуг нь саналаа хүргүүлсэн юм байна лээ. Энэ дээр ерөнхийдөө одоо энэ хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой анхны хөрөнгө оруулалт нь 800 сая төгрөг болох юм байна аа. Цаашид жил бүр 95-160 тэрбум төгрөг төсвийг шаардахаар байна. Нийгмийн ажилтны орон тоог 3188 хүнээр нэмэгдүүлэхээр заасан байна гэж байгаа нь төсөвт хүндрэл учруулна аа. Учир нь одоо 2026 оны төсвийн тухай хууль дээр ямар нэгэн ийм зардлын нэмэлт суугдаагүй учраас энийг дэмжих боломжгүй ээ гэж Засгийн газраар хэлэлцэж шийдвэрлэсэн байгаа.

С.Бямбацогт: Батын Батбаатар гишүүн асуултаа асууя.

Б.Батбаатар: Ийм анхдагч хууль байх нь зүйтэй байх аа. Тэгээд хуулийн төслөөс зарим зүйлүүдийг асууя. Асуулттай холбоотой саналууд байгаад байгаа юм. Төслийн 4.1.3-д болохоор нийгмийн ажилтныг дээд боловсрол эзэмшсэн мэргэжилтэн гээд тодорхойлчихсон байдаг. Энэ нь заавал нийгмийн ажил мэргэжлээр төгссөн байхыг шаардаж байгаа юм уу? Эсвэл одоо бусад нийгмийн ухааны мэргэжилтэй хүнд давтан сургалтаар ажилтан болох юм уу гээд. Тэгээд нийгмийн ажилтан гэх нэр томъёондоо боловсролын түвшнээсээ гадна мэргэжлийн чиглэл, мэргэжлийн шаардлага, дадлага, ёс зүйн шалгуур тодорхой тусгах нь зүйтэй байх аа. Тэгэхгүй бол нөгөө мэргэжлийнх нь чанар нь сулрах салбар бүр дээр өөр өөрөөр тайлбарлагдаад байх эрсдэл үүсэж магадгүй гээд.

Хоёрт нь үйлчлүүлэгчийн зөвшөөрөл ба өөрөө шийдвэр гаргах эрх. Хуулийн зорилтод тэр бие даан шийдвэр гаргах чадварыг дэмжинэ гэж заасан атлаа нөгөө нийгмийн ажилтан төлөөлөл хэрэгжүүлэх, мэдээлэл бүртгэх байгууллагад шилжүүлэх үед үйлчлүүлэгчийн зөвшөөрлийг хэрхэн авах вэ гэдэг энэ зохицуулалт нь хангалттай байгаа юу, үгүй юү гэдэг дээр анхаармаар юм байна. Төлөөлөл төлөөлөл хэрэгжүүлэх эрхийн хязгаар гээд байж байгаа. Тэгэхлээр 14 дүгээр зүйлд нийгмийн ажилтан үйлчлүүлэгчдийн өмнөөс төлөөлөл хэрэгжүүлнэ гэж заасан. Гэхдээ энэ төлөөлж байгаа хууль зүйн итгэмжлэлтэй адилхан эрх үүсгэх юм уу эсвэл зөвхөн үйлчилгээ авахад дэмжлэг үзүүлэх чиглэлээрээ байх юм уу гэдгийг бас. Мэдээллийн санг мэргэжлийн холбоо удирдах нь зохистой юм уу, үгүй юм уу гээд. 45 дугаар зүйлд энэ нийгмийн ажилтны мэргэжлийн энэ холбоо чинь мэдээллийн сангийн үйл ажиллагааг улсын хэмжээнд удирдан зохион байгуулна гэхчхэн.

Тэгэхээр хувийн эмзэг мэдээлэл ихээр агуулагддаг ийм санг төрийн бус буюу мэргэжлийн холбоо удирдах энэ мэдээллийн нөгөө аюулгүй байдал, хувь хүний нууцын тухай болон төрийн хяналтын хувьд хэр зохистой байх юм бэ? Ингэж энийгээ өөрчлөх тал дээр хариуцах юм уу, үгүй юм уу? Харин зүгээр мэргэжлийн холбоо бол мэргэжлийн арга зүйн оролцогч байх талаасаа байвал тэр хувилбар нь илүү дээр болов уу гэж би бодоод байх юм. Тэгээд энэ нийгмийн ажлын үйлчилгээ

хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй хүн, хүчирхийллийн хохирогч, ахмад настан, амьдралын хүнд нөхцөлтэй иргэдийн эмзэг мэдээлэлтэй бас шууд холбоотой. Тэгэхлээр нөгөө төсвийн төслийн мэдээллийн сангийнхаа бүлэгт энэ мэдээллийн сан алдагдсан тохиолдолд яах вэ. Хэн яаж, ямар хариуцлага, хэзээ үүрэх юм бэ гэдэг асуудал.

Нийгмийн ажилтны улс төрийн эрхийг бүрэн хориглосон асуудлууд байж байгаа юм. Тэр нь хэд байлаа даа. 39.1.1-д байж байна. Нийгмийн ажилтанд улс төрийн үйл ажиллагаа явуулах улс төрийн намын гишүүнчлэлтэй байхыг хориглочихсон. Энэ хориг чинь нөгөө төрийн албан хаагч бол мэдээж ойлгомжтой. Тэгэхээр нөгөө төрийн бус байгууллага, хувиараа үйлчилгээ үзүүлж байгаа нийгмийн ажилтан яах юм? Үндсэн хуулиар олгогдсон нөгөө улс төрийн эрх тиймээ үйлчлүүлэгчийн эрх энэ асуудлууд дээр ямар байх юм. Үйлчилгээ үзүүлэх үедээ улс төрийн нөлөөлөл ашиглахгүй байх гэж засаж өөрчилбөл зөв болов уу гэж бодоод байна.

Нийгмийн ажилтны холбоо чинь өөрөө бүртгэл хөтлөх, сургалт зохион байгуулах эд нар гээд ингээд ёс зүйн хариуцлага хүлээлгэх, хянах, шийтгэх гээд ингээд энэ олон стандарт тогтоох эд нар олон эрхүүдийг ингээд зэрэгцүүлэн төвлөрүүлчих нь ашиг сонирхлын зөрчил үүсэхгүй юу? Энэ юунууд чинь нэг чиг үүргээ дотор нь жоохон салгах барих зүйл дээр нь анхаарвал зөв болов уу гэж бодож. 33 дугаар зүйлдээ болохоор гомдлыг холбооны ажлын алба хүлээн авч хорооныхоо гишүүдэд хуваарилж улмаар хороо нь өөрөө шийдвэрлэхээр байгаа. Тэгэхээр үйлчлүүлэгч нь үйлчилгээ үзүүлсэн байгууллага нийгмийн ажилтай холбоонд ямар нэг тийм нэг бүтэцтэй холбоотой маргаан гарвал хараат бусаар шийдвэрлэх тийм баталгаа байна уу, үгүй юү гэдэг дээр нь бас анхаарч үүн дээр бас хэлэлцээд эхэлбэл зарчмын зөрүүтэй саналуудыг өгнө өө гэсэн ийм бодол.

С.Бямбацогт: Батбаатар гишүүн асуултаа гүйцээгээд асуучихъя.

Б.Батбаатар: 23.2.2-т нь байж байсан. Нийгмийн ажилтнууд нь мэргэжлийн хариуцлагын даатгалтай байх тийм шаардлагыг тавьчихсан байгаа. Тэгэхээр Монголд одоо яг ийм төрлийн даатгалын бүтээгдэхүүн бэлэн байгаа юм уу? Хуулийн хэрэгжилтэд энэ чинь өөрөө гацаа болчих юм биш биз дээ? Мэргэжлийн даатгал гээд тавьчаад байдаг. Тэгээд тэр төсөлдөө боловсрол, эрүүл мэнд, шүүхийн шийдвэр, нийгмийн хамгааллын салбарт нийгмийн ажил хэрэгжинэ гэж заасан ч гэсэн тухайн салбаруудын нийгмийн ажилтны удирдлага, тайлагнал, төсөв арга зүйгээ хэн нь нэгтгэх юм.

37.1.4-д нийгмийн ажилтан төрийн байгууллага албан тушаалтны нөгөө хууль бус шийдвэрийг биелүүлэхээс татгалзана гэхихсэн байгаа юм. Харин хувийн байгууллага, сургууль, эмнэлэг, асрамжийн газар зэрэгт ажил олгогчийн хууль бус үүрэг даалгавраас татгалзах хамгаалалт туссан зүйл харагдаж өгөхгүй байгаад байна. Эд нарт.

С.Бямбацогт: Хууль санаачлагч Отгоны Саранчулуун гишүүн хариульъя.

О.Саранчулуун: Батбаатар гишүүний асуултад хариульъя. Баярлалаа.

Нэгдүгээрт ер нь мэргэжлийн холбоотой холбоотой зохицуулалт дээр давтан сургалт, мэргэжлийн чадваржуулалт угаасаа шилжилтийн хуулийг шилжилтийн

зохицуулалтаар тусгасан байгаа. Тэгж сургаж байж одоо байгаа 60 хувь гаруй яг бакалавр нь өөр чиглэлээр сурсан нийгмийн ажлын орон тоон дээр байгаа ажилтнуудаа сургах нь өөрөө мэргэжлийн холбооны үүрэг рүү чиглүүлж өгч байгаа гэсэн үг. Тэгэхгүй бол бид нар анхнаасаа ийм мэргэжлийн хүн байна гээд шаардчих юм бол одоо дутагдалтай байгаа дээрээ нэмээд дахиад хүний нөөцийн дутагдалд орох ийм асуудал гараад байгаа гэсэн үг.

Өөрийн шийдвэр гаргах эрх буюу төлөөлөх энэ эрх гэдэг дээр өөрийгөө илэрхийлэх чадамжгүй буюу асран хамгаалагч юм уу ямар нэгэн байдлаар өөрийгөө илэрхийлэх чадамжгүй хүмүүс байдаг. Тэрэн дээр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс ч байж болно. Энэ дээр нийгмийн ажилтнууд олон улсад бол төлөөлөн ажиллах, ялангуяа хууль шүүхийн процесс дээр хамт байлцдаг ийм туршлага байдаг юмаа. Тэгээд энэ зарчим руу бид нар чиглэж байгаа учраас энийг тусгаж зохицуулсан байгаа гэсэн үг. Тэгэхээр нийгмийн ажилтан өөрөө одоо хувь хүнд чиглэсэн, гэр бүлд чиглэсэн үйлчилгээ үзүүлэхдээ зөвшөөрөл авдаг байгаа зөвшөөрөл. Нууцыг хадгалах, тэр тухайн үед ямар үед нууцыг нь ямар үед ашиглах вэ, ямар үед холбон зуучлах вэ гэдэг дээр зөвшөөрөл авдаг ийм мэргэжлийн процесс болдог.

3 дахь асуулт нь мэдээллийн сангийн тухай асууж байна. Мэдээллийн сан бол одоо байгаа нийгмийн сэтгэл, нийгмийн сэтгэл зүйн, энэ нийгмийн эрүүл мэндийн үйлчилгээнүүдийн өөр өөр салбарт цуглуулагдаж байгаа мэдээллүүдийг нэгтгэх, хоорондын уялдаа холбоог хангах ийм бүтцийн асуудлыг ярьж байгаа. Маш их өгөгдлийг бид нар 4-5 салбарын 20-30 бараг асуумжаар авдаг ийм мэдээлэл мөртөө хоорондоо уялдаа холбоо багатай учраас 4 салбарын төрийн байгууллагууд өөрсдөө мэдээлэл нийлүүлэгчийн статустайгаар тийшээгээ мэдээллээ оруулдаг ийм бүтцийг угсрах зорилготой гэсэн үг. Тэгэхээр энэ дээр бол хувь хүний эмзэг мэдээллийг бүх нийгмийн ажилтан ч юм уу ямар нэгэн гишүүн ороод авдаг ийм бүтцийг энэ мэдээллийн сан дээр зураагүй байгаа. Гэхдээ энэ дээр би бас нэмэлт хариултыг ажлын хэсгээсээ хариулбал хариулж өгөөч гэж хүсэж байна.

Нийгмийн ажил ба улс төрийн эрхийн заалтыг бид нар эргэж харъя. Санаачлагч гишүүд болон ажлын хэсгийн гишүүдээрээ бид нар эргэж харж бас сайжруулах, эргэж харах хэрэгтэй гэж бодож байна. Мэргэжлийн холбоо өөрөө Ёс зүйн хороотой. Нийгмийн ажил өөрөө хүний хамгийн эмзэг хүнд өөрийгөө хамгаалах чадваргүй ч юм уу хамгийн эмзэг ийм бүлгийн хүн амд хүрдэг үйлчилгээ учраас ёс зүйн шаардлага нэлээн өндөр тавих хэрэгтэй байдаг. Хүний хувийн нууц. Тэгэхээр энэнтэй холбоотой асуудлыг олон улсад мэргэжлийн холбоод зохицуулдаг бүтэцтэй учраас энийг энэ хуулийн бүтцэд оруулж өгсөн байгаа юмаа. Тэгээд сонгуулиар тэрийгээ шалгаруулдаг, холбоо нь өөрөө бас дотроо дэд бүтцүүдтэй. Сургалтын хэсэг, ёс зүйн хэсэг гээд ингээд байхаар зохицуулж байгаа. Би минут хүрэхгүй байгаа учраас ажлын албанаасаа нэмэлт юу нэмэлт хариултуудыг хүсье. Ажлын албанаас.

С.Бямбацогт: 4 дүгээр микрофон ажлын хэсэг хариулъя.

Г.Оюунболд: Батбаатар гишүүний асуултад хариулъя. Хуульч Оюунболд байна. Бид нар мэргэжлийн холбооны хувьд хараат бус байх зохицуулалтуудыг яах вэ хуулийн төсөл дээр угаасаа мэргэжлийн холбоонд төрийн үйл ажиллагаанаас ангид байхын тулд хараат бусаар байгуулагддаг байгаа. Одоогийн байдлаар тодорхой нийтийн эрх зүйн статустай мэргэжлийн холбоодууд ажиллаж байгаа. Тэрний үйл ажиллагаа нь дотооддоо хараат бус байх нь бол тухайн хорооны өөрийн

хөгжлийн асуудлаас шалтгаалдаг. Тэрэн дээр илүү анхаарал тавих шаардлагатай байх. Таны хэлж байгаачлан улс төрийн эрхийг хязгаарлаж байгаа холбоотой зохицуулалтуудыг би бас эргэж харах боломжтой байгаа. Яах вэ ер нь бол дэлхий дахинд нөгөө мэргэжлийн үйлчилгээ үзүүлдэг одоо хуульч ч юм уу тиймээ сэтгэл зүйч ч юм уу эмч ийм улсууд дээр зарим тохиолдолд улс төрийн эрхийн хязгаарлалтууд тавигддаг юм билээ. Тийм учраас хуулийн төсөл дээр харьцуулсан судалгаа хийгээд энэ байдлыг томъёолчихсон байгаа. Шаардлагатай бол ажлын хэсэг дээр цаашид ярих бололцоотой байна аа. Баярлалаа.

С.Бямбацогт: Баярлалаа. Хүрэлбаатарын Булгантуяа гишүүн асуултаа асууя.

Х.Булгантуяа: Саранчулуун гишүүн ба хамт өргөн мэдүүлсэн гишүүддээ анхдагч бас энэ хуулийг Улсын Их Хурлаар оруулж бэлтгэн хэлэлцүүлж байгаад баяр хүргэе. Ер нь манай улс нийгмийн хамгааллын асуудлыг нэг л хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбар халамж тараах төдийхнөөр шийдэх юм шиг боддог. Нийгмийн халамжийн шинэ хуулийг Улсын Их Хуралд өргөн барихаар Хөдөлмөр нийгмийн хамгааллын Гэр бүл, нийгмийн хамгааллын яам бас ажиллаж байгаа. Энэ хууль дээр ч гэсэндээ халамжаас илүүтэйгээр нийгмийн үйлчилгээнүүдийг төрөөс болон төрийн бус байгууллагуудтай хамтран илүү их олгодог байж байж иргэдийг халамжаас хөдөлмөрт шилжүүлэх юмаа гэж ийм концепцтойгоор явж байгаа.

Тэгэхээр энэ хууль ялангуяа манай нийгмийн ажилтнууд бол нэн чухал юм. Тэгээд би энэ хуулийг төсвийн хувьд боломжгүй гээд Засгийн газраас дэмжээгүй гэдгийг ойлгохгүй байна. Энэ дээрээс ерөөсөө энэ мэдээллийн сан байгуулах, шинэ хуулиа сурталчлахтай холбоотой нэг жоохон зардал гарахаас өөр улсын төсвөөс нэмж гараад байх зардал бараг бага. Тэртээ тэргүй өнөөдөр эрүүл мэндийн салбар, шүүхийн шийдвэр, боловсрол, ингээд хүүхэд хамгаалал халамжийн нийгмийн хамгааллын салбарт гээд нийтдээ 3 мянга гаруй нийгмийн ажилтнууд ажиллаж байгаа. Түрүүн хэлсэнчлэн харин энэ нийгмийн ажилтнуудын маань хувьд хүндрэл бэрхшээл нь гэх юм бол өнөөдөр боловсролын салбарт ажиллаж байгаа нийгмийн ажилтан гэхэд тэр хүн ирээдүйнх нь карьерын зам нь их хүнд. Явсаар байгаад цаашаагаа нийгмийн ажилтан хүн сургуулийн захирал болж болох уу, үгүй юү?

Эрүүл мэндийн салбарын нийгмийн ажилтан гэхэд эрүүл мэндийн салбараас үйлчилгээ авч байгаа олон иргэдэд нийгмийн хамгааллын туслан дэмжих үйлчилгээнүүдийг үзүүлээд явж байгаа ч гэсэн тэр хүн ирээдүйд нийгмийн ажилтнаасаа илүү гарахааргүй юм шиг ийм болчихоод байдаг. Тэгэхээр дэлхийн энэ улс орнуудын жишиг нь болохоороо 1 дүгээрт ийм хуультай болж байж эрх зүйн байдлыг нь хангах.

Хоёрдугаарт бүүр цаашаагаа тэр битгий хэл мэргэжлийн шатлалтай болох. Ингээд цаашаагаа дээрээс нь нэмээд өөрийнхөө салбар дотроо ахин дэвших ийм боломж үүд хаалгыг нээхгүй бол ирээдүйд өнөөдөр нийгмийн ажилтан гэж 5 жил ажиллаад, 10 жил ажиллаад цаашаагаа нийгмийн ажилтнаас өөрөөр ахиж дэвших боломж бололцоо салбар дотор нь байхгүй бол залуу хүмүүс ажиллахгүй байна аа.

Манай хүүхэд хамгааллын салбарт гэхэд ХЭҮК-оос гаргасан тайлан дээр гарсан байна лээ. Нийт хүүхэд хамгааллын ажилтнуудын 50 орчим хувь нь 1-2 жил ажиллаад л ажлаа сольчихдог оо гэж. Тэгэхээр ийм байгаад байгаа учраас энэ нийгмийн ажилтны эрх зүйн байдлыг сайжруулах, хамгаалах хэрэгцээ шаардлага

байгаад байгаа юм. Дээрээс нь нэмээд бас нэг үүсээд байгаа нөхцөл байдал нь гэх юм бол нөгөө Соронзон захирлын Байгалаа Байгалаа гэдэг гээд байдаг шиг манай нийгмийн ажилтнуудаар ажлын байрны тодорхойлолт нь тодорхой биш байгаад байхаар маш их хэрэгтэй, хэрэггүй ажлуудыг тайлан мэдээллүүдийг нэгтгэдэг.

Тэгэхээр би Саранчулуун гишүүнээс 1 дүгээрт энэ ажлын байрны энэ салбар дээрээ ахиж дэвших боломж бололцоо Та энэ хуулийн судалгааг ингээд харахад ямархуу байна вэ?

Хоёрдугаарт дээрээс нь нэмээд мэдээллийн сангийн тухай оруулсан байна. Энэ ганц төсөв гарч улсын төсвөөс дэмжлэг хэрэгтэй байгаа нь энэ гэж хэлсэн. Хэд орчим төгрөгийн төсөв өөр үүнтэй холбоотой, энэ хуультай холбоотой ямар төсвүүд гарна гээд Засгийн газрын зүгээс дэмжихгүй гээд байгаа юм бэ?

Манай нийгмийн ажилтнууд цаашдаа ер нь ахиц дэвших боломж бололцоог бид нар хангахад юун дээр анхаарах ёстой юм бэ гэдэг энэ хэдэн асуултыг асуух гэсэн юм. Тэгээд дээрээс нь нэмээд бид нар ер нь нэг зөвхөн нэн шаардлагатай төсөл арга хэмжээн дээр л санхүүжүүлнэ гэсэн мөртөөсөө сая 2026 оны төсөв дээр 1.3 их наядын шинэ төсөл хөтөлбөрийг Улсын Их Хурал дээр, ажлын хэсэг дээр дэмжигдээд түүнээс нь бараг 400 орчим тэрбум төгрөг нь Үндэсний аудитын газраас зураг төсөвгүй Төсвийн тухай хууль зөрчсөн, дараа нь төсвийн ерөнхийлөн захирагч сайд нар нь ч гэсэн үүнийг аваад хэрэгжүүлэхэд их хүнд төсөл хөтөлбөрүүдийг баталсан шүү. Тэгэхээр яг хэрэгтэй хэрэггүй...

С.Бямбацогт: Хууль санаачлагч Отгоны Саранчулуун гишүүн хариулъя.

О.Саранчулуун: Булгантуяа гишүүнд баярлалаа. Асуултад хариулъя. Ажлын байрны ахиц дэвшлийг бид нар одоо ингэж яримаар байгаа юм. Нийгмийн ажлын хуультай болохын өмнө ба дараа гэдэг. Одоо хэрвээ өмнө бол өнөөдөр ямар байгаа гэхлээр дунджаар энэ ажлын байран дээр ажиллаж байгаа хүн 3 жил болоод ажлаасаа гарч байгаа. Тэгээд нийт ажиллаж байгаа орон тоон дээр ажиллаж байгаа нийгмийн ажилтнуудын 60 хувь нь мэргэжлээрээ ажиллаагүй байгаа. Энэ мэргэжлээр сурсан, заасан нийгмийн ажил гэж юу вэ гэдгийг заасан энэ оюутнууд төгсөөд ажлаа хийх гэхлээр ажил олгогч нар нь тэр хүмүүс нь яг тэр нөгөө Байгалаа Байгалаа гэдэг шиг л одоо янз бүрийн ажил дээр ингээд өөр өөр тодорхойлолтоор ажиллуулаад байгаа учраас энэ хүмүүс сонгохгүй байгаа юмаа.

Тэгэхээр энэ дээр карьерын хувьд өнөөдөр энэ ингээд зул бөхөж байна гэдэг шиг ийм байгаад байгаа мэргэжил байхгүй юу. Хэрвээ хуультай болчихоор энэ хуулиар гол нь юуг шийдэх гээд байгаа гэхлээр мэргэжлийн холбоог төр өөрөө байгуулж өгье. Яагаад төр өөрөө байгуулж 120 сая төгрөг гаргах гээд байгаа вэ гэхлээр өнөөдөр энэ хүмүүсийн гараар нийгмийн халамж хамгааллын тэр 400, 500 тэрбум төгрөг чинь явж байна шүү дээ, зарцуулагдаж байна шүү дээ. Тэгээд энийг илүү чанартай болгох юм бол халамжаас хөдөлмөрт нээрээ хүмүүс шилжинэ шүү дээ аягүй бол. Уг нь угаасаа л тийм тооцоолол бид нар гарч байгаа шүү дээ. Тэгэхээр ийм агуулгатай байгаа. Тэгэхээр ахиж дэвших боломжийн тухайд бол ийм байна.

Хоёрдугаарт нь мэдээллийн сангийн тооцоон дээр хүмүүс мэдээллийн сан дээр ингэж ойлгоод байх шиг байгаа юм. Нийгмийн ажлын хүмүүс ингээд өөрсдийн гэсэн мэдээллийн сантай байж магад, байх юм байна гэж ойлгогдсон байж магадгүй.

Энэ нь мэдээлэл нийлүүлэгч буюу төрийн 5 салбарын мэдээллийн халамж статистик гэр бүлийн яам, ЭМЯ, боловсролын яамны салбаруудын ажиллаж байгаа нийгмийн ажилтнуудын мэдээлэл үйлчилгээ мэдээллийн сангаар дамжуулан энд байгаа бүх өгөгдлийг илүү сайжруулах, цэгцлэх ийм тогтолцоог бид нар ярьж байгаа. Энийг бид нар 800 сая төгрөгөөр төсөвлөж ингэж тооцож байгаа байхгүй юу. Энүүний чинь цаана нөгөө хөгжүүлэлт зардал гээд түрүүн би баахан зардлуудыг ингээд үзсэн байгаа.

Тэгэхээр эхний ээлжид ямар ч байсан ингэж босгож авъя аа. Одоо байгаа нийгмийн ажилтнууд нь хороон дээр зөвхөн дата цуглуулж улсын статистикт мэдээлэл өгөх гэж байгаа зэрэг агуулгаар ингээд бид нар бараг төсөвт бараг тэрбумаасаа илүү зардлыг энэ судалгаанд зарцуулж байгаа шүү дээ. Өнөөдөр нэг айлд 4-5 өрх, 4-5 салбарын 20 гаруй маягт мэдээлэл нэг айлд өрхөөс авагдаж байгаа. Гэхдээ хоорондоо энэ их өгөгдлүүд хоорондоо ярилцдаггүй. Тэр айл сайжирсан юм уу, тэр амьдрал яаж байна, нөгөө эрсдэлтэй хүүхэд яаж байна гэдэг асуудал дээр байхгүй. Тэгээд энийг маш бага зардлаар цэгцлээд эхлүүлчихье. Гэхдээ Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаман дээр эхэлье гэдгийг гэр бүлийн яам салбарт байгаа хүмүүс бүгдээрээ ярилцаад өнөөдөр ийм төсвийг гаргасан.

Засгийн газрын өгсөн санал болохлоор өмнөх хуулийн энэ сайжруулалтаас өмнө буюу 106 тэрбум төгрөгийг зарцуулсан ийм тооцоо юм шүү нөхөд өө. Энийг бас та хэд ойлгооч ээ. Тэгээд хууль санаачлагчдаас нэмж хариулт өгөөч ээ гэж би хүсэж байна. Ариунзаяа гишүүнийг хууль санаачлагч учраас нэмээд энэ ахих дэвших боломжийн талаар бас еще хариулт, зардалтай холбоотой бас тайлбар нэмж хариулж өгөөч ээ гэж хүсэж байна.

С.Бямбацогт: Хууль санаачлагч Аюушийн Ариунзаяа гишүүн нэмж хариулъя.

А.Ариунзаяа: Нэмэлт хариулт учраас нэгхэн минутад багтаж хариулах гээд байна. Энэ мэдээллийн сантай холбоотой санхүүжилтийг төр хариуцна гэсэн жижигхэн бүлэг байгаад байгаа юм. Тэгээд энэ бол төр өөрөө энэ мэдээллийн сангаа өөрөө үнэ төлбөргүй ч хийгээд өгсөн ч болно. Энэ зүгээр хууль санаачлагчийн л гаргасан тооцоолол байхгүй юу. Тэрнээс биш хууль дээр мөнгө төгрөг заасан нэг ч үг өгүүлбэр байхгүй ээ. Тэгэхээр Лайсенс цэг мн буюу зөвшөөрөл мн дээр бид нар Зөвшөөрлийн хууль дээр ажиллаж байгаа. Тэнд мэдээллийн санг нь бол Лайсенс мн дээр Өмгөөлөгчдийн холбоо, Хуульчдын холбооны мэдээллийн санг байршуулах гэж байгаа байхгүй юу. Үгүй энэ хэлбэрээрээ байж болно шүү дээ. Үнэ төлбөргүй төр өөрөө хариуцаж байж болно.

Хамгийн гол нь нийгмийн ажил гэдэг чинь өөрөө мэргэжил юм шүү. Бусад мэргэжилтэй яг адилхан холбоотой байгаад яг адилхан мэргэжлийн хүмүүсийг яг энэ ажил дээр нь ажиллуулаач ээ гэдэг ийм л одоо учир зорилготой хууль байгаа юмаа. Орон тоо ердөөсөө нэмэхгүй. Орон тоо нэмэгдүүлж байгаа...

С.Бямбацогт: Булгантуяа гишүүн тодруулж асууя.

Х.Булгантуяа: Тэгэхээр хууль санаачлагчдаас нэмж тодруулж асуухад мэдээллийн сан дээр нийгмийн ажилтнуудаас мэдээлэл үйлчилгээ авч байгаа иргэдийн мэдээлэл байршина гэж ойлгож байгаа зөв үү? тэгээд мэдээллийн сангийн аюулгүй байдлыг хэрхэн яаж хангах вэ? Яагаад гэвэл энэ дээр нийгмийн ажилтнууд

зарим нь төрийнх байгаа. ТББ-д ажиллаж байгаа, ОУБ-д ажиллаж байгаа нийгмийн ажилтнууд ч гэсэн байна гэсэн үг ээ. Тэгэхээр үүнтэй холбоотой энэ аюулгүй байдлыг хэрхэн яаж хангах вэ? бид нар шинэ хүүхэд хамгааллын хуулиар бас хүүхэд хамгааллын цахим бүртгэлийн системийг бий болгоно гэж оруулж өгсөн. Тэрүүн дээр хүүхэд хамгааллын нийгмийн ажилтан, өрхийн эрүүл мэнд, цагдаа гээд ингээд энэ хүмүүс энэ хүүхдүүдийн тухай бүх мэдээллүүдийг оруулах юм бол ялангуяа эрсдэлд байгаа хүүхдүүд маш их нүүдэг. Хөдөө орон нутгаас хот руу, хотын нэг хорооноос нөгөө хороо руу гээд. Тэгэхэд бид нар энэ бүх мэдээллүүд бид нарт ил тод нээлттэй байх ийм хамгааллын ажилтнуудад ийм орон зайг үүсгэхээр хуульчилсан. Тэгэхээр яг үүнтэй адилхан гэж ойлгож байгаа зөв үү.

С.Бямбацогт: Ажлын хэсэг 4 дүгээр микрофон хариулъя.

Л.Долгор: Булгантуяа гишүүний асуултад хариулъя. Эрүүл мэндийн нийгмийн ажилтан Долгор. Таны хэлж байгаа яг ойлголт зөв байна. Жишээ нь ЭХЭМҮТ дээр өсвөр насны хүүхэд гэмтсэн байгаад ирэх юм бол бид нар гэмтлийн учир шалтгааныг нь тодруулахтай холбоотой нөхцөл байдлын үнэлгээг эрүүл мэндийн нийгмийн ажилтан хийж байгаа. Тэндээсээ хэрвээ хүчирхийлэлтэй холбоотой кэйс байх юм бол 108 руу мэдэгдээд цагдаа болон дараагийн шатын байгууллагууд тухайн хүүхэд маань сургуульд сурдаг учраас боловсролын байгууллагын нийгмийн ажилтан гэх мэтчилэнгээр энэ кэйс ингээд урт хугацаанд үргэлжилнэ. Тэгээд эмнэлгээс гарсны дараа хорооны нийгмийн ажилтан гэх мэтчилэнгээр ингээд нэг кэйс ингээд урт олон байгууллагын оролцоотойгоор удаан үргэлжилдэг гэсэн үг. Тэгэхээр энийг бол хандах эрхийн хязгаарлалтаар бол мэдээллийн нууцлалыг хангах боломжтой. Энийг нь төрд байгаа төрийн Хур систем, И-халамж гэх мэт бүх системүүдийг уялдуулах замаар шийдэх боломжтой гэдгийг Цахим хөгжлийн яамныхантай ярилцсан. Тэгэхээр энийг хууль дээрээ нарийвчилж илүү тодорхой болгох боломжтой.

С.Бямбацогт: Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн асуултаа асууя. За уучлаарай. Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Чинбатын Ундрамын урилгаар Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 11-ийн Б ангийн багш сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа Төрийн ордонтой танилцаж байна аа. Энэ хавар Улсын Их Хурлын чуулганаар хүүхэд багачуудынхаа эрүүл мэнд, амь нас, аюулгүй байдалд зориулж Улсын Их Хурал тамхидалтын эсрэг тамхинд хяналт тавих тухай хууль мөн дугуй скүүтер сурон, мопед унахыг зохицуулах хууль мөн сургуулийн орчинд эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах, хүүхдүүдийн дээрэлхэлтийг хязгаарлах ийм хуулиудыг хэлэлцэж байгаа. Энэ хуулиуд дээр та бүхэн саналаа өгөх боломжтой шүү гэдгийг бас хэлье. Ингээд нийт сурагчид хүүхэд багачууддаа сурлагын өндөр амжилт, амьдралд нь эрүүл энх, аз жаргал сайн сайхан бүхнийг Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс хүргэе ээ.

Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн асуултаа асууя.

Х.Баасанжаргал: Харамсалтай нь Засгийн газраас ирсэн бичгийг хараад жоохон харамсаж байна. Юу гэвэл энийг бид нар энэ хуулийг энэ тогтолцоог тэр чигээр нь бид нар зардал гэж харж байна аа л гэсэн үг. Гэтэл энэ чинь өөрөө зардал биш хөрөнгө оруулалт гэдгийг ерөөсөө бид нар олж харахгүй байна аа гэсэн үг. Нөгөө талаараа бид нар үе тэнгийн дээрэлхэлт ч гэдэг юм уу хүүхэдтэй холбоотой хүнд онц ноцтой гэмт хэрэг гарах ч гэдэг юм уу энэ болгон дээр бүгдээрээ

нийгмээрээ шуугиад өнгөрдөг. Гэтэл үүний чинь цаана төрийг төлөөлөөд ажиллах ёстой тогтолцооны анхан шатан дээр очоод ажиллах хамгийн гол механизм өөрөө энэ нийгмийн ажил байгаад байгаа юм. Энэ нийгмийн ажлыг өөрийг нь бие дааж, тусдаа мэргэжлийн үйлчилгээ рүү шилжүүлэх ийм шилжилтийн маш чухал хууль гэж би бол хувьдаа харж байгаа юм. Тэгээд үүнийг манай гишүүд ойлгоод дээрээс нь Засгийн газар үүнийг дараагийн 5 жил, дараагийн 10 жил гарах маш том Засгийн газраас гарах нийгмийн халамжийн зардлыг бууруулах хөрөнгө оруулалт гэж хараач ээ л гэж хүсэх гээд байгаа юм.

Тэгээд гишүүдийг энэ хуулийг дэмжихийг хүсье. Асуултын тухайд бол асуулт саналаа бол нэг хэлчихье. Юу гэвэл ялангуяа энэ иргэний мэдээллийн аюулгүй байдал өөрөө төр дээр байх ёстой. Үйлчилгээ үзүүлж байгаа нийгмийн үйлчилгээ авч байгаа энэ хүний хувийн хамгийн эмзэг мэдээллүүд энд байна. Тэгэхээр энэ үйлчилгээ өөрөө төр дээр байх ёстой. Аюулгүй байдлыг төр өөрөө бүрэн хариуцах ёстой. Энэ зардал өөрөө төрийнх нь өөрийнх нь зардал байх ёстой. Тийм учраас энэ мэдээллийн аюулгүй байдал гээд түрүүн Булгантуяа гишүүн асуусан. Тэгээд энэ дээр ялангуяа аюулгүй байдлын хувьд хүний хувь хүний эмзэг мэдээлэлтэй холбоотой асуудлын тухайд, дээрээс нь нийгмийн ажилтан өөрөө ямар баталгаа, ямар хариуцлага хүлээх вэ үүнийг задалсан тохиолдолд. Санаатай болон болгоомжгүй задалсан тохиолдолд ямар хариуцлага хүлээхээр орж ирж байгаа вэ. Энийг аягүй тодорхой хэлж өгөөч ээ гэж байгаа юм.

Хоёрдугаарт нийгмийн ажил өөрөө бие даасан холбоо, мэргэжлийн холбоо болоод ингээд Хуульчдын холбоо гэдэг шиг ингэж хөгжих нөхцөл суурь хэр бүрдсэн гэж харж байгаа вэ? Хуульчдын холбооны хувьд энэ бие даасан холбоогоо байгуулах, холбооны удирдлагаа сонгох, холбоо өөрөө эргээд өөрийнхөө татвараар санхүүжээд явах гээд энэ процесс бол бас нэлээн багагүй хугацаа бол зарцуулсан. Тэндээс ямар сургамж авч энэ хууль дээр тусгасан бэ гэсэн ийм 2 дахь асуулт байна.

Тэгээд Хуульчдын холбоо бол одоо төрөөс ямар ч санхүүжилт авдаггүй цэвэр хуульчид өөрсдөө сард 20 мянган төгрөгийн татвар төлөөд ингээд саяхан өөрсдийн гэсэн байртай болсон байгаа юм. Өөрсдөө лицензийнхээ хариуцлагыг хүлээдэг, ингээд хуульчийн ёс зүйн асуудлыг өөрөө тэндээ бас шийддэг ийм бие даасан тогтолцоо болж хөгжиж яваа. Тэгэхээр цаашид ганцхан нийгмийн ажил гэхгүй өөр бусад эмчийн ч гэдэг юм уу, энэ мэргэжлийн холбоодуудыг хөгжүүлэх өөрсдөө бие даах лицензийн хариуцлагын асуудал бол энэ хуулиар шийдэгдэх боломжтой болно оо гэж харж байгаа. 2 дахь асуулт ийм 2 асуулт байна аа.

С.Бямбацогт: Ажлын хэсэг хариульъя. 4 дүгээр микрофон.

Г.Оюунболд: Баасанжаргал гишүүний асуултад хариульъя аа.

Мэдээллийн аюулгүй байдал дээр ихээхэн анхаараад ажлын хэсэг дээр байнгын хорооны хурлын өмнө Цахим хөгжлийн яам, Е-Монголиа академитай бид уулзаж ярилцсан байгаа. Тэгэхээр нөгөө хувь хүний эмзэг мэдээлэл Хур дан системээр эзэмшиж нөгөө эзэмшигчийн өөрийн зөвшөөрлөөр явдаг ийм процесс байгаа. Тэгэхээр энэ нөгөө хувь хүний эмзэг мэдээллийг төрд нөгөө хөдөлмөр халамж үйлчилгээний газар юм уу эсвэл ЭМЯ-нд байдгаараа байгаад хоорондоо солилцох процесс хандах эрхийн хязгаарлалтаар энийг илүү тодруулах шаардлагатай юм байна аа. Энд хуулийн энэ төслийн энэ заалтыг нарийвчилж

аюулгүй байдлын зохицуулалтыг нэмж оруулах боломжтой байгаа гэдэг тодруулга өгмөөр байна.

Мэргэжлийн холбооны хувьд бид Хуульчдын холбооны туршлага дагах хуулийн төслүүдийг бас нэлээд судалсан. Одоо байгаа сургуулийн нийгмийн ажилтны холбоо болон бусад нийгмийн ажилтны холбоодын төлөөлөл тэдгээрийн гүйцэтгэх удирдлагуудтай уулзалт хэд хэдэн удаа зохион байгуулж тэдгээр холбоод нь энэ мэргэжлийн холбооныхоо нэг хорооны чиг үүргийг гүйцэтгэх байдлаар дэмжин ажиллах бололцоотой. Дээрээс нь хуулийн төсөл дээрээ санал солилцох процессуудыг өнгөрсөн нэг жилийн хугацаанд хийсэн байгаа. Тэгэхээр мэдээж хуулийн нөгөө хэлэлцүүлэх явцад бэлтгэл ажлыг зайлшгүй хангах шилжилтийн үеийн зохицуулалтуудыг илүү боловсронгуй болгох ийм шаардлага байгаа. Баярлалаа.

С.Бямбацогт: Нэмээд хариулчихъя. 4 дүгээр микрофон ажлын хэсэг.

Э.Баттөр: Сайн байцгаана уу? Төрийн мэдээлэл солилцооны Хур системээр дамжуулж энэхүү мэдээллийн сангийн мэдээллийг төрөлжсөн мэдээллийн сан болгож дамжуулна. Тэгэхэд Хур системээр дамжуулахад болохоороо иргэний баталгаажуулалтын суваг болон үйлчилгээний ажилтны баталгаажуулалтын сувгийг бол баталгаажуулах боломжийг бүрэн бүрдүүлсэн байдаг. Тэгээд тухайн системд бол ямар хүн ямар мэдээллийг авав гэдгийг бол бүх бүртгэл логик бүртгэлүүдэд бол хийгдэнэ. Тэгээд түүнээс гадна тухайн мэдээллээ бол мэдээллийн эзэмшигчид болохоороо тухайн мэдээллийг хаанаас, хэн, хэзээ, хэрхэн яаж дуудсан тухай юу бол E-Монгол аппликэйшн дээр бол үндэсний цахим шуудангаар бол хүрч байгаа. Тэр үүргээр бол давхар хяналт нь бол явах боломжтой. Үндэсний дата төвийн Их өгөгдөл систем нэгтгэлийн газрын дарга Баттөр.

С.Бямбацогт: Гишүүд асуулт асууж. Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн тодруулъя.

Х.Баасанжаргал: Би нийгмийн ажилтантай холбогдоод үйлчилгээ авсан тохиолдолд тэр бүртгэлд орчих нь байна шүү дээ. Дараа нь миний тэр дата мэдээлэлтэй хэн танилцаад, хэн татаад, хэн ямар зорилгоор аваад байна вэ гэдэг нь надад өөрт маань дараа нь харагдах уу? Тэгээд хариуцлагын асуудал 2 дээр.

С.Бямбацогт: Ажлын хэсэг 4 дүгээр микрофон.

Э.Баттөр: E-Монгол аппликэйшн дээр байгаа Үндэсний цахим шуудан гэж цэс байгаа. Тэрэн дээр бол ямар мэдээлэлтэй хэн, хэзээ, хэрхэн яаж танилцсан, ямар системээр танилцсан тухай бол бүх танилцуулга лог мэдээлэл хүрч байдаг. Тэрүүгээр бол иргэн хяналтаа бүрэн тавиад явах боломжтой.

С.Бямбацогт: Гишүүд хуулийн төсөлтэй холбогдуулан асуулт асууж, хариулт авч дууслаа. Одоо хуулийн төслүүдийн талаар байнгын хорооноос гаргасан санал дүгнэлтийг дэмжсэн эсрэг байр суурьтай намын бүлгийг төлөөлж болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу гишүүд дэмжсэн дэмжээгүй байр сууриа илэрхийлж үг хэлнэ ээ. Нэр өгсөн дарааллын дагуу энэ чинь хууль санаачлагч үг хэлэхгүй биз дээ. Дэг дээр тийм дэг байгаа билүү? За Аюушийн Ариунзаяа гишүүн 1 дүгээр микрофон. Дараад нь Сархадын Зулпхар гишүүн.

А.Ариунзаяа: Хууль санаачлагчийн хувьд бас гишүүдээ дэмжиж үг хэлэхийг одоо хүсэж, уриалж үг хэлэх цаг авсан юмаа. Намайг 2020 онд сайдаар томилогдож байхад яг энэ хуулийн төсөл бас яригдаж байсан. Тэгээд тэр цагаас хойш өдий 6 жил өнгөрсөн байна. Хуулийн төслийг Засгийн газар луу санал авахаар 2 бүүр жилийн өмнө явуулж байсан. Тэгээд 2025 оны 8 сар, 8, 9 сард л одоо бас Засгийн газрын зүгээс саналаа өгөхдөө тооцооллыг дутуу юм уу буруу харж тухайн үеийн тооцооллыг бид нар бас зассан байгаа. Ямар нэгэн орон тоо нэмэхгүй. Одоо хуулийн төсөлд Наранбаяр гишүүний хэлсэнчлэн ямар нэгэн асуусан асуугаад байсан шүү дээ ийм зардал байна аа гэж. Хуулийн төсөл дээр ямар ч мөнгөтэй холбоотой үг өгүүлбэр байхгүй. Тэгэхээр энэ дээр бол гишүүд маань санаа зоволтгүй. Бид яг одоо нийгмийн ажилтан, нийгмийн ажил гэдгийг яг ажил мэргэжлийнх нь хувьд бас онцолж ийм хуулийг оруулж байгаа юмаа.

Монгол Улсад ажил мэргэжлийг үндэсний ажил мэргэжлийн ангилал ба тодорхойлолт гэсэн ийм хүрээгээр нь тодорхойлдог. Манай улсад 4229 ажил мэргэжил бүртгэлтэй байдаг. 65 их сургуульд 2300 хөтөлбөрөөр дамжуулж сургалтуудыг явуулдаг аа. Тэгээд эдгээрийн яг нэг нь бол яг энэ нийгмийн ажил нийгмийн ажилтны мэргэжил байдаг юмаа. Тэгэхээр шүдний эмнэлэгт очоод эмч байхгүйгээр өөр мэргэжлийн хүн таныг үзвэл яах вэ. Өмгөөлөгч дээр очоод хуульчаар сураагүй өмгөөллийн эрхгүй байвал яах вэ гэдэгтэй нэгэн адил нийгмийн ажил үйлчилгээг бол яг нийгмийн мэргэжлийн хүн уг нь үзүүлэх юм бол яг одоо цогц сайн үйлчилгээ авах юмаа.

Монгол Улсад ер нь бол 1.3 сая хүүхэдтэй. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд 14, 15 орчим мянган хүүхэд байгаа. 108 утасны дуудлагын төвд бол 2024 оны хувьд 101 мянган дуудлага ирсэн. Хүчирхийлэлд өртсөн 16 мянган хүүхэд шуурхай тусламжийн үйлчилгээнд 36 мянган хүүхэд, хамгаалах нөхөн сэргээх үйлчилгээнд 16, 17 мянга, асрамжийн төвд 895 хүүхэд, түр хамгаалах байраар үйлчлүүлсэн 2289 хүүхэд, хараа хяналтгүй 240 хүүхэд, хөдөлмөр эрхэлж байгаа 430 хүүхэд, унаач хүүхэд 16 мянган хүүхэд яг Монгол Улсад 2024 оны тоон мэдээллээр байгаа юм.

Энэ унаач хүүхэд гэдэгтэй холбоотойгоор ер нь бол Дээд шүүхийн шийдвэрээр 2019 онд хаврын уралдааныг хорьсон байдаг аа. Тэгээд Үндсэн хуулиараа Дээд шүүхийн шийдвэр чинь эцсийнх байдаг биз дээ. Дээд шүүхийн шийдвэрийг хүн болгон мөрдөх ёстой байдаг биз дээ. Энэ ердөөсөө хаврын уралдааныг Баасанжаргал л эсэргүүцээд байгаа ийм асуудал огт биш. Энэ дээр бол бид нар Дээд шүүхийн шийдвэр гарсан л бол Дээд шүүхийн шийдвэрийг ямар ч асуудлаар бид нар биелүүлдэг байх ёстой гэдгийг эргээд энэ Үндсэн хуулиа санах ёстой.

Ахмад настны тоо 406 мянган ахмад настан байна. Нийт хүн амын 12 орчим хувийг эзэлж байгаа. Ганц бие ахмад настан 40 орчим мянга, хөгжлийн бэрхшээлтэй 12 мянган ахмад настан, ахмад настануудын 85.5 хувь нь нэг болон түүнээс дээш төрлийн өвчнөөр өвдсөн, эмийн хөнгөлөлт, эрүүл мэндийн үзлэг, сэтгэл зүйн дэмжлэгт төдийлөн бүрэн дүүрэн хамрагдаж чаддаггүй. Хөгжлийн бэрхшээлтэй 110 мянган хүн байгаа. Нийгмийн халамжийн үйлчилгээнд тэгвэл 2024 онд 2 сая 700 мянган хүн хамрагдсан байгаа. За эдгээрийн 73 хувь нь эх хүүхэд, 26 хувь нь бол ахмад настан. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ ч гэсэн гэж байдаг. Асрамжийн төвүүдээр ч гэсэн хүмүүс үйлчлүүлдэг. Эдгээр бүхий л үйлчилгээнд бид нийгмийн ажилтнуудаар дамжуулаад нийгмийн эмзэг бүлэг болон яг энэ хэрэгцээ шаардлагад одоо төрийн энэ халамж үйлчилгээ хэрэгцээ

шаардлагатай байгаа 7 салбарт бол нийгмийн ажилтнууд ажилладаг аа. Тэгэхээр боловсролын салбарт ч гэсэн сургуулиудад бид нар нийгмийн ажилтны...

С.Бямбацогт: Баярлалаа. Зочин танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Пүрэвжавын Сайнзориг, Наранцэцэгийн Алтаншагай нарын урилгаар нийслэлийн ерөнхий боловсролын 104 дүгээр сургуулийн 10.2-ын А ангийн багш сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа Төрийн ордонтой танилцаж байна. Манай Сайнзориг гишүүн байна, Алтаншагай гишүүн байна уу? Хоёулаа байна аа. Манай 2 гишүүн бас хуралдаа идэвхтэй оролцож байна. Хуралдаанаа тасалдаггүй, олон хууль санаачилж, үг хэлдэг идэвхтэй гишүүдийн нэг шүү манай 2 гишүүн. Тэгээд удахгүй дунд сургуулиа төгсөөд их сургуулийн босго алхах гэж байгаа та бүхэндээ хүссэн мэргэжлээрээ, хүссэн сургуульдаа элсэн ороорой. Тэгээд улс эх орондоо их хэрэгтэй ихийг хийж бүтээсэн, эх оронч сайн иргэн болж төлөвшөөрэй гэж нийт Улсын Их Хурлынхаа гишүүдийн нэрийн өмнөөс амьдралд нь эрүүл энх, аз жаргал сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе өө.

Сархадын Зулпхар гишүүн үгээ хэлье.

С.Зулпхар: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд, ажлын хэсгийнхний өдрийн амгаланг айлтгая. Нийгмийн хөгжил, нийгмийн нарийн ээдрээтэй харилцаатай уялдан тодорхой ажил мэргэжил, үйлчилгээ бий болсон байдаг бол үүний нэг нь нийгмийн ажил юм байгаа юм. Нэн ялангуяа сүүлийн 30 гаран жилд Монгол Улсад нийгмийн харилцаа бол их нарийн ээдрээтэй, зарим тохиолдолд бас одоо эрсдэлтэй, зарим тохиолдолд сорилттой ийм байгаа. Тэгэхлээр энэ сорилтыг давах, эрсдэлийг давах үүднээс нийгмийн ажил мэргэжил манай нийгмийн харилцааны маш чухал бүрэлдэхүүн хэсэг болсон энэ салбар одоо жишээ нь өөрөө бий болсоор даруй 30 гаран жил боллоо. Тэгээд энэ хугацаанд нийгмийн ажил мэргэжлээр боловсролын салбарт нийгмийн хамгааллын салбарт хөдөлмөр эрхлэлт, эрүүл мэнд цаашлаад шүүхийн шийдвэр биелүүлэхтэй холбоотой бүхий л энэ харилцаан дээр нийгмийн ажил үйлчилгээ нэвтэрчхээд байна. Салбарын хуулиудаар бусад органик хуулиудаар зохицуулагдаж байгаа ийм харилцаа. Тэгэхлээр энд бол юу гэж ойлгох ёстой вэ гэхлээр тогтолцоо бол хэдийнэ бий болчихсон. Тогтолцоо байгаа боловч нэгдмэл эрх зүйн орчин байхгүй. Тэгэхлээр нэгдмэл эрх зүйн орчин байхгүй бол цаашид энэ ажил мэргэжил энэ үйлчилгээг цааш нь хөгжүүлээд явах нөгөөтээгүүр бидний хувьд шаардлагатай тэр түвшинд нь энийг хэрэгжүүлэх энэ боломж бол өөрөө хязгаарлагдаж байгаа юм. Энэ үүднээс нь аваад үзэх юм бол Саранчулуун гишүүнээр ахлуулсан гишүүд бид энийг хамтдаа санаачилсан. Энэ хууль бол та бүхэн сайтар хэлэлцэж энийг дэмжиж өгөх ёстой хуулиудын нэг шүү гэдгийг энэ зориуд хэлж байгаа юмаа.

Гишүүд маань их тодорхой асуулт асууж байна, санал хэлж байна. Зөв өө. Зарим зүйл дээр бид анхдагч хууль учраас салбар дундын уялдаа холбоог нарийн харах шаардлага бол бий. Нөгөөтээгүүр магадгүй одоо төрийн албан хаагч болон төрийн албан хаагч биш нийгмийн ажилтнуудын эрх үүрэг улс төрийн болоод эвлэлдэн нэгдэх эрхтэй холбоотой асуудлыг ч гэсэн эргэж харах нарийвчлан зохицуулах ийм шаардлага байгаа. Үүнийг ажлын хэсэг дээр ажиллаад шийдчихэж болно оо гэж ойлгож байна. Энэ хуулийн маш чухал онцлог бол энэ ажил мэргэжил үйлчилгээг төрөл хэлбэрээр нь нарийн стандартын түвшинд хүргэх шинэ түвшнийг эрэлхийлж байгаагаараа бол онцлогтой гэж ойлгох ёстой. Энэ хууль бий болсны

дагуу мэргэжлийн удирдлага бий болно. Өнөөдөр мэргэжлийн удирдлага байхгүй, салангид салбарын удирдлага байж байгаа.

Мэргэжлийн удирдлага нь өөрөө төрийн нөгөө чөлөөлье гэдэг том зорилт байж байгаа шүү дээ. Тэр чөлөөлье гэдэг зорилттой бүрэн нийцэж байгаа. Учир юу гэхлээр зэрэг төрийн зарим чиг үүргийг ТББ-аар нь мэргэжлийн холбоодоор нь дамжуулж хэрэгжүүлэх, мэргэжлийн холбоодоор дамжуулаад энэ үйлчилгээний чанар хүртээмжийг цаашлаад энэ үйлчилгээний өөрийнх нь түвшнийг өргөх бас чухал одоо зүйл болж байгаа юмаа. Төсөвтэй холбоотой зүйл яригдаж байна. Бид ажлын хэсэг дээр их нарийвчлан ярьсан. Энэ төсөвтэй холбоотой ямар ч зүйл байхгүй.

Булгантуяа жишээ нь гишүүний Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд байх үед Хүүхэд хамгааллын хууль батлагдаж байсан тэр үед хүүхэд хамгааллын чиглэлээрх 900 нийгмийн ажилтны орон тоог баталж байсан. Энэнтэй уялдсан байдал тэр 3 мянган жишээ нь нийгмийн ажлын чинь 900 нь аль хэзээний ажил дээр оччихсон, зарим нь ТББ-аар жишээ нь үйл ажиллагаа хэрэгжүүлж байгаа. Төсөв дээр ямар нэгэн байдлаар дарамт учруулахгүй байдлаар энэ санал сүүлд хэлэлцэгдсэн. Гэхдээ Засгийн газраас өгч байгаа санал бол анхны жишээ нь төслийн хэлбэрээр байх шиг байгаа юм. Тэгэхлээр эндээс бол гишүүд маань та бүхэн зөв ойлгоорой. Ямар нэгэн төсөвт ачаалал өгөх зүйл ерөөсөө байхгүй шүү.

Ийм учраас та бүхнийг энэ хуулийн төслийг нарийвчлан судалж зарим гишүүд маань яг санал өгснийхөө дагуу ажлын хэсэгт нь орж хуулийн төслийг чамбайруулж гаргаж өгөөч ээ гэж байгаа юм. Бид аж үйлдвэрийн жишээ нь өсөлтийг эрэлхийлсэн, эдийн засгийн өсөлтийг эрэлхийлсэн, дэд бүтцийн жишээ нь хөгжлийг эрэлхийлсэн, эрчим хүчний хөгжлийг эрэлхийлсэн зөрчлүүдийг дэмжсэн хуулиудыг баталж байгаа. Үүнтэй адилхан нийгмийнхээ дэд бүтцийн хөгжлийг эрэлхийлсэн энэ хуулийг та бүхэн дэмжиж хэлэлцэж өгнө өө гэдэгт эргэлзэхгүй байна аа. Анхаарал хандуулсанд баярлалаа.

С.Бямбацогт: Зулпхар гишүүнд баярлалаа. Одоо Цэндсүрэнгийн Мөнхтуяа гишүүн хуулийн төслийн талаар үг хэлнэ ээ. Тийм 2 дугаар микрофон.

Ц.Мөнхтуяа: Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе ээ. Нийгмийн ажлын тухай анхдагч хуулийн төслийг санаачлан оруулж ирж буй Отгоны Саранчулуун гишүүндээ болон хамт өргөн мэдүүлж буй 26 гишүүндээ баяр хүргэж амжилт хүсье гэж хэлмээр байна аа. Ер нь бол энэ нийгмийн ажлын тухай хууль орж ирснээр нийгмийн ажилтнуудын статус нь маш тодорхой болно оо гэж бид нар үзэж байгаа. Ер нь энэ боловсролын салбарт боловсролын салбарын салбарт ажиллаж буй багш ажилчдын гээд ярингуут л нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, эмч гээд ийм сургуульд 1, 2 байдаг энэ мэргэжлүүд хаягддаг. Тийм учраас энэ нийгмийн ажлын хуулийг ингэж санаачилж оруулж ирж байгаа нь түүхэн ач холбогдолтой гэж би бол үзэж байгаа. Тийм учраас энэ хуулийг дэмжиж хамт өргөн мэдүүлж байгаа гишүүн.

1999 онд анх сургуулийн нийгмийн ажилтан гэдэг мэргэжлийг бий болгож МУБИС дээр анхны төгсөгчдийг ингэж гаргаж байсан. Тэр төгсөгчдийн нэг нь би өөрөө байгаа. Нямдорж гээд ШУТИС-ийн багш бид нарт анх нийгмийн ажилтны А үсгийг зааж байсан. Тэгээд нийгмийн ажилтнууддаа бүгдээрэнд нь амжилт хүсье гэж хэлмээр байна.

Ер нь бол одоо нийгмийн ажилтныг түрүүн тодорхойлоод манай гишүүд аягүй сайн хэлж байна л даа. Нийгмийн ажилтан гэдэг ерөөсөө л нэргүй зарц сургууль дээр. Нэг эзний бишээ олон эзний нэг зарц гэдэг үг байдаг даа. Яг тэр ажлыг хийдэг ээ. Одоо энэ сургууль дээр байгаа хичээл ирц, таслалт, эцэг эхтэй ажиллах, тайлан судалгаа гээд ингээд дуусдаггүй их ажилтай. Гэтэл яг өөрийнх нь ажлын статус нь шал өөр байх жишээний тиймээ. Ингээд өөрийнхөө үндсэн ажлаа хийж чадахгүй нөгөө олон эзний зарц хийсээр байгаад түрүүн хэн Булгаа гишүүн хэлсэн шүү дээ. Байгалаа Байгалаа гэдэг шиг гээд. Яг л ийм ажлыг ингээд энэ олон жил 1999 оноос хойш манай сургуулийн нийгмийн ажилтнууд үүрч яваа. Нийт Монгол Улсын хэмжээнд 3 мянга гаруй нийгмийн ажилтан байдаг гэсэн ийм судалгаа байна. ЕБС-д бол 900 гаруй нийгмийн ажилтан ажиллаж байгаа. Энэ нийгмийн ажилтнуудын ажлын байрны орчин нөхцөл маш хүнд, сэтгэл зүйн дарамт, хүчирхийлэл, хайхрамжгүй байдал, ядуурал, зан үйлийн асуудалтай ийм хүнд кэйсүүдтэй өдөр бүр нүүр тулдаг аа.

Дараагийн асуудал нь нийгмийн ажилтны эрх үүрэг, хууль, ерөнхий хуульд тодорхой нэг ганц нэгхэн заалт орчихсон байгаа. Бодит хэрэгжилтээр нь бүүр юу ч байхгүй. Тэгээд цалин хөлс нь үнэхээрийн бага. Тэгээд ямар ч тийм стрессийн менежмент стресс тайлах юм байдаггүй нийгмийн ажилтнууд дээр. Ийм маш олон асуудал байгаа учраас энэ нийгмийн ажилтны хууль орж ирэх зайлшгүй шалтгаан нөхцөл үүссэн гэж үзэж байгаа. Тэгээд бас нэг юм хэлэхэд Боловсролын зээлийн сангаар мэдээлэлд ойр байдаг дарга, тэгээд дарга нар, сайд нар, эрх мэдэлтнүүдийн хүүхдүүдийг одоо энэ боловсролын зээлийн сангаар гадаад дотоодод тэтгэлэгт сургаад явуулаад байна аа. Энэ тэтгэлэгтэй нийгмийн ажилтан, сургуулийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйч багш нарыг хамруулдаг болох ийм саналыг би оруулж байна аа. Ер нь энэ тэтгэлэг боловсролын зээлийн энэ гадагшаа явдаг тэтгэлэгт судалгаагаар харахад ерөөсөө тийм жирийн ард иргэдийн хүүхэд, жирийн багш явсан тийм кэйс байхгүй юм байна лээ. Тийм учраас энэ эрх мэдэл албан тушаалтнуудын хүүхдүүдэд ийм өндөр илүү боломж байдаг. Жирийн багш, жирийн иргэдэд энэ боломжийг нээж өгөх талаас нь би хөөцөлдөж ажиллана гэдгээ энд ташрамд хэлмээр байна.

Ингээд материаллаг орчны орчин нөхцөлийн хувьд бол ер нь тусгай өрөө нууцлал хангах асуудал дутмаг. Судалгаа кэйс бүртгэлийн систем нь ихэнхдээ цаасаар явагддаг. Цахим дижитал систем хангалтгүй. Тэгээд...

С.Бямбацогт: Мөнхтуяа гишүүнд баярлалаа. Гишүүд үг хэлж дууслаа. Одоо санал хураалт явуулах ёстой. Ирцэнд 126 гишүүнээс 107 гишүүн орсон. 84.9 хувийн ирцтэй байгаа. Танхимд сууж байгаа гишүүд хангалтгүй байна аа. Ирц санал хураахад. Одоо яг энэ чуулганы хуралдааны танхимд Баярбаатар гишүүн, Сандаг-Очир гишүүн, Булгантуяа гишүүн, Ариунзаяа гишүүн, Заяабал бишээ Жангабыл гишүүн, Зулпхар гишүүн, Мандхай гишүүн, Уянга гишүүн, Энхтүвшин гишүүн, Эрдэнэбат гишүүн, Номинчимэг гишүүн биш Саранчулуун гишүүн хэлсэн. Бум-Очир гишүүн, Ганхүлэг гишүүн, Замира гишүүн, Нара гишүүн, Сарнай гишүүн, Батбаатар гишүүн, Найдалаа гишүүн, Мөнхсоёл гишүүн, Уянгахишиг гишүүн, Энхнасан гишүүн, манай Бямбасүрэн гишүүн төрсөн өдөр нь болж байгаа, Мөнхтуяа гишүүн, Шижир гишүүн, Энхтуяа гишүүн, Мөнхбаясгалан гишүүн, Тэмүүжин гишүүн, Бейсен гишүүн, Баттулга гишүүн, Ганзориг гишүүд байна аа. Бусад гишүүд маань өрөөндөө ажлаа хийж байгаа байх гэж ойлгож байна. Тэгээд ирц хангалтгүй л байна даа. Санал хураахад тийм үү?

Нэгтгээд хураачихъя 16 цагаас санал хураалттай 16 цагаас. Өнөөдрийн асуудлаас өнөөдөртөө хэлэлцэх гээд үзье хэдүүлээ. Тийм болохоор 16 цагаас санал хураалттай. Гишүүдийг үг хэлэх, асуулт асуух хэлэлцүүлэгт оролцох гишүүд мэдээж тийм үү үгээ хэлж асуултаа асуугаад үргэлжлээд явна. Санал хураалтад 16 цагт шүү гэдгийг бас зарлаарай. Санал хураалтыг хойшлууллаа. Хамт өргөн мэдүүлсэн хуулиудыг бас хойшлуулна. Санал хураалт явагдах учраас.

12.32 цаг

Дараагийн асуудалдаа оръё.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх БОХХАА-н байнгын хорооны санал дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Болдын Уянга танилцуулна аа. Индэрт урьж байна аа.

Б.Уянга: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 5 дугаар сарын 16-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг 2025 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр БОХХАА-н байнгын хороонд шилжүүлсэн.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах үүрэг бүхий ажлын хэсгийг Байнгын хорооны 2025 оны 19 дүгээр тогтоолоор байгуулсан бөгөөд ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга, бүрэлдэхүүнд нь Улсын Их Хурлын гишүүн Н.Алтаншагай, Б.Бат-Эрдэнэ, Г.Ганбаатар, С.Замира, Ц.Мөнхбат, Б.Мөнхсоёл, С.Одонтуяа нарын гишүүд ажилласан.

БОХХАА-н байнгын хороо 2026 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн хуралдаанаараа дээрх хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу явуулж, хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцлээ.

Хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн Д.Батбаяр төсөлд тусгасан их, дунд, бага гэсэн тухайн нутаг дэвсгэрт хэрэгжих төслийн зэрэглэлийг хэрхэн тогтоох. Зэрэглэл тус бүрд төрийн оролцоо ямар байх, Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэг төслийн зэрэглэлийг Засгийн газраар баталж мөрдүүлж байгаа нь тогтвортой байх эсэх. Их эрсдэлтэй төслүүдэд төрийн хяналт иргэдийн оролцоог тусгасан талаар. Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа ААН-үүд байгаль орчны нөхөн сэргээлтийг зохих стандартын дагуу хэрэгжүүлэх хяналт тавих талаар хуулийн төсөлд тусгасан эсэх, Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тайланг алдаатай боловсруулж баталсан тохиолдолд хариуцлага тооцох механизмыг бүрдүүлсэн эсэх, Улсын Их Хурлын

гишүүн Б.Бейсен уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа ААН-үүдэд дахин боловсруулах үйлдвэртэй байх, хаягдлыг бууруулах асуудлыг хуулийн төсөлд тусгасан талаар асуулт асууж, хариулт авлаа.

Ажлын хэсгээс төслийг байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл, цар хүрээ, хүчин чадал, эрсдэлийг харгалзан 3 зэрэглэлд ангилж, байгаль орчин нийгэмд үзүүлэх нөлөөллийг тус бүр тодорхойлох. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тайланд шинжилгээ хийж, дүгнэлт гаргах. Ерөнхий шинжээч шинжээчийн эрхийг төрийн захиргааны төв байгууллага олгох. Ерөнхий шинжээч шинжээч нь төрийн албаны тухай хуульд заасан шаардлагыг хангасан, байгаль орчны чиглэлээр ажилласан жил, мэргэжлийн чадвар, ажлын туршлагатай байх шаардлагыг тусгах. Төсөл хэрэгжүүлэгч үнэлгээ хийсэн мэргэжлийн байгууллага хамтран байгаль орчны нөлөөллийн үнэлгээний тайланг нутаг дэвсгэрийн захиргаа, төслийн нөлөөлөлд өртөх иргэдэд танилцуулж санал авах ажлыг зохион байгуулах зэрэг зарчмын зөрүүтэй 10 санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно оо.

Мөн хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддоржоос зарчмын зөрүүтэй 4 санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй байна аа.

Байнгын хорооны хуралдаанаар зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг нэг бүрчлэн хэлэлцэн санал хураалт явуулсан бөгөөд олонхын санал авсан, аваагүйгээр нь бүлэглэн анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Байнгын хорооны санал дүгнэлтийн хамт та бүхэнд хүргүүлсэн болно оо.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх БОХХАА-н байнгын хорооны санал, дүгнэлт зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье ээ. Анхаарал тавьсанд баярлалаа.

С.Бямбацогт: Уянга гишүүнд баярлалаа. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя. Хуулийн төслийн хэлэлцүүлэгтэй холбогдуулж энэ хуулийн төсөл дээр Улсын Их Хурлын гишүүн Уянга ахлаад Алтаншагай, Батчимэг, Бат-Эрдэнэ, Замира, Идэрбат, Мөнхбат, Мөнхсоёл, Одонтуяа гишүүд ажилласан байна аа.

Дэд ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Цэндийн Сандаг-Очир Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд, Шүрэнчулууны Батбаяр ТНБД-ын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Цэрэндоржийн Уранчимэг ТХГН-ийн БХЗГ-ын дарга, Баасанжавын Алтанзул Хүрээлэн буй орчны бодлого үнэлгээний газрын Байгаль орчны үнэлгээ, аудитын хэлтсийн дарга, Ишгалдангийн Бямбахүү судлаач, Мягмарсүрэнгийн Энхмэнд судлаач.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд хууль сануулъя. Улсын Их Хурлын тухай хуулийн 21.24-нд нэгдсэн хуралдаанд мэдээлэл хийж байгаа Засгийн газрын гишүүн ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орсон холбогдох албан тушаалтан үнэн зөв, бодит, бүрэн гүйцэд мэдээлэл өгөх үүрэгтэй. 21.25.Нэгдсэн хуралдаанд мэдээлэл хийх, асуултад хариулах, тайлбар өгөх албан тушаалтан өөрийн танилцуулсан мэдээллийн үнэн зөвийг хариуцах бөгөөд мэдээллийг санаатайгаар нуун

дарагдуулах, худал мэдээлэл өгөх, танилцуулах, Улсын Их Хуралд худал мэдээлэл ирүүлэхийг хориглоно. 21.31-д чуулганы хуралдаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүрэлцэн ирээгүй, тайлбар өгөхөөс татгалзсан, хуралдаанд оролцсон этгээд хуралдааны дэг зөрчсөн бол парламентыг үл хүндэтгэсэн үйлдэлд тооцож тухайн этгээдэд Төрийн албаны тухай болон холбогдох бусад хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ гэж заасан байгаа байдаг. Тийм болохоор та бүхэн үнэн зөв, бодитой мэдээлэл өгч, Улсын Их Хуралд хүндэтгэлтэй хандахыг хүсье ээ.

Урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуултууд асууна. Ирсэн ирцээрээ эрэмбэлэгдсэн байгаа. Мөнгөнцогийн Ганхүлэг гишүүн асуултаа асууя.

М.Ганхүлэг: 2012 онд батлагдсан Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийн төслийг хэлэлцэж байна. Анхны хэлэлцүүлгийн үеэр нарийвчлаад харахад нэлээн хүч түрсэн өнгө аястай, ялангуяа Иргэдийн нийтийн хурлаар аливаа төслүүдийг оруулахгүй байх, иргэдийн оролцоог нэгдсэн санал бодлыг сонсохгүй байх ийм заалтууд орж ирж байгаа учраас нэлээн шүүмжлэлтэй энэ дээр хандаж байнгын хороон дээр байр сууриа илэрхийлсэн. Мэргэжлийн байнгын хороо бас энийг дэмжсэнийг ойлгохгүй байгаа. Байгаль орчны яамны тодорхой ажилтан албан тушаалтнууд энэ дээр илт дэмжих ийм байдлуудыг бий болгож явж байгаад жоохон харамсаж байгаа шүү гэдгээ түрүүлээд хэлчихье ээ.

Дэмжихгүй байгаа хэд хэдэн шалтгаан, нарийвчилж асуух хэд хэдэн зүйлүүд байна аа. Хамгийн эхнийх нь болохоор тухайлсан томоохон төслүүдээ том, жижгээр нь бид бүхэн ангилаад, байгаль орчинд нөлөөлж байгаа байдлаар нь 3 зэрэглэлд хуваах юм байна аа. Энэ зэрэглэлийг аль нэгэн субъектийн байдлаар байдаг юм уу, үзэмжээр бас шийдэх ийм эрсдэл рүү орох магадлалууд байна аа. Зэрэглэл нэг нь бол байгаль орчинд өндөр нөлөөтэй, зэрэглэл 2 нь бол дунд нөлөөтэй, зэрэглэл 3 нь бол бага нөлөөтэй гэж үзэж байгаа юм байна. Энийг үндсэндээ сайд шийдэж, энэ зэрэглэлийг тогтоох асуудлыг Засгийн газарт орж хэлэлцүүлэх юм байна аа. Байж болно оо. Гэхдээ энэ зэрэглэлийг тогтоож байгаа энэ байдал дээр хяналт тавих энэ явах энэ процесс дээр бид бүхэн нарийвчлан яаж одоо зохицуулах вэ? Танилцуулсан мэдээлэл дээр зэрэглэл 3 буюу бага эрсдэлтэй гэж үзэж байгаа ангилал дотор химийн хортой болон цацраг идэвхт бодис аюултай хаягдлын төслүүд дээр жишээ нь гэх юм бол цацраг идэвхт бодис агуулсан тоног төхөөрөмж ашигладаг байгууллага нь зэрэглэл 3 руу орсон байгаа юм. Тэгээд тодорхой жишээнд болгон дээр ингээд ярих юм бол хэн энийг тогтоох юм, яаж энэн дээр одоо үндсэндээ ямар зарчим барих юм бэ гэдэг эхний ийм ойлгомжгүй байдал үүсэхээр байна аа.

Мөн дээрээс нь төсөл хэрэгжүүлэгч дуугаа өөрөө захиалж байгаа, төлбөрөө төлөөд энэ менежментийн төлөвлөгөөгөө үндсэндээ хийлгэж байгаа. Одоо түүнийг нь мөн л тодорхой эрх бүхий субъект дэмжинэ, дэмжихгүй түүнээс гарсан үнэлгээний хороо үндсэндээ ажиллаж байгаа. Үнэлгээний хорооны чадамж, хараат бус байдал, тэдэнд ямар нэгэн цалин урамшуулал эдгээр зүйлүүд тодорхой биш сайн дураар шахуу, унших уншиж байгаа юмнуудыг нь сайн мэдэхгүй, маш олон төслүүдийг үнэлгээний хороогоор ингээд үндсэндээ оруулаад гаргах ийм тохиолдлууд өмнөх кэйсүүд дээр байгаа. Цөөн хэдэн хүн тухайн орон нутагт байгалийн ийм онц ноцтой ийм төслүүдийг дэмжих ийм байдлууд бий болоод явж байсан кэйсүүд байгаа.

Тэгэхээр энэ үнэлгээний хороог яаж хараат бус байлгах юм? Энэ төслийг үнэлж байгаа хүмүүс яаж үнэн шударгаар ажиллах энэ байдлыг бид бүхэн бий болгох юм бэ? Бас л ингээд нэг ийм субъектийн ийм байдал руу оруулах нь ээ. Хамгийн гол үндсэндээ байгаа асуудал маань миний одоо дургүйлхээд байгаа зүйл нь бол нэг 8, 9-хөн л үндсэндээ асуудлыг бүрдүүлээд ингээд нарийвчилсан үнэлгээгээ авч байгаа юм.

8.4.8 дээр Иргэдийн нийтийн хурлаар тогтоол биш байгаа байхгүй юу хөөрхий. Зүгээр санал тэмдэглэл энийгээ хавсаргачих аа, иргэдэд нь танилцуулаад ингээд нэг хурал зохион байгуулчих аа л гэдэг ийм заалт байгаа юм. Тэгээд ийм заалтыг нь ядаж байлгахгүй болгох нөхцөлийг л ойлгохгүй байгаад байна л даа. Нөлөөллийн бүс гэдгийг би байнгын хороон дээр асуусан. Нөлөөллийн бүс нь үндсэндээ тодорхой тухайн төслөөсөө хамаарна гэж байгаа юм. Ямар үндсэндээ чиглэлийн төсөл байгаагаас хамаараад тэр радиус нь орох тэр иргэд нь ингээд тодорхой болно оо гэж байгаа юм. Ингээд харахаар нэг, хоёрхон иргэд санал өгөөд тухайлсан төслүүд хүртэл явах эрсдэл рүү орох гээд байгаа юмаа.

С.Бямбацогт: Ажлын хэсгийн ахлагч Болдын Уянга хариулъя.

Б.Уянга: Ганхүлэг гишүүнд баярлалаа. Байнгын хороон дээр бид нар зарим зүйлүүдэд хариултыг өгсөн байгаа. Нэмээд мэргэжлийн яам нь саналаа хэлээд миний дутууг нөхөөд яваарай. Хамгийн эхний санаа таны хэлж байгаа зүйл бол сая сүүлд уншдаг 8.4.8 буюу Иргэдийн нийтийн хурлын санал тэмдэглэл гэдгийг арай өөрөөр томьёолж байна гэсэн агуулга байгаа. Төслийн нөлөөллийн бүс гэж илүү дэлгэрэнгүй оруулж ирж байгаа энэ үзэл баримтлал нь угаасаа л таны түрүүний хэлсэнчлэн 2012 онд батлагдахдаа үзэл баримтлалд нь байсан агуулга буюу иргэдийн саналыг авна аа гэдэг энэ агуулга нь юмаа. Энэ нь 2012 ондоо энэ чигээрээ санал тэмдэглэл байдлаар хэрэглэгддэг байж байгаад 2016 онд хуульд авсан журам гарснаас болоод заавал тогтоолоор баталгааждаг болсон нь өнөөдөр аливаа төсөл явахад 2 жил гаруй гацах ийм нөхцөлийг бүрдүүлээд байгаа учраас энэ төсөл маань өөрөө шинэчилсэн найруулга биш нэмэлт, өөрчлөлт байгаа учраас 2012 оныхоо үзэл баримтлал руу илүү нарийвчлан тодорхойлж оруулж ирж байгаа.

Ингээд төслийн энэ нөлөөллийн бүсэд тэгвэл хэрхэн хүрэх юм бэ гэж. Тэгэхээр зэрэглэл нэг буюу нөлөөлөл ихтэй гэж бүлэглэж байгаа энэ төслүүд нь болохоор 4 байдлаар нөлөөллийн бүсийн иргэдээс мэдээллийг нь авч саналыг нь тусгана гэж байгаа. Төслийн нөлөөллийн бүсийн иргэдийн өрхийн нийгэм эдийн засгийн талаар мөлхөө судалгааг хийх ёстой болж байгаа. За бүлгийн ярилцлагыг хийх ёстой болж байгаа. Ганцаарчилсан ярилцлага тэгээд олон нийтийн хэлэлцүүлэг буюу энэ зохион байгуулалт нь өөрөө Иргэдийн нийтийн хурал байж болно. Тэгэхээр энэ хурлынх нь агуулга нь өөрөө засаг захиргаа түүний нэгж удирдлагын тухай хууль дээр хэвээр хадгалагдаж байгаа зохицуулалт учраас харин илүү зэрэглэл нэг төсөлдөө илүү хатуу байдлаар яг тэнд амьдарч байгаа иргэдээсээ саналыг нь ав гэдэг зохицуулалтыг салбарын яам нь 2022 оноос хойш ирсэн гомдол чирэгдлүүд дээрээ үндэслээд боловсруулсан орсон ийм төсөл байгаа гэж нэмж хариулъя аа.

Ингээд төслүүдийг 3 зэрэглэлд хувааж байгаа. 3 зэрэглэлийг хоорондоо шилжих үү гэж та байнгын хороон дээр их онож асуусан. 3 зэрэглэл хоорондоо 1 дүгээр зэрэглэл зэрэглэл буурах боломжгүй байгаа. Зэрэглэл 2 мэргэжлийн байгууллага хэрвээ энэ нөлөөлөл ихтэй байна гэж үзэх юм бол зэрэглэл нэг рүү ахих

боломжтой. Ийм байдлаар Засгийн газар журамлахаар төсөл нь бэлтгэгдсэн ажлын хэсэг дээр танилцуулагдсан. Ер нь ингээд яам өөрөө маш их ачааллыг авч бүх төрлийн газ Монгол Улсын нутаг дэвсгэр дээр газар эзлэн оршиж байгаад л үйлдвэр үйлчилгээний газар бүр дээр үнэлгээг хянадаг байсан энэ хяналтыг орон нутаг руу шаардлагатай гэнэ. Заримыг нь зүгээр мэдэгдэл хүргүүл ээ гээд илүү өөрсдөө хяналтаа сайжруулах арга руугаа орж байгаа. Энэ дээр нэмээд хариултыг яамнаас өгье. Сайд өгөх юм болов уу?

С.Бямбацогт: Ажлын хэсэг хариулах уу? хэн хариулах вэ? 4 дүгээр микрофон Батбаяр дарга хариулъя.

Ш.Батбаяр: Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны ТНБД-ын үүргийг түр орлон гүйцэтгэгч Батбаяр. Гишүүний асуултад хариулъя аа. Энэ мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүн бол төрийн албаны тангараг өргөсөн төрийн жинхэнэ албан хаагчдаас бүрэлдэж байгаа. Мөн эрдэмтэн, салбарын эрдэмтэн судлаачид, их, дээд сургуулийн багш нар оролцсон байгаа. Тэгэхээр энэ эдгээр албан хаагчид бол бүгд төрийн албан хаагчид байгаа. Тийм учраас Төрийн албаны тухай хуулийн дагуу шударга тангараг өргөсөн учраас шударга ажиллах үүрэг хүлээж байгаа. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны ТНБД-ын тушаалаар тодорхой хугацаанд санхүүгийн урамшуулал дэмжлэгийг мэргэжлийн зөвлөлийн гишүүдэд олгодог байгаа.

Хоёрдугаарт нөлөөллийн бүсийг тогтоох асуудал дээр мэргэжлийн байгууллага нөлөөллийн бүсийг тогтоодог байгаа. Нөлөөллийн бүс нь тухайн төслөөсөө шалтгаалаад харилцан адилгүй байгаа. Экологийн бүслүүрээсээ болон одоо говь, хангай хээрийн бүс нутагт...

С.Бямбацогт: Хариултаа дуусгачихъя. 4 дүгээр микрофон.

Ш.Батбаяр: Ямар төсөл хэрэгжүүлж байгаагаасаа шалтгаалаад харилцан адилгүй байгаа учраас мэргэжлийн шинжээч, мэргэжлийн байгууллагууд энийг тогтоож байгаа. Хуульд орж байгаа гол үзүүлэлт нь иргэдийн тухайн нөлөөллийн бүсэд орж байгаа иргэдийн дал гаруй хувь нь энэ 4 аргачлалаар уулзалт, ярилцлага, ганцаарчилсан уулзалт, мөлхөө судалгаануудад хамрагдаж байгаа юм аа. Өмнөх одоо, одоо хэрэгжиж байгаа хуулиар бол зөвхөн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар шийдэгдэж байсан. Одоо бол бүх нөлөөллийн бүсэд байгаа иргэдийн дахин хэлэхэд дал гаруй хувь нь далаас дээш хувь нь энэ судалгаанд орж саналаа илэрхийлж байгаа юмаа. Боломж нь бүрдэж байгаа юм.

С.Бямбацогт: Мөнгөнцогийн Ганхүлэг гишүүн тодруулж асууя.

М.Ганхүлэг: Ажлын хэсгийн ахлагч маань яах вэ зэрэглэл буурахгүй л гээд тэгж байх шиг байна л даа. Тэгэхдээ журмыг бол өөрчилчих боломж нь яам болон Засгийн газарт нь байгаа. Тэгэхээр энийг жоохон хатуу оруулж ирсэн заалт бол энэ хууль дээр байхгүй шүү. Тэр журмыг яаж ч баталж болно. Гол нь үзэмжээр хандах ийм үндсэндээ эрсдэл байна аа л гэж би хэлээд байгаа юм. Тэгээд би тодорхой асуугаад байна шүү дээ. Энэ цацраг идэвхт бодис агуулсан тоног төхөөрөмж ашигладаг байгууллага гэдгийг та бүгдийн тараасан энэ танилцуулга дээр зэрэглэл 3 руу оруулчихсан байна аа. Тэгээд ингээд гэх мэтчилэнгээр ингээд үндсэндээ энэ зэрэглэлийг дур мэдэж тогтоогоод ингээд байвал яах юм бэ л гэдэг тухай. Тэр журмаар үндсэндээ бууруулахгүй л гээд тэгж байна. Тэгээд журмаа өөрчлөөд

бууруулдаг болно оо гэж хэлээд ингээд зэрэглэлийн асуудал явчих ийм үндсэндээ байдал руу орох гээд байгаа учраас энийгээ хатуу оруулж ирвэл яасан юм бэ?

Тэр нөлөөллийн бүсийг би бас дэмжихгүй биш дэмжиж байна. Нөлөөллийн бүсээсээ ч ав, Иргэдийн нийтийн хурлаар нь албан ёсны тодорхой тэмдэглэл тэр саналыг нь аваад л явдаг ийм...

С.Бямбацогт: Хариулчихъя. Ажлын хэсгийн ахлагч Уянга гишүүн хариулья.

Б.Уянга: Ганхүлэг гишүүнд баярлалаа. Ер нь журам Засгийн газраар батлах нь сайд журмыг батлахаас илүү дээр ээ. Улсын Их Хурал хуульдаа хавсралт байдлаар аливаа зүйлийг оруулчихаар хууль нь өөрчлөгдөх боломж нь бүүр хатуурах учраас ер нь ажлын хэсэг дээр, яамнаас орж ирсэн санал дээр энэ ангиллын асуудлыг хамгийн зөв шийдэл нь засаг өөрөө батлах ёстой юм байна. Бүх яамд өөрсдөө тойрч сууж байгаад ярих юм байна гэдэг чиглэлээр энэ хуулийн төсөл орж ирсэн. Гэхдээ яг өнөөдөр та протоколд үлдэж байгаа энэ албан чуулганы индэр дээрээс энэ бүх эрсдэлийг анхааруулж тэмдэглүүлж байгаа нь их сайшаалтай.

Одоо энэ журам Засгийн газраар 8 сарын 1-нээс өмнө батлагдах ёстой болж байгаа. Тэгэхээр энд гишүүдийн санаа зовж хэлж байгаа бүх зүйлүүдийг тэмдэглээд журам нь хамгийн гол нь батлагдаад зөв хэрэгжих дээр нь бид нар анхаарах ёстой юм билээ. Тэгээд энэ дээр нь тал талаасаа анхаарах үүрэг нь бид нарт байгаа.

С.Бямбацогт: Нэмэлт асуулт Мөнгөнцогийн Ганхүлэг гишүүн.

М.Ганхүлэг: Тийм зарчмын одоо хуулийн үзэл баримтлалын хүрээнд тэр нэг асуудлаа зөв оношлогоор юм шиг санагдаад байгаа юмаа. Тэгээд энийг зарчмын зөрүүтэй саналууд гаргаж шийдвэрлэх гээд үзнэ ээ. Асуудал нь энэ том төслүүд явахгүй байгаа асуудал нь иргэд хуралдахгүй байгаа юм шигээр тайлбарлаад байна л даа. Тэгж ойлгуулаад байна. Иргэдийн нийтийн хурал 2 жил хуралдахгүй байгаа болохоор том төслүүд явахгүй байна энийг нь хасчихъя гэдэг ийм агуулга л орж ирж байна шүү дээ. Эсрэгээрээ бид нар энэ иргэдийн нутгийн хурлын чадамжийг сайжруулах, хуралдах нөхцөлийг нь бий болгох энэ асуудлаа шийдэх тал руугаа явахгүйгээр улам л иргэдтэйгээ дайсагнах том төслүүд чинь яах вэ хуулиараа бид нар ингээд хүч түрэх юм байна. Гэтэл яг бодит байдал дээр хэрэгжих болоод ирэхлээр иргэдтэйгээ очоод л нүүр тулна шүү дээ. Иргэний дайн үүсвэл яах юм. Буцаад энэ иргэд чинь биднээс санал авсангүй гээд бид нар яаж энэ сонгогдсон тойрогтоо буцаж очиж ажиллах юм. Тэгээд хүчээр энэ асуудлыг шийдэх гэж байгаа энэ агуулгаа зөөлрүүлэх чиглэлийн юмыг дараа дараагийн хэлэлцүүлэг дээр бид нар ярих ёстой, ярих ёстой тийм.

С.Бямбацогт: Ажлын хэсгийн гишүүн Сандаг-Очир сайд хариулья.

Ц.Сандаг-Очир: Ганхүлэг гишүүний тавьж байгаа асуудлыг ойлгож байгаа. Болгоомжлол, эрсдэл. Асуудлууд хаана, хэзээ, юун дээр үүсээд байна вэ гэхээр ерөөсөө энэ уул уурхайн төсөл хөтөлбөрүүд дээр асуудал үүсэж байгаа маргаан. Орон нутгийн багийн, иргэдийн нийтийн хурлууд хуралдахгүй байгаа учраас төсөл хөтөлбөрүүд гацаад байна гэдэг талаасаа яриагүй ээ. Одоогийн байгаа хууль дээр иргэдийн оролцооны асуудал байгаа. Шинэчилсэн найруулгаар орж ирж байгаа хуулийн төслөөр энэ иргэдийн оролцоог улам бүүр тодорхой болгож, нээлттэй болгож иргэдийн оролцоог хангах талаас нь харин ч бүүр одоо тухайн нөлөөллийн

бүсэд багтаж байгаа иргэдийн саналыг түлхүү ярилцаж, тухайн гүйцэтгэгч компани ажлаа хурдтай шуурхай явуулъя гэвэл тухайн нөлөөлөлд багтаж байгаа багийн иргэдэд тэр болгонд нь асуудлуудаа ярьж, танилцуулж, нөлөөллийн энэ үнэлгээнийхээ асуудлаар, байгаль орчны сөрөг нөлөөллийнхөө асуудлаар тухайн ард иргэдэд, орон нутагт ямар үр дүнтэй төсөл болох юм гэдэг талаар бүх...

С.Бямбацогт: Хариултаа гүйцээчихье. Сандаг-Очир гишүүний микрофон сайдын.

Ц.Сандаг-Очир: Танилцуулсан ААН-үүдийн төсөл үйл ажиллагаа амжилттай явна. Таны хэлээд байгаа шиг нөлөөллийн иргэдийн саналыг авахгүйгээр гэдэг юм уу хүч түрсэн байдлаар явж байгаа асуудал энэ хуульд ерөөсөө байхгүй. Хэрвээ тийм асуудлаар хандвал энэ төсөл хөтөлбөр харин ч таны хэлдгээр компани гүйцэтгэгч компани гэдэг юм уу орон нутгийн иргэдийн эсэргүүцэлтэй тулаад ажил явахгүй ээ. Тийм учраас хуулийн санаачилгаар тухайн сумын нөгөө өнөөдөр нөхцөл байдал бол сумын Засаг дарга нар үнэлгээний материалд дэмжсэн, дэмжээгүй тогтоолоо ерөөсөө саналаа өгөхгүй байгаа шүү дээ. Тодорхой одоо хуулийн зохицуулалт байхгүй. Тэгээд яах гэж байгаа нь мэдэгдэхгүй. Нөгөө төсөл хэрэгжүүлэгч компаниуд болохоор бараг 2 жил орчим хүлээж байгаа асуудлууд байж байна. Энэнээсээ болоод төсөл, хөтөлбөр, зээл юм авчихсан ААН-үүд үйл ажиллагаагаа явуулахгүй асуудлууд байж байна.

Нөгөө талаар сумын иргэд юунд уурлаад байна вэ гэхээр тухайн суманд нь ашигт малтмалын нөөц ашиглалтын төлбөрөө татвараас нэг ч төгрөг орохгүй дээшээгээ татчихаад байгаа юм. Тийм учраас сумын иргэдэд ямар ч үр нөлөөгүй болоод байгаа юм. Тэгэхээр одоо ашигт малтмал...

С.Бямбацогт: Дуламын Бум-Очир гишүүн асуултаа асууя.

Д.Бум-Очир: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе. Би нэг хуулийн төсөл дээр ажиллаж байгаа юмаа. Тэр хуулийн төсөл маань энэ орж ирж байгаа хуультай шууд уялдаа холбоотой. Нэр нь юу вэ гэхээр Нийгэмд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль. Өнөөдөр бид байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай асуудал ярьж байгаа юм. Энэ нийгэмд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай асуудал бол маш олон жил яригдаад, бүрэн шийдэгдэж чаддаггүй. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнийхээ нэг хэсэг нь юм уу одоо дагах байдлаар заримдаа нэр төдий хийгдээд ингээд явдаг ийм асуудал байгаа юмаа. Үүний хамгийн тодорхой жишээг өнөөдөр бид нар Туулын хурдны зам дээр хараад сууж байгаа. Нийгэмд нөлөөлөх байдлын үнэлгээг нарийвчилж маш сайн хийсний үндсэн дээр сая сайд хэллээ.

Тэгэхээр иргэдийн зөвшилцөл орж ирэх ёстой. Тэгэхээр энэ үнэлгээ дутуу хагас, сайн хийгддэггүйн улмаас төсөл хөтөлбөрүүд зогсох, гацах, иргэд эсэргүүцэх энэ нөхцөл байдал үүсдэг ээ. Маш олон жил бид Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульдаа жишээ нь нийгэм гэдэг агуулга 3 удаа дурдагдсан байгаа. Журамдаа 6 удаа дурдагдсан байгаа. Ингээд нийтдээ 9. Ийм 9 заалтаар нийгэмд нөлөөлөх байдлын үнэлгээг бид нар бүрэн хийж чадахгүй байгаа юм гэдэг ийм нөхцөл байдал үүсээд байгаа юмаа.

Ингээд энэ хуулийн төслийг санаачлаад анхны миний бодож байсан одоо Баасанжаргал гишүүн надтай хамт энэ дээр ажиллаж байсан. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний хууль, Нийгэмд нөлөөлөх байдлын үнэлгээний

хуулиа нэг хууль байвал яадаг юм бэ гэдэг ийм зарчмаар явсан. Дэлхийн маш олон оронд ийм жишиг байдаг. Гэтэл яг нийлүүлж болохгүй нөхцөл байдлууд бас үүссэн. Тэгээд нэгэнтээ тусад нь хууль болох шаардлагатай юм байна гэдэг ийм одоо шийдвэр гаргаад Нийгэмд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль гээд. Яг энэ байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний хуулийнхаа зүйл заалт аргачлал одоо шат дараалал, үе шат, элдэв юмтайгаа маш сайн уяад нэг ийм хуулийн төсөл бичээд үндсэндээ хэлэлцүүлэхэд бэлэн болгочихсон байж байгаа юмаа.

Би яг үүнтэйгээ холбоотойгоор ажлын хэсэг болоод холбогдох мэргэжилтнүүдээс юу асуумаар байна вэ гэхээр Нийгэмд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль тусдаа байх нь зүйтэй юм уу, үгүй юм уу. Миний гаргаад байгаа энэ шийдвэр ямар вэ гэдэг дээр та бүхэн байр сууриа илэрхийлээд өгөөч ээ гэж би хүсмээр байгаа юм 1 дүгээр зүйл. Өөрөөр хэлбэл миний байр суурь яагаад ингэж тогтсон бэ гэхээр дэлхий дээр байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, Нийгэмд нөлөөлөх байдлын үнэлгээгээ хамтад нь авч явж байгаа улс орнууд бүтцийн хувьд, институцийн хувьд агентлагтай байна хамтад нь шийддэг. Жишээ нь Австрали эс үгүй бол одоо регулятор буюу зохицуулах Засгийн газрын нэгжтэй байна. Ингээд яг үнэлгээг нь хариуцдаг агентлаг юм уу нэгтгэж хариуцдаг байгалийн ч, нийгмийн ч, бусад асуудлуудыг нь ч нэгтгэж хариуцдаг ийм нэгжтэй тусгай агентлагтай учраас хууль нь хамтдаа явж болоод байгаа юм байна гэж ойлгосон.

Манайх болохоор нийгмийн асуудал нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаман дээр, байгаль орчны асуудал нь байгаль орчин дээр, Соёлын яамтай би бас ярьж үзсэн. Соёлын өвийг хамгаалах тухай хууль дээр, эрүүл мэндийн асуудал нь Эрүүл ахуйн хууль дээр, хөгжлийн бодлого төлөвлөлтийн үнэлгээний асуудал нь Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль дээр гээд олон хууль дээр явчихсан байгаа юм. Тэгээд би бол юу гэж харж байгаа вэ гэхээр энэ хуулиуд бойжоод ирээдүйд Нэгдсэн үнэлгээний тухай хуультай аль нэг цаг үед Монгол Улс болох юм байна аа гэж би хувьдаа ойлгож байгаа юм. Гэтэл яг өнөөдөр нөлөөллүүд гэдэг маань бидний нэгдсэн хуультай болохыг хүлээхгүйгээр иргэдэд тулгарч байдаг ийм асуудал.

Тийм учраас энэ хуулийн бойжилтыг хүлээхгүйгээр Нийгэмд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль гэдэг тодорхой хуультай болоод, чиг үүргээрээ Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны чиг үүргийг энэ дээр татан оролцуулаад явбал яасан юм бэ? Тэгэхгүй бол одоо Засгийн газрын хууль дээр яамдын чиг үүрэг ч гэсэн тодорхой байж байгаа. Байгаль орчны асуудлаа байгаль орчин нь эрхэлдэг, нийгмийн асуудлаа Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын асуудал нь яана. Ингээд 2 яамны дунд хаягдаад байгаа юм биш үү гэсэн ийм нөхцөл байдал үүссэн учраас тусад нь хууль бичээд явж байгаа юмаа.

Тэгэхээр ажлын хэсгийн дарга түүнчлэн би бол яг үнэлгээний газрын даргаар ажиллаж байгаа Алтанзул дарга дээр яг нөхцөл байдал ямар байдаг юм бэ? Та ажлын туршлагаасаа нэг хариулаад өгөөч ээ. Энэ нь тусдаа хуультай байх нь зүйтэй юу гэдэг дээр байр сууриа илэрхийлээд өгөөч ээ гэж хүсэх гэж байгаа юм.

С.Бямбацогт: Ажлын хэсэг 4 дүгээр микрофон хариулъя. Ажлын хэсэг 4.

Б.Алтанзул: Байгаль орчны үнэлгээ аудитын хэлтсийн дарга Алтанзул. Гишүүний асуултад хариулъя. Өнөөдрийн нөхцөл байдлаар нийгмийн нөлөөллийн үнэлгээг ер нь өмнө нь тайланд тусгадаггүй байсан үнэлгээний тайланд. 2023 оны

Засгийн газрын 58 дугаар тогтоолоор баталсан Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журамд зааснаар бол нийгмийн нөлөөллийн үнэлгээг тооцдог болсон. Энэ үнэлгээгээр мэргэжлийн байгууллага ямар асуудлыг авч хэлэлцэх вэ гэхлээр тухайн төсөл хэрэгжиж байгаа нутаг дэвсгэрийн оршин суугчдад үзүүлэх нөлөөлөл ямар нөлөөлөл байгаа юм бэ гэдэг талаар мэргэжлийн байдлаар тодорхой тусгаж өгдөг болсон. Хариулт дууслаа.

С.Бямбацогт: Ажлын хэсэг нэмж хариулъя. Уянга гишүүн.

Б.Уянга: Бум-Очир гишүүнд баярлалаа. Одоогийн энэ Байгаль орчны нийгмийн байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль маань болохоороо 2025 оны 5 сард өргөн баригдаад ингээд явсаараа байгаад одоо хэлэлцүүлж байгаа. Тэгэхээр ингээд яг энэ хуульдаа нийгмийн гэдэг агуулгаа уул нь нэг оруулбал. Уул нь байгаль орчин нийгмийн үнэлгээ хийдэг болно оо гэдэг концепцыг нь энэ хуулийн дэвшил болоод одоогийн төслөөр ороод ирчихсэн байгаа. Гэхдээ яг яаж хийх вэ гэдэг дээр нь нэлээн сайн ажиллая гэвэл миний бодлоор зүгээр хувь гишүүний бодлоор бараг тусдаа хууль нь өргөн баригдаад явбал илүү хурдан 2024-2028 оны хоорондоо амжаад батлуулах байх аа гэж бодож байна. Тэгээд тэр хуулийн төсөл дээр нь бас цаашдаа хамтраад ажиллахад асуудалгүй ээ.

Түрүүн манай Ганхүлэг гишүүний асуулт дээр энэ цацраг идэвхт бодис агуулсан тоног төхөөрөмж ашигладаг байгууллага гэж юуг хэлээд байгаа юм гэдэг энэ нөгөө рентген аппарат хэрэглэж байгаа эмнэлгийг хэлж байгаа юм байна лээ. Шүдний эмнэлгүүдэд бас ингээд шүдний зураг эд нар авдаг өөр эмнэлгүүд. Тэгэхээр тэр эмнэлгүүд нь хүчин чадлаасаа хамаараад ингээд зэрэглэл 3 руу орж...

С.Бямбацогт: Бум-Очир гишүүн тодруулъя.

Д.Бум-Очир: Энэ нийгмийн асуудал нь одоо бас хангалттай, чанартай бүрэн дүүрэн хийгдэж чадахгүй байгаа тухай асуудал аягүй олон шат шатанд яригддаг зүйл гэдгийг бид нар мэдэж байгаа. Энэ хэрэгжиж чадахгүй байгаа бас нэг шалтгаан нь юу вэ гэхээр бие даасан арга аргачлалтай байх ёстой. Засгийн газрын ажлын хэсэг гаргаад энэ 2020 оны 12 дугаар сард Засгийн газрын ажлын хэсгийн хэсэгт зориулсан тайлан гэдэг ийм тайланг МУИС, Оксфордын их сургууль эрдэмтэд судлаачид нэлээд гаргасан. Энэ аргачлал дээр яг нийгмийн нийгэмд нөлөөлөх байдлын үнэлгээг ямар журмаар яаж зохицуулах юм, аргачлал нь бие даасан аргачлал нь ямар байх юм бэ гэдгийг маш нарийн хийгээд өгчихсөн байгаа юм. Бид өдий болтол яг нарийн зохицуулсан ийм журам аргачлал байхгүй байгаа учраас энэ ажил маань учир дутагдалтай хийгддэг. Түүнийгээ дагаад янз бүрийн хэл үг, эсэргүүцэл хөдөлгөөн элдэв зүйл тасардаггүй...

С.Бямбацогт: Үг хэлчхэв үү? За тэглээ. 13 цаг болж байна. 14 цагаас чуулганы хуралдаанаа үргэлжлүүлье. Үдийн завсарлага. 14 цагаас цагтаа цуглаад гишүүд Буланы Бейсен гишүүн, Доржзодовын Энхтуяа гишүүн гээд асуултуудаа эхлэх нь байна аа.

Чуулганы завсарлага.

С.Бямбацогт: Үдээс хойших чуулганы нэгдсэн хуралдаанаа эхлүүлье. Буланы Бейсен гишүүн асуултаа асууя. Ажлын хэсгээ оруулаарай. Буланы Бейсен гишүүн асуултаа асууя.

Б.Бейсен: Энэ байгаль орчинд нөлөөлөх байдал үнэлгээний тухай хуулийн төслийг дэмжиж байгаа. Тэгэхдээ энэ Байгаль орчны яамныхан маань бас нэг хэд хэдэн зүйл анхааруулахгүй бол болохгүй байна. Энэ цацраг идэвхт бодисууд байж байна. Түрүүн би Ганхүлэг гишүүн, Бум-Очир гишүүн 2-ын саналыг дэмжиж байгаа. Лабораторийн химийн хорт бодисууд байж байна. Уул уурхайн хог хаягдлын асуудал байж байна. Зарим алтны уурхайнууд цианит хэрэглэж байгаа асуудал байж байна. Энэ бас байгальд сөргөөр нөлөөлж байгаа асуудал байж байгаа. Арьс ширний үйлдвэрийн хром хэрэглэж байгаа асуудал байж байна. Хром чинь одоо галлагенийн бүлгийн нэгдэлийн элемент мөртөө хүний биед хөгшрүүлэх нөлөөтэй бас тийм юм байдаг. Авто засварын газруудын уул уурхайн мотор кропны хаягдал тоснууд байж байна. Мөн эмнэлгийн хог хаягдал, шприц, тэгээд хуучин галзуугийн вакцины шил шприцийг шатаадаг байсан. Одоо эмнэлгүүдээс шатахгүй хог хаягдлыг аваад устгаж байгаа асуудал байгаа. Энэ мэтийн хог хаягдал дээр урамшуулал авчхаад мөн адилхан болж устгадаг зарим ил хаядаг асуудал байж байгаа. Энэ дээр манай яамны хяналтынхан бас анхаарч ажиллана биз. Тэгээд энэтэй холбоотой 2 асуулт асууя гэж бодож байна.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн төсөлд нийгмийн болон эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээг хэрхэн тусгасан бэ? Төслийн нөлөөлөлд өртөх иргэдийн нийгмийн нөлөөллийн асуудлыг хэрхэн шийдвэрлэх вэ? Сая Бум-Очир гишүүн, Ганхүлэг гишүүн бас асуусан.

2 дахь асуудал одоогоор байгаль орчны үнэлгээ хийх зөвшөөрөл авсан мэргэжлийн байгууллага 107 байгаа. 2023 онд аттестатчилал хийгдэж шаардлага хангаагүй мэргэжлийн байгууллагуудын эрхийг цуцалсан байгаа. Энэтэй холбоотой 2 дахь асуудал. Байгаль орчны үнэлгээний мэргэжлийн зарим байгууллагуудын чадавх сул, хийсэн ажлын тайлан хангалтгүй байна. Энэ хууль батлагдсанаар ямар ахиц гар гарах вэ? Энэ талаар асууя. Дараа тодруулъя.

С.Бямбацогт: Хэн хариулах вэ? ажлын хэсгийн ахлагч Болдын Уянга гишүүн хариулъя.

Б.Уянга: Яг нэмэлт мэдээллүүдийг яамнаас хариулах байх. Эрүүл мэндийн үнэлгээтэй холбоотой зохицуулалтыг яг одоо энэ оруулж ирсэн хуулийн төслийн 7.7-д нөлөөллийн үнэлгээний журам, үнэлгээ хийх төслийн ангиллыг Засгийн газар батална аа. За эндээ юу орох вэ гэхээрээ байгаль орчны нөлөөллийн үнэлгээний нэмэлт тодотгол, нийгмийн нөлөөллийн болон эрүүл мэндийн үнэлгээтэй холбоотой зохицуулалтыг тусгана гэж орж ирсэн. Тэгээд энэ журмаараа эрүүл мэндтэй холбоотой асуудлуудаа үнэлгээний агуулгыг оруулж өгөхөөр энэ төсөл дээр орж ирсэн.

Энэ мэргэжлийн байгууллагуудтай холбоотой асуултууд ажлын хэсгийн үеэр маш их яригдсан. Мэргэжлийн байгууллага нь яг үнэлгээгээ хийхдээ маш өндөр үнийг нэхдэг болсон юм байна. Үнэлгээнд нь үнэд нь тааз байхгүй байна аа гэсэн гомдлууд их ирсэн байсан. Энэ хуулийн төсөлд бас энэ мэргэжлийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой журмыг 4.4-рөө Засгийн газрын гишүүн батална гэдэг

байдлаар бас оруулж ирсэн байна лээ. Тэгээд нэмэлт таны асуултад яамнаас хариулах байх. Ажлын хэсгээс.

С.Бямбацогт: Индрийн 4 дүгээр микрофон ажлын хэсэг хариулъя.

Б.Алтантулга: Б.Бейсен гишүүний асуултад хариулъя аа. Аюултай хог хаягдал химийн бодистой холбоотой бүх үйл ажиллагаанууд зэрэглэл нэгд орсон байгаа. Журмын дагуу журмын төсөлд заагдсанаар зэрэглэл нэгээс зэрэглэл 2 луу доошоо буух боломжгүйгээр журмыг бол баталж байгаа. Тэгэхээр энэ дээр санаа зоволтгүй байгаа. Харин их яригдаж байгаа энэ цацраг идэвхт бодис агуулсан тоног төхөөрөмж ашигладаг байгууллагууд гэдэгт бол эмнэлгийн байгууллагууд, шүдний эмнэлэг түрүүн хэлсэн рентген тоног төхөөрөмжүүд хууль хяналтын байгууллагын рентген тоног төхөөрөмжүүд болон бусад байгууллагууд орж байгаа. Эд нар маань бас тусдаа зөвшөөрөл авдаг, хил гаалиар орж нэвтрэхдээ зөвшөөрөл авдаг, олон улсын стандарт шаардлагыг хангасан байдаг. Тэгэхээр энэ дээр нөгөө чөлөөллийн аяныхаа хүрээнд бид давхардсан энэ хяналтын тогтолцоогоо багасгаж байгаа юмаа. Ерөнхий үнэлгээгээ энэ 3 дугаар зэрэглэлийн байгууллагууд хийлгэнэ, хийлгэхгүй биш хийлгэнэ. Тэгээд хийлгэсэн ерөнхий үнэлгээнийхээ тайланг мэдүүлээд мэдэгдээд үйл ажиллагаа явуулах болж байгаа юмаа.

С.Бямбацогт: Бейсен гишүүн тодруулж асууя.

Б.Бейсен: Би сая Бум-Очир гишүүн, Ганхүлэг гишүүн бас ярьж байна. Ер нь мэргэжлийн байгууллагууд хог хаягдлаа замбараагүй хаядаг. Энэ асуудлууд дээр хяналтын асуудал дээр манай яамныхан хамтраад ажиллаад яахгүй бол зарим одоо хүнсний байгууллагууд байж байна, өвөлдөө малын тэр бүх нядалгааны газрууд юм асгаж байна, зундаа тэгээд тэр нь өмхийрөөд эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх асуудлууд байж байна. Энэ тал дээр бусад байгууллагуудтай хамтраад мэдээллийг нь аваад хамтарч ажиллавал зөв байх гэсэн санал хэлье ээ. Баярлалаа.

С.Бямбацогт: Санал хэллээ. Доржзовдын Энхтуяа гишүүн асуултаа асууя.

Д.Энхтуяа: Энэ хуулийн төслийг ерөнхийд нь дэмжиж байна аа. Анх удаагаа энэ байгаль орчны нөлөөллийн энэ хуулийн төсөл дээр нэмэлт өөрчлөлтөөр нийгмийн нөлөөллийн талаарх асуудлыг оруулж ирсэнд маш сайшаалтай хандаж байна. Тэгээд олон гишүүд ч гэсэн энэ дээр саналаа хэлж байна аа. Гэхдээ нийгмийн нөлөөллийг оруулж ирсэн хэрнээ нэг ганц 2 үгээр нийгмийн нөлөөлөл гэж хэлээд тэгээд хязгаарласан юм шиг надад санагдаж байна. Тэгэхээр нийгмийн нөлөөлөл гэдэг нь одоо яг юу юм. Нийгмийг орчин үе хүн амын уламжлалт амьдрал ахуй, аж ахуйн хэлбэр, хүн амын эрүүл мэнд, эрүүл аюулгүй орчинд амьдрах гэх мэтчилэн маш өргөн хүрээнд энэ үр дагаврыг хэрхэн яаж тодорхойлох, түүнийгээ одоо хэрхэн сааруулах төсөл хөтөлбөр хэрэгжиж байхад тиймээ энэ байгаль экологийн нөхөн сэргээлтээс гадна хүний ахуй амьдралтай холбоотой энэ бусад зүйлүүдээ яаж тодорхойлсон юм, тодорхойлолт нь бол маш хязгаарлагдмал одоо ийм төсөл орж ирсэн байна аа.

Тэгэхээр ер нь бол энэ байгаль орчныг хамгаалах талаар өмнөх энэ хуулиасаа нэлээн олон зүйлийн ухралтыг хийсэн юм шиг харагдаж байна.

Хоёрт нь бол иргэд орон нутгийн оролцоог маш их хумьж хязгаарласан байна. Тэгэхээр мэдээжийн хэрэг яах вэ мэдээж төсөл хэрэгжихэд тодорхой хугацаа

хэрэгтэй. Өнгөрсөн хугацаанд мэдээжийн хэрэг төсөл хэрэгжихэд маш олон даваагүй байсан энэ бүгдийг бас хязгаарлах гэж товчлох гэж үзсэн байх. Гэхдээ энэ эцсийн эцэст бид нар бол байгальтайгаа, нийгмийн зохицолтойгоо хүмүүс нь л энэ нутагт амьдрах учраас энийг бол маш сайн тодорхойлж өгөх шаардлагатай байсан гэж ингэж харж байна.

Гуравт нь бол ерөнхийдөө энэ хуулийн төслийг уншихад түрүүн Ганхүлэг гишүүн хэлж байна лээ. Энэ төсөл хэрэгжүүлэгч ААН-үүдийн хүсэл сонирхлыг илүү давамгайл харсан ийм байдал харагдаж байна аа. Хялбаршуулах нэрийн доор энд орон нутгийн иргэдийн оролцоог бол маш их хязгаарласан байна. Энэн дээр би ингээд хязгаарлалтуудыг ингээд харахад ерөнхийдөө та бүхэн хязгаарлагдаагүй ээ. Ингээд иргэд, олон нийт, сумын иргэд, аймгийн иргэд оролцох оролцоог нь маш хангалттай нээж өгсөн гэж байгаа боловчиг яг нөгөө тодорхой албан тушаалтнуудад илүү их давуу эрхийг олгочихсон ийм байдал харагдаж байна. Тэгэхээр энэ нь юу вэ гэхээр нөгөө л нөгөө авлигал, хээл хахууль энэ одоо ихэнхдээ энэ байгаа байгаль орчны уул уурхайн ийм төслүүд л явагдана шүү дээ. Тэгэхээр энэ дээр бол ийм авлигал хээл хахуулийг их өөгшүүлсэн юм шиг төсөл харагдаж байна аа.

Ингээд миний асуулт бол энэ төслийн 7.14 дээр сум, дүүргийн Засаг дарга нь төсөл хэрэгжүүлэгчээс ирүүлсэн хүсэлтийг хүлээн авч ажлын 10 хоногт багтаан хариу өгөх бөгөөд энэ хугацаанд шийдвэрлээгүй тохиолдолд хариу өгсөнд тооцно гэж байгаа байхгүй юу. Тэгэхээр нөгөө Иргэдийн нийтийн хурал, багийн нийтийн хурал нөгөө ард иргэдийнхээ санал хүсэлтийг авах нөгөө уламжлалт тиймээ газар хөндөхгүй байх гэх мэтчилэн маш их олон зүйлүүд энд орхигдож байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ түрүүний миний хэлээд байгаа ухралт болсон нь эндээс ингээд харагдаад байна аа. За энэ дээр нэг хариулт авчихъя.

Хоёрт нь энэ төсөл хэрэгжүүлэгч нь төслийн товч танилцуулга газрын эрхтэй холбоотой баримт бичиг байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээтэй холбоотой хүсэлтийг тухайн сум дүүргийн Засаг даргад гаргана гээд тэгж байна. Тэгэхээр энэ дээр газрын эрхтэй холбоотой бичиг баримт гэж яг ямар хуулийн үг хэллэгт байдаг, яг энэ газрын эрхтэй холбоотой бичиг баримт гэж ямар юмыг ойлгох юм бэ? Энэ дээр нарийвчилсан тодорхойлолтыг авъя.

Гуравдугаар асуулт нь бол энэ төслийн 9 дүгээр зүйлийн 10, 9.10 дугаар зүйлийн 10.5-д бичсэн байна л даа. Төслийн нөлөөлөлд өртөх иргэд. Иргэд гэж хэнийг хэлж байгаа юм. Нөлөөлөлд өртөх гэдэг орчныг ямар шалгуураар, ямар хүрээгээр тооцох гэсэн ийм аргачлалыг энэ дээр тодорхой зааж өгөөгүй ингэж харагдаж байна л даа. Тэгэхээр ер нь бол бид нар 2000 оноос хойш энэ кадастрын алба бол ер нь уул уурхайн ихэвчлэн уул уурхайн энэ бизнес энэ төс...

С.Бямбацогт: Хэн хариулах вэ? ажлын хэсгээс 4 дүгээр индэр.

Ш.Батбаяр: Энхтуяа гишүүний асуултад хариульъя аа.

Өмнөх хууль дээр байгаль орчны, нийгмийн үнэлгээний асуудал огт тусгагдаагүй байсан үнэн. Гэхдээ яамнаас Засгийн газрын 2023 оны 2 дугаар сарын 08-ны өдрийн 58 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журмыг баталсан байгаа. Энэ үнэлгээний журамдаа бид нийгмийн үнэлгээний асуудлыг маш томоор оруулж ирсэн байгаа.

2.4.2.3 дээр нийгэм нутгийн иргэдийн амьдралын чанар, хөдөлмөр эрхлэлт, аж ахуйн орлого, хөрөнгө, эрүүл аюулгүй байдал, эрүүл мэнд, хууль тогтоомжид заасан хүний эрх ашиг сонирхол, жендер, соёл уламжлал гэх мэт сөрөг нөлөөллийг арилгах, зөрчигдсэн эрхийг сэргээх, шилжүүлэн суурьшуулалт, нөхөн олговрын үйл ажиллагаа, соёлын өвийг хамгаалах, олон нийтийн оролцоо төслийн мэдээллийг ил тод нээлттэй байлгах, иргэдийн санал сонсох, төслийн үйл ажиллагаатай холбоотой аливаа нэг гомдол хүлээн авч барагдуулах арга хэмжээ болон бусад төлөвлөгөөтэй уялдсан байдлыг хангана аа гээд оруулж ирсэн зохицуулалтыг оруулж ирсэн байгаа.

Хоёрдугаар асуулт. Газрын харилцаа гэдэг нь газрын гэрчилгээ авах процессыг хэлж байгаа. Энэ дээр бол тухайн байгууллагын үйл ажиллагаа явуулж байгаа төсөл маань тухайн орон нутагт газар аваад тэрэн дээрээ объект бариад үйл ажиллагаа явуулах тохиолдолд гэдгийг оруулж байгаа юм. Улаанбаатар хотод үсчний газар нэг давхар түрээсэлж ажиллахыг хэлэхгүй. Зөвхөн тэр орон нутагт газар худалдаж аваад барилга бариад үйл ажиллагаа явуулж байгааг хэлж байгаа юмаа. Аргачлалын хувьд Байгаль орчны сайд, Хууль зүйн сайдын хамтарсан тушаалаар 2025 онд аргачлалыг баталсан байгаа. Энэ аргачлалыг шинээр сайжруулалт хийгдээд төсөл яаман дээр явагдаж байгаа.

С.Бямбацогт: Ажлын хэсгийн гишүүн Одонтуяа гишүүн нэмж хариулъя. Салдангийн Одонтуяа гишүүн.

С.Одонтуяа: Тэгэхээр маш олон гишүүд энэ нийгмийн нөлөөллийн үнэлгээний талаар асууж байна. Тэгэхээр би нэг жишээн дээр ярья. Эгийн голын УЦС-ын судалгааны ажлууд эхлээд явж байгаа. Энэнтэй холбогдуулаад бид энэ Эгийн голын УЦС-ын нөлөөллийн бүсэд хамрагдаж байгаа иргэдтэй газар дээр нь очиж уулзалт хийсэн юмаа. Тэгээд энэ иргэд яг нөлөөллийн бүсэд ороод тэр одоо байгаа газар нь ингээд төсөл хэрэгжих хэрэгжвэл яг ус нь давтагдах ийм эрсдэлтэй байсан учраас нүүлгэн шилжүүлэх тусад нь энэ айлуудыг жишиг баг болгох, тэнд хүүхдүүдийнх нь сургуулийн асуудал шийдэх, өөрсдийнх нь орлогын эх үүсвэр жимс жимсгэнээ тарих ч гэдэг юм уу ийм зүйл дээр нэлээд том төсөл яригддаг. Тэгэхээр энэ хууль ямар үед гол амжилттай хэрэгжих вэ гэхээр Улсын Их Хурлаар орох Ашигт малтмалын тухай хуульд тодорхой хувийг сум орон нутагт нь өгдөг болж байж...

С.Бямбацогт: Гүйцээгээд хариулчихъя.

С.Одонтуяа: Зардал очиж байж энэ орон нутагт энэ асуудлууд нь бол бас шийдэгдэх зардал нь шийдэгдэх юмаа. Түрүүн Энхтуяа гишүүн хөндлөө. Энэ нэг цөөн хүн шийддэг асуудал байна уу гээд. Тэгэхээр өмнө нь харин цөөн хүн шийддэг байсан зөвхөн багийн дарга, багийн Иргэдийн нийтийн хурал гэж. Тэгэхээр тухайн дарга бол юугаа шийддэг байсан бэ гэхээр одоо багтаа нэг компьютер ч гэдэг юм уу, машин унаа ч гэдэг юм уу, одоо бол хүрээг нь өргөтгөөд бүх иргэдээс нь нөлөөллийн бүсийн иргэдээс бүгдээс нь санал авах, санал гомдлыг нь шийдвэрлэх ийм зүйлүүд байгаа. Тэгэхээр нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуульд бас энэ багийн Иргэдийн нийтийн хурлын хугацааг аваад хаячихсанаас болоод энэ хурлууд нь хуралдахгүй байгаад байгаа юмаа. Тэгэхээр энийг ер нь буцааж оруулж заавал улиралдаа хуралддаг энэ асуудлуудаа хамтарч шийддэг байж байж энэ хууль сайн хэрэгжих болчихоод байгаа.

С.Бямбацогт: Энхтуяа гишүүн тодруулж асууя.

Д.Энхтуяа: Тэгэхээр ер нь бол энэ 2000-аад оноос энэ олгож өгсөн энэ лицензийн асуудлаас болоод говийн бүс дан ялангуяа байгаль экологийн тэнцвэрт байдлаа маш их алдсан байгаа. Тэгэхээр зүгээр нэг хотод нэг кадастрын албаны хүн ямар ч одоо байгаль экологи мөн уламжлалт ахуйтай нь холбосон ямар нэгэн мэдээлэлгүйгээр л лицензийн давхардал байхгүй л бол тэгээд лиценз олгоод л ирсний горьг бид нар амсаж байгаа байхгүй юу. Тэр оршин суугчдын тэр сумын иргэдийн асуудал хөндөгдөж байна. Өв уламжлал, ахуйн асуудал, экологийн асуудал дээрээс нь Үндсэн хуулиар олгогдсон эрүүл орчинд амьдрах энэ бүх асуудлууд бол нөлөөлж байгаа юмаа.

Тийм учраас би асуугаад байгаа юм. 10 хоногийн дотор багийн, сумын Засаг дарга энэ асуудлыг шийдээд хэрвээ хариу өгөхгүй бол шууд зөвшөөрснөөр тооцно гэсэн ийм заалт оруулж ирсэн байгаа байхгүй юу. Тэгэхээр сумын аймгийн Засаг дарга бол ер нь ихэнхдээ энэ говийн бүс чинь бол тэгээд л хөдөө сумдаараа ингээд л явж байхад 10 хоног бараг бичигтэйгээ танилцаж амжихгүй тэгээд л энэ асуудал бол автоматаар цааш...

С.Бямбацогт: Үг хэлчихсэн үү? Ажлын хэсэг Болдын Уянга гишүүн ажлын хэсгийн ахлагч хариулъя.

Б.Уянга: Энхтуяа гишүүнд баярлалаа. 7.14 заалт яг одоо бид нарт тараагдаж гишүүдэд тараагдаж өгсөн материал дээр болохоороо ажлын 10 өдөр буюу хоёр 7 хоног яг өдрөөр тоолбол 14 хоногт нь ерөнхий үнэлгээний үед юм байгаа юм ерөнхий үнэлгээ. Ерөнхий үнэлгээг болохоороо сум, дүүргийн Засаг дарга нараас хариу авч байгаа байдал. Тэгэхээр ийм яг одоо хуанлийн өдрөөрөө бодвол 14 хоногт тэгээд ажлын 10 хоногт байсныг нь ажлын хэсэг дээр 20 байсан нь зөв үү буюу нэг сар, 15 байсан нь зөв үү буюу гурван 7 хоног гэж ярилцаж ажлын хэсэг яамнаас ирсэн саналыг нь нэлээн дэлгэрэнгүй харж байгаад санал хураагаад 15 хоног гэдгээр орж ирснээр өнөөдөр санал хураагдах юм байгаа юм.

Энийг бол ерөөсөө л тайлбарлаж байгаа юм нь төрийн байгууллагуудыг хариуцлагажуулъя л гэж байгаа юм. Ингээд ерөнхий үнэлгээний дараа нарийвчилсан үнэлгээ хийгдэнэ. Нарийвчилсан үнэлгээ хийгдэх үеэр харин нөлөөллийн бүсийн иргэдүүд рүүгээ тулж ажиллана аа гэсэн ийм зохицуулалтыг танилцуулсан байгаа.

С.Бямбацогт: Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Наранцэцэгийн Алтаншагай, Пүрэвжавын Сайнзориг нарын урилгаар нийслэлийн ерөнхий боловсролын боловсролын 74 дүгээр сургуулийн 12-ын А ангийн багш сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна аа. Та бүгдийнхээ сурлагад нь өндөр амжилтыг хүсье ээ. Амьдралд нь аз жаргал, эрүүл энх, сайн сайхан бүхнийг нийт Их Хурлын гишүүдийнхээ нэрийн өмнөөс хүсэн ерөөе өө. Тэгээд удахгүй сургуулиа төгсөөд хүссэн сургуульдаа их, дээд сургуульдаа хүссэн мэргэжлээрээ суралцаж эзэмшээд, эх орондоо ихийг хийж бүтээсэн эх оронч иргэн болоорой гэж хүсье.

Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн асуултаа асууя.

Д.Энхтүвшин: Хуулийн төсөлтэй холбоотой 3 асуулт байна.

Нэгдүгээрт нь болохоор энэ хуулийн 6 дээр 6-г хүчингүй болгоно гэсэн заалт байгаа юм. 6 дугаар зүйлийг одоо мөрдөгдөж байгаа ерөнхий үнэлгээ хийх төслийн ангиллыг бүхэлд нь хүчингүй болгоно оо гээд. Тэгэхээр 7-гийн 8 дээр 8, 9 дээр энэ зэрэглэл тогтоох, энэ үнэлгээ хийх аргачлалыг Засгийн газрын гишүүн батална гээд. Тэгэхээр энэ хооронд энэ хуулиараа хүчингүй болгочихсон байдаг. Тэгээд ийм хурдан бас энэ журам аргачлал маань гарч чадах болов уу? Зөвшөөрлийн тухай хууль дээр ингээд хараад үзэхэд 2, 3 жил болж байхад аргачлал нь гараагүй жишээлбэл. Одоо сая энэ 7 хоногийн Засгийн газрын хуралдаанаар жишээлбэл гарч байх жишээтэй. Тэгэхээр ийм асуудал үүсээд дунд нь хийдэл гарах тийм юм байх вий дээ. Энэ талаар нэг хариулт өгөөч? Энийг яаж шийдэх гэж байгаа юм.

Хоёрдугаар асуулт нь болохоор энд юу гэж заасан байгаа юм. Ерөнхий шинжээч байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тайланд шинжилгээ хийж дүгнэлт гаргах ерөнхий шинжээч нь тэр 3 шаардлага тавьсан байгаа юм. Нэг нь болохоор мэргэжлийн чадвартай тэгээд ажлын туршлагатай гээд. Тэгээд дээр нь байгаль орчны чиглэлээр 8-аас доошгүй жил ажилласан гээд. Тэгэхээр яг энэ заалт маань өөрөө 8-аас доошгүй жил ажилласан ер нь бол нийт хэдэн хүн байдаг юм. Энэ талаар хийсэн судалгаа байгаа юу? Бас цөөн хэдэн хүн болоод энэ үйл ажиллагааг хязгаарлах, энэ 8-аас дээш жил туршлагатай цөөн хэдэн хүн илүү давамгай энэ өрсөлдөөнийг хязгаарлах бололцоо боломж бий болчих юм биш биз дээ гэсэн болгоомжлолын үүднээс асууж байна. Тэгээд энэ талаар мэдээлэл өгөөч? Энэ 8-аас дээш доошгүй жил ажилласан яг энэ ерөнхий шинжээчийн шаардлага хангах ер нь хэдэн хүн байдаг юм.

Гуравдугаарт нь болохоор төсөл, төслийн нөлөөлөлд өртөх, төслийн нөлөөлөлд өртөх иргэдэд энэ төсөл хэрэгжүүлэгч байгууллага үнэлгээ хийсэн мэргэжлийн байгууллага нь танилцуулж санал авах ажлыг зохион байгуулна гэж байна. Тэгэхээр уул нь энэ маш чухал заалт оруулж ирсэн. Энийгээ жоохон процессыг нь тодорхой болгоод өгчихвөл зүгээр юм уу гэж санагдаад байгаа юм. Өөрөөр хэлбэл яг ямар хугацаанд өгөх юм. Жишээлбэл ингээд санал авах хугацаа нь ингээд байхад өнгөрчихсөн хойно нь ч юм уу ингээд тасралтгүй саналууд гараад байдаг. Тэгээд тэр нь жишээлбэл хэрвээ тодорхой хугацаанд саналуудаа ингээд хэлэлцүүлгээ хийгээд саналуудаа авчихвал залруулах бололцоо боломжууд ААН-үүдэд гарна шүү дээ тиймээ. Тэгэхээр энэ бололцоо боломжийг нь хангахгүй ингээд тасралтгүй санал гараад л, гомдоод ч юм уу бас иймэрхүү асуудлууд гараад байвал энэ нь өөрөө ингээд энэ заалтын ач холбогдол сулрах ийм магадлалтай учраас энийг илүү процессжуулах боломж ч юм уу ажлын хэсэг дээр ярьсан зүйл байгаа юу гэсэн ийм 3 асуулт байна. Баярлалаа.

С.Бямбацогт: Ажлын хэсэг 4 дүгээр микрофон.

Ш.Батбаяр: Энхтүвшин гишүүний асуултад хариулья аа.

Журмын хувьд байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр батлагдсан менежментийн төлөвлөгөөнд нэмэлт, өөрчлөлт оруулах, хянах, тайлагнах, журам аргачлалыг бид боловсруулчихсан байгаа хуулийн төсөлтэйгөө хамт. Тэгэхээр хууль батлагдмагц Засгийн газрын хуралдаанаар оруулж шийдүүлэх ажил байгаа.

Ангилал зэрэглэлийг тогтоох хувьд түрүүн хэлчихсэн. Одоо дээш доош гүйх боломжгүй байгаа. Ерөнхий шинжээчид тавьж байгаа шаардлага бол бас амьдрал

дээрээс гарч ирсэн шаардлага байгаа. Түрүүн хэлсэнчлэн 3 ангиллаар 11-15 хүнтэй зөвлөлүүд байгаа. Мэргэжлийн зөвлөлүүд байгаа. Энэ зөвлөлд маань дандаа төрийн албан хаагчид байгаа, олон жил ажилласан мэдлэг туршлагатай удирдах албан тушаалтнууд байдаг. Энэ мэргэжлийн зөвлөлийн үйл ажиллагааг удирдлага, чиглэлээр хангаж, зохион байгуулж ажиллахын тулд эрхэлсэн түшмэлийн хэмжээний буюу газрын даргын хэмжээний хүн байж байж энэ мэргэжлийн зөвлөлийн үйл ажиллагааг хэвийн явуулах юм байна гэж үзсэн. Өмнө нь бас туршлага бидэнд байгаа. Тэгэхээр энэ мэргэжлийн зөвлөлийн үйл ажиллагааг удирдлага чиглэлээр хангахын тулд газрын даргын түвшний хүн байна. Тэгэхээр манай яаманд одоогоор 7 газартай, 7 газрын дарга байна. Мөн түүнчлэн яаманд тогтвор суурьшилтай аж ажиллаж байгаа 26 хүн байна. 8-аас дээшээ жил ажилласан.

С.Бямбацогт: Ажлын хэсгийн ахлагч Болдын Уянга гишүүн нэмж хариулъя.

Б.Уянга: 3 дугаар асуултад хариулъя. Нөлөөлөлд өртөх иргэдэд мөн нутгийн засаг захиргааны байгууллагуудад мэдээлэл өгөхөд процессын асуудал буюу 10.5 дугаар заалтыг та хөндөж байна аа. Энийг бол ажлын хэсэг дээр найруулаад нэлээн тодорхой болгож оруулж ирсэн заалт байгаа юм. Одоо ер нь энэ нөлөөллийн тайлан үнэлгээ тайлангууд хийгдээд яг газар дээр юу болж байна вэ гэхээрээ мэргэжлийн байгууллагууд нь хойшоо суучхаад байгаа юм. Шууд захиалагчийг нь яг тэр нөлөөлөлд өртөж байгаа иргэдтэйгээ шууд тулгаад тэр тайланд бичигдсэн байгаа ургамлыг, тэр тайланд бичсэн байгаа усыг, тэр тайланд бичсэн байгаа ой модыг захиалагч хариулах боломжгүй шүү дээ. Нэлээн нарийн тийм зүйлүүдийг ярих асуувал яах вэ.

Тэгэхээр энэ 10.5 дугаар зохицуулалт дээр заалт дээр болохоор нөлөөллийн бүсийн иргэддээ очиж нөлөөлж, тэнд амьдарч байгаа иргэдийн 70 хувьд нь хүрч ажиллахдаа өөрсдөө яв аа, тэгээд захиалагчтайгаа хамт яв аа, очоод тайлбарла аа гэсэн ийм яг нарийн процесс нь журмаар л орж ирэхээр байгаа юм.

С.Бямбацогт: Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн тодруулж асууя.

Д.Энхтүвшин: Тэр бэлэн болчихсон журмыг нь хуваалцаж болох уу? Тэрийг өг гэж 1 дүгээрт. 2 дугаарт асуулт дээр болохоор ер нь 8-аас дээш доошгүй жил ажилласан энэ шаардлага хангаж байгаа 26 хүн байгаа гэж ойлголоо. Тэгэхээр энэ 26 хүн хангалттай ачааллаа хуваалцаад явчихна гэж ойлголоо. Зөв үү. 3 дахь тэр асуулт дээр болохоор гол нь би нөгөө нэг санал авах энэ хугацаа гэдгийг нь яах вэ журмаар гэхээс илүү хууль дээр заагаад өгчихвөл ямар хугацаанд хангалттай энэ юу хэлэлцүүлэг танилцуулах юмаа хийгээд, тэгээд тэнд одоо жишээлбэл засаж залруулах, орон нутгийн иргэдийн тэр байгаль орчинтой холбоотой асуудлууд дээр нь энэ засаж залруулах бололцоо боломжийг нь олгоод, тэгээд арга хэмжээ аваад явбал гэсэн санаагаар тодорхой оруулчихвал гэж ийм санаа байгаад байгаа юм.

Тэгэхгүй болохоор ийм сунжилдсан ингээд хэзээ ч хамаагүй ингээд санал гаргаж болдог энэ нь болсон болоогүй тэгээд л эсэргүүцэл гаргадаг, эсэргүүцдэг иймэрхүү асуудал.

С.Бямбацогт: Ажлын хэсэг 4 дүгээр микрофон хариулъя.

Ш.Батбаяр: Журмын төслийг танд өнөөдөр бичгээр хүргүүлье. Санал авах тэр хугацаан дээр ерөнхий үнэлгээг хийлгэх зөвшөөрлийн албан тоот байдаг байхгүй юу. Орон нутгаас явуулдаг энэ маань ерөнхий үнэлгээ хийлгэхийг зөвшөөрч байна гээд орон нутгийн засаг даргын албан бичиг байдаг. Энийгээ ажлын 15 хоног болгож, 10 хоногийг 15 хоног түрүүн хэлсэн болгож сунгасан байгаа. Тэгээд энэ зөвшөөрөл албан тоот ирсэн ирээгүй тохиолдолд одоо зөвшөөрсөнд тооцоод үнэлгээгээ хийнэ л гэж байгаа. Ерөнхий үнэлгээгээ л хийнэ гэж байгаа. Дараа нь бол нарийвчилсан үнэлгээний асуудал тусдаа асуудал байгаа.

С.Бямбацогт: Зочин танилцуулъя. Нийслэлийн ерөнхий боловсролын англи хэлний Кингс Кидс сургуулийн 9-ийн А ангийн багш сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа Төрийн ордонтой танилцаж байна аа. Та бүгдийнхээ сурлагад нь өндөр амжилт, амьдралд нь аз жаргал, эрүүл энх, сайн сайхан бүхнийг Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийнхээ нэрийн өмнөөс хүсэн ерөөе. Онц сураарай тэгээд аав ээжийнхээ үгэнд сайн орж байгаарай.

Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан гишүүн асуултаа асууя.

Л.Мөнхбаясгалан: Би ажлын хэсгийн Уянгаа гишүүн, Одонтуяа гишүүн 2-оос асуугаад тэгээд яамны зүгээс нэмж хариулт өгвөл өгөөрэй гэж хүсэж байна. Төслийн 10.5 дээр энэ их аятайхан заалт орж ирсэн мөртөө байгаль орчны нөлөөллийн үнэлгээний тайланг төсөл хэрэгжүүлэгч үнэлгээ хийсэн мэргэжлийн байгууллага хамтран төслийн нөлөөлөлд өртөх иргэдэд танилцуулж санал авах ажлыг зохион байгуулна гэж байгаа юм. Нөлөөллийн бүс гэж орж ирсэн нь маш талархууштай санагдаж байна. Тэгэхээр энэ дээр надаа 2 асуулт, нэг кэйс байна. Юу вэ гэхээр одоо тэр нөлөөллийн бүсэд өртөөд байгаа иргэдийг нүүлгэн шилжүүлдэг юм уу эсвэл эд хөрөнгийг нь нөхөн төлдөг тийм үү. Одоо ч тэр зохицуулагддаг шүү дээ. Энүүгээр бас дахиад журмаар зохицуулагдах юм шиг байна. Эрүүл мэндийн асуудлыг нь ерөөсөө яадаггүй тоодоггүй. Гэтэл Монгол Улсын иргэн өнөөдөр эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхтэй гэсэн Үндсэн хуулийн тулгуур заалт чинь байхгүй байгаа. Жишээ нь энэ байгаль орчны ямар ч хууль дээр манай говийн бүс дандаа хамгийн өндөр асуудалтай байдаг.

Өмнөговь аймгийн Цогтцэций суманд миний бие Улсын Их Хурлын гишүүн болсон цагаасаа нүүлгэн шилжүүлсэн Цагаан-Овоо багийн иргэдэд эрүүл мэндийн нөлөөллийн эрүүл мэндийн шинжилгээ хийлгэх гээд өнөөдрийг хүртэл барахгүй байна. НЭМҮТ эрдмийн зөвлөл нь аргачлал батална гээд чадахгүй байна. Тэгэхээр энэ нөгөө ард иргэдийнхээ эрүүл мэндийн асуудлыг орхиод байгаа юмаа. Тэгэхээр та бүхэн энийг журмаар гээд сая журам уншиж өглөө шүү дээ тиймээ. Энэ журам биш энийгээ хуульчилмаар байна. Тэгээд төслийн нөлөөлөлд өртөх иргэд гэхээр чинь одоо тухайн төсөл хэрэгжихэд нэг 10 айл ч юм уу, 5 айл байх юм бол зөвхөн тэдний саналыг авах нь байна шүү дээ. Багийн хурлын саналыг яагаад болиулчаж байгаа юм. Багийн хурал чинь заавал байх ёстой гэж бодоод байна. Тэгээд энэ дээр асуугаад тодруулъя.

С.Бямбацогт: Болдын Уянга гишүүн ажлын хэсгийн ахлагч хариулъя.

Б.Уянга: Мөнхбаясгалан гишүүнд баярлалаа. 10.5 дугаар заалт дээр бас нэлээн тойрч ярьсан юм байгаа юм. Яаж нөлөөллийн бүсийн иргэддээ мэдээллийг нь өгөөд, эргээгээд саналыг нь аваад тусгуулах вэ гээд. Тэгээд энэ заалт бас процессын хувьд тогтвортой үргэлжлэх ёстой. Тэгэхээр журам дээр оруулж ирэхдээ

нэлээн эндээс бид нар хууль батлаад орхих биш яг журамд нь энэ хуулийн заалтын агуулга нь бүрэн тусах эсэх дээр нь салбарын сайдтай хамтарч ажиллаж хэрэгжүүлэлт дээр нь анхаарах ёстой юм билээ.

Эрүүл мэндийн асуудлын талаар ер нь харин тийм Тантай санал нэг байна аа. Ер нь нийгмийн үнэлгээ хийе гэхэд л яг яаж хийх вэ гээд л гацчихаж байгаа юм. Ингээд энэ яамнаас 2022 оноос хойш боловсруулж байгаа энэ үнэлгээний хуулийн төсөл дээрээ эрүүл мэнд гэдэг үгийг оруулж л ирж нэг дэвшил авчирч байгаа юм. Нийгмийн нөлөөллийн үнэлгээг сая сүүлд гаргасан журмын шинэчлэлээрээ нэг хэд хэдэн заалтуудыг журам дээрээ оруулж өгсөн байсан. Эрүүл мэндийн асуудлууддаа оруулна аа гээд 7.7 дээрээ тусгачхаад яг яах вэ гэхээр ингээд нэг ийм манай эсвэл төрийн байгууллага дотроо хоорондын зохион байгуулалтын асуудал байна уу? Эрүүл мэндийн байгууллага нь ингээд тусдаа ингээд босоод яваад, Гэр бүл, нийгмийн хамгаалал нь бас ингээд ийм хөндлөн хамтын ажиллагаа байхгүй.

Тэгээд магадгүй Бум-Очир гишүүн бол нийгмийн үнэлгээ хийх хуулийг тусад нь өргөн барина гээд байгаа юм. Тэгэхээр тэр ЭМЯ, эрүүл мэндийн салбарынхан өөрсдөө эрүүл мэндийн үнэлгээг тэгвэл ингэж хийе гээд орж ирэх нь зөв юм шиг байгаа юм. Тэгэхгүй болохоор ингээд хамтад нь нэгтгэчихье гэнгүүт Байгаль орчны яам жишээ нь эрүүл мэндийн асуудал руу шууд хойшоо суучхаж байгаа юм. Тэгээд энэ их Цагаан-Овоо багийнхан энэ говийн бүсийн энэ их асуудлуудын мэдээлэл нь ирээд байнгуут тэр 7.7 дугаар журмаа батлахдаа эрүүл мэндийн үнэлгээг хамтад нь хийнэ ээ л гэж оруулж ирж байгаа юм шиг байгаа юм. Тэгэхээр энэн дээр энэ гишүүдийн анхаарал хандуулж хэлж байгаа бүх зүйлийг нь протоколдоод холбогдох яамдууд руу нь Их Хурлын тогтоол байдлаар ямар байнгын хорооноос ч юм уу эсвэл өгүүлэх ёстой байх гэж бодож байна аа.

Багийн хурал бол засаг захиргаа түүний нэгж удирдлагын тухай хуулиараа хэвээрээ үргэлжилж байгаа. 2012 оны энэ хууль дээр хүртэл санал тэмдэглэл гэж гэдэг агуулгаар байдаг. Тэгээд нөлөөлөлд өртөх иргэд тэнд байгаа иргэдийнхээ саналыг тусгаад, тусгаснаа батлаад танилцуулах юм бол яаман дээр зэрэглэл нэгийн энэ төслүүдийн төслийг хүлээж авъя гээд ийм асуудал руу орж байгаа юм байна лээ. Тэгээд яг хөдөө орон нутгаар явахаар манайд багийн хурлаар дэмжээгүй юмыг дэмжихлээ гээд ингээд загнуулдаг. Тэгээд яамнаас нь асуухаар энэ бол зөвшөөрлийн хуульд ороогүй агуулга учраас бид нар ерөнхий саналыг нь тусгасан эсэхийг нь хардаг юмаа л гэсэн хариулттай байх юм.

Тэгээд яг энэ хуулийг дагаад Засаг захиргаа нутаг дэвсгэрийн тухай хуульд өөрчлөлт оруулъя гэж орж ирээгүй. Дээр нь Зөвшөөрлийн тухай хууль бас орж ирсэнгүй ээ. Тэгэхээр ингээд дараагийн...

С.Бямбацогт: Нэмээд ажлын хэсгийн гишүүн Салдангийн Одонтуяа гишүүн хариулъя.

С.Одонтуяа: Мөнхбаясгалан гишүүн маш чухал асуудал хөндлөө. Эрүүл мэндийн асуудал гээд. Тэгэхээр одоо энэ гол юмнууд нь нөгөө зардалгүйгээсээ бас ингээд болоод байдаг. Тэгэхээр одоо энэ АМНАТ-ийн хууль гээд тэртээ тэргүй энэ ААН ингээд төлөөд явдаг. Тэгэхээр энэ ААН нэгэнтээ улсад төлж байгаа юм чинь эндээс нь тодорхой хувийг суманд өгье гэдэг хууль орж ирж байгаа. Тэгэхээр энэ суманд орж ирж байгаа мөнгөнөөс нь энэ эрүүл мэндэд нь зарцуулах энэ зүйлийг бид нар бас юугаар юм ямар ч байсан нэг хууль эрх зүйн юугаар зохицуулах ёстой.

Одоо жишээлэхэд манай тусгай хамгаалалттай газар нутаг дээр иргэд маань ингээд дайжаад ирдэг. Тэгэхээр бид аль болохоор дайжуулахгүйн тулд тэнд түргэний машин өгдөг ч юм уу сая 2024 онд энэ ажлыг нэлээд хийсэн. Тэгэхээр энэ яг нөлөөллийн бүсэд орж байгаа иргэд сэтгэл санааны маш ийм хямралтай байдаг. Яагаад гэхлээр хийгдэх нь мэдэгдэхгүй ингээд газрын гэрчилгээ нь бүтэхгүй ингээд асууд...

С.Бямбацогт: Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан гишүүн тодруулж асууя.

Л.Мөнхбаясгалан: Уг нь энд Байгаль орчны сайд байж байсан бол их зөв юм байлаа. Одонтуяа гишүүний хэлдгээр яг үнэн. Мөнгө нь шийдэгддэггүй бишээ уучлаарай Эрүүл мэндийн сайд. Мөнгө нь шийдэгддэггүй гээд мөнгийг нь одоо жишээлбэл Цогтцэций сумын асуудал дээр Цогтцэций сумын Засаг даргын газраа шийдээд бүүр эрүүл мэндийн данс сайдын тэр нөгөө юуных нь данс руу хийчихсэн байхгүй юу НЭМҮТ-ийн данс руу. Тэгчхээд байхад аргачлал нь байхгүй. Тэгэхээр одоо бид нарын энэ хууль чинь миний санал оруулж байгаагаар та хэд журамлахгүй наадхаа хууль дээрээ оруулж ир. Яагаад гэхээр хуулиас давсан журам журмыг засах маш амархан. Ялангуяа Эрүүл мэндийн сайд, Байгаль орчны сайд нар байнга солигддог. Тэгээд энэ нь ингээд журам нь өөрчлөгдөөд байх магадлалтай байхгүй юу. Тэгэхээр энийгээ юун дээр хууль дээрээ санаачилж оруулж ирье.

Дээрээс нь энэ саналыг авчхаад яг яах гэж байгаа юм. Санал ажиллах ажлыг зохион байгуулна гэж байна шүү дээ. Санал авах ажлыг зохион...

С.Бямбацогт: Хэн хариулах вэ? Одонтуяа гишүүн хариулъя ажлын хэсгийн гишүүн.

С.Одонтуяа: Тэгэхээр энэ аргачлал нь байхгүйгээс ингээд байгаа мөнгө нь шийдэгддэггүй ээ гэж байна. Тэгэхээр энийг бид ажлын хэсгийнхэн анхааралдаа авъя. Энэ эцсийн хэлэлцүүлэг дээр энэ асуудлуудыг нь оруулж ирэх ёстой байх. Энэ хууль нэмэлт, өөрчлөлт нэг хэд хэдэн асуудлууд дагалдах хуулиуд нь орж ирээгүй байгаа. Тэгэхээр бид энэ хуулиа батлагдмагц бас хэд хэдэн дагалдах хуулиудыг тусад нь нэмэлтээр ойрын үед өргөн барихаар ер нь орхигдсон асуудлуудаа бэлдэж байгаа. Энэ хуулийг яагаад бас ингээд хугацаа алдалгүй баталъя гээд байгаа гэхээр бизнесийнхэн эндээс их олон гомдол ирж байгаа учраас ямар ч байсан энэ хурдхан ангилаад, энэ хүнд суртлыг нь арилгаадахъя гэж байгаа. Тэр гомдлыг яаж авч хэлэлцэх юм бэ гэж. Тэгэхээр өмнө нь ерөөсөө иргэд хаашаа гомдлоо өгөх нь тодорхойгүй байсан бол одоо энд бүүр нарийвчлаад...

С.Бямбацогт: Гүйцээгээд хариулчихъя Одонтуяа гишүүний микрофон.

С.Одонтуяа: Иргэд энэ санал авах үедээ яг энэ хамтарсан багт энэ гомдлоо гаргах ёстой юм байгаа юм. Хамтарсан баг энэ гомдлыг хүлээж аваад энэ гомдлуудыг хэрхэн яаж шийдвэрлэхээ эргээд энэ иргэддээ мэдэгдэж тайлагнах юм. Хэрвээ энэ иргэдэд гол нь уулзаж санал авч байгаагийн чинь гол зорилго нь тэр шүү дээ. Ямар нэгэн гомдол санал байна уу гээд. Тэгэхээр энэ гомдол санал хэрвээ шийдэгдэхгүй бол дараагийн шатанд засаг захиргааныхаа журмаар дахиад гаргах юу нь байгаа. Гол нь урьд нь энэ механизм ажиллаагүй. Одоо бол энэ хуульд ерөөсөө шууд энэ хамтарсан багтаа гаргаад явахаар байгаа юм.

С.Бямбацогт: Баярлалаа. Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Жаргалсайханы Золжаргалын урилгаар Нийслэлийн ерөнхий боловсролын Эрдмийн өргөө сургуулийн 8-9 дүгээр ангийн багш сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа Төрийн ордонтой танилцаж байна аа. Та бүгдийнхээ сурлагад нь өндөр амжилтыг хүсье. Амьдралд нь аз жаргал, эрүүл энх, сайн сайхан бүхнийг Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс хүсье. Тэгээд онц сураарай, багшийнхаа үгэнд, аав ээжийнхээ үгэнд сайн орж байгаарай.

Далайн Батбаяр гишүүн асуултаа асууя алга байна. Мэндбаярын Мандхай гишүүн асуултаа асууя.

М.Мандхай: Энэ салбар ер нь энэ парламент бүрэлдсэнээс хойш ер нь 3 сайдын нүүр үзсэн хууль гэж хэлж болно. Тэгээд ингээд энэ хуулийг харахаар төслүүдийг эрэмбэлдэг болох юм байна. Ямар ч байсан байгаль орчны үнэлгээ нь нэг өөр өөр байх юм байна гэдэг нь харагдаж байгаа. Энэнтэй холбоотойгоор би нэг ноцтой нэг бас нэг надад асуудал байгаа юм асуулт байгаа юм. Байгаль орчны асуудалд ер нь чөлөөлөх, хөнгөлөх энэ үнэлэхгүй болох гэсэн ойлголт ер нь байх ёсгүй гэж бодож байгаа. Байгаль орчны өөрөө үнэлгээ бол одоо мэргэжлийн зөвлөл мэргэжлийн энэ процесс явагддаг ийм чухал асуудал байдаг. Тэгэхлээр энийг тодорхой асуудлыг нь үнэлгээг нь хийхгүй, үнэлэхгүй байх ийм асуудлыг энэ хуульд оруулж ирж болохгүй байх аа. Гэтэл энэ 7.12 дээр энэ хуулийн 7.7-д заасны дагуу баталсан нөлөөллийн үнэлгээ хийх төслийн ангилалд заагаагүй төсөлд байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийлгэхийг шаардахгүй гэж оруулсан байгаад байгаа юм. Байгаль орчинд яг энэ хохирол учруулахгүй төсөл гэж ер нь яг ямар төслийг та хэд үнэлж гаргаж ирж байгаа юм бэ гэдэг дээр нэг хариулт өгөөдхөөрэй.

Хоёрт энэ 7.13 дээр төсөл хэрэгжүүлэгч нь төслийн товч танилцуулга газрын эрхтэй холбоотой баримт бичиг байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээтэй холбоотой хүсэлтийг тухайн сум дүүргийн Засаг даргад гаргана гэхчхэн байгаа. Яг одоогийн бодит байдал дээр орон нутагт эрх мэдлийг нь өгөх хэрэгцээтэй одоо нэрийн доор ер нь бол энэ байгаль орчны асуудал дээр хайр гамгүй ер нь ашиглаж байгаа шүү дээ. Яг үндсэндээ бол энэ суурь ер нь энэ улс төрийн нөлөөлөлд автдаггүй. Энэ өөрөө институцийн суурь асуудал ерөөсөө бэхжээгүй байх үед орон нутаг руу энэ асуудлыг өгч шийдвэрлүүлэх гэж байгаа нь яг ямар учир шалтгаан энэний цаана байгаа юм бэ гэдгийг тодруулаад өгөөч ээ.

Одоо үндсэндээ энэ хууль дээр яамнаас мэргэжлийн байгууллагаас эрх мэдлийг нь тасалж аваад орон нутагт нь өгөх гэж байгаа асуудал яваад байна аа. Ингэснээс болоод энэ байгаль орчинд учруулж байгаа энэ хор хөнөөл, эрсдэл, энэ үнэлэх нарийн мэргэжлийн чухал асуудлууд ер нь орхигдоод байгаа гэдгийг онцгой анхаарах ёстой байх аа.

Энэ 7.14 дээр сум дүүргийн Засаг дарга нь төсөл хэрэгжүүлэгчээс ирүүлсэн хүсэлтийг нь аваад ажлын 10 хоногт багтаан хариу өгөх гэдэг нэг ийм заалт ороод ирчихсэн байгаа. Тэгэхээр үндсэндээ энэ Засаг дарга хүсэлт аваад 10 хоногт хариу өгнө. Хариу өгөхгүй байх юм бол зөвшөөрсөнд тооцож байгаа юм байна аа. Тэгэхлээр энэ орон нутгийн энэ улс төрд одоо нөлөөлж байгаа энэ улс төрийн өндөр нөлөөтэй энэ асуудлыг ер нь яаж шийднэ гэж харж байгаа юм бэ? Энийг эрсдэлгүй гэж та хэд үзэж энэ хуульдаа оруулж байгаа юм уу? 1 дүгээрт.

2 дугаарт энэ асуудал 10 хоногийн дотор хариу өгч чадахгүй бол ингээд зөвшөөрсөнд тооцоод явж байгаа нь энэ мэргэжлийн бус байгууллагуудын шийдвэрийг үл ойшоож байгаа юм уу? Энэ дээр нэг тодорхой хариу өгөөч ээ. Энэ 10 хоногт багтаагаад ирэхгүй байх юм бол энэ ямар нэгэн шийд гараагүйг өгсөнд тооцож байгаа энэ утга яг энэний цаана яг ямар зүйлийг бодож, ямар утгатай энэ тайлбарлаж байгаа вэ гэдэг дээрээ нэг хариу өгөөч.

Мөн цахимаар гэж үзье л дээ. Одоо цахимаар ингээд мэдээлэл нэгтгэж өгч байгаа юм байна. Тэгэхээр цахимаар ирүүлсэн албан бичгийг та нар шүүхийн өмнө хүчин төгөлдөр байгаа гэж үзэх үү? Энэ хуулиар зохицуулагдаж байгаа талаар мэдээлэл юу байна гэдгийгээ хариулаад өгөөрэй.

Зэрэглэлийн хувьд энэ 5 жил, 10 жил гэсэн нэг ийм зэрэглэлийг гаргаж ирж байгаа юм байна. Үндсэндээ 5-10 жил гэдэг үнэлгээ хийхгүй энэ хугацаанд үнэлгээ хийгдэхгүй орхих гэж байгаа юм уу? тэгээд хэрэв ингээд хүчин чадал юу гэдэг юм бизнес нь жоохон өргөтгөсөн ийм өөрчлөлт ороогүй байх юм бол үндсэндээ ингээд нөлөөллийн үнэлгээ хийхгүй ээ гэдгээрээ яваад өгөхлөөр дараа нь энэ нөгөө үүсэх үр дагавар, тэр эрсдэлүүдийг одоо...

С.Бямбацогт: Ажлын хэсгийн ахлагч Болдын Уянга гишүүн хариулъя.

Б.Уянга: Мандхай гишүүний асуултад хариулъя. Баярлалаа. Энэ төслүүдийг 3 зэрэглэлд эрэмбэлж байгаа нь болохоороо 2022 оноос яг мэргэжлийн яам нь олон улсын энэ стандартуудыг судалсны үндсэн дээр гаргаж ирсэн юм билээ. Олон улсад болохоороо А, В, С гээд ингээд үнэлээд явчихдаг. Манайх хуульдаа нутагшуулж буулгахдаа зэрэглэл 1, 2, 3 гээд тэгээд таны яг асууж байх үед энэ над руу дэд ажлын хэсгээс өгсөн IBRD-ийн ер нь Европтоо ингэж ангилж байгаа төслүүдийг нь хартал ерөөсөө ямар ч төслийг бусад гэж үлдээхгүйгээр л бүгдийг нь сайхан ангилаад л энэ бол ийм нөлөөтэй гээд явчхаж байгаа ийм дүр зураг ажиглагдаж байна. Тэгэхээр энэ хуулийн төсөл ажлын хэсэг дээр яг энэ ажилласан судлаачдын тайлбарыг ингээд сонсох тусам манайх нэг шат ахиж байгаа юм байна аа гэдэг ойлголтыг авсан.

Ер нь ингээд нэг сая зэрэглэл 3 дээр байгаа төслүүдийг огт үнэлгээ хийхгүй юм уу гэж Мандхай гишүүн асуулаа. Нарийвчилсан үнэлгээг л хийхгүй юм байгаа юм. Ерөнхий үнэлгээг бол хийнэ. Ерөнхий үнэлгээг хийхдээ сум болон дүүргийн Засаг дарга руу ингээд мэдээллийг нь явуулаад нарийвчилсан үнэлгээ хийх үү гээд ингээд асууж байгаа. Би буруу бол манай мэргэжлийн яамнаас нь хариулаарай. Тэгэнгүүт сум дүүргийн Засаг дарга нь хий гэж хариугаа өгөхдөө л хугацаа байхгүй учраас ирүүлэхгүй тэгээд нарийвчилсан үнэлгээ нь хийгдэхгүй. Тэгээд одоо зүгээр автомашины зогсоол эсвэл төвийн шугамд холбогдсон үйлчилгээний төв, авто угаалга, үсчин, дархан, уран дархны газар, тэгээд еще алт мөнгө, гоо сайхан хэвлэл гээд энэ бүгд нэг ямар нэгэн субъектив гарын үсгийн хүлээлттэйгээр нарийвчилсан үнэлгээ нь хийгдэхгүй нөхцөл байдал үүсээд байгаа учраас ерөнхий үнэлгээг нь бол хийнэ. Ерөнхий үнэлгээнээс нь нарийвчилсан үнэлгээ хийе гэх юм бол Засаг дарга нараас зөвшөөрлийг нь авна. Тэгээд 15 ажлын гурван 7 хоног хүлээгээд тэгээд хариу ирэхгүй бол ерөнхий нарийвчилсан үнэлгээ хийхийг зөвшөөрч байна аа л гэсэн ийм л ойлголт эргээд хүрч байгаа.

Өнөөдөр аялал жуулчлалын мэргэжлийн холбооны Удирдах зөвлөлийн даргатай яг энэ чуулган эхлэхээс өмнө холбогдсон. Тэгээд тэднийхээс бүүр энэ

нарийвчилсан үнэлгээг хийж байгаа хугацаагаа юун 5, юун 10, 15 жил болгоод өгөөч ээ гэсэн хүсэлтийг нэлээн оройтож өглөө л дөө. Тэгээд энэ дээр Тусгай хамгаалалтын тухай хууль Б.Бат-Эрдэнэ гишүүн дээр явж байгаа. Энэ хуулийг дагуулаад нэлээн сайн яривал ярилцъя гээд хэлсэн байгаа. Шалтгаан нь ерөөсөө л нөгөө аялал жуулчлалыг дэмжих зээл авдаг. Тэгээд тэр зээлийнх нь нэг шаардлага нь үнэлгээ байдаг үнэлгээ. Тэгээд тэр зээлдээ орж чаддаггүй. Яагаад гэхээр үнэлгээнийх нь хүчинтэй хугацаа нь 5 жил байнгуут тэр нь ингээд зээл нь 6 жилээр гарна гэвэл ингээд шаардлагыг нь хангахгүй нөхцөл байдал үүсээд байна аа гээд. Яг газар дээрээ, хөрсөн дээрээ буухдаа манай энэ олон зөвшөөрөл манай энэ олон үнэлгээ субъектив гарын үсэг аягүй их түвэг удаж байгаа юм билээ. Тэгэхээр би харин ч салбарын яам маань нэлээн сайн гомдлуудыг авч үзсэн юм байна л гэж бодсон. Нэмэлт хариултыг өгөөрэй яамнаас.

С.Бямбацогт: Байгаль орчны сайд Цэндийн Сандаг-Очир гишүүн хариулъя.

Ц.Сандаг-Очир: Мандхай гишүүний чухал асуулт асууж байгаа юмаа. Өнөөдрийн мөрдөгдөж байгаа хүчин төгөлдөр мөрдөж байгаа хуулиар ер нь байгаль орчинд их, дунд, бага зэргийн нөлөөлөлтэй бүхий л төслүүд бүгд нарийвчилсан үнэлгээ юмнууд шаардаж хийлгэж байгаа. Тэгвэл энэ шинэ шинэчилсэн хуулиар нөлөөллийн бүсээр нь уул уурхайн компаниуд гэдэг юм уу, байгаль орчинд нөлөөлөл, сөрөг нөлөөлөл ихтэй төслүүдийг 1 дүгээр зэрэглэл, дунд зэрэглэлийн нөлөөлөлтэй төсөл хөтөлбөрүүдийг 2 дугаар зэрэглэл, бага сөрөг нөлөөтэй төслүүдийг 3 дугаар зэрэглэл гээд энэ нь өөрөө эргээд иргэн ААН-үүдэд маш олон үнэлгээ хийлгэх энэ хүнд суртал чирэгдлийг арилгаж байгаа, нөгөө талаар энэ чөлөөлье гэсэн аянтай агаар нэг байгаа. Гуталчин гэдэг юм уу, үсчин, гоо сайхан хийх гэж байгаа хүн заавал нарийвчилсан үнэлгээ хийлгэх шаардлага...

С.Бямбацогт: Гүйцээгээд хариулчихъя.

Ц.Сандаг-Очир: Тийм. Жижиг бизнес эрхэлж байгаа ААН-үүдэд энэ үнэлгээ хийлгэх хүндрэл шаардлага байхгүй болж байгаа энэ хуулиар. Ерөнхий үнэлгээгээ хийлгээд 2 жил тутамдаа магадлалаа хийлгээд ингээд явна аа. Одоогийн мөрдөгдөж байгаа хуулиар 5 жил тутамдаа үнэлгээгээ нарийвчилсан үнэлгээгээ хийлгэж байгаа. Энүүгээрээ хийлгээд ахиад сунгах хугацааг нь 10 жил гэж ингэж оруулж ирж байгаа. Нөгөө талаар энэ хууль батлагдсанаар жилдээ 10 гаруй мянган үнэлгээ хийлгэдэг. Яаман дээр аймгийн Байгаль орчны газар дээр. Тэгвэл одоо 30 орчим хувь нь үнэлгээ хийлгэж байгаа энэ хүнд суртал голлож байгаа. Нэг төсөлд үнэлгээ хийлгэхэд дор хаяж дунджаар 100-200 гаруй хоногийн хугацаанд үнэлгээ хийлгэнэ гээд ингээд ААН-үүдийг хүндрэл учруулдаг.

Тэгвэл одоо энэ хууль батлагдвал 43 хоногт багтааж үнэлгээг эцэслэн батлах ийм хүнд суртлыг арилгаж байгаа иргэн аж ахуй...

С.Бямбацогт: Мандхай гишүүн тодруулж асууя.

М.Мандхай: Яах вэ цагаан дээр хараар ингээд техник үйл ажиллагааг хөнгөвчлөх юм шиг боловч миний нөгөө нэг түрүүний хэлээд байгаа суурь институцийн асуудал буюу яг өнөөдөр үндсэндээ үнэлгээний компани халаасны компани болчихсон олон компаниуд байгаа шүү дээ. Тэгэхээр үндсэндээ одоо бид нарын хувьд энэ 10 хоногт Монгол Улсын энэ зарим нэгэн газар доорх баялаг өөрөө хэдэн мянган км-ийн цаана, хэдэн аймаг, сум, баг дамжсан жишээлбэл ийм

баялагтай газар үндсэндээ тухайн аймаг сум 10 хоногтоо багтааж шинжилж чадаагүй байх юм бол зөвшөөрсөнд тооцоод явчих эрсдэл харагдаж байгаа юмаа. Яах вэ ингээд үсчин зүгээр гоо сайханч гэдэг ийм жижиг үйлчилгээнүүд дээр тайлбар хэлж байгаа юм шиг боловч энэний цаана нөгөө халаасны компани чинь өөрөө үнэлгээгээ ерөнхий үнэлгээгээр эрсдэлгүй ээ гээд үнэлчих юм бол 3 дугаар зэрэглэлээрээ явчих гээд байгаа байхгүй юу. Ингээд ирэхээр энэ чинь...

С.Бямбацогт: Хариулт уу. За санал хэлчихлээ. Ер нь бол бас Мандхай гишүүний ярьж байгаа үндэслэлтэй шүү. Тэгээд л өөрсдийн хамаарал бүхий компаниудаар үнэлгээний компани байгуулагдчихдаг, байгуулчихдаг, тэгээд тэрүүгээрээ үнэлгээ хийлгэдэг. Тэд нар нь дааж дийлэхгүй мөнгө нэхдэг тэгээд үнэлгээ хийж байгаа гэдэг нь формалдаж халтуурддаг. Иймэрхүү бас асуудлууд байдаг шүү Байгаль орчны яамныхан. Тийм болохоор тэгээд гоё юм ярьчаад цаад талдаа тийм үү энэ байдал чинь алга болох ёстой шүү. Эндээ анхаарцгаагаарай.

Одсүрэнгийн Номинчимэг гишүүн асуултаа асууя.

О.Номинчимэг: Дарга аа асуулт давхацсан тул асуултаасаа татгалзъя аа.

С.Бямбацогт: Батын Батбаатар гишүүн асуултаа асууя.

Б.Батбаатар: Тэр 7.1.6 дээр байгаа шинжээчийгээ 8 жилээр гээд нэг зүйл оруулчихсан байх юм. Энэ Төрийн албаны хуультайгаа таарч байгаа юм уу, таарахгүй байгаа юм уу гэдэг асуудал байна. Дээрээс нь байгаль орчны нарийвчилсан үнэлгээ бид нар цаг хугацаа, хүнд суртал, авлига үүсгэх нөхцөл бүрдүүлэхгүйн төлөө л хуулиараа шахаж өгөх энэ ажлуудаа л хийх юмаа Их Хурал өөрөө аятайхан хийгээд хуулийнхаа нэр томъёог болгочихмоор байгаа юм. Зүйл заалтуудыг нь. Тэгэхгүй нөгөө шахаад шахаад захиргааны аргаар шахаад шахаад гардаггүй зүйлүүд бас байгаад байдаг. Хүнд суртал нь буюу цаашлаад авлигал үүсгэх нөхцөлүүдийг нь хуульд үүсгэхгүй байх тэр боломжуудаа их эвтэйхэн хиймээр байна аа.

Дээрээс нь энэ төсөлд иргэдийн оролцоог хангаад ил тод байршуулах зохицуулалт туссан байна аа гээд тэгж байна. Тэгээд энэ засаг захиргааны нэгжээр хязгаарлаж болохгүй байх аа. Зөвхөн тухайн баг сумын юу байдаг юм орон нутгийн засаг захиргааны нэгжээр хуваарилж гарч байна. Энэ чинь нөгөө төслүүд чинь засаг захиргааны нэгжийн хилийн заагаар явахгүй шүү дээ. Байгаль чинь өөрөө өгөгдөл нь хил хязгааргүй зүйл байж байдаг. Тэгэхээр энийгээ тэр талд нь анхаарч оруулсан юм нь юу байгаад байгаа юм бэ гэдэг зүйл байж байна.

Жижиг, дунд төслүүд, том төслүүдээ ингээд суурилсан ангилал байх юм уу? Тэгээд энэ ангиллынхаа шалгууруудыг хуульд оруулах юм уу, журамдаа үлдээх юм уу гэдэг байж байна. Тэр менежментийн төлөвлөгөөг тухайн төслийн гээд. Байгаль орчны үнэлгээний цахим системийгээ төрийн бодлоготой нийцүүлж нэвтрүүлэхээр тусгасан байна гэж байна. Тэгээд цахим санд байршуулах мэдээллээс нууц арилжааны нууц нэрээр тийм хасагдах мэдээллийн хүрэх хүрээгээ хэрхэн хязгаарлах вэ? Иргэдэд бодит шийдвэр гаргах боломж олгох гол мэдээлэл нь хаалттай үлдэх эрсдэл байна уу гээд.

Хуулийн төсөл батлагдсанаар төрийн байгууллага хооронд бичиг цаас цаг хугацаа алдах асуудлыг багасгана гэж байна. Энэ шинэчлэл маань тэгээд хугацаа

одоогийнхоос яг хэдэн хувиар буурахаар тооцсон хэмжсэн шалгуурууд нь байгаа юу? Байгаль орчны нөлөөлөлд өртсөн иргэдийг ил тод мэдээллээр хангах эрх зүйн орчин бүрдэнэ гэж байна. Мэдээлэл авсан иргэн эсэргүүцэл гомдол гаргавал төслийн зөвшөөрөл олголтыг түр түдгэлзүүлэх юм уу, эсвэл маргаан шийдвэрлэх тусгай хугацаа байгаа юу гэдгийг бас асууж байна. Үнэлгээний шинжээчдийн шаардлага шалгуур үүрэг хариуцлагыг тодорхой болгохоор тусгасан байна. Тэгээд шинжээч нь тухайн төсөл хэрэгжүүлэгчдээ ашиг сонирхлын зөрчилтэй бол түүнийг үнэлгээнд оролцуулахгүй байх, дүгнэлтийг нь хүчингүйд тооцох дээр зохицуулалтаа тусгасан уу. Тэгээд ийм асуултууд байна. Тэрнээс гадна бас саналууд байгаад байгаа юмаа.

Энэ олон нийтийн оролцоог хэлбэрийн төдий болгохгүйн тулд санал авсан тухай тэмдэглэлээс гадна иргэдийн саналыг хэрхэн тусгасан. Тусгаагүй бол яг ямар үндэслэлээр татгалзсан тухай тайлангаа цахим санд заавал нийтлэх тийм зохицуулалтыг орхигдуулсан. Энүүнийгээ оруулах ёстой юм байна гэж хууль хэлэлцээд эхлэхээр зарчмын зөрүүтэй саналууд өгч оруулъя гэж бодож байна. Нөлөөллийнхөө бүсийг засаг захиргааны нэгжээр биш усны сав газар, бэлчээр ашиглалт, нүүдлийн зам, тоос тоосжилт, дуу чимээ, тээврийн маршрут зэрэг бодит нөлөөллөөр нь тодорхойлох хэрэгтэй. Ингэхгүй нэг суманд төсөл хэрэгжээд хөрш сумын иргэд хохирдог байдлыг оруулж болохгүй.

Тодорхой бүс нутагт лиценз зөвшөөрөл олгох шатанд урьдчилан хийх, одоо нөгөө хуримтлагдах нөлөөллийнхөө үнэлгээг төсөл эхлэх үед биш урьдчилан хийх шаардлагатай. Үгүй бол олон жижиг төсөл төслүүд тус тусдаа бага нөлөөтэй гэж үнэлэгдсэн нийлбэрээрээ байгаль орчинд ноцтой...

С.Бямбацогт: Ажлын хэсэг индрийн 4 дүгээр микрофон хариулъя.

Ш.Батбаяр: Батбаатар гишүүний асуултад хариулъя аа. Ерөнхий шинжээчийн болон шинжээчийн шаардлага нь Төрийн албаны тухай хуульд нийцэж байгаа.

Хоёрдугаарт одоогийн болон шинэчилсэн найруулгаар нэмэлт өөрчлөлтөөр нарийвчилсан болон ерөнхий үнэлгээний бүх тайлан мэдээлэл еic.mn буюу байгаль орчны мэдээллийн санд нээлттэй байршиж байгаа дурын иргэн энэ мэдээлэлтэй танилцаж байх боломжтой байгаа.

Гуравдугаар асуулт одоогийн хуульд засаг захиргааны нэгжээр санал авдаг байсан бол шинээр орж байгаа өөрчлөлтөөр нөлөөллийн бүс гээд нөлөөлөлд орж байгаа бүх засаг захиргааны нэгжүүд болон иргэдээс санал авахаар илүү оролцоог нэмэгдүүлж байгаа.

Гуравдугаарт цаг хугацааны асуудал бол нэлээн том өөрчлөлт орж байгаа. Одоогийн зохицуулалтаар нарийвчилсан үнэлгээг хийлгэхэд хамгийн доод тал нь 120 хоног, зарим тохиолдолд 2 хүртэлх жилийн хугацаа гардаг. Хамгийн доод тал нь 20 сая төгрөгийн зардал гарч байгаа. Шинэ зохицуулалтаар 43 хоногт багтааж нарийвчилсан үнэлгээг батлуулах боломжтой болж байгаа.

Мэргэжлийн зөвлөлийн гишүүдийн ашиг сонирхолтой холбоотой асуудлыг мэргэжлийн зөвлөлийн журам байгаа яамны сайдын баталсан. Тэрүүгээр зохицуулдаг. Одоо хэрвээ ашиг сонирхлын зөрчилтэй эсвэл зөрчилтэй бол саналын

эрхийг нь хасдаг, асуудал гаргасан тохиолдолд эрхийг нь хасах хүртэл зохицуулалт журамд байгаа.

С.Бямбацогт: Баярлалаа. Ганбатын Хосбаяр гишүүн. Уучлаарай. Зочин танилцуулъя. Монгол Улс дахь Франц сургуулийн багш ажилтнууд Улсын Их Хурлын үйл ажиллагаа Төрийн ордонтой танилцаж байна аа. Та бүгдийнхээ ажилд нь амжилт, амьдралд нь эрүүл энх, сайн сайхан бүхнийг Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн өмнөөс хүргэе ээ.

Батбаатар гишүүн тодруулж асууя.

Б.Батбаатар: Одоо хэлэлцэх эсэхээ шийдчихээр тэгээд байнгын хороо үргэлжлээд чуулганаар ороод энэ хууль батлагдах нь зүйтэй. Энэ хуулийг бол одоо харин анхны хэлэлцүүлэг шүү дээ. Ингээд цаашаа үргэлжлээд явахаар ер нь батлагдах нь зүйтэй гэж үзэж байгаа юм хуулийн өөрчлөлт явах ёстой гээд. Тэгээд бас зарим саналыг гүйцээж хэлчхээд байнгын хороон дээр зарчмын зөрүүтэй саналуудаар хуулийнхаа төсөлд оруулаад явах ёстой байх аа гэж ингэж ойлгоод байгаа юм. Шинжээчийн хараат бус байдлыг баталгаажуулахын тулд үнэлгээний шинжээч мэргэжлийн байгууллагын ашиг сонирхлын мэдүүлэг, өмнө хийсэн үнэлгээ, хүчингүй болсон дүгнэлт, сахилгын түүхийг цахим санд ил болгох заалтыг тусгах нь зүйтэй гэж үзэж байна аа. Би бас ажлын хэсгийнхэнтэй цаашид хэлэлцэхэд анхааруулж яриад байна.

Тэгээд байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлахдаа төслийн хүчин чадал байршил, нөлөөллийн цар хүрээг харгалзана гэж ерөнхий бичгээсээ гадна эрсдэлийн ангилал шалгуур үзүүлэлтийн хувьд суурь байдлаар ингэж зааж гээд. Бусад саналууд байгаа. Тэгэхдээ үүнийгээ би энэ хуулийн төслийг хэлэлцэхийг дэмжиж байна.

С.Бямбацогт: Тэгээд хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг яваагүй анхны хэлэлцүүлэг явж байгаа. Одоо анхны хэлэлцүүлэг эцсийн хэлэлцүүлэгт зарчмын зөрүүтэй саналууд гаргах боломжгүй болсон байгаа. Ажлын хэсэг гэхдээ сая Батбаатар гишүүний ярьж байгаа саналуудыг анхааралдаа аваад хэрхэн яаж тусгах бололцоо байгааг судлаарай. Ганбатын Хосбаяр гишүүн асуултаа асууя.

Г.Хосбаяр: Монголчууд бид бол одоо байгаль дэлхийнхээ эрхшээлд амьдардаг ийм ард түмэн. Тэгээд энэ байгаль орчны асуудал, байгаль орчны нөлөөлөл бидний өдөр тутмын амьдралд энэ оршин байгаа ахуй нөхцөлд маш чухал зүйл ээ. Тийм учраас Монголчууд бид энэ байгаль дэлхийдээ онцгой анхаарч бас энэ байгаль дэлхийдээ байгаль дэлхийтэйгээ зөв харьцаж ингэж ирсэн ард түмэн. Тэгээд ер нь бид нар яах вэ энэ байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ гэхээр сөрөг талын юмыг л их яриад байгаа. Одоо нөгөө уул уурхай ашиглалт, зам барилга эсвэл энэ байгаль экологи гээд дандаа л энэ нэг сөрөг нөлөөлөл сөрөг юмыг л их ярьдаг. Тэгэхээр энэ эерэг нөлөөллийн үнэлгээ гэж ер нь юм хийгддэг үү? Жишээлбэл одоо манай Өвөрхангай аймагт энэ усны төсөл буюу Онги Цагаан бургастай төсөл гээд ТЭЗҮ хийгдэж эхлэхээр тендер нь зарлагдсан байгаа. Тэгэхтэйгээ зэрэг энэ төслийг байгаль экологийн төсөл энэ гол сэргэнэ. Мөн одоо энэ говийн улаан нуур сэргэнэ мөн энэ гадаргын усыг нөөцөлж энэ гол дагуух байгаль орчныг сэргээх ийм байгаль орчинд томоохон эерэг өөрчлөлт авчрах төсөл гэж ингэж харж байгаа.

Тийм учраас энэ дээр ийм эерэг үнэлгээ хийгээд тэгээд энийгээ энэ ард иргэдэд үнэн зөв мэдээллээр хангаад, эерэг ойлголтуудыг ингээд эртнээс өгөөд явах ийм зүйлийг Байгаль орчны яам хийдэг үү? Би энийг Байгаль орчны сайдаас асуумаар байна. Тэгэхээр одоо энэ усны төслүүд буюу Хэрлэн тоонот, Онги, Орхон Онги, Орхон Онги төслийн нэг хэсэг энэ Онги цагаан бургастай төслийг ер нь юу гэж харж байгаа вэ? Энэ ер нь ойрын үед ажил нь аль зэрэг урагштай явах вэ? Энэ олон улсын тэр гэрээ конвенц, усны энэ асуудлуудтайгаа ер нь болж байгаа юу? Энэ тал дээр нэг мэдээлэл өгөөч. Мөн тэр эерэг байдлын үнэлгээ гэдэг дээр.

Дараа нь 2 дахь асуудал нь болохтойгоо зэрэг энэ орон нутагт нэг түгээмэл тархацтай баялаг ашиглах гэж нэг бөөн юм болж байна аа. Нэг талд нь энэ элс хайрга, дайрга олборлож түгээмэл тархацтай баялгаа хамгийн ойрхноос авч зам, барилга, байшин барилга, бүтээн байгуулалтаа хиймээр байдаг. Гэтэл нөгөө талд нь нутгийн ард иргэдийн энэ явдаг замаар эсвэл малаа бэлчээдэг газраас ингээд хамгийн ойрхон зай хэмжээ юмыг нь харж байгаад ингээд элс хайрга дайрга ухаад олборлоод аваад байх юмаа. Жишээлбэл одоо энэ хот хоорондын замд явж байхад ч гэсэн харагддаг шүү дээ. Хамгийн ойрхон уул толгодыг онгойтол онгойтол ухаад аваад ингээд хайрга дайргыг нь ашиглаад зам хийчихдэг. Тэрийгээ дараа нь нөхөж сэргээж засдаггүй. Тэгэхээр яагаад тэр үгүй ядаж харагдахгүй газраас авч болдоггүй юм бэ? Энэ дээр ер нь энэ хувийн компаниуд үнэлгээ хийхдээ ер нь асуудалд яаж ханддаг юм бэ?

Ер нь одоо үнэлгээ хийхдээ шалгуур шаардлага тавьдаг ийм зүйл байгаа юу? тэр шалгуур шаардлага нь ямар байгаа вэ? Ийм 2 асуудал дээр асуулт дээр хариулт авъя.

С.Бямбацогт: Ажлын хэсэг 4 дүгээр микрофон хариулъя. Ажлын хэсэг хариулъя.

Ц.Уранчимэг: Гишүүний асуултад хариулъя. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Тусгай хамгаалалттай газрын бодлогын газрын дарга Уранчимэг. Тэгэхээр үнэхээр энэ чухал асуудал байна. Ер нь байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг бид нар болохлоор заавал сөрөг нөлөөллийг бууруулах гэж хараад байгаа. Тэгэхээр байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий болон нарийвчилсан үнэлгээ нь яг агаар, ус, хөрс, амьтан, ургамал, биологийн олон янз байдал тэр бүх газар нутаг дэвсгэр дээр явуулж байгаа үйл ажиллагаа нь сөрөг нөлөөлөлтэй бол тэрийг бууруулах, тэгээд яг энэ үйл ажиллагаа одоо энэ төслөө хэрэгжүүлж байхдаа зөв дэвшилтэт техник технологийг хэрэглэх ялангуяа одоо энэ байгалийн нөөцийг зөв зохистой ашиглах технологиудыг яг энэ нөлөөллийн үнэлгээгээрээ яг санал болгож оруулж ирдэг.

Хэрвээ энэ төсөл үнэхээр маш сайн ийм төсөл оруулж ирээд дараа дараагийн том мега төслүүд рүү оруулж ирэхэд бас энэ технологийг түгээн дэлгэрүүлэх ажлыг энэ зөвлөмжөөр, дүгнэлтээр, тайлангаар мэргэжлийн байгууллагууд төсөл хэрэгжүүлэгч 2 хамтран Монгол Улсад цаашид маш байгаль орчинд ээлтэй тухайн нутаг дэвсгэрт үр өгөөжийг нь өгөх эдийн засгийн ач холбогдолтой экологийн чухал энэ төслүүдийг орж ирдэг ээ. Тэгэхээр энэ дээр нэг талыг харах нь туйлын учир дутагдалтай. Гэхдээ яах вэ мэдээж яг хамгийн чухал өнөөдөр яг энэ хөгжлийн чиг хандлагатай нийцэж, технологийн шинэ дэвшлийг ялангуяа усыг дахин ашиглах, сэргээгдэх эрчим хүч, саарал усаа гаргадаг тэр тухайн бүс нутгийн онцлогт тохирсон технологиудыг ашиглах ийм шийдлүүдийг оруулж ирдгээрээ бас энэ оруулж ирж,

дүгнэлт зөвлөмж гаргадаг нь манай байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий болон нарийвчилсан үнэлгээнд тусдагаараа их чухал ач холбогдолтой байгаа юмаа.

С.Бямбацогт: Тодорхой хариулсангүй ерөнхий л хариулчихлаа даа. Тодорхой асуулт асуусан шүү дээ. Одонтуяа гишүүн ажлын хэсгийн ахлагч хариулъя.

С.Одонтуяа: Энэ Орхон-Онги төсөл намайг сайд байх үед шийдвэр нь гараад одоо ингээд үргэлжлээд явж байгаа. Тэгэхээр Хосбаяр гишүүнтэй санал нэг байна. Энэ бол бид эхлээд шууд үйлдвэрлэлийн биш экологийн төслийг нь эхлээд хэрэгжүүлье гэж шийдвэр гарсан. Өөрөөр хэлбэл эхлээд Онги голоо урсацыг нь нэмэгдүүлье, ингэснээрээ Улаан нуурыг сэргээе. Улаан нуурыг сэргээгээд энд нүүдлийн шувууд ирж буцдаг бол бас энэ олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийн дагуу санхүүжилт орж ирдэг ийм механизм байгаа. Тэгэхээр энэ экологийн төслүүд нэлээд явж байгаа гэдгийг хэлье.

2-т энэ бас ажлын хэсгийнхэн хариулахгүй байх шиг байна. Үнэлгээний тухай хуулийн 9.9-д заасны дагуу байгаль орчныг хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлэх баталгаа болгож менежментийн төлөвлөгөөнд тусгасан нийт зардлын 50 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг дансандаа байршуулж байгаа. Тийм учраас эндээс бол...

С.Бямбацогт: Гүйцээгээд хариулчихъя Одонтуяа гишүүн.

С.Одонтуяа: Тэгэхээр энэ өөрөө их чухал заалт. Энэ мөнгөн хөрөнгийн баталгаагаар бид энэ компани үүргээ төсөл хэрэгжүүлэгч үүргээ биелүүлэхгүй тохиолдолд энэ мөнгөө зарцуулах ийм боломжтой. Дээрээс нь байгалийн нөөц ашигласны төлбөрүүдээс маш их мөнгө орон нутагт орж байгаа. Энэ орон нутагт орсон мөнгөөрөө тухайн орон нутаг хангалттай усаа сэргээх, ойгоо сэргээх, бүх юмаа сэргээх ийм боломжууд нь нээлттэй байдаг юмаа.

С.Бямбацогт: Ганбатын Хосбаяр гишүүн тодруулж асууя.

Г.Хосбаяр: Би тэр нөгөө түгээмэл тархацтай баялаг ашиглахдаа ингээд хот суурин, сум суурин газрын хамгийн ойрхон эсвэл төв зам дагуу хүний түмэн амьтан явдаг нүдэн дээр ил газраас л ингээд хайрга дайрга элсээ аваад байх юмаа. Энийгээ өөрчилж болдоггүй юм уу гэдэг ийм зүйлийг л тодорхой асуугаад байгаа юм. Энэ дээр ямар нэгэн тэр үнэлгээ хийж байгаа газартаа чиглэл өгч болдоггүй юм уу? Тэгэхгүй бол мэдээж тэр геологи хийж байгаа ч юм уу, судалгаа хийж байгаа, лиценз авах гэж байгаа газар бол хамгийн л одоо зам дагуу байршил сайтай хамгийн ойрхон газраас л авахыг мэдээж эрмэлзэнэ шүү дээ. Гэтэл энэ чинь түмэн амьтдын нүдэн дээр байгаль орчны сүйтгэчихсэн юм шиг ингэж харагдаж байна.

Нөгөө талаар энэ Сандаг-Очир сайдаас би нөгөө усны төсөл дээр ер нь ямар байр суурьтай, ер нь яг яах вэ? Энэ төслүүд ер нь урагштай байгаа юу гэж ийм л асуултыг асуугаад байгаа юм.

С.Бямбацогт: Ажлын хэсэг тодорхой хариулъя. Ерөнхий юм яриад тэгээд асуултад хариулсан болоод л бөөрөнхийлөөд л байх юм. 4 дүгээр микрофон.

Ш.Батбаяр: Түгээмэл тархацтай ашигт малтмалын хувьд бол нийслэл орон нутгийн зүгээс байршлаа сонгоод хүрээд ирдэг байгаа. Тэгээд ашигт малтмалын хуулиар зохицуулагддаг харилцаа байгаа. Тэгэхээр үнэлгээн дээр бид бол мэдээж гол мөрний урсац тогтоц болон ойн сан бүхий газар дээр байвал үнэлгээ ч хийхгүй, зөвшөөрөл явагдахгүй, тэр ажил хийгдэхгүй. Бусдаар бол нийслэлийн орон нутгийн хэмжээнд шийдэгддэг байгаа. Тэгээд зөвшөөрөл нь Ашигт малтмалын тухай хуулиар шийдэгддэг манай яамтай хол хамааралгүй болчихоод байгаа юм.

С.Бямбацогт: Сайд хариулъя. Сандаг-Очир гишүүний микрофон өгье. Устай холбоотой асуудал байгаа.

Ц.Сандаг-Очир: Орхон-Онги, Хэрлэн Тоонот энэ томоохон гол устай холбоотой төслүүдийн талаар бас нээлттэй ярьж болох бас ярьж болохгүй байгаа. Яагаад гэхээр урд хөрштэй холбоотой бас янз бүрийн асуудлууд байдаг юм байна лээ. Тийм учраас би Хосбаяр гишүүнд тусгайлан энэ талаар төслийн явц болоод гадаад, дотоодын улс орнуудын баримталж байгаа байр суурь гэсэн талаар мэдээллийг товчид нь тусгайлан өгье гэж бодож байна.

Түгээмэл тархацтай таны асууж байгаа асуулт бол сая ТНБД хэллээ. Түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглах тухай хуулиар зохицуулагдах харилцаа. Манайх зөвхөн орон нутгийн түгээмэл тархацтай ашигт малтмал дээр ашиглана гэсэн тэр төсөл дээр үнэлгээ гаргах энэ хуулийг л харилцааг л зохицуулах хууль аа. Тийм учраас тэр орон нутаг нь хаанаасаа ямар түгээмэл тархацтай ашигт малтмалаа ашиглуулах гэдэг асуудал нь орон нутаг бөгөөд түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулиараа зохицуулагдах харилцаа шүү. Энэ...

С.Бямбацогт: Отгоны Саранчулуун гишүүн асуултаа асууя.

О.Саранчулуун: Сайн байцгаана уу? Жил хагасын өмнө билүү бид нар Ораногийн асуудлыг ярьж байсан. Тэр үед орж ирсэн материал дээр юу байсан бэ гэхлээр байгаль орчны нөлөөллийн үнэлгээ гэдэг дотор эрүүл мэнд гэдэг бүлгээ оруулчихсан байсан байхгүй юу. Тэгээд эрүүл мэнд гэдэг бүлгийг яагаад энэ уул уурхай дээр байгаль орчин дотроо эрүүл мэндийг оруулаад, байгаль орчны үнэлгээ хийгдсэн гэдэг нь илүү том харагдаад, цаана нь хүний эрүүл мэндтэй холбоотой асуудлууд нь арай жижигхэн бүдэг тусгагдсан байсныг би хөндөж байсан. Яагаад гэхээр тэр олборлож байгаа арга нь Монголд шинэ технологи шинэ учраас хүний эрүүл мэндэд ноцтой нөлөө үзүүлэхээр байна. Шууд хохирол нь ил харагддаггүй. Тэгэхдээ алсдаа гарах хор уршигтай гэдэг ийм нийгмийн эрүүл мэндийн асуудал байсан.

Тэгэхэд бол ямар хариултыг авч байсан бэ гэхээр гэрээлэн гүйцэтгэгч нартайгаа хийсэн ажил гүйцэтгэгч нартайгаа ярьдаг тэр олон улсын гэрээ конвенцын дагуу шийднэ ээ гэдэг ийм хариултыг аваад тэр одоо чуулганы уулзалт хуралдаан дуусаж байсан санагдаад байгаа юм. Тэгэхээр ер нь ЭМЯ-ны яам бол эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээ хийлгэнэ гээд уул нь байгаад байгаа. Гэхдээ эрүүл мэндийн нөлөөллийнхөө үнэлгээг ямар шалгуур үзүүлэлтээр яаж хийдэг юм гэдгийг нь асуухаар тэр үед би бас хариулт авч чадаагүй. Тэгэхээр бичлэг нь ч гэсэн байж л байгаа байх. Тэгэхээр энэ байдал өнөөдрийн энэ хуулийн өөрчлөлтөөр дээрдэх үү, энэ байдал дээрдэх үү гэдэг нэг асуудал байгаа.

2 дахь асуулт нь саяын энэ хөндөж байгаатай чинь юу холбогдоод байгаа гэхлээр хөдөлмөрийн аюулгүй өнөөдөр байгаль орчинд үзүүлж байгаа нөлөөллийн нэг шалтгаан эх үүсвэр нь ХАБ байхгүй юу. Монгол Улс ХАБ-ын олон улсын конвенцод байх ёстой байвал зохилтой 2 том конвенц байхад нэгэнд нь элсчихсэн, нэгэнд нь элсэх тухай асуудлаа яриад л байгаад байгаа байхгүй юу. Тэгэхээр хөдөлмөрийн аюулгүй байдлаа бүрэн хангаагүй газар бас байгаль орчинд давхар хүний эрүүл мэндэд хортой. Тэгэхээр энийг бид нар ялгаж салгадаг болох ёстой болоод байна л даа.

Хоёрдугаар асуудал нь хад юу гэдэг билээ бараг бут бүр Бурхан хад бүрд хаан эзэн бий гэдэг ийм үг байдаг. Монгол одоо монголчууд бол байгаль орчноо маш их хүндэлж хайрладаг ийм үндэстэн. Олон үндэстэн ястантай ийм улс. Цөөнхүүд байна. Угсаатны цөөнх байна тиймээ. Тэгэхээр тэр хүмүүсийн амьдралын соёл заншилд итгэж найдаж явдаг. Түүнээсээ итгэл үнэмшлээ авч өдөр тутмынхаа аж төрөх ёсоо холбодог ийм соёлтой газар хэрвээ хор хохирол учрах юм бол эргүүлээд тэр хохирлыг нь яаж хэмжих юм, тэгээд яаж алга болгох юм. Одоо оруулж ирж байгаа хууль дээр болохоор хор хохирлыг тооцоолох тухай асуудал нь байгаа. Хохирол гарвал буцаагаад яаж нөхөх юм гэдэг тэр хариу арга хэмжээг нь би асуумаар байгаа байхгүй юу. Яаж сэргээх юм, яаж буцааж хариу үзүүлэх вэ гэсэн ийм 2 асуулт дээр хариулт өгнө үү?

С.Бямбацогт: Ажлын хэсгийн ахлагч Болдын Уянга хариулъя.

Б.Уянга: Саранчулуун гишүүнд баярлалаа. Эрүүл мэндийн агуулгыг манай гишүүд хөндөж байгаа. Яг аргачлал нь байхгүй гэдэг дээр л ер нь нийгмийн нөлөөллийн үнэлгээг хийх дээр хүртэл аргачлалын асуудал дээр хүндрэлтэй буланд шахагдаад явчихдаг. Тэгэхээр энэ хууль 8 сарын 1-нээс хүчин төгөлдөр мөрдөгдөнө гэж байгаа. Хэрвээ батлагдчихвал хугацаандаа. Тэгээд 7.7 яг энэ орж ирж байгаа Засгаас өргөн барьчихсан хуулийн 7.7-г унших юм бол нөлөөллийн үнэлгээгээ ингэж хийе, ингэж журамлая, тэгээд энэ ийм ийм төслүүд дээр ингэнэ ээ гээд хамгийн том журмыг нь Засгийн газар батлаад, тэр дотор нь нийгмийн болон эрүүл мэндийн үнэлгээтэй холбоотой зохицуулалтыг тусгана аа гээд хуульчилчхаж байгаа юм.

Тэгэхээр энэ одоо яг эрүүл мэндийн аргачлалыг батлах хугацааг нь Их Хурлаас тавьж өгч байна гэсэн үг. Тэгэхээр бид нар шахах юмтай болж байгаа. Яг энэ 7.7-д заасан том журмаа 8 сарын 1 гэхэд баталж байж цаашаагаа энэ яг зэрэглэлийнхээ дагуу чөлөөлөгдөх нь чөлөөлөгдөөд, хяналт нь сайжрах нь сайжраад явна. Тэгэхээр энэ 8 сарын 1-ний дотор батлах ёстой энэ журамдаа боломжийнхоо хэрээр л суулгах байх. Тэгээд мэдээж ЭМЯ-наас нь бас холбогдох мэргэжилтнүүдийг нь аваад ажиллуулах шаардлага үүснэ. Тэгээд бид нар шат шатаар ахиж байгаа гэж л хариулахаар байна аа. Хэм хэм яаж хэмжих вэ, яаж хариу арга хэмжээ авах вэ гэдэг дээр болохоор одоо хуулийн заалт дээрээ бид нар эрүүл мэнд, нийгмийн гэдэг үгээ одоо авч орж ирж байна аа. Яг энэ нарийн процессын зохицуулалтыг нь болохоор журмаараа гэдгээр ингээд үлдэж байгаа.

Байнгын хороон дээр 2025 оны 5 дугаар сарын сүүлээр энэ хууль засгаас өргөн баригдаад орж ирэхэд нэлээн шүүмжилж байсан агуулга нь энэ юм байгаа юм. 7.7 яасан том юм, дотор нь нийгмийн нөлөөллийн үнэлгээ нь ч орчих юм байна, эрүүл мэндийн асуудал нь ч орчих юм байна. Тэгээд яг энийгээ хийж чадаж байгаа эсэх шинжээч гээд л мэргэжлийн байгууллага гээд л нэлээн их шүүмжилсэн юм байгаа юм. Тэгэхдээ ингээд яг одоо энэ хуулийг бид нар чуулган дээр өнөөдөр

хэлэлцэж байх явцад ч гэсэндээ маш их коментууд ирж байна л даа. Юу гэж ирж байна гэхээр байгаль орчинд газрыг ашиглаж байгаа маш олон салбар байна аа. ХАА-н салбар нийт нутаг дэвсгэрийн 70 хувийг хамарч байна аа, уул уурхайн салбар 4 хувийг чүүтэй айтай хамраад 0.25 хувьд нь олборлолт явуулж байхад энэ хуулийг нэг уул уурхайн салбарт зориулсан юм шиг ойлгоод байх юм гээд коментууд урсаад ирж байна л даа. Тэгэхээр энэ цааш цаашдаа бусад энэ байгаль орчинд нөлөөлөхүйц салбаруудаас байгаль орчны менежментийн төлөвлөгөөг нь аваад тэгээд тэр нөхөн сэргээлт эд нарыг нь хариуцлагажуулах ёстой.

Тэгэхээр Байгаль орчны яамнаас энэ хуулийг улам сайжруулах зөндөө олон ажлууд үлдсэн хэвээр. Тэгэхдээ энэ хууль орж ирэхэд хөндөгдсөн заалтууд дээр нь л ажиллаж байгаа учраас хязгаарлагдмал түвшинд ажилласан гэдгийг хэлье ээ.

С.Бямбацогт: Гишүүд асуулт асууж, хариулт авах цаг дууссан байна. 90 минутын хугацаатай байсан. Одоо тэгээд Баасанжаргал гишүүнээр асуултаа дуусгахаар сунгачихъя аа. Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн асуултаа асууя.

Х.Баасанжаргал: Би нэг эхлээд нэг 2 кэйсийг яриадахъя. Бүгдээрээ мэдэх ёстой бөгөөд цаашид яах вэ гэдэг дээр хариулт гарц гаргалгаа олж өгөөрэй гэж хэлэх гээд байгаа юм.

Нэгдүгээрт, Булган аймгийн Хутаг-Өндөр суманд сүүлийн 30 гаруй жил баригдана гэж яригдаж байгаа Эгийн голын УЦС. Эгийн голын энэ УЦС баригдах энэ багийн энэ суурин дээр одоо нэг 30 гаруй өрх айл амьдарч байгаа. Урьд нь 100 гаруй өрх айл амьдарч байсан ийм багийн төв байсан. Энд Эгийн голын УЦС баригдана гэснээс хойш энэ газар дээр ямар ч газар олголт, ямар ч тэр хүмүүсийг энгийн хэвийн амьдралаа аваад явчих наад захын эдийн засгийн хувийн өмчийн баталгаа огт байхгүй 30 гаруй жил болж байгаа. Өөрөөр хэлбэл Улаанбаатар хот бусад аймаг орон нутагт амьдарч байгаа хүмүүс бүгдээрээ өөрийн гэсэн нэр дээрээ газартай байгаа бол тэнд амьдарч байгаа хүмүүсийн огт газар байхгүй, хоёрхон хүнсний дэлгүүр дээр зөвшөөрөл байгаа.

Тэгээд энэ асуудлыг энэ 30 гаруй өрх яах юм бэ гээд ярихаар энд УЦС баригдана гээд байгаа. Тэнд байгаа иргэд УЦС-ыг ерөөсөө эсэргүүцдэггүй. Хамгийн гол нь энэ хүмүүсийн асуудлыг шийдээд өгөөч ээ гээд ингээд өдий болтол ингээд шийдэлгүй л явж байгаа гэсэн үг. Өмнө нь бол Оюун-Эрдэнэ сайд байхдаа бол шинэ багийн төв барих ажлыг зохион байгуулах ажлыг бол Одонтуяа сайд байхад ажлын хэсгийг нь гаргаад ингээд явж байсан. Тэгээд энэ ажил цаашаа юу болсон юм бол оо?

Тэгэхээр би энүүгээр юу хэлэх гээд байна гэвэл нийгмийн нөлөөллийн үнэлгээ гэдэг чинь төсөл эхлэхээс өмнө бөгөөд төсөл эхэлсний дараа, төсөл эхэлнэ гэж зарлахад хүртэл тэр хүмүүсийн амьдрал дорддог юмаа, бүгд гацаанд ордог юмаа гэх гээд байгаа юм. Тэгэхээр яг энэ талаас нь энэ хуулийн төсөл дээр ямар ахиц дэвшил байгаа вэ гэсэн нэг асуулт.

Хоёр дахь кэйс бид нарын сайн мэдэх Эрдэнэт үйлдвэр Эрдэнэт үйлдвэрийн цагаан тоосны асуудал. Бүгдээрээ Эрдэнэт үйлдвэрийн буянаар өдий зэрэгтэй улс эх орон өдий дайтай л явж байгаа. Гэтэл тэр Эрдэнэт үйлдвэрт насаараа ажиллаж байгаа хүмүүс, тэр Эрдэнэт хотод бүх насаараа ингэж амьдарч байгаа гэр бүлээрээ байгаа тэр хүмүүст учирч байгаа нийгмийн нөлөөллийн тэр дундаа нийгмийн эрүүл

мэндийн нөлөөллийн үнэлгээнийх нь талаарх мэдээлэл маш хаалттай, маш бүрхэг өдий одоо ингээд энэ олон жил явж байгаа. Би өөрөө тэнд хүүхэд насаа өнгөрүүлсэн. Миний аав ч гэсэндээ тэр Эрдэнэт үйлдвэрт насаараа ажиллаж байгаад хүнд металлын хордлого гэдэг онош тэтгэвэрт гарсных нь дараа тогтоогдсон. Тэгээд тэтгэвэрт гарсны дараа энэ онош тогтоогдохоор үйлдвэрийн шалтгаалах өвчин бишээ гэж явдаг юм байна лээ. Ингээд бүгдээрээ тэтгэвэртээ гараад удалгүй бурхны оронд явдаг. Энэ чинь бас дахиад нийгмийн хүний эрхэд нөлөөлөх нөлөөллийн үнэлгээ гэдэг чинь энэ бүхнийг зохицуулаач ээ гэж энэ хууль өөрөө байгаа. Тэрнээс ямарваа нэгэн төслийг эхлүүлэх зорилготой ерөөсөө хууль биш. Маш урт хугацааны нөлөөллийг заавал шалгадаг, тогтмол хянадаг байх тухай гэж ингэж өргөн том зургаар нь хармаар байна аа гэсэн үг.

Энэ 2 кэйс дээр үндэслээд миний нэг ийм асуулт байна. Энэ өөрөө зөвхөн уул уурхай биш томоохон төсөл, зам гүүр, барилга байгууламж, тэр байтугай Хархорин хотыг барихтай хүртэл энэ чинь өөрөө холбоотой асуудал. Тэгэхээр энэ томоохон энэ асуудлуудыг бид нар зөвхөн уул уурхай гэж хязгаарлахгүйгээр энэ төсөл үйл ажиллагаанд оролцож байгаа болно гэж дүгнэлт гаргаж байгаа энэ мэргэжилтнүүдийн асуудал, мэргэжилтнүүдийн хариуцлагын асуудлыг яаж энэ хуульд тусгаж байгаа вэ?

Хоёрдугаарт гэвэл хуулийн төсөл өргөн баригдсан хүрээндээ л хөндсөн заалтуудыг л хөндөх учраас түрүүн Бум-Очир гишүүн хэлээд байсан. Яг энэ нийгэм хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээ гэдэг юм ингэж ерөөсөө цогцоороо орж чадахгүй байна аа. Тэгээд Байгаль орчны яаманд ер нь энийг том дүр зургаар нь харж энэ өөрчлөлтийг томоор нь хийх, агуулгаар нь хийх, бүтнээр нь хийх, урт хугацаанд хийх ийм ямар төлөвлөгөө байгаа вэ?

С.Бямбацогт: Байгаль орчны яам хариулах уу? Хэн хариулах вэ? Хариуцлагын асуудал. 4 дүгээр микрофон ажлын хэсэг хариульъя. Тэгээд мэргэжилтнүүд маань тэгээд гоё хууль батлуулж авчхаад хэрэгжүүлж чадахгүй бол ямар хариуцлага хүлээх вэ? Тэр нөлөөллийн үнэлгээг тийм үү хийчхээд тэр асуудал үүсэх юм бол дараад нь үр дагаварт нь ямар хариуцлага хүлээх вэ? Тэр үнэлгээний компаниудын хариуцлага.

Ш.Батбаяр: Үнэлгээний компаниудын хариуцлага дээр бол өнгөрсөн хугацаанд яамнаас 2 удаа адистатчилал явуулсан байгаа. Тэгээд 170 гаруй ААН-ийн зөвшөөрлийг цуцалсан. Одоо 107 ААН үнэлгээний үйл ажиллагаа явуулж байгаа. Өнгөрсөн жил 2 ААН зөрчилтэй мэдээллийг мэргэжлийн зөвлөлийн хурал руу оруулсан. Үүнтэй холбоотой бид хариуцлага тооцоод тухайн үнэлгээг нь буцаагаад ААН-ийн зөвшөөрлийг цуцлах арга хэмжээ авсан байгаа. Мэргэжлийн зөвлөлийн ёс зүйгүйн хувьд бол түрүүн хэлсэнчлэн энэ хуулийн нэмэлтээр бид бүүр байгаль орчны салбарт 8-аас дээш жил ажилласан, шинжээч бол бүүр 4-өөс дээш жил ажилласан гэж шаардлагыг нэмэгдүүлж хариуцлагажуулж оруулж ирж байгаа тийм.

Мөн яамны сайдын тушаалаар энэ мэргэжлийн зөвлөлийн ёс зүйн дүрэм гэж байгаа. Энэ дээрээ тодорхой арга хэмжээнүүдийг тусгасан байгаа. Түрүүн хэлсэнчлэн зарим тохиолдолд тухайн төсөлтэй ашиг сонирхлын зөрчилтэй тохиолдолд саналын эрхгүй, ёс зүйн зөрчил гаргасан тохиолдолд мэргэжлийн зөвлөлөөс хасах, мэргэжлийн эрхийг цуцлах арга хэмжээнүүдийг авдаг аа. Мөн орон нутагт төсөл зарлаад уддаг дээр бол би яг энэ хуулийн өөрчлөлтийн гол

концепцод тусаж байгаа. Түрүүн хэлсэнчлэн процесс удаан учраас зарим тохиолдолд 2, 3 жил болдог учраас энэ зөвхөн үнэлгээн дээрээ л 2, 3 жил удаад байгаа байхгүй юу. Тэгэхээр энийг бид энэ хуулийн өөрчлөлтөөр 43 хоног дотор асуудлыг шийдье. Иргэд ААН дээр байгаа л даа. Юу нөлөөллийн бүсэд байгаа иргэд ч гэсэн энэ хамаарчхаж байгаа байхгүй юу. Тэгэхээр үнэлгээгээ хурдан хийлгээд дараа дараагийнх нь процесс нь хурдан яваад ирэхээр энэ ажилд бас энэ хууль тодорхой асуудалд нэмэр болж байгаа гэж би ойлгож байгаа.

С.Бямбацогт: Баярлалаа. Байгаль орчны сайд нэмж хариулъя. Сандаг-Очир гишүүн.

Ц.Сандаг-Очир: Өнөөдрийн хуулийн анхны хэлэлцүүлгээр олон гишүүдээс ер нь цаашдаа энэ үнэлгээний асуудлаар нийгмийн нөлөөллийн асуудлыг ер нь аягүй олон гишүүн хөндөж байна аа. Тэгээд өнөөдрийн мөрдөгдөж байгаа хуулиараа, өнөөдрийн үнэлгээ хийгдэж байгаа байдал бол голцуу одоо байгаль орчны сөрөг нөлөөллийн үнэлгээнүүдийг бууруулах чиглэлээр хийгдэж байна. Цаашдаа ер нь тухайн төсөл хэрэгжиж байгаа төслийн одоо бүсэд багтаж байгаа иргэдийн нийгмийн нөлөөллийг яаж авч хэлэлцдэг юм гээд. Бум-Очир гишүүн цаашдаа түрүүн асуусан. Энэ хуулийн нэг дагалдах хэсэг байх ёстой юм уу эсвэл тусгайлан нийгмийн үнэлгээний хууль байх ёстой юм уу гэж. Бид бүхэн бол цаашдаа энэ нийгмийн үнэлгээний нөлөөллийн тусдаа хууль байх ёстой юм байна аа гэж ер нь үзэж байгаа. Энэ нь өөрөө бараг одоогийн энэ үнэлгээний хуулиасаа илүү ач холбогдолтой. Үнэлгээний нөлөөлөлд автаж байгаа бүсийн олон иргэдийн нийгмийн асуудал, эрүүл мэндийн асуудал...

С.Бямбацогт: Гүйцээгээд хариулчихъя. Сандаг-Очир гишүүний микрофон.

Ц.Сандаг-Очир: Тийм учраас бид нар энэ асуудлыг цаашдаа тусгайлсан хуулиар зохицуулаад явах нь зүйтэй гэж ярилцаж байгаа зүйлүүд байна. Тийм учраас Их Хурлын гишүүд маань хууль санаачлах ажлын хүрээнд нийгмийн нөлөөллийн үнэлгээний хуулийг боловсруулаад ороод ирсэн тохиолдолд бид нар бас дэмжинэ. Яам бас бүх талаар дэмжиж хамтран ажиллана гэж ингэж бодож байна аа.

С.Бямбацогт: Тодруулъя Баасанжаргал гишүүн.

Х.Баасанжаргал: Нөгөө тодорхой хариуцлага байгаа гэж нэг ийм тодорхойгүй хариулт битгий өгөөсэй гэж хүсэж байна. Би бүүр кэйстэйгээ кэйс жишээн дээр хариултаа авъя. Зам барих томоохон тиймээ хэд хэдэн айлын бэлчээр даац малын өвөлжөө хаваржаа дайраад өнгөрлөө. Энд бол байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийж үзээд, энд бол байгаль орчинд бол нөлөөлөх байдал бол бага аа. Ямарваа нэгэн хуримтлал үүсгэх эргээд нөхөн сэргээх шаардлага байхгүй ээ гээд дүгнэлт гараад зам баригдах ажил явагджээ. Гэтэл үүнтэй холбоотой хожим нь ямарваа нэгэн хор үр дагавар гараад, энэ нөлөөллийн үнэлгээ өөрөө үндэслэлгүй ээ, дутуу хяналт шалгалт явуулжээ. Тухайн орчны ургамлын бүтцийг сайтар судлаагүй байна аа гэдэг дүгнэлт гараад, гарвал тэр үнэлгээ хийсэн хүн жишээ нь компани, мөн мэргэжилтнийхээ хувьд лицензтэй мэргэжилтнийхээ хувьд ямар хариуцлага хүлээх вэ?

С.Бямбацогт: Маш тодорхой асуулт асуулаа. Яг л иргэдийн амьдралд тохиолддог зовлон бэрхшээл. Энэ дээр тэгээд тодорхой хариулт өгчихье. 4 дүгээр микрофон.

Б.Алтанзул: Гишүүний асуултад хариулъя аа. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Байгаль орчны үнэлгээ аудитын хэлтсийн дарга Алтанзул байна. Шугам дэд бүтэц буюу зам барилгын ажлын үед өртөж байгаа, нөлөөлөлд өртөж байгаа айл өрхийн газар бол зайлшгүй бас яадаг нөлөө сөрөг нөлөөлөлд автдаг. Энийг бууруулах сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зөвлөмжийг Байгаль орчны үнэлгээний тайланд тусгадаг юм. Хэрвээ мэргэжлийн байгууллага буруу зөрүүтэй тайлан тусгасан бол хянан магадалгааг хийлгэх нөхцөл үүсдэг. Энэ нь бол хүний эрүүл мэнд, эрүүл мэнд, байгаль орчинд онц ноцтой сөрөг нөлөөлөл үзүүлсэн гэсэн дүгнэлт гарвал хянан магадалгааг тухайн байгууллагын одоо мэргэжлийн байгууллагын зардлаар дахин хийлгэх ийм нөхцөл үүсдэг, арга хэмжээ авдаг.

Мэдээж үнэлгээг буруу хийсэн зөрүүтэй тайлагнасан энэ асуудал дээр бол мэргэжлийн байгууллага мэргэжлийн зөвлөл үнэлгээг хүчингүй болгох арга хэмжээг авна. Энэ үнэлгээ хийсэн...

С.Бямбацогт: Тэгээд яг хариуцлага тиймээ үнэлгээг буруу хийсэн, дутуу хийсэн тохиолдолд үүссэн үр дагавар хохирлыг хэн барагдуулах вэ, яг ямар хариуцлага хүлээлгэх вэ гээд тодорхой асуугаад байна л даа. Яг тодорхой. Тэрийг л хариулчих.

Б.Алтанзул: Тийм үүссэн зардлыг бол үнэлгээ хийсэн мэргэжлийн байгууллага хариуцна.

С.Бямбацогт: 4 дүгээр микрофон хариулъя.

Ш.Батбаяр: Байгаль орчинд нөлөөлсөн хохирлыг нөхөн төлүүлэх асуудал дээр бол жил бүрийн 1 дүгээр улиралд байгаль орчны менежментийн төлөвлөгөөгөө төслүүд маань батлуулдаг байгаа. Төсөл дотор маань нөхөн сэргээлтийн зардлыг тусгаж өгдөг. Тэр нөхөн сэргээлтийн зардлынхаа 50 хувийг Сангийн яамны дансанд байршуулдаг байгаа. Хэрвээ нөхөн сэргээлт хийгээгүй тохиолдолд тэгээд хийгээгүй тохиолдолд тэр дансанд байршуулсан барьцаа хөрөнгөөр нь нөхөн сэргээлтийг хийнэ.

2 дугаарт нөхөн сэргээлтийг хийлгэх зардлын хохирлыг нэхэмжилнэ.

3 дугаарт байгууллагын лицензийг цуцлах ажлыг хийдэг байгаа.

С.Бямбацогт: Ингээд сайхан таагаад л хариулах юмаа тиймээ. Маш тодорхой асуугаад байна шүү дээ. Байгаль орчны нарийвчилсан үнэлгээ дутуу хийгээд, буруу хийгээд түүнээсээ болоод тийм үү ард иргэд оршин сууж байгаа иргэд эдгээрт байгаль орчинд учирсан хохирлыг хэн барагдуулах вэ, ямар хариуцлага, буруу үнэлгээ хийсэн компанид ямар хариуцлага хүлээлгэх вэ гэж тодорхой л асуугаад байна л даа. Энийгээ эцсийн хэлэлцүүлэг дээр тэр гүйцээж хариултаа наад хуульдаа тодорхой оруулаарай ажлын хэсэг.

Баасанжаргал гишүүн.

Х.Баасанжаргал: Саяын авсан кэйс дээр ховор ургамал устчихжээ гэж бүүр бодоод тэгвэл яаж ямар хариуцлага хүлээх юм бэ л гэж асуусан гэсэн үг. Тэгэхээр та хэд маань дараагийн хамгийн сүүлийн эцсийн хэлэлцүүлэг дээр би энэ асуултыг маш тодорхой асууна. Тэгээд бэлдэж ирээд дээрээс нь тэр мэргэжилтэн өөрөө ямар хариуцлага хүлээх вэ? Компани лицензээ хураалгачихдаг юм байна. Дахиад тэр мэргэжилтэн дахиад нэг өөр газар очоод нэг газар ажилд орно эсвэл дахиад шинээр компани байгуулна шүү дээ. Тэгвэл тэр үнэлгээ чинь өөрөө ямар хариуцлага хүлээх юм? Тэр хүн мэргэжлийн хариуцлага хүлээдэг юм уу, хүлээдэггүй юм уу? Даатгал энэ тэр гэж байдаг юм уу, байдаггүй юм уу гээд. Энэ чинь өөрөө системтэй асуудал байх ёстой байхгүй юу. Тэгээд энэн дээр та хэд эцсийн хэлэлцүүлэг дээр бэлдэж ирээрэй гэж хэлье.

С.Бямбацогт: Байнгын хорооноос гаргасан санал дүгнэлттэй холбогдуулж анхны хэлэлцүүлгийн ажлын хэсгээс бэлдсэн асуулт асууж, хариулт авч дууслаа гишүүд. Зарчмын зөрүүтэй 14 саналаар санал хураалгах ёстой. Санал хураалтыг 16 цагаас больё. Зарчмын зөрүүтэй саналтай холбогдуулж үг хэлэх гишүүд санал хураалтын үед үгээ хэлнэ ээ.

15.25 цаг

Дараагийн асуудалдаа оръё.

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг.

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх ТББХ-ны санал дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Лхагвын Мөнхбаатар танилцуулна аа. Индэрт урьж байна аа.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурал Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 1 дүгээр дүгнэлтийг 2026 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн нэгдсэн хуралдаанаараа Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 14 дүгээр зүйлд аль ч шүүх авч хэлэлцэхгүй байгаа эрх зүйн маргааныг хэргийн харьяаллыг тогтоолгохоор иргэн, албан тушаалтан, төр, олон нийтийн байгууллага Үндсэн хуулийн цэцэд гомдол гаргавал хэргийн харьяаллыг тогтоож холбогдох шүүхэд шилжүүлнэ гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн 64 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт Үндсэн хуулийн цэц, түүний гишүүн үүргээ гүйцэтгэхдээ гагцхүү Үндсэн хуульд захирагдах бөгөөд аливаа байгууллага, албан тушаалтан, бусад хүнээс хараат бус байна.

Далдугаар зүйлийн нэг дэх хэсэгт Үндсэн хуульд хууль, зарлиг төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино гэж заасантай нийцэхгүй байна гэсэн дүгнэлтийг хэлэлцэж, уг дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэж үзэн ирсүгэй гэсэн дүгнэлтийг хэлэлцэж уг дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэж үзэн Монгол Улсын Их Хурлын 5 дугаар тогтоолыг баталсан.

Тус дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөнтэй холбогдуулан Улсын Их Хурлын даргын 2026 оны 152 дугаар захирамжаар Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатар ахалж, гишүүдэд Улсын Их Хурлын гишүүн Батбаатар, Батсүмбэрэл, Пүрэвдаваа, Тэмүүжин, Уянгахишиг, Цогтбаатар нарын бүрэлдэхүүнтэй байгуулсан.

Ажлын хэсэг дээрх асуудлыг судлан үзэж хэлэлцээд Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.7.4-д хуулиар харьяаллыг нь тогтоогоогүй эрх зүйн маргааны хэргийн харьяаллыг тогтоох гэж, Улсын дээд шүүхийн шүүн таслах ажиллагааны талаарх бүрэн эрхийг тогтоосон байх тул Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 14 дүгээр зүйлийг хүчингүй болгох нь зүйтэй гэж үзсэн талаар Улсын Их Хурлын гишүүн Мөнхбаатар танилцууллаа.

Ажлын хэсгээс боловсруулсан Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг ТББХ 2026 оны 4 дүгээр сарын 28-ны өдөр Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.10-д заасныг баримтлан хэлэлцлээ.

Хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед зарчмын зөрүүтэй санал гараагүй тул анхны хэлэлцүүлгээс эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх горимын саналыг Улсын Их Хурлын гишүүн Мөнхбаатар гаргасныг байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх ТББХ-ны санал дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье ээ.

С.Бямбацогт: Мөнхбаатар гишүүнд баярлалаа. Улсын Их Хурлын гишүүд байнгын хорооны санал дүгнэлттэй холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилсан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна аа. Ирцийн дарааллаар гишүүдийн нэрс орсон байгаа. Хишигдэмбэрэлийн Тэмүүжин гишүүн асуултаа асууя.

Х.Тэмүүжин: Асуулт гэхээс илүүтэйгээр нэг протоколд үлдээх зорилготойгоор үг хэлж байгаа юм. Улсын Их Хурлаас анх удаа Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргаад тэр хүсэлтийн дагуу процессын эрүү цэцийн процессын хуультай холбоотой энэ заалтыг хүчингүй болгох ийм алхам хийгдсэн. Энэ алхмыг хийхдээ 1 дүгээрт бид Улсын Их Хурал хууль тогтоогчийнхоо хувьд шууд хуулийг хүчингүй болгож болох байсан боловч Үндсэн хуулийн цэцэд хүндэтгэлтэй хандаад, Цэцийн үйл ажиллагааны тодорхойлж байгаа хууль тогтоомжид Цэцийн санаа бодлыг тусгаж өөрчлөлт оруулах зорилготойгоор Улсын Их Хурлаас хүсэлт гаргасан. Тэгээд Цэцийн хуралд би өөрөө очсон. Тэнд хэлэлцэгдэж яригдсан нэг 2 зүйлийг би энд протокол болгож тэмдэглэн үлдээх ёстой гэж үзэж байгаа.

Нэгдүгээрт Үндсэн хуулийн цэц яг энэ маргаантай холбоотой асуудлаар нэг байр суурийг маш тодорхой илэрхийлсэн. Үндсэн хуулийн цэцийн гишүүн бид бол

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлэхдээ Үндсэн хуульд захирагдана гэдэг энэ зарчмынхаа дагуу явж байгаа. Үндсэн хуульд бол Цэцэд энд дурдагдаж байгаа чиг үүргийг шилжүүлж өгөөгүй учраас бид зөвхөн Үндсэн хуульд захирагдана гэдэг энэ зарчмынхаа дагуу энийг бол Үндсэн хуульд нийцэхгүй байна гэдэг дүгнэлтийг гаргаж байгаа. Гэхдээ иргэний үндсэн эрхтэй холбоотой асуудлыг Үндсэн хуулийн цэц авч хэлэлцэх эрхтэй байгаа шүү.

Өнөөдөр хүчин төгөлдөр үйлчилж байгаа 1992 оны Үндсэн хуулиар 64 дүгээр зүйлийн нэгд заасан дээд хяналт тавих гэдэг агуулга болон 66 дугаар зүйлийн 1, 2 дахь заалтад байгаа маргааныг хянан шийдвэрлэнэ. Маргаантай асуудлыг хянан үзнэ гэдэг энэ агуулгууд чинь маргаан маргаантай асуудлаараа бол ялгаатай бөгөөд цаашид шударгаар шүүлгэх эрх нь хөндөгдөж байна гэж үзэж иргэн үндсэн эрхийн асуудлаар гомдол гаргах юм бол Үндсэн хуулийн цэц маргааныг авч хэлэлцэх бүрэн боломжтой бөгөөд Үндсэн хуульд ийм агуулга байгаа шүү гэдгийг тодотгож дахин дахин хэлсэн гэдгийг би протоколд тэмдэглэж үлдээж байна.

Ер нь практик үйлдлээрээ Үндсэн хуулийн цэц иргэний үндсэн эрхийн маргаантай холбоотой асуудлуудыг шийдвэрлээд цаашид явах нь ээ. Сүүлийн гарсан хэд хэдэн шийдвэр дандаа иргэний үндсэн эрхтэй холбогдож байгааг хууль тогтоогчид анзаарах хэрэгтэй. Тийм учраас одоо хууль тогтоогчдод Үндсэн хуулийн цэцийн болон Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийг боловсронгуй болгож, иргэний үндсэн эрхтэй холбоотой асуудлуудыг Үндсэн хуулийн цэц хянан шийдвэрлэхтэй холбоотой хуулийн орчныг тодорхой болгож өгөхгүй бол хуультай, хуульгүй хамаа байхгүй ҮХЦ Үндсэн хуульд заагдсан чиг үүргээ Үндсэн хуулийг дээдлэх зарчмынхаа дагуу хэрэгжүүлээд явахад иргэний үндсэн эрхийн маргаан Цэцэд хянагдаад шийдэгдэх нь ээ. Хууль тогтоогч ажлаа хийх ёстой шүү гэдэг энэ агуулга энэ маргааныг хэлэлцэх явцад цөөнгүй удаа дурдагдсан гэдгийг би бүүр цохон энэ протоколд тэмдэглэн үлдээж байна.

Хоёрт нь иргэний үндсэн эрхийн эрхтэй холбоотой маргаан шийдэгдээд явахаар 66 дугаар зүйлийн 2.2-т дурдагдаж байгаа 4 зүйлээс гадна шүүхийн шийдвэрүүд болон ер нь иргэний үндсэн эрхэд халдсан төрийн байгууллагуудын үйл ажиллагаа хууль ёсны арга хэрэгслээрээ хангагдаагүй нөхцөлд Үндсэн хуулийн шүүх рүү явдаг тогтолцоо бүрдэх нь ээ. Тэгэхээр ганц Үндсэн хуулийн цэцийн тухай хууль болон Цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хууль биш бас л бусад процессын хуулиуд дээр Улсын Их Хурлын дэг дээр бас томоохон өөрчлөлтүүдийг хийж өгөхгүй бол Үндсэн хуулийн цэц болон Улсын Их Хурал өөр бусад институцүүдийн дунд хуульгүйгээр явах практикийг биднүүс зөв, бурууг хэмжихэд түвэгтэй болох нь байна шүү гэдгийг бас энд дурдаж хэлэхийг хүсэж...

С.Бямбацогт: Үг хэлчихлээ. Жуковын Алдаржавхлан гишүүн асуултаа асууя. Алга байна. Батын Батбаатар гишүүн асуултаа асууя алга байна. Гомбын Ганбаатар гишүүн асуултаа асууя.

Г.Ганбаатар: Асуулт ч юу байх вэ дээ. Зүгээр яах вэ ерөнхийдөө бид нар Цэц дүгнэлтээ хүлээгээд авчихсан юм чинь нэг их асуугаад ч яах вэ. Энэхүү хуулийн Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд ингээд өөрчлөлт оруулах гэж байгаа хуулийн төслийг дэмжиж байгаа. Ер нь яах вэ бид нарын энэ одоогийн Их Хурлын болон чуулганы дэгийн тухай хуульд Үндсэн хуульд нийцээгүй маш олон заалт байна аа. Тийм учраас Их Хурлынхаа чуулганы Улсын

Их Хурлын болон чуулганыгаа хуралдааны дэгийн тухай хуулиа Үндсэн хуульдаа нийцүүлэх шаардлага байгаа гэж үзэж байгаа. Зүгээр тухайлбал одоо Ерөнхий сайдыг огцруулах үед нөгөө итгэл үзүүлэх үед илэрхий алдаа гарч байсныг Цэц дээр авч хэлэлцээд, Үндсэн хуулийн Үндсэн хууль зөрчсөн байна аа гэсэн дүгнэлт гаргаж байсан.

Мөн Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн нэг дэх хэсэгт Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаа Үндсэн хуулийн 30 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар 4 жил байна гээд заасан байгаа. Гэтэл манай Үндсэн хуулийн 30 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт Ерөнхийлөгчөөр 50 нас хүрсэн сүүлийн 5-аас доошгүй жил эх орондоо байнга оршин суусан Монгол Улсын уугуул иргэнийг 6 жилийн хугацаагаар зөвхөн нэг удаа сонгоно оо гэснийг нь зөрчсөн эсэх талаар үндсэндээ Үндсэн хуулийн цэцэд дунд суудлаар хэлэлцэх гээд байж байх жишээтэй.

Тэгэхээр ийм мэтчилэнгээр одоо Улсын Их Хурлын тухай хуульд мөн дэг Улсын Их Хурлын дэг маань тэр чигээрээ үндсэн хуулийн зөрчилтэй байгаа учраас үүнийг нэг эргэн харж нягтлаад яаралтай шийдвэрлэх нь зүйтэй гэсэн ийм байр суурьтай байгаа.

С.Бямбацогт: Үг хэлчихлээ. Хүрэлбаатарын Булгантуяа гишүүн асуултаа асууя алга байна. Жудагийн Баярмаа гишүүн асуултаа асууя. Алга байна аа. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Зочин танилцуулъя. Нийслэлийн ерөнхий боловсролын 24 дүгээр сургуулийн 12-ын А ангийн багш сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа Төрийн ордонтой танилцаж байна аа. Удахгүй дунд сургуулиа төгсөөд, хүссэн их дээд сургуульдаа, хүссэн мэргэжлээрээ суралцаад улс эх орондоо ихийг хийж бүтээх эх оронч иргэн болж төлөвшихийг та бүхнээсээ хүсэж байна. Та бүхнийхээ сурлагад нь өндөр амжилт, амьдралд нь эрүүл энх, сайн сайхан бүхнийг Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс хүсэн ерөөе.

Санал хураалтыг 16 цагаас болгоё.

15.36 цаг

Дараагийн асуудалдаа оръё.

Эрхтэн, эд эс шилжүүлэн суулгах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлэг

Төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Баярмагнайн Баярбаатар танилцуулна аа. Индэрт урьж байна таныг.

Б.Баярбаатар: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Чинбүрэн, Алдаржавхлан, Ариунзаяа, Батсүмбэрэл нараас 2025 оны 3 дугаар сарын 31-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Эрхтэн, эд эс шилжүүлэн суулгах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурал 2026 оны 4 дүгээр сарын

23-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо 2026 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн хуралдаанаараа хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу явуулсан бөгөөд эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ариунзаяа амьгүй донорын гэр бүлд олгох оршуулгын тэтгэмжийг тодорхой мөнгөн дүнгээр болон хүн амын амьжиргааны доод түвшинтэй уялдуулах боломжийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Энхнасан амьгүй донорын гэр бүлд олгох оршуулгын тэтгэмжийг эрүүл мэндийг дэмжих сангаас гаргах нь хуульд нийцсэн эсэх, Улсын Их Хурлын гишүүн Бейсен тээгч эхээр хүүхдээ төрүүлэх зохицуулалтын талаар тус тус асуулт асууж, хариулт авлаа.

Улсын Их Хурлын 2026 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед хуралдаан даргалагчаас өгсөн гүйцээн боловсруулах чиглэлийн дагуу Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1 дэх заалтыг баримтлан зарчмын зөрүүтэй 4 саналаар санал хураалт явуулахад хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно оо.

Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналыг хуулийн төслүүдийн холбогдох зүйл, хэсэг, заалтад нэмж тусган хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаарыг нийцүүлэн өөрчилж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн хуулийн төслийг та бүхэнд тараасан болно оо.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Эрхтэн, эд эс шилжүүлэн суулгах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Иргэний улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Донорын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулсан талаарх Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны танилцуулга, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье ээ.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

С.Бямбацогт: Баярбаатар гишүүнд баярлалаа. Ажлын хэсэг ахалж ажилласан байгаа.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя. Намжилын Эрдэнэбаяр ЭМЯ-ны ТНБД, Сэмбэдоржийн Жаргалсайхан ЭМЯ-ны Бодлого төлөвлөлтийн газрын ахлах шинжээч, Нямдоржийн Отгонжаргал ЭМЯ-ны Эмнэлгийн тусламжийн бодлогын хэрэгжилтийн газрын мэргэжилтэн, Панданы Батчулуун Эрхтэн, эд эс шилжүүлэн суулгах үйл ажиллагааг зохицуулах албаны зөвлөх, Баяраагийн Алтантулга Эрхтэн шилжүүлэх, суулгах үйл ажиллагааг зохицуулах албаны дарга, Ганбатын Гэрэлцэцэг Өөжинмед Үр шилжүүлэн суулгах эмнэлгийн эмч.

Ажлын хэсгийн гишүүдэд Улсын Их Хурлын тухай хуулийн 21.24-д нэгдсэн хуралдаанд мэдээлэл хийж байгаа Засгийн газрын гишүүн ажлын хэсгийн

бүрэлдэхүүнд орсон холбогдох албан тушаалтан болон холбогдох албан тушаалтан үнэн зөв бүрэн мэдээлэл өгөх үүрэгтэй.

21.25.Нэгдсэн хуралдаанд мэдээлэл хийх, асуултад хариулах тайлбар өгөх албан тушаалтан өөрийн танилцуулсан мэдээллээ үнэн зөвийг хариуцах бөгөөд мэдээллийг санаатайгаар нуун дарагдуулах, худал мэдээлэл өгөх, Улсын Их Хуралд худал мэдээлэл ирүүлэхийг хориглоно гэж заасан.

21.31-д чуулганы хуралдаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүрэлцэн ирээгүй, тайлбар өгөхөөс татгалзсан, хуралдаанд оролцсон этгээдийн этгээд хуралдааны дэг зөрчсөн бол парламентыг үл хүндэтгэсэн үйлдэлд тооцож, тухайн этгээдэд Төрийн албаны тухай хууль болон холбогдох бусад хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ ээ гэж заасныг та бүхэнд сануулъя. Парламентын үйл ажиллагаанд Улсын Их Хуралд хүндэтгэлтэй хандахыг та бүхнээсээ хүсье.

Улсын Их Хурлын гишүүд байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна аа. Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн асуултаа асууя.

С.Эрдэнэболд: Хуулийг үзэл баримтлалын хувьд дэмжиж байгаагаа дахин илэрхийлье. Тэгээд манай Батчулуун эмч өөрөө бас яг энэ хуулийн зохицуулалтын тодорхой бус байдлаас болоод хэлмэгдэж эрүүл мэндээрээ хохирсон. Тэгээд өөрөө гарч ирээд энийгээ бодлогын ажил болгоод явж байгаад нь талархалтай хандаж байгаа.

Хэдэн асуулт байна. Тэгээд явцын дунд та бүхэн тэмдэглээд авчхаарай. 4.3.1 дээр тэр 4.3.1-ийг дахин бичихдээ редакцын хувьд дахин бичихдээ муутгачихсан байгаа юмаа. Амьгүй донор гэж тархины үйл ажиллагаа бүрэн таслал эргэшгүй алдагдсан гээд өмнөх дээр нь болох юм бол бүрэн үхжиж гэсэн байгаа. Тэгэхээр нөгөө энэ бол яаж байна гэхлээрээ утга шилжээд монгол хэлний найруулга зүйн хувьд бол хоёрдмол утгатай болчихсон зүйл байгаа шүү.

Дараагийн хувьд нь гэх юм бол эцсийнх учраас тэр био банкныг дэмжиж байгаа. Био банкынхаа тодорхойлолтыг жоохон өргөн хүрээнд олон улсын юунаас харлаа, илүү их дэлгэрэнгүй тодорхойлолттой байдаг юм байна. Манай тодорхойлолт маш ерөнхий болсон байна. Энийг дахиж задалмаар санагдлаа.

5.1.6 дээр байгаа мэдээллийг танилцуулж зөвшөөрөл авах гэдгийг яагаад дарж байгаа юм бэ? Энэ чинь хамгийн эмзэг чухал зүйл биз дээ. Дараад нь тэр реципиент гэдэг үгийг зайлшгүй ингэж орос галигаар бичих үү, эс үгүй бол үүнийг монголоор бичих тийм арга байна уу? Байхгүй бол яах вэ мэргэжлийн хүмүүсээс нь, хууль санаачлагчаас асууя.

6.2.1 дээр редакцын алдаа байна. Монгол Улсын гээд тэрийг та бүхэн Үндсэн хуулийн бичилтийнх нь дагуу засмаар байна. 7.1.1 харгалзахгүйгээр гэж байгаа. Энэ Үндсэн хуулийн 14.2 дээр байгаа гадуурхаж үл болно гэдэг үг байгаа. Тэгээд тэр нь тэрэн шигээ яг Үндсэн хуулийн нөгөө бичилт найруулгыг нь аваад харгалзахгүйгээр гэхийн оронд үл харгалзан гээд явчихаар утга илүү тодорхой найруулга зүйн хувьд зөв болох гээд байна. 8.1.1 дээр редакцын алдаа байна. Өөрсдөө хараарай. 8.1.3 дээр гэрлэгч нь гэрлэлтээ бүртгүүлснээс хойш 3-аас доошгүй жил болсон байх гэхихээд таслалын ард хэрэв гэрлэгчид дундаасаа төрсөн хүүхэдтэй бол жил

харгалзахгүй гэж байгаа. Энэ 2 өөр утга байгаа учраас энэ хэрэв гэрлэгчид гэдэг хэсгийг тусад нь зүйл болгож оруулах зайлшгүй шаардлагатай. Эргэлзээ үүсгэхгүй, хоёрдмол утга үүсгэхгүйн тулд. 8.1.4 дээр заавал хөгжлийн бэрхшээлгүй хүн гэлгүйгээр хөгжлийн бэрхшээлгүй таслалын ард болон сэтгэцийн эмгэггүй гэдгийг гээд явчихвал их зөв байна.

Мөн эрх бүхий байгууллагаас байгууллага тодорхойлсон байх гэдэг дээр эрх бүхий таслал мэргэжлийн гэж оруулах нь зөв байна аа. 9.1.6 дээр эрүүл мэнд, амь нас, аюулгүй байдал гэсэн агуулга дээр амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдал гэж найруулах нь зүйтэй харагдаж байна. Яагаад гэхлээр эрэмбийн дарааллаар амь нас нь эхэндээ чухал гэдэг агуулгаар. Би нөгөө цаг бага байгаа учраас товчхон яриад байгаа. 10.1 дээр тархины үхэл тодорхойлох мэргэшсэн багаар тархины үхэлтэй болох нь тогтоогдсон тохиолдолд амьгүй донороос эрхтэн, эд эс авна гэж байгаа. Энэ нөгөө энэ хууль дээрээ бас яг энэ амьгүй донорыг хүндэтгэх гэсэн агуулга явж байгаа шүү дээ. Тэгэхээр энийг ядаж шилжүүлэн авна ч гэдэг ч юм уу, шилжүүлж авна гэдэг зөөлрүүлсэн үгээр тавихгүй бол шууд одоо дэлгүүрийн лангуунаас юм авч байгаа юм шиг маш хүндэтгэлгүй бичилтийн мэдрэмжийн хувьд агрессив сонсогдож байна шүү. Тэгэхээр энэ дээрээ бол бас хүний эрхийн мэдрэмжтэй байх үүднээс ийм үг оруулмаар байна. 10.5 дээр за энийг больё.

Ингээд гэх мэт ийм найруулга зүйн болон хоёрдмол салаа утга илэрхийлсэн байж болзошгүй зүйлүүд нэлээн байгааг та бүхэн харгалзаж үзээч ээ. Эцсийн хэлэлцүүлэг явж байгаа учраас. Ядаж адаглаад цэгийн цэг өгүүлбэрийн хооронд нэг зай авах, 2 зай авахаа жигдлээч ээ. Том жижиг үсгүүдээ жигдлээч ээ. Дээрээс нь энэ чинь өөрөө хүний амь нас, эрүүл мэнд маш том асуудал яригдаж байгаа учраас эдгээр асуудал дээр анхаараач ээ. Саяын асуултуудад хариулт аваад дахиад нэг тодруулна аа.

С.Бямбацогт: Ажлын хэсгийн ахлагч Баярмагнайн Баярбаатар гишүүн хариулъя.

Б.Баярбаатар: Эрдэнэболд гишүүний асуултад би эхлээд хариулчихъя. Дараа нь манай Алтантулга дарга хариулахад бэлдээрэй. Тийм өнгөрсөн хууль санаачлагч хуулийн төслийг өргөн барьснаас хойш яг жилийн дараа бид энэ хуулийг эцэслэн батлахаар нэг жилийн хугацаанд дэмжлэг үзүүлэх ажлын хэсэг болон Улсын Их Хурлын гишүүдээс бүрдсэн ажлын хэсэг цэг таслалгүйгээр хэлэлцэж өнөөдөр бас хэлэлцүүлэг явж байна. Таны гаргасан саналуудыг бид эцсийн хэлэлцүүлэг өнөөдөр явагдаж байна. Эцэслэн батлах редакц үед бид нар редакцын засваруудаа хийгээд оруулаад ирэх юм. Тэгэхээр эдгээр зүйлүүд дээр бас зарим эцсийн найруулгуудыг хэлэлцэх үед редакцын засваруудаа хийгээд дараа 7 хоногийн одоо Баасан гарагт батлагдах болов уу гэж харж байгаа. Тэгээд тэр үед энэ редакцын засварууд хийгдээд ороод ирнэ ээ гэдгийг хэлье. Мэргэжлийн байгууллагаас нь Алтантулга дарга 4 номерын микрофон дээр хариулчих даа.

С.Бямбацогт: 4 дүгээр микрофон индрийн ажлын хэсэг хариулъя.

Б.Алтантулга: Сайн байцаана уу? Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Эрхтэн шилжүүлэн суулгах албаны дарга Алтантулга байна. Эрдэнэболд гишүүний асуултад нэмж хариулъя. Бид нар энэ хуулийн төсөлдөө одоо мөрдөгдөж байгаа манай донорын тухай хууль дээр реципиент гэдэг нь болохоороо эмчлүүлэгч болон эмчлүүлэхээр хүлээгдэж байгаа энэ хүнийг хэлнэ гэж Донорын тухай хууль дээр утга

найруулгын хувьд тайлбарласан байгаа. Энэ хүрээлэлдээ ч гэсэн хууль батлагдсанаас хойш энэ реципиент гэдэг бол эмч, эмнэлгийн мэргэжилтэн тэр дундаа иргэд олон нийтийн дунд яг бүрэн хэрэглэгдээд нэвтэрчихсэн ийм үг хэллэг, тэр дундаа ч олон улсдаа ч гэсэн яг реципиент гэдгээрээ яг явагддаг. Энэ ч үүднээсээ бид нар энэ шинэ хуулийн төсөлдөө энэ реципиент гэдэг энэ хэллэгээр нь яг авч үлдсэн нь зүйтэй юмаа гээд ажлын хэсгээрээ ярилцаж шийдээд энэ реципиент гэдгээрээ явсан байгаа.

Манай Био банкны хувьд гэх юм бол бид нар манай энэ эрхтэн эд эсийг шилжүүлэн суулгах тухай хуулийн төсөл дээр шинэ дэвшилтэт технологийн асуудлуудыг бид нар оруулж ирж байгаа. Энэ зууны хамгийн төгс эмчилгээ бол энэ үүдэл эсийн эмчилгээний энэ асуудлыг оруулж ирэхийн тулд энэ био банк...

С.Бямбацогт: Хариултаа гүйцээгээд хариулчихъя.

Б.Алтантулга: Энэ био банкны асуудлыг шийдэх шаардлагатай юм байна гээд. Одоо бол бид нар яг энэ улсын хэмжээнд нэг ямар ч л байсан төрийн зохицуулалттай энэ био банк байх шаардлагатай. Мөн үүнээс гадна хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага дэргэдээ био банктай байж болно оо гэдэг энэ асуудлыг оруулж ирээд, Био банканд судалгаа шинжилгээ, эмчилгээний зорилгоор ашиглаж болно. Энэхүү үйл ажиллагааны процессыг бол журмаар журам боловсруулж ингээд батлуулна гэдэг байдлаар оруулж өгсөн. Тархины үхэлтэй энэ донорын тухай ойлголтын хувьд яг энэ бид нар мэргэжлийн үг хэллэгийн дагуу яг иргэд олон нийтийн дунд эргэлзээ төрүүлэхээргүй, хоёрдмол утгагүй байдлаар бид нар хуулийн төсөлд оруулахыг илүү хичээсэн. Бусад редакцуудын асуудлыг бол бид нар хийж болох байх аа.

С.Бямбацогт: Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн тодруулж асууя.

С.Эрдэнэболд: Тийм. Би та бүхнийг нөгөө шүүмжлээд байгаа биш дэмжиж байгаагаа эхлээд илэрхийлчихсэн. Гэхдээ нөгөө Монгол хэлний зөвлөлөөс ч юм уу ер нь нэг яг ийм мэргэжлийн талаасаа та нар хангалттай ажилласан байх. Тэгэхдээ яг Монгол хэлний зөвлөл талаасаа ингээд бас энэ хуулиуд дээрээ хуулиудын редакц дээрээ давхар ажиллуулдаг баймаар байгаа юм. Энэ Төрийн хэлний зөвлөл гээд. Би яг дахиад зөндөө юм яривал энэ зөндөө юм ярихаар байна. Тэгээд манай Баярбаатар гишүүн энэ дээр маш идэвхтэй уйгагүй ажиллаж байгаа. Агуулгыг дэмжиж байгаа учраас ингээд зарим зүйлийг орхиж байгаа.

Гэхдээ нэг зүйлийг би тодруулж асуумаар байна. 15.6 дээр холбогдох эрүүл мэндийн байгууллагын дүгнэлтээр өөрөө жирэмслэх ураг тээх ураг тээх хүүхэд төрүүлэх чадваргүй нь тогтоогдсон эмэгтэйд тээгч эхээр дамжуулан хүүхэдтэй болохыг зөвшөөрөх бөгөөд бусад тохиолдолд тээгч эх ашиглахыг хориглоно оо гэж байгаа. Энэ дээр яг олон улсын туршлага ямар байдаг юм? Яагаад энийг заавал хориглоод байгаа юм бэ?

С.Бямбацогт: 4 дүгээр микрофон Алтантулга ажлын хэсэг хариулъя.

Б.Алтантулга: Эрүүл мэндийн хөгжлийн төв Алтантулга. Эрдэнэболд гишүүний асуултад нэмж хариулъя. Хуулийн төсөл дээр одоо яг мөрдөгдөж байгаа Донорын тухай хуульдаа ч гэсэн хэрэв тээгч эх ашиглаж байгаа энэ тохиолдолд бол тухайн эмэгтэй маань өөрөө жирэмсэн болох боломжгүй нь холбогдох эрүүл

мэндийн байгууллагын дүгнэлтээр батлагдсан тохиолдолд энэ тээгч эхийг ашиглана гэж энэ хуулийн төсөлд оруулсан. Олон улсад хэд хэдэн туршлагууд байдаг. Зарим улс оронд бол бүх нөхцөлд тээгч эх ашиглахыг зөвшөөрсөн ч ийм тохиолдол байна. Зарим нь тээгч эх ашиглах нь энэ заавал ч үгүй эрүүл мэндийн энэ дүгнэлтийн шалтгаантайн улмаас энэ тогтоочихсон тохиолдолд энэ тээгч эх ашиглахыг зөвшөөрсөн ийм байдаг.

Бид нар энэ өнөөдрийн байдлаар Монгол Улсад үр шилжүүлэн суулгах 5 эрүүл мэндийн байгууллага байдаг. Эдгээр 5 эрүүл мэндийн байгууллагын төлөөлөлтэйгөө хамтарч уулзаад яг энэ тээгч эх ашиглах тохиолдоход ямархуу нөхцөл байдалтай байдаг юм бэ гээд ажлын хэсгээрээ ярилцаад яг тээгч эх ашиглах тохиолдолд тухайн эмэгтэй маань ямар нэгэн эрүүл мэндийн шалтгааны...

С.Бямбацогт: Гүйцээгээд хариулчихъя энэ чухал асуудал учраас. Иргэд бас мэдээлэл авч байгаа. За 4 дүгээр микрофон.

Б.Алтантулга: Тийм энэ хүүхэд тээх нь энэ боломжгүй болсонд холбогдох эрх бүхий эрүүл мэндийн байгууллагын дүгнэлтээр батлагдсан тохиолдолд тээгчийг ашиглаж болно оо гэдэг энэ хуулийн төсөлтэй томъёоллоор оруулсан байгаа. Нэг ёсондоо энэ маань юу гэсэн үг вэ гэхээр та ямар нэгэн байдлаар би тухайн эмэгтэй маань гоо сайхныхаар ч юм уу эсвэл би хүүхэд тээхгүй гэдэг өөрийн хүслээрээ бол тээгчийг ашиглах боломжгүй ээ. Энэ тохиолдолд заавал ч үгүй эрүүл мэндийн шалтгааны улмаас батлагдсан тохиолдолд тээгч эхийг ашиглаж болно оо л гэдэг энэ асуудлыг зохицуулсан байгаа.

С.Бямбацогт: Асуулт нэмэлт асуулт Эрдэнэболд гишүүний микрофон өгье.

С.Эрдэнэболд: Энэ өөрөө аягүй их тийм хүний эрхийн хувьд их ээдрээтэй асуудал байгаа юмаа. Шууд хууль дээр ингэж тавих нь өөрөө хэр байдаг юм болдоо. Би энийг уншаад олон улсын жишээ кэйсүүдийг нэлээн үзсэн. Их маргаантай асуудал. Манайх шууд ингэж хүчээр ингэж тавих нь өөрөө хүний эрхийн зөрчилтэй агуулах зохицуулалт байх магадлал өндөртэй байна аа. Тэгэхээр хүний эрхийн дэд хорооны даргаар шинээр сонгогдсон Баасанжаргал гишүүнд бас хандмаар байна. Яг энэ 15-ын тийм л дээ тэгэхдээ яах вэ 15.6 дээр ер нь энэ ХЭҮК-оос энэ дээр дүгнэлт гаргуулаад, хууль батлагдахаас өмнө энэ дээр яаралтай бас нэг ийм тодорхойлолт авах нь зөв байж магадгүй шүү. За боллоо.

С.Бямбацогт: Ажлын хэсгийн ахлагч Баярмагнайн Баярбаатар хариулъя.

Б.Баярбаатар: Хуулийг хэлэлцүүлэгт бэлтгэх явцад Хүний эрхийн комиссоос санал аваад нийтдээ 22 санал ирсэн. 22 саналыг бид нар 100 хувь хуульдаа тусгаж өгсөн байж байгаа. Саяын заалттай холбоотой Хүний эрхийн комиссоос ямар нэгэн тийм эсрэг comment бол санал ирээгүй. Энэ зүйл заалтыг бид нар олон талаас нь ярилцсан. Зүгээр энгийн үгээр илэрхийлэхэд Монгол Улс бол тээгч хийхийг зөвшөөрсөн улс. Гэхдээ өнөөдөр гоо сайхны мэс засал ч юм уу янзан бүрийн шалтгаанаар тээгч эх ашиглах нь өөрөө буруу юмаа. Яг л үнэхээр өнөөдөр ураг тээх боломжгүй, жирэмслэх боломжгүй үед л энэ тээгч эхийг ашиглах нь өөрөө зөв гэдэг агуулгаар оруулж ирсэн. Тэгээд манай мэргэжлийн эмнэлгийн байгууллага Өөжинмед эмнэлэг эд нар ч гэсэн энэ дээр санал нэгдээд ингээд энэ хуульдаа ингэж өнөөдөр мөрдөгдөж байгаа хуулиа яг энэ зүйл заалтаар нь оруулаад ирсэн байгаа

шүү гэдэг. Одоо мөрдөгдөж байгаа хуульд энэ заалт байж байгаа. Донорын хууль дээр тийм.

С.Бямбацогт: Наранцэцэгийн Алтаншагай гишүүн асуултаа асууя алга байна. Буланы Бейсен гишүүн асуултаа асууя.

Б.Бейсен: Энэ Эрхтэн, эд эс шилжүүлэн суулгах тухай хуулийн төслийг дэмжиж байгаа юм. Яагаад гэвэл байр нь баригдчихаад байдаг хуулийг нь баталж өгөхгүй бол бас болохгүй. Нөгөө талаараа манай Монгол Улс маань эд эрхтэн шилжүүлэх тал дээр нэлээн дээгүүр явж байгаа. Элэг бөөр шилжүүлэн суулгах асуудал дээр. Тэгээд энэ 3 асуудал асууя гэж бодож байна.

Нэгдүгээрт энэ эд эс эрхтэн шилжүүлж байгаа эмч нарын эрх зүйн байдлыг энэ хуульд яаж тусгасан юм бэ? Жишээлбэл одоо сая Батчулуун эмч эд нар чинь нэг шөрмөсний төлөө бас ингээд ял аваад, эрүүл мэндээрээ хохирсон асуудал гарсан шүү дээ. Энийг тодорхой тусгасан уу? Цалин хөлс нь зүгээр нэмэгдэл илүү цагийн юугаар авч байна уу? Цалин хөлсийг нь бас нэмж тогтоох тал дээр ямар бодлого орж байна? Одоо амьдрал бэлэглэж байгаа улсууд шүү дээ 1 дүгээрт.

Хоёр дахь асуудал дэлхийн чиг хандлага болохоор чинь амьгүй донор тархи үхэжчихсэн юм уу тийм аваар осолд ороод амьдрах чадваргүй болсон тийм улсуудаас эд эрхтэн аваад шилжүүлэн суулгадаг юм байна. Аль болохоор амь донороосоо авах, ах дүү нараас нь авах асуудлыг хойш нь тавьдаг юм байна. Яагаад гэвэл тэр улс бас хүн маань эрхтэн өгч байгаа хүн маань эрүүл мэндээр хохирдог, дараа нь өндөр эмчилгээний төлбөр шаарддаг асуудал байгаа юм л даа. Энэ талын асуудал дээр ямар бодлого барьж байна?

Гурав дахь асуудал энэ хүүхдийн элэг бөөр шилжүүлэн суулгах асуудал байгаа. Цусны өвчтэй хүүхэд дээр яс чөмөг шилжүүлэн суулгах, үүдэл эс суулгах асуудал байж байна. Энийг ер нь цаашдаа ЭХЭМҮТ-тэй яахгүй бол энэ том хүний юутай бас физиологийн хувьд анатоми физиологийн хувьд зохихгүй асуудлууд байж байгаа. Энийг цаашдаа тэр хүүхдийн ерөнхий мэс засал, урологийн алба, цусны албатай хамтраад шийдэх тал дээр ямар бодлого барьж байна?

С.Бямбацогт: Ажлын хэсэг 4 дүгээр микрофон хариулъя.

Б.Алтантулга: Эрүүл мэндийн хөгжлийн төв Алтантулга. Бейсен гишүүний асуултад хариулъя. Эхнийх нь бол энэ бид нар энэ хуулийн төслөө анх боловсруулаад явж байхад бол ялангуяа яг энэ эрхтэн эд эс шилжүүлэн суулгах үйл ажиллагаанд оролцож байгаа эмч эмнэлгийн мэргэжилтнүүдийг нь хамгаалах энэ асуудлуудыг оруулах гэж ингэж ажилласан. Хуулийн явцад бол бие даасан энэ хуулийн төсөл маань манай Мөнхсайхан гишүүн санаачлаад өргөн бариад явж байгаа. Энэ нь бол эмнэлгийн мэргэжлийн тухай хуулиараа илүү зохицуулаад тусдаа бие даасан хуулиараа явуулах нь байна зүйтэй юм байна гэж үзээд энэ хуулийн төслөөр явж байгаа гэж ойлгож байгаа.

Дараа нь бол энэ олон улсад бол таны дурдсанчлан яг үнэн. Олон улсад яг энэ эрхтэн шилжүүлэн суулгах үйл ажиллагааны 90 гаруй хувь нь амьгүй донороос, үлдсэн 10 гаруй хувь нь амьд донороос хийгддэг. Энэ юу гэсэн үг вэ гэхээрээ хэрвээ тухайн хүн үнэхээр амь нас нь эрсдэх гээд байгаа ойрын 1 сарын хугацаанд эрсдэх гээд байгаа тохиолдолд тухайн гэр бүлийн гишүүдээс нь амьд донороос эрхтэн

шилжүүлэн суулгах ийм тогтолцоо байдаг. Бусад бүх тохиолдол нь төлөвлөгөөт мэс засал буюу энэ амьгүй буюу энэ тархины үхэлтэй донороос эрхтэн шилжүүлэн суулгах үйл ажиллагаа яригддаг.

Монгол улсад өнөөдрийг хүртэл энэ байдал маань эсрэгээрээ буюу 90 гаруй хувь нь амьд донороос, үлдсэн 10 гаруй хувь нь амьгүй буюу тархины үхэлтэй донороос хийгддэг байгаа. Тэгэхээрээ бид нар энэ шинэ хуулийн төсөлдөө энэ opt out opt in гэдэг холимог тогтолцоог оруулж өгснөөрөө энэ пропорционал маань олон улсын жишигтэйгээ нийцэх юм байна аа гэдэг энэ ойлголтод хүрч энэ шинэ хуулийн төсөлд оруулсан байгаа.

3 дахь асуудлын тухайд бол энэ ЭХЭМҮТ дээр бид нар энэ эрхтэн эд эс шилжүүлэн суулгах энэ асуудлыг бол дэмжиж ингэж зохицуулалтыг хийж ажиллаж байгаа. Өнөөдрийн байдлаар ЭХЭМҮТ дээр элэг шилжүүлэн суулгах мэс засал хийгдэж байна. Бид нар бөөр шилжүүлэн суулгах багийг хамтран байгуулаад ингээд шилжүүлэн суулгах мэс заслын үйл ажиллагааг зохион байгуулаад явж байна. Мөн цусны үүдэл эс шилжүүлэн суулгах энэ хүүхдэд ясны хавдартай энэ хүүхдэд маань цусны үүдэл эс шилжүүлэн суулгах энэ тогтолцоог бид нар Улсын 1 дүгээр төв эмнэлэгтэй хамтраад багийг бэлдэх, чадавхжуулах эрх зүйн орчныг нь бүрдүүлэх энэ эмчилгээний дэвшилтэт технологийг ингээд нэвтрүүлээд явж байгаа.

Манай энэ хуулийн төсөл дээр маань мөн дурдсанчлан амьгүй донорт ямар нэгэн насны хязгаар заахгүй гэж орсон байгаа. Энэ маань бол энэ хүүхдээс хүүхдэд харамсалтайгаар хэлж байгаа ч гэсэн хүүхдээс хүүхдэд эрхтэн шилжүүлэн суулгах энэ боломжийг мөн нээж өгч байгаагаараа энэ хуулийн төсөл маань онцлогтой байгаа.

С.Бямбацогт: Бейсен гишүүн тодруулж асууя.

Б.Бейсен: Энийг ярьж байгаа маань энэ 3 жилийн өмнө Туркийн Башкент Университитийнх нь Эх нялхсын эх хүүхдийн эрүүл мэндийн төвд хүүхдийн элэг, бөөр шилжүүлэн суулгах төвийг байгуулж байгаа гэсэн дэлхийн 17 оронд байгуулж өгсөн байна. Тухайн үед сайдууд анхаараагүй байхгүй юу. Энэ дээр бид бас холбоотой ажиллая. Дараагийн асуудал энэ тархи үхэжсэн амьгүй донороос авсан дээрхт авсан тохиолдолд ар гэрт нь олгох тэтгэмжийн хэмжээг яаж тогтоох гэж байна?

С.Бямбацогт: Хариулъя ажлын хэсэг 4 дүгээр микрофон.

Б.Алтантулга: Эрүүл мэндийн хөгжлийн төв Алтантулга. Бейсен гишүүний асуултад нэмж хариулъя. Бид нар амьгүй донороос болсон тохиолдолд гэр бүлийн гишүүнд нь оршуулгын тэтгэмж өгөх асуудлыг шинэ хуулийн төсөл дээрээ бид нар нэмж боловсруулаад, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин тэнцүүлсэн тэнцээтэй хэмжээний оршуулгын тэтгэмжийг Эрүүл мэндийг дэмжих сангаас олгоно оо гэдэг жишээ нь хуулийн төсөлдөө бид нар тусгасан байгаа.

Тэгэхээрээ энэ маань бол бид нар амьгүй донорын гэр бүлтэй уулзаад энэ донор болох хүсэлт тавих энэ явцад бол манай албаны зүгээс тухайн гэр бүлд энэ туслах ямар аргаар туслах байдаг гэдгийг судалж үзээд, олон улсад жишигт нийцсэн нь жишээ нь БНСУ-д амьгүй донор болсон тохиолдолд оршуулгын тэтгэмж өгдөг юм байна гэдэг тогтолцоог бид нар судалж үзээд энэ тогтолцоогоо бид нар энэ шинэ

хуулийн төсөлдөө оруулж ирсэн байгаа. Тэгэхээрээ одоо бол тэр даатгал төлөгч эсэхээс нь үл хамаараад амьгүй донор болсон тохиолдолд Эрүүл мэндийг дэмжих сангаас хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний оршуулгын тэтгэмжийг олгоно оо гэдэг энэ заалт маань орсон байгаа.

С.Бямбацогт: Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Жигжидийн Батжаргалын урилгаар нийслэлийн ерөнхий боловсролын 153 дугаар сургуулийн 12-ын А ангийн багш сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа Төрийн ордонтой танилцаж байна аа. Та бүхэн маань удахгүй болох гэж байгаа ЭЕШ-даа амжилттай сайн бэлдэж, хүссэн сургуульдаа, хүссэн мэргэжлээр суралцаж эзэмшиж, улс эх орондоо бүтээлч, эх оронч сайн иргэн болон төлөвшихийг нийт Улсын Их Хурлынхаа гишүүдийн нэрийн өмнөөс та бүхэндээ хүргэе ээ. Сурлагын өндөр амжилт хүсье ээ. Амьдралд нь аз жаргал, эрүүл энх, сайн сайхан бүхнийг хүсье. Аав ээж, багш нарынхаа үгэнд сайн орж байгаарай.

Одоо нэг гишүүн асуулт асуусны дараа асуулт асууж, хариулт авсны дараа санал хураалт явагдана. 16 цаг болж байна. Гишүүдийг чуулганы танхимдаа хүрэлцэн ирж санал хураалтдаа оролцохыг урьж байна аа. Батын Батбаатар гишүүн асуултаа асууя.

Б.Батбаатар: Энэ хууль яаралтай батлагдах хэрэгтэй. Батлагдахыг нь дэмжиж байгаа. Ажлын хэсгийнхнээс өмнөх хэлэлцэх эсэх асуудлуудаар нь эхний хэлэлцүүлгийн үеэр асуулт асуугаад, саналуудаа хэлээд ингээд үлдээчихсэн. Зарим зүйл нь өөрчлөгдөж орж ирж байна гэж ойлгож байгаа.

Одоо Ерөнхий сайд Учрал юм уу, Их Хурлын дарга Бямбацогтоос асуулт шахуу зүйл байгаа. Энэ хуулийг хэлэлцэх эсэх дээр Их Хурлын чуулганы танхим дотор Б.Энхбаяр, Бат-Амгалан, Батшугар 3 сайд л сууж байсан. Засгийн газрын гишүүн 20 орчим сайд нар бүгдээрээ Их Хурлын гишүүд. Хүний ард иргэдийнхээ эрүүл мэндийн төлөө яаралтай батлагдах ёстой хууль дээр жил гаран ажлын хэсэг хэлэлцээд ингээд явж байгаа хууль дээр Засгийн газрын гишүүн 3 сайд бусад нь дандаа ирцэд орчихсон эсрэг санал өгч байсан. Эд эрхтэн шилжүүлэн суулгах энэ хуулийг хэлэлцэх үү, үгүй юу гэдэг санал дээр Засгийн газрын 17 сайд эсрэг санал өгсөн гэсэн үг. Ирэх 7 хоногт энэ хуулийн эцсийн найруулгыг нь сонсож хууль батлагдана. Тэгэхлээр үүн дээр Засгийн газар бол иргэдийнхээ эрүүл аюулгүй амьдрахын төлөө эхний Их Хурлын өмнө үүрэг хүлээж, хариуцлага хүлээж байгаа гүйцэтгэх төв байгууллага шүү дээ.

Тэгэхээр үүн дээр Бямбацогт Их Хурлын дарга гишүүдийнхээ ирц ер нь өглөө 10 цагтаа ирвэл энэ чуулган бас болно шүү дээ. 9 цагт ирлээ гээд уншдаг чинь цагийн төлөвлөлтгүй л байна гэсэн үг. Ирц бүртгүүлэх бүтэн цагийн хугацаан дотор хэн нь хэдэн цагт орж ирж, хэдэн минутад орж ирэх нь хамаагүй шүү дээ. Тийм болохоор энэ хуулийг батлах үед Засгийн газрын 20 гишүүнийг бүгдээрээ сууж энэ хуулийг батлах талд нь санал өгөх, дэмжих ёстой гэдэг зүйлийг Их Хурлын даргын хувьд Засгийн газарт анхааруулж хэлээрэй гэж ийм хүсэлтийг тавьж байна. Хэлэлцэх эсэх дээр нь 17 сайд эсрэг санал өгсөн. Ирцэд ороод тэгээд энд 3 сайдаас бусад нь байгаагүй эсрэг санал өгсөн. Энийг иргэд сонсож байх ёстой гэж ингэж ойлгож байгаа.

С.Бямбацогт: Батбаатар гишүүн чухал асуудал хөндөж байна аа. Манай Улсын Их Хурлын гишүүд ирцдээ орчхоод санал хураалтдаа оролцолгүй гараад

явчихдаг. Түүнээсээ болоод эсрэг санал өгдөг. Энэ маш чухал хууль. Эд эрхтэн эс шилжүүлэн суулгах тухай хуулийн төслийг 2025 оны 3 сарын 31-ний өдөр манай Их Хурлын гишүүн Чинбүрэн, Ариунзаяа, Алдаржавхлан, Батсүмбэрэл нар өргөн барьсан. Хэлэлцэх эсэхийг нь шийдэх үед сая бас Засгийн газрын гишүүд байхгүй эсрэг санал өгч байсан гэж Батбаатар гишүүн ярьж байна. Тийм болохоор одоо эцэслэн батлах эцсийн хэлэлцүүлэг дээр Засгийн газрын гишүүдийг танхимдаа орж ирж санал хураалтад оролцохыг хүсье ээ.

Энэ чухал хууль аа. Тийм болохоор 16 цагаас санал хураалттай гэж би бас 12 цагт зарласан, 16 цагаас санал хураалттай шүү. Гишүүд санал хураалтдаа танхимдаа бэлэн байгаарай гэж хүссэн. Эд эрхтэн эс шилжүүлэх тухай хууль үндсэндээ бүтэн жил гаруй хэлэлцэгдээд Улсын Их Хурлын гишүүн Баярбаатараар ахлуулсан Энхнасан, Баясгалан, Болормаа, Рэгдэл, Отгонбаяр, Сарнай, Эрдэнэбат нарын ажлын хэсгийн гишүүд жил гаруй ажиллаад одоо ингээд эцэслэн эцсийн хэлэлцүүлэг хийж байна. Ажлын хэсэгтээ баярлалаа. Хариуцлагатай ажиллаж энэ хуулийг оруулж ирсэнд. Одоо иргэдийн бас амь нас эрүүл мэндэд эд эрхтэн эс шилжүүлэхтэй холбоотой хүлээгдэж нэлээн дээсэн дөрөөн дээр байгаа. Тийм болохоор сая Батбаатар гишүүний ярьж байгаа санал зөв шүү. Засгийн газрын гишүүдийг, Их Хурлын гишүүдийг санал хураалтдаа оролцохыг танхимдаа урьж байна.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Одоо байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулна. Зарчмын зөрүүтэй саналыг дэмжсэн, эсрэг байр суурьтай намын бүлгийг төлөөлж мөн аль нэг нам эвслийн бүлэгт харьяалагдаагүй тус бүр 2 хүртэл гишүүн үг хэлж болно. Санал хураалт дээр үгээ хэлнэ. Зарчмын зөрүүтэй 4 санал байгаа. Гишүүдийг санал хураалтдаа гишүүд санал хураалтдаа бэлтгэе.

Санал хураалтад өнөөдрийн хуралдаан 126 гишүүнээс 109 гишүүн ирцдээ орсон байгаа, ажилдаа ирсэн гэсэн үг өглөө. Одоо санал хураалтад бэлэн 40 гишүүн болсон байна. Танхимд 54 гишүүн, 55 гишүүн сууж байна аа. Тэгээд бусад гишүүдийг ирцэд, өглөө ирцдээ орсон гишүүдийг одоо бас танхимдаа хүрэлцэн ирэхийг урьж байна. Санал хураалт явагдах гэж байна. 51 гишүүн боллоо. Ирцдээ бэлэн болсон. Уул нь 57, 58 гишүүн болоод ирснийг мэдэж байна. Танхимд 57 гишүүн сууж байна. Ирцэд яг 54 гишүүн санал хураах бэлтгэлээ хангасан байна. Бусад одоо бэлтгэлээ хангаагүй гишүүд бэлтгэлээ хангая. Бэлэн бус гишүүд бэлтгэлээ хангая.

Ирцийн санал хураалт явуулъя. 56 гишүүн ирцдээ орсон байна. Зарим ирцдээ орчхоод гараагүй эсрэг гарч байгаа гишүүд гараа өргөөд ирцдээ анхаарал. 61 гишүүн сууж байна уу тиймээ. Ирцдээ орж чадаагүй гишүүд Ганмаа гишүүн, ецге хэн хэн байна?

Зарчмын зөрүүтэй 4 санал байгаа. Гишүүд санал хураалтдаа бэлтгэсэн. Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор. Эрхтэн эд эс шилжүүлэн суулгах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1 дэх заалтыг үндэслэн хураалгасан санал.

1.Төслийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн эрхтэн, эд эс, эд гэсний дараа эс гэж, мөн зүйлийн 6.2.1 дэх заалтын гэрлэлтээ бүртгүүлснээс хойш 3-аас доошгүй

жил гэсний дараа бэлгийн эс шилжүүлэн суулгах тохиолдолд 1-ээс доошгүй жил гэж, мөн заалтын гэрлэгч дундаасаа гэсний дараа төрсөн гэж, мөн зүйлийн 6.2.2 дахь заалтын гадаад улсын иргэн гэсний дараа харьяалалгүй хүн гэж, мөн заалтын эрхтэн эд гэсний дараа эс гэж тус тус нэмж мөн зүйлийн 6.2.1 дэх заалтын тус улсад гэснийг хасах. Санал гаргасан Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 109 гишүүн оролцсоноос 61 гишүүн буюу 56 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

2.Төслийн 15 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 15.13, 15.14 дэх хэсэг нэмэх:

15.13.нэг донорын бэлгийн эсийг зөвхөн тухайн нэг гэр бүлд ашиглахыг зөвшөөрнө.

15.14.үр хөврөлийг эцэг эхээс нь бусад хүмүүст ашиглахыг хориглоно. Санал гаргасан Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 109 гишүүн оролцсоноос 63 гишүүн буюу 57.8 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

3.Төслийн 22, 23 дугаар зүйлийг нэгтгэн 22 дугаар зүйл болгож доор дурдсанаар өөрчлөн найруулах:

22 дугаар зүйл. Амьгүй донорын гэр бүлд олгох тэтгэмж болон амьд донорт үзүүлэх дэмжлэг.

22.1.Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний оршуулгын тэтгэмжийг Эрүүл мэндийг дэмжих сангаас олгоно.

22.2.Амьд донорт эмнэлгийн тусламж үйлчилгээг хөнгөлөлттэй үзүүлэх журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, рашаан сувилалд сувилуулах журмыг Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

22.3.Хуульд заасан бусад. Санал гаргасан Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 109 гишүүн оролцсоноос 67 гишүүн буюу 61.5 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

4.Зарчмын зөрүүтэй 3 дугаар санал буюу хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний оршуулгын тэтгэмжийг Эрүүл мэндийг дэмжих сангаас олгох санал дэмжигдсэнтэй холбогдуулан Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл болон Засгийн газрын Тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах. Санал гаргасан Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 109 гишүүн оролцсоноос 68 гишүүн буюу 62.4 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Эрхтэн эд эс шилжүүлэн суулгах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүллээ.

Энэ их чухал хуулийг ажлын хэсэг хангаж ажилласан Баярбаатар нарын гишүүддээ, санаачилсан Чинбүрэн нарын гишүүддээ нийт гишүүдийнхээ өмнөөс баяр хүргэе. Ирэх 7 хоногт эцэслэн баталъя. Чухал хууль одоо иргэдийн амь нас дээсэн дөрөөн дээр байгаа энэ цаг үед хурдан батлах шаардлагатай байгаа учраас ирэх 7 хоногт эцэслэн батлах санал хураалт явагдана шүү. Бэлтгэлээ сайн хангаарай гэж хүсье ээ.

16.16 цаг

Дараагийн асуудалдаа оръё.

Санал хураалтууд одоо явагдана.

Нийгмийн ажлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх санал хураалт

Нийгмийн ажлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Уучлаарай санал хураалтдаа бэлдэх ёстой шүү. Шинэ санал хураалт учраас. Гишүүд санал хураалтдаа бэлтгэе. 69 гишүүн санал хураалтдаа бэлэн болсон байна. Санал хураалт явуулъя.

1.Нийгмийн ажлын тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 109 гишүүн оролцсоноос 64 гишүүн буюу 58.7 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн Ахмад настны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 109 гишүүн оролцсоноос 68 гишүүн буюу 62.4 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

3.Боловсролын ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

109 гишүүн санал хураалтад оролцсоноос 64 гишүүн буюу 58.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

109 гишүүн санал хураалтад оролцсоноос 69 гишүүн буюу 63.3 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

5.Нийгмийн халамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

109 гишүүн оролцсоноос 66 гишүүн буюу 60.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

6.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

109 гишүүн санал хураалтад оролцсоноос 67 гишүүн буюу 61.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

7.Хүүхэд хамгааллын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

109 гишүүн санал хураалтад оролцсоноос 68 гишүүн буюу 62.4 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

8.Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

9.Нийгмийн ажлын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

109 гишүүн санал хураалтад орсноос 66 гишүүн буюу 60.6 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

9.Нийгмийн ажлын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя аа.

Санал хураалтад 109 гишүүн оролцсоноос 67 гишүүн буюу 61.5 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Нийгмийн ажлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг санал хураалтад оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүллээ.

Энэ хууль дээр төсвөөс нэмэлт зардал гаргахгүй, мөн нэмэлт орон тоонууд бий болохгүй ээ. Өөрөөр хэлэх юм бол төсөвт ачаалал өгөхгүй гэж хууль санаачлагч нар олон удаа асуултад хариулахдаа ярьсан шүү. Тийм болохоор биднүүс улс орныхоо нийгэм, эдийн засаг, төсвийнхөө даацыг бодох ёстой. Энэ хүрээндээ хуулийн төслөө хэлэлцүүлэгт бэлтгэлтэй бас анхаарах ёстой шүү гэдгийг сануулъя аа.

16.20 цаг

Дараагийн асуудалдаа оръё.

Дараагийн санал хураалтууд.

Байгаль орчны нөлөөллийн тухай хуулийн анхны хэлэлцүүлэг санал хураалт

Байгаль орчны нөлөөллийн тухай хуулийн анхны хэлэлцүүлгийг явуулсан. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууссан байгаа.

Одоо байнгын хорооноос санал хураалгахаар бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна аа. Зарчмын зөрүүтэй саналыг тайлбарлаж, түүнийг дэмжсэн эсрэг байр суурьтай намын бүлгийг төлөөлж мөн аль нэг нам, эвслийн бүлэгт харьяалагддаггүй тус бүр 2 хүртэл гишүүн үг хэлж болно оо.

Зарчмын зөрүүтэй 14 санал байгаа. Гишүүд санал хураалтдаа бэлтгэе. Санал хураалтдаа 61 гишүүн бэлэн болсон байна. Бэлэн болж амжаагүй гишүүд санал хураалтдаа бэлтгэе. Түрүүн 69 гишүүн байсан. Гишүүд санал хураалтдаа бэлтгэе. Би бэлдээгүй байна шүү дээ бас. 68 гишүүн бэлэн болсон байна.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар БОХХАА-н байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

Нэг.БОХХАА-н байнгын хороо дэмжсэн санал.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалт буюу 7 дугаар зүйлийн 7.9 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

7.9.Төслийг байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл, цар хүрээ, төсөл хэрэгжих газар нутгийн байршил, хүчин чадлыг харгалзан дараах байдлаар ангилна.

7.9.1.зэрэглэл нэг буюу их эрсдэлтэй төсөлд байгаль орчин нийгмийн бүрэлдэхүүн хэсэгт үзүүлэх сөрөг болон хуримтлагдах нөлөөлөл нь төслийн нөлөөллийн бүсийн хэмжээгээр хязгаарлагдахгүй, байгаль орчин нийгмийн сөрөг нөлөөллийг бууруулахад нэмэлт арга хэмжээ шаардлагатай газар чөлөөлөлтийн хамрах хүрээ ихтэй үйл ажиллагааг;

7.9.2.зэрэглэл 2 буюу дунд эрсдэлтэй төсөлд байгаль орчин нийгмийн бүрэлдэхүүн хэсэгт үзүүлэх сөрөг нөлөөлөл нь төслийн нөлөөллийн бүсийн хэмжээгээр хязгаарлагдах боломжтой, байгаль орчин нийгмийн сөрөг нөлөөллийг

бууруулахад нөхцөл болзолтой арга хэмжээ шаардлагатай газар чөлөөлөлтийн хамрах хүрээ хязгаарлагдмал үйл ажиллагааг;

7.9.3.зэрэглэл 3 буюу бага эрсдэлтэй төсөлд эрсдэлтэй төсөлд байгаль орчин нийгмийн бүрэлдэхүүн хэсэгт үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл хязгаарлагдмал эсхүл эрсдэлгүй үйл ажиллагааг. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Уянга, Алтаншагай, Бат-Эрдэнэ, Ганбаатар, Замира, Идэрбат, Мөнхбат, Мөнхсоёл, Одонтуяа. Цаашид ажлын хэсэг гэх. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 109 гишүүн оролцсоноос 63 гишүүн буюу 57.8 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалт буюу 7 дугаар зүйлийн 7.13 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

7.13.Төсөл хэрэгжүүлэгч нь Байгаль орчны ерөнхий үнэлгээнд санал авах хүсэлтийг төслийн товч танилцуулга, газрын эрхтэй холбоотой баримт бичгийн хамт тухайн сум, дүүргийн Засаг даргад гаргана. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор. За ажлын хэсгийн ахлагч Болдын Уянга гишүүн микрофон өгье.

Б.Уянга: 7.13-ыг гүйцээн боловсруулах чиглэл авъя дарга. Мандхай гишүүн нэлээн их санал яг түрүүн 1 дүгээр хэлэлцүүлэг дээр хэлсэн. Тэгээд ажлын хэсэг дээр тухайлан сууж байгаад сайжруулаад ороод ирье.

С.Бямбацогт: Гишүүдийн бас асуулт хариулт авч байх үед асуулт асууж хариулт авч байх үед Мандхай нарын гишүүд нэлээн чухал саналууд гаргаж байсан. 7.13-ыг гүйцээн боловсруулах чиглэл өгье өө. Гишүүдийн гаргасан саналыг тусгаад.

3.Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалт буюу 7 дугаар зүйлийн 7.10 дахь хэсгийн ажлын 10 хоногт гэснийг ажлын 15 хоногт гэж, хариу өгсөнд гэснийг зөвшөөрсөнд гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 109 гишүүн оролцсоноос 60 гишүүн буюу 55 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

4.Төслийн 2 дугаар зүйлийн 3.1.4 дэх заалтын үнэлгээ гэж гэсний дараа зэрэглэл 1, зэрэглэл 2 гэж гэснийг төслийн 4 дүгээр зүйлийн 3 дугаар зүйлийн 4 дүгээр зүйлийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсгийн байгаль орчны гэснийг байгаль орчин нийгмийн гэж гэснийг болон төслийн 5 дугаар зүйлийг хасаж 3.1.4 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж төслийн 3 дугаар зүйлд нэмэх.

Энэ маш ойлгомжгүй өгүүлбэр бичиж байна шүү. Энийгээ анхаарах ёстой шүү.

3.1.4.Байгаль орчны төлөв байдлын үнэлгээ гэж зэрэглэл 1, зэрэглэл 2 Төслийн техник эдийн засгийн төлөвлөлтийн баримт бичиг, зураг төсөл, улсын болон бүс нутаг салбарын хэмжээнд хэрэгжүүлэх хөгжлийн хөтөлбөр төлөвлөгөөг боловсруулах явцад тэдгээрийг хэрэгжүүлэх нутаг дэвсгэрийн байгаль орчин нийгмийн төлөв байдлыг судлан тогтоож цаашид төсөл хөтөлбөр төлөвлөгөө

бодлого боловсруулахад анхаарах, байгалийн нөхцөл, орчны онцлогийг тодорхойлохыг. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 109 гишүүн оролцсоноос 61 гишүүн буюу 56 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

5.Төслийн 3 дугаар зүйлийн 4 дэх заалт буюу 7 дугаар зүйлийн 7.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

7.6.Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тайланд шинжилгээ хийж, дүгнэлт гаргах ерөнхий шинжээч, шинжээчийн эрхийг Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олгох бөгөөд дараах шаардлагыг хангасан байна.

7.6.1.ерөнхий шинжээч нь Төрийн албаны тухай хуулийн 23.2.2-т заасан шаардлагыг хангасан байгаль орчны чиглэлээр 8-аас доошгүй жил ажилласан, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх мэргэжлийн чадвар, ажлын туршлагатай байх.

7.6.2.шинжээч нь Төрийн албаны тухай хуулийн 18.1.4-д заасан шаардлагыг хангасан байгаль орчны чиглэлээр 3-аас доошгүй жил ажилласан байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх мэргэжлийн чадвар, ажлын туршлагатай байх. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. За ажлын хэсгийн ахлагч Болдын Уянга микрофон өгье.

Б.Уянга: Энхтүвшин яг энэ 8 жил, 3-аас доошгүй жил гэдэг дээр Энхтүвшин гишүүн болон Батбаатар сайд нар санал гаргасан, гишүүд санал гаргасан учраас гүйцээн боловсруулах авъя.

С.Бямбацогт: Сайн байна. Яг иймэрхүү чиглэлээр гишүүдийн саналдаа хүндэтгэлтэй хандаад сайжруулах ёстой. Гүйцээн боловсруулах чиглэл өглөө.

6.Төслийн 3 дугаар зүйлийн 7 дахь заалт буюу 9 дүгээр зүйлийн 9.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

9.4.Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр батлагдсан менежментийн төлөвлөгөөнд нэмэлт, өөрчлөлт оруулах, хянах, тайлагнах журам, аргачлалыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт.

Санал хураалтад 109 гишүүн оролцсоноос 67 гишүүн буюу 61.5 хувийн санал энэ санал дэмжигдлээ.

7.Төслийн 3 дугаар зүйлийн 9 дэх заалт буюу 10 дугаар зүйлийн 10.5 дахь хэсгийн хамтран гэсний дараа төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн захиргаа гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. За ажлын хэсэг Болдын Уянга гишүүн.

Б.Уянга: Би 10.5 дээр болохоор Ганхүлэг гишүүн, Энхтуяа гишүүн, Мөнхбаясгалан гишүүдийн асуулт давхацсан учраас бас гүйцээн боловсруулах авъя.

С.Бямбацогт: Баярлалаа. Бас гишүүдийнхээ саналд хүндэтгэлтэй хандаад анхаарч үзэж байгаа ажлын хэсэгт баярлалаа. Гүйцээн боловсруулах чиглэл өгье.

7 дугаар санал тийм ээ. 8 төслийн 3 дугаар зүйлийн 10 дахь заалт буюу 14.1.2 дахь заалтын орон нутгийн захиргаа гэснийг нутгийн нутаг дэвсгэрийн захиргаа гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт.

Санал хураалтад 109 гишүүн оролцсоноос 66 гишүүн буюу 60.6 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

9.Төслийн 7 дугаар зүйлийн хуулийг дагаж мөрдөх хугацааг 2026 оны 8 дугаар сарын 1 гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 109 гишүүн оролцсоноос 68 гишүүн буюу 62.4 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

10.Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн нэр томъёог жигдлэх, зүйл хэсэг заалтын дугаарыг нийцүүлж өөрчлөх, бүтэц найруулга, хууль зүйн техникийн засварыг хийх. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт.

Санал хураалтад 109 гишүүн оролцсоноос 67 гишүүн буюу 61.5 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Хоёр.БОХХАА-н байнгын хороо дэмжээгүй санал.

Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалт буюу 7 дугаар зүйлийн 7.14 дэх хэсгийг хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Сэддорж. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 109 гишүүн оролцсоноос 60 гишүүн буюу 55 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 10 дахь заалт буюу 18 дугаар зүйлийн 18.7 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

18.7.Иргэн тухайн төслийн үйл ажиллагаатай нь холбогдуулан газрын хэвлийн баялгийн ашиглалтын нөхцөл байдал, байгаль орчинд үзүүлж байгаа нөлөөлөл, нөхөн сэргээлтийн талаар мэдээлэл авах танилцах хүсэлтийг төсөл хэрэгжүүлэгч төрийн байгууллага албан тушаалтанд гаргаж болох бөгөөд төслийн нөлөөлөлд өртөх иргэдийн олонхын бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр байгаль орчны нөлөөллийн үнэлгээг эерэгээр дүгнэхийг хориглоно. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Сэддорж. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт.

Санал хураалтад 109 гишүүн оролцсоноос 61 гишүүн буюу 56 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

3.Төслийн 3 дугаар зүйлийн 9 дэх заалт буюу 10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

10.4.Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 10.5 дахь 5-д заасан танилцуулгаас гарсан саналыг нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланд тусгасан эсэх болон үнэлгээний шинжилгээ хийсэн шинжээч мэргэжлийн зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн төслийг хэрэгжүүлэх эсэх асуудлыг шийдүүлэх бөгөөд хэрэв байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тухайн төсөл нь усны нөөц, амьжиргаа, тогтвортой байдалд ноцтой сөрөг нөлөө үзүүлэх нь тогтоогдсон тохиолдолд төслийг хэрэгжүүлэхийг хориглоно. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Сэддорж. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт.

Санал хураалтад 109 гишүүн оролцсоноос 48 гишүүн буюу 44 хувийн саналаар энэ санал дэмжигдсэнгүй. Сэддорж гишүүний санал босож байна аа.

4.Төслийн 3 дугаар зүйлийн 9 дэх заалт буюу 10 дугаар зүйлийн 10.5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

10.5.Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний тайланг төсөл хэрэгжүүлэгч үнэлгээ хийсэн мэргэжлийн байгууллага хамтран төслийн нөлөөлөлд өртөх иргэдэд танилцуулж, санал авах ажлыг зохион байгуулах бөгөөд төслийн улмаас иргэдэд учирсан хохирол, зардал, амьжиргааны алдагдал, усны хүртээмж, байгаль орчин, нийгмийн нийгэм, соёлын орчинд үзүүлсэн үр дагавар нөлөөллийг хамруулан иж бүрнээр үнэлж бүрэн нөхөн төлнө өө. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Сэддорж.

Санал хураалтад 109 гишүүн оролцсоноос 45 гишүүн буюу 41.3 хувийн саналаар ажлын хэсгийн санал дэмжигдсэнгүй. Сэддорж гишүүний санал дэмжигдэж байна аа.

Зочин танилцуулъя. Нийслэлийн ерөнхий боловсролын 24 дүгээр сургуулийн 12-ын Б ангийн багш сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа Төрийн ордонтой танилцаж байна аа. Та бүхэндээ удахгүй болох гэж байгаа ЭЕШ-даа амжилттай бэлдэж, хүссэн сургуульдаа хүссэн мэргэжлээрээ суралцахыг хүсэн ерөөе. Мөн улс эх орондоо бүтээлч, эх оронч, сайн иргэн болж төлөвшихийг Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс хүсэн ерөөе. Амьдралд нь аз жаргал, эрүүл энх, сайн сайхан бүхнийг хүсье ээ. Тэгээд аав ээжийнхээ, багшийнхаа үгэнд сайн орж байгаарай.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дууслаа. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр БОХХАА-н байнгын хороонд шилжүүллээ. За болоогүй шүү гишүүд ээ, дахиад асуудал байгаа шүү.

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэгтэй холбогдуулж гишүүд асуулт асууж, хариулт авч дууссан.

Одоо Байнгын хорооны гаргасан горимын саналаар санал хураалт явуулна аа. Гишүүд санал хураалтдаа бэлтгэе ээ. Гишүүд санал хураалтдаа бэлдье. 50 гишүүн бэлэн болсон байна. Түүрүүн 69 гишүүн бэлэн болсон байсан. Одоо гишүүд санал хураалтдаа бэлдэж амжаагүй гишүүд санал хураалтдаа бэлдье. 56 гишүүн бэлэн болсон байна. Яагаад орохгүй байна. Гишүүд санал хураалтдаа бэлдсэн үү гишүүд. За бүртгэлийн санал хураалтыг явуулчихъя.

58 гишүүн ирцдээ орсон. Мандхай гишүүн хуруугаа уншуулаад орчих, өөр ороогүй гишүүд байна уу. Баасанжаргал гишүүн уучлаарай. Өөр ирцдээ бүртгэлдээ ороогүй гишүүд байна уу? Мөнхсоёл гишүүн хуруугаа уншуулаад ирцдээ орчихъё. Санал хураалт явуулна аа гишүүд ээ. Анхааралтай байгаарай.

Нэг.Байнгын хорооноос Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг анхны хэлэлцүүлгээс эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх горимын санал гаргасныг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 109 гишүүн оролцсоноос 64 гишүүн буюу 58.7 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гаргасан горимын саналыг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар ТББХ-нд шилжүүллээ.

16.37 цаг

Дараагийн асуудалдаа оръё.

Одоо нэг асуудал. Тэгээд дуусна аа.

Баталсан хуулийн эцсийн найруулгыг сонсоно оо.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 46.1.3-т Улсын Их Хурал Энэ хуулийн 46.1.2-т заасан хууль тогтоолын эцсийн найруулгатай танилцаж ёсчлохыг зөвшөөрөх гэж заасны дагуу хуулийн эцсийн найруулгыг холбогдох байнгын хороо бэлтгэж, Улсын Их Хуралд танилцуулахад бэлэн болсон байна аа.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Өнөөдрийн 2026 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлаа Улсын Их Хурлын гишүүд амжилттай хэлэлцэж дууслаа. Хуралдаанд оролцсон гишүүддээ баярлалаа.

Сая 109 гишүүнээс санал хураалтад оролцохгүй байгаа гишүүд цаашдаа санал хураалтдаа оролцоно шүү. Ирцдээ орчхоод ингээд санал хураалтад орохгүй алга болчихдог байдлыг таслан зогсоох ёстой шүү бид бүхэн. Үүнийг бас гишүүддээ сануулж хэлье. Ирцдээ ороод санал хураалтад оролцсон эрхэм гишүүддээ онцгойлж баяр хүргэе.

Өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

14.52 цагт

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ П.МЯДАГМАА